



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-28</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>29-151</i>
<hr/>	
<i>1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>32-41</i>
<i>2. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлөх тухай асуудал</i>	<i>41-50</i>
<i>3. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал</i>	<i>50-54</i>
<i>4. Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>54-107</i>
<i>5. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг томилох тухай асуудал</i>	<i>107-119</i>
<i>6. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>119-148</i>
<i>7. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	<i>148-149</i>
<i>8. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	<i>149-151</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 30-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 54.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Г.Дамдинням, Б.Жавхлан, Ц.Туваан;
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Д.Батлут, Х.Ганхуяг, Ш.Раднаасэд,
Ж.Сүхбаатар, Б.Энх-Амгалан;

Тасалсан: Ц.Анандбазар, Ц.Сэргэлэн, Ч.Хүрэлбаатар;

Хоцорсон: С.Амарсайхан-05 минут, Э.Батиугар-10 минут, Х.Болорчулуун-08 минут, Х.Булгантуяа-07 минут, С.Ганбаатар-1 цаг 13 минут, Д.Ганбат- 27 минут, Ц.Даваасүрэн-06 минут, Г.Мөнхцэцэг-10 минут, Д.Өнөрболор-3 цаг 08 минут, Б.Саранчимэг-45 минут, Ч.Ундрал-10 минут, Н.Учрал-49 минут, Д.Цогтбаатар-03 минут, Б.Чойжилсүрэн- 05 минут, Ж.Эрдэнэбат-32 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Ш.Адъяа нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Ш.Адъяа нар үг хэлэв.

Нэг.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунцэцэг, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Ц.Даваасүрэн нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн сайд С.Чинзориг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар хуралдааныг 10 цаг 05 минутаас 10 цаг 35 минутад даргалав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуралдааныг 10 цаг 35 минутаас даргалав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 19.3.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.6.тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмж.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 21
Бүгд: 51
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлөх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунангаас ирүүлсэн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх тухай өргөдлийг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар тус тус танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Н.Ганибал, С.Одонтуяа, Ш.Адъяа, Д.Ганбат, Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Нэр дэвшигчийг чөлөөлөх саналыг нууц санал хураалтаар явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Жаргалсайханы Хунанг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх нь зүйтэй гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 23
Бүгд: 52
55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:30/

Уг асуудлыг 11 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Д.Энхбат оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг чөлөөлөх, томилох тухай саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Нэр дэвшигч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигч Д.Энхбат хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал үг хэлэв.

Нэр дэвшигчийг томилох саналыг нууц санал хураалтаар явуулав.

Г.Занданшатар: Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилж, Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 16
Бүгд: 51
68.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:43/

Уг асуудлыг 11 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Г.Эрдэнэбулган, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, мөн зөвлөлийн гишүүн А.Насандэлгэр, Н.Отгончимэг, Б.Ундрах, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга Х.Ариунболд, мөн газрын Хууль тогтоомж, дотоод ажлын хэлтсийн дарга Э.Бадамсамбуу нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, дэд дарга Ц.Батбаатар, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Г.Тэмүүлэн, С.Одонтуяа, Н.Алтанхуяг, Ц.Сандаг-Очир, Б.Жаргалмаа, Ш.Адъяа, Ц.Цэрэнпунцаг, Ж.Батжаргал, Д.Ганбат, Н.Ганибал, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Ц.Идэрбат, О.Цогтгэрэл, Ч.Ундрам, Б.Батгөмөр, Г.Мөнхцэцэг, Н.Энхболд нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, мөн зөвлөлийн гишүүн Н.Отгончимэг, Б.Ундрах, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга Х.Ариунболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар хуралдааныг 14 цаг 39 минутаас 14 цаг 47 минутад, 14 цаг 49 минутаас 15 цаг 51 минутад даргалав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хуралдааныг 15 цаг 51 минутаас даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 15

Бүгд: 48

68.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээлэл сонсох /Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар/ асуудлыг дараагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр хойшлуулж байгааг мэдэгдэв. /16:06/

Тав.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргад нэр дэвшигч Д.Сүнжид оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг нар байлцав.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг томилох тухай саналыг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар танилцуулав.

Нэр дэвшигч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы асуусан асуултад Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын даргад нэр дэвшигч Д.Сүнжид хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Д.Цогтбаатар, Б.Пүрэвдорж, Н.Ганибал, М.Оюунчимэг, Б.Жаргалмаа нар үг хэлэв.

Нэр дэвшигчийг томилох саналыг нууц санал хураалтаар явуулав.

Г.Занданшатар: Дугарын Сүнжидийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	32
Татгалзсан:	22
Бүгд:	50

64.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажилд томилох тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажилд томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:50/

Уг асуудлыг 16 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн яамны Автотээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Э.Мөнхнасан, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Ж.Ичинноров, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хууль, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Энхтуяа, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, Хот байгуулалт, хөгжлийн

газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Хан-Уул, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зохицуулагч М.Говьсайхан, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-ын Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн М.Уранбилэг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Наранцэцэг, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Н.Ганибал, С.Одонтуяа нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Амгалан, Х.Ганхуяг, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Д.Цогтбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төрөл, хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “авто замаар” гэсний өмнө “замын хөдөлгөөний эрчим буурч,” гэж нэмж, мөн заалтын “цагаас доош буурч” гэснийг “цагт хүрэхгүй” гэж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтын “Орон сууцны

тухай хуулийн 3.1.3-т заасан орон сууц хөгжүүлэх” гэснийг “гэр хорооллыг барилгажуулах” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 4.1.4 дэх заалтыг, мөн зүйлийн 4.1.8 дахь заалтын “энэ хуулийн 14.2-т заасан” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 15

Бүгд: 42

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.9.“автотээврийн хэрэгсэл” гэж Автотээврийн тухай хуулийн 3.1.1-д заасныг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 14

Бүгд: 42

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 14

Бүгд: 42

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “**ХОЁРДУГААР БҮЛЭГ**”-ийн гарчгийн “**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨЛБӨРТЭЙ БҮС, АВТО ЗОГСООЛ**” гэснийг “**НИЙСЛЭЛИЙН НИЙГИЙН ТЭЭВЭР, АВТО ЗОГСООЛ**” гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн дараа шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 16

Бүгд: 42

61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5 дахь хэсгийн “шалтгаалан” гэснийг “хамааран” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн **“ГУРАВДУГААР БҮЛЭГ”** **“НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭР, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ”** гэсэн гарчгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 16
Бүгд: 44
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Автотээврийн тухай хуулийн 15.1 дэх хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “авто замын даацыг” гэснийг “тээврийн хэрэгслийн өсөлт, авто замын сүлжээний нягтрал, замын хөдөлгөөний түгжрэлийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийн “тээврийн хэрэгслийн” гэсний өмнө “тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44

61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтын “авто зогсоолыг” гэснийг “автобусны буудал, авто зогсоолыг” гэж, 13.1.3, 13.1.4, 13.5.1, 13.5.4 дэх заалтын “чиглэлийн” гэснийг “нийтийн” гэж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “дүрэм, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг” гэснийг “дүрмийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.5.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 14
Бүгд: 45

68.9 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.4 дэх хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“16.4.Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 16.2-т заасан хугацаанд үнэлгээ хийлгээгүй бол уг хугацаа дууссанаас хойш 14 хоногт багтаан үнэлгээг хийлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 15
Бүгд: 45
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “байршил буюу дэд төвийг түшиглэн” гэснийг “дэд төвийн байршилд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 15
Бүгд: 45
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтын “барилгажилтын төслийг” гэснийг “хот байгуулалтын холбогдох баримт бичгийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 19.1.2 дахь заалтын “гэрээ байгуулах” гэсний дараа “, төслийн нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;” гэж, мөн зүйлийн 19.1.5 дахь заалтын “талбарыг” гэсний өмнө “нэгж” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 14
Бүгд: 46
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.7 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 15
Бүгд: 46
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.1.4, 20.1.5 дахь заалт тус тус нэмэх.

“20.1.4.холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын ажлын уялдааг нэгдсэн удирдлагаар хангах;

20.1.5.төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг хөгжүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтын “нийслэлийн авто замын даацыг харгалзан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.4 дэх заалтын “байдал, замын хөдөлгөөний төлбөртэй бүс, түүнийг тойрон өнгөрөх замын” гэснийг “байдлын” гэж өөрчилж, мөн зүйлийн 23 дугаар зүйлийн 23.2.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 17
Бүгд: 45
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2 дахь хэсэг нэмэх.

“22.2.Нийслэлийн Засаг дарга Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан ерөнхий архитекторын чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжбье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 16
Бүгд: 45
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаан даргалагчаас дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “65” гэснийг “70” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжбье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 28
Бүгд: 45
37.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Гурав.Найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэснийг “ГУРАВДУГААР БҮЛЭГ” гэж, “ТАВДУГААР БҮЛЭГ” гэснийг “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэж, “ЗУРГАДУГААР БҮЛЭГ” гэснийг “ТАВДУГААР БҮЛЭГ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжбье гэсэн санал хураалт явуулъя.

2.Төслийн 9 дүгээр зүйлийн дугаарыг “8” гэж, 10 дугаар зүйлийн дугаарыг “5” гэж”, 11 дүгээр зүйлийн дугаарыг “6” гэж, 12 дугаар зүйлийн дугаарыг “9” гэж, 13 дугаар зүйлийн дугаарыг “7” гэж, 14 дүгээр зүйлийн дугаарыг “10” гэж, 15 дугаар зүйлийн дугаарыг “11” гэж, 16 дугаар зүйлийн дугаарыг “12” гэж, 17 дугаар зүйлийн дугаарыг “13” гэж, 18 дугаар зүйлийн дугаарыг “14” гэж, 19 дүгээр зүйлийн дугаарыг “15” гэж, 20 дугаар зүйлийн дугаарыг “16” гэж, 21 дүгээр зүйлийн дугаарыг “17” гэж, 22 дугаар зүйлийн дугаарыг “18” гэж, 23 дугаар зүйлийн дугаарыг “19” гэж, 24 дүгээр зүйлийн дугаарыг “20” гэж, 26 дугаар зүйлийн дугаарыг “21” гэж, 27 дугаар зүйлийн дугаарыг “22” гэж тус тус өөрчлөх

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 12
Бүгд: 45
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал:

1.Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшиний гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмж, үүнтэй холбогдуулан 1 дүгээр зүйлийн хүснэгтийн 3 дахь заалтын “, цахилгаан тэжээлт автомашин” гэснийг хасах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

11	Цахилгаан тэжээлт автомашин	0-100 000	0-80 000
----	-----------------------------	-----------	----------

гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 21
Бүгд: 45
53.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Э.Бат-Амгалан, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Ц.Мөнх-Оргил, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Д.Цогтбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 12.6 дахь хэсгийн “төлбөрийг” гэснийг “төлбөрийн орлогыг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 15.9.2 дахь заалтын “боловсон хүчин” гэснийг “хүний нөөц” гэж тус тус өөрчилж, 15.10 дахь хэсгийн “, нэг өнгийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 17^{1.5} дахь хэсгийн “олгоно” гэсний өмнө “энэ зүйлийн 17^{1.2}-т заасан журмын дагуу” гэж нэмж, 17^{1.7} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17^{1.7}.Энэ хуулийн 17^{1.5}-д заасан хязгаарт багтаан олгох автотээврийн хэрэгслийн төрөл, ангилал, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлтийг нийслэлийн Засаг дарга батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 13
Бүгд: 44
70.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 10.1.10 дахь заалтыг болон мөн зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “замын хөдөлгөөний төлбөртэй бүс болон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “торгох шийтгэл” гэсний өмнө “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан оногдуулсан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. /Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал/

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.5.Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 13.2.9, 22.4-т заасан үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 15
Бүгд: 45
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “38 дугаар зүйлийн” гэсний өмнө “25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хариуцсан газартай” гэснийг “хариуцсан байгууллагатай” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 18
Бүгд: 45
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 9.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.7.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй барьсан, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг зөрчсөн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгах зэргээр орц, гарцыг гаргах арга хэмжээг авах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 16
Бүгд: 45
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Энэ хуулийн 9.1.7-д заасан барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгахтай холбоотой зардлыг буруутай этгээдээр гаргуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.3.Энэ хуулийн 9.1.2-т заасан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын сонгон шалгаруулалтад Барилгын тухай хуулийн 44.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, эсхүл мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд оролцож болно.

9.4. Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх бол аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.5. Энэ хуулийн 9.4-т заасан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд нь энэ хууль болон гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

4. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “70 хувиас” гэсний дараа “илүүгүй” гэж, “60 хувиас” гэсний дараа “илүүгүй буюу төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-иос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-иос доошгүй хувь нь авто зогсоол” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г. Занданшатар: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах /Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал/ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г. Занданшатар: 1. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 9.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2. Энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван сарын дотор уг хэсэгт заасан гэрээг нөхөн байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа үг хэлэв.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 16
Бүгд: 44

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т заасан нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх зохицуулалтыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 15

Бүгд: 44

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13.7 дахь хэсгийн “зориулалтыг” гэсний өмнө “хийц, бүтээц,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 15

Бүгд: 44

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 18

Бүгд: 44

59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “түүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар” гэснийг “тухайн шатны Засаг даргаар” гэж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэснийг “Засаг дарга” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 35.2.1 дэх заалтыг хасаж, 35.2.2 дахь заалтын дугаарыг “35.2.1” гэж өөрчлөн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.2.1.амьтны хүрээлэн ажиллуулах журам;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 15
Бүгд: 44
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалтын “5 000 000-10 000 000” гэснийг “3 000 000-10 000 000” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Г.Амартүвшин нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

13. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 23.6.11 дэх заалтыг хасаж, 23.6.12 дахь заалтын дугаарыг “23.6.11” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42

59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6.2 дахь хэсгийн “12.6.3-г” гэснийг “12.6.3, 12.8-д” гэж, “татварын хэмжээг” гэснийг “татварын хувь, хэмжээг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 20

Бүгд: 42

52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “хүртэл” гэснийг “дуустал” гэж, 2 дугаар зүйлийн “бараа” гэснийг “барилгын материал” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 14

Бүгд: 42

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

16. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.10.гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 12

Бүгд: 42

71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

17. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “22.5.15, 22.5.16 дахь заалт” гэснийг “22.5.18, 22.5.19 дэх заалт” гэж өөрчилж, 22.5.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.5.19.гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 13
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Хүн, хуулийн этгээд энэ хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11.19 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэж торгох шийтгэлийг хугацаанд нь төлөөгүй нь энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах үндэслэл болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, С.Одонтуяа, Г.Амартүвшин нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6.30 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг хасаж, 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.Амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйл буюу 12.5 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн” гэсний өмнө “хэсэгчилсэн ерөнхий” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хэсгийн “11.24 дүгээр зүйл,” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэж, мөн” гэснийг хасаж, “7.6 дугаар зүйлийн 9, 10” гэснийг “7.6 дугаар зүйлийн 9” гэж тохиолдол бүрд өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“21.5.4.Энэ хуулийн 21.2.7-д заасан эрх шилжүүлэн авсан бол энэ хуулийн 21.2.4, 21.2.6-д заасан шийдвэр гаргах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 29.8.1 дэх заалтын “жагсаалтын эхэнд” гэсний дараа “, цахим системд хүсэлт гаргасан огноогоор” гэж, 29.11 дэх хэсгийн “аймаг,” гэсний дараа “сум,” гэж нэмж, мөн хэсгийн “газар

ашиглалтын” гэснийг “эдэлбэр газрын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 12.4, 12.6 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Бүсчлэлд тавигдах шаардлагыг хот, тосгон, бусад суурины эдэлбэр газарт дүрмээр зохицуулах бөгөөд бүсчлэлийн дүрмийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“**5 дугаар зүйл.**Энэ хууль батлагдахаас өмнө Газрын тухай хуульд заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гаргасан газар эзэмших, ашиглах хүсэлтийг хүлээн авсан эрх бүхий этгээд уг хүсэлтийг шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 33.1.25 дахь заалтын “хэмжээг” гэсний өмнө “жишиг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 15
Бүгд: 42
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

23. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1, 2 дахь заалтыг 1.1, 1.2 дахь дэд заалт болгож, төсөлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3, 4 дэх дэд заалт нэмэх:

“3/Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэл Улаанбаатар хотын орон сууцны байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл /фасад, дээвэр, босоо шугам, хаяавч, узель/-д шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

4/Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 42
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дахь заалтыг 2 дахь заалт болгон “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо /Г.Тэмүүлэн/, Төрийн байгуулалтын байнгын хороо /Н.Энхболд/,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

24.Бусад саналын талаар:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 12
Бүгд: 42
69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, “Азтай савар” ТББ-ын тэргүүн Ц.Зориглон, мөн ТББ-ын зохицуулагч Э.Бүжинлхам, удирдах зөвлөлийн гишүүн Ц.Болормаа, “Эм-Ди-Эс энд Хаанлекс” хуулийн фермийн хуульч М.Ариунзул, Өмгөөллийн “Легал Гайд” хуулийн фермийн хуульч Н.Баясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, “Азтай савар” ТББ-ын тэргүүн Ц.Зориглон, мөн ТББ-ын зохицуулагч Э.Бүжинлхам, удирдах зөвлөлийн гишүүн Ц.Болормаа, “Эм-Ди-Эс энд Хаанлекс” хуулийн фермийн хуульч М.Ариунзул, Өмгөөллийн “Легал Гайд” хуулийн фермийн хуульч Н.Баясгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

Бүгд: 41

61.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 19, 20 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Төмөр замын татах хэсгийн ажилчдын төлөөлөл, Хаан банкны санхүүгийн удирдлагын газрын хамт олон, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрал, Д.Өнөрболор, Ж.Эрдэнэбат нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 57 дугаар сургуулийн 1981 оны төгсөгчид, Хэнтий аймгийн Хэрлэн сумын залуучуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Х.Булгантуяа, Э.Бат-Амгалан нарын урилгаар Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн шилдэг сурагчид, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн ахмадуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Ц.Цэрэнпунцаг нарын урилгаар Социал демократ Монголын оюутны холбооны гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын урилгаар “Залуу хүн” клубийн Чингэлтэй дүүргийн гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугар, Н.Учрал, П.Анужин нарын урилгаар нийслэлийн Ерөнхий боловсролын 12 дугаар

сургуулийн сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг нарын урилгаар Сүхбаатар дүүргийн 9,11 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Багануур дүүргийн иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 8 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 20 минут үргэлжилж, 72 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 79.2 хувийн ирцтэйгээр 19 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 30-ны
өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай”
танхим
10 цаг 05 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүдийн амрыг эрье. Ирц хүрсэн байна. Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Арванхоёр асуудал хэлэлцэнэ.

Нэгд, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Зарчмын зөрүүтэй I саналтай.

Хоёрт, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлөх тухай асуудал.

Гуравт, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудал.

Дөрөвт, Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Тавт, Цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээлэл сонсоно. Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар мэдээллийг сонсоно.

Зургаад, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Долоо.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэнэ. Эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Наймд, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг хэлэлцэнэ. Анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Ес, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын 3 гишүүн өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг хийнэ.

Арав.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл. Энэ анхны хэлэлцүүлгийг хийнэ. Энэ болохоороо Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан төсөл байна.

Арваннэг, “Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хүүхдийн эрхийг хангах хамгаалах асуудлаар явуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Арванхоёрт, Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

хуулийн 13.4 дэх гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Ширнэнбаньдын Адьшаа нараас тус тус ирүүлсэн албан бичгүүдийг танилцуулъя.

Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданишатар танаа Миний бие Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Батсуурь гэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданишатар танаа Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлтээ хүргүүлж байна. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа гэсэн байна.

Одоо Жамбын Батсуурь гишүүн үг хэлье.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Монгол орны бүх нутаг дэвсгэрт цасан бүрхүүл тогтоод сар орчим болчихлоо. Анхны цас нэлээд хэмжээгээр орсон түүнээс хойш 2, 3 ч удаа орчихлоо. Хөдөөд нөхцөл байдал нэлээд хүнд боллоо. Намар дулаахнаараа байж байгаад анхны цас маш их орсон учраас өвөлжсөөндөө бууж амжилгүй, отор нүүдэлд явж амжилгүйгээр хатуу өвөлтэй золгочихлоо.

Хүмүүсийн ярьж байгаагаар өмнө болж байсан 66 оны улаан морин жилийн

зуд, мөн 80-аад оны зудаас илүү ийм зуд болох нь гэсэн ийм таамаглалыг дэвшүүлж байна. Яагаад вэ гэхлээр цаг дулаан байхад орсон цас хайлаад, мөстөөд тэр мөсөн дээр тэр, чимээгүй байгаарай хөөе хөөе. Цас ороод дулаан байсан учраас мөстөөд, мөсөн дээр дахин их хэмжээний цас орсон учраас бодит байдал бол нэлээд хүнд зудын хэмжээнд хүрчихсэн байна гэсэн ийм зүйлийг хүмүүс ярьж, хэлж байна. Та бүхэн ч гэсэн сонсож, мэдэж байгаа байх. Тойргоос чинь байнга ярьж байгаа байх. Яг ийм үед хөдөөд түши, дизелийн түши олохгүй 4700-5000 гараад явчихлаа. Олдоц байхгүй байна. А92 гэдэг бензин орон нутагт өгөхгүй, А95 авбал ав гэсэн байдалтай хандаж байна. А95 нь өөрөө мөн 4000 гаран үнэнтэй байж байна. Ийм хүнд нөхцөл, байдалд өнөөдөр Засгийн газар ард иргэдэд нэгэн зүйлийг амламаар байна. 2013 оны жилийн эцсийн тооллогоор 70 гаруй саяын мал, хавар 30-аад сая төл авсан.

Тэгэхлээр энэ жил нийт малчдыг энэ зуд зурхнаас хохирол багатай давах, туулахаас хэрэглээнд оруулах, нядалгаанд оруулах энэ асуудлыг бүх малчдад уриалах хэрэгтэй байна. Ингээд сайхан өвлийн хүйтэнд 3, 4 сарын хугацаанд өөрийн ахуйн аргаар хадгалах, энэ хадгалж байх хооронд Засгийн газар маш яаралтай арга хэмжээ авмаар байна. Экспортод гаргадаг юм уу, хагас боловсруулсан бүтээгдэхүүн хийж гаргадаг юм уу. Ингэж малчдын амьдралыг энэ угтсан хүндрэлээс угтсан ийм арга хэмжээнүүдийг Засгийн газар авах, Засгийн газарт Их Хурал ийм чиглэл өгөхгүй бол байдал, нөхцөл хүндэрлээ. Энэ жил сонгуулийн жил та бүхэн хүссэн зүйлээ хийх бял танхиа чинь байгаа. 20 онд ямаагаа самнаад ноолуураа аваагүй байхад 60, 70 мянгаар тогтож байсан ноолуурыг 100 мянгаар авъя гээд дансанд нь мөнгийг нь шилжүүлж байсан ийм бэлэн түүх та нарт байгаа, бэлэн туршилага.

Тийм учраас энэ жил жилдээ 10 гаруй сая мал нядалдаг юм байна. Энэ жил 30, 40, 50 сая хүртэлх ийм малыг нядалгаанд оруулж энэ махыг нь үнийг нь унагахгүйгээр засаг экспортдоо гаргана уу, зоорь юугаа хамгаална уу, нөөцөд авна уу энэ байдлаа эртхэн шийдэхгүй хөдөөгийн хоёр, гурван зуун мянган малчид түүнийг дагасан сургуулийн сурагчид, өвчин зовлон, сургууль соёл гээд бүхий л зүйл эдийн засагт асар их хэмжээний хохирол авчрах нь. Гэнэтийн шуурга гэнэтийнх байдаг. Энэ зуд гэнэтийнх биш 3, 4 сарын өмнөөс хавар хохирол гарах нь гэдэг нь мэдэгдэж байгаа учраас өнөөдөр Засгийн газрын, Их Хурлын ур чадварын л асуудал бий болж байна.

Тийм учраас Засгийн газар, Хөдөө аж ахуйн яам, бусад холбогдох яам, Уул уурхайн яам энэ түлшээ яаж буулгах юм. Түлшний үнэ өсөөгүй байгаа, түлшний хэрэглээ хөдөөд Монголд орж ирэх хэмжээнд байгаа гэж хэлээд байгаа боловч хомсдолтой хэвээр л байгаад байгаа юм. Тэгэхлээр энэ асуудлуудыг Засгийн газар яаралтай шийдэж, ард түмэнд гарч мэдэгдэл хиймээр байна. Та бүхэн хэрэглээнд малаа тарган байгаа дээр нь. Энийг чинь үнийг нь буулгахгүйгээр бид бүхэн энэ 4 сарын хугацаанд арга хэмжээ авна гэдгээ өнөөдөр гарч зарламаар байна. Ерөөсөө өөр арга байхгүй.

Гэнэтийн шуурга гэнэтийнх байдаг. Энэ бол гэнэтийнх биш шүү. Хавар энэ махны үнэ унаж байна гэх юм бол би малчдыг ойрлоод энэ талбай дээр нь авчраад асга л гэж хэлнэ шүү. Яагаад вэ гэхлээр 3 сарын өмнө, 4 сарын өмнөөс хэллээ шүү гэдгийг та бүхэнд бас анхааруулж байна. Ингээд анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Одоо Ширнэнбаньдын Адьшаа гишүүн үг хэлье.

Ш.Адьшаа: Эрхэм гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Өнөөдөр

Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын талаар байр сууриа зайлиггүй илэрхийлэх шаардлага гарсан. Иргэдээ судалж авсан 1072 хувьцааг буцааж олгоё гэдэг ийм Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны 1 сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьж таван сар гаруйн дараа Улсын Их Хурал хүлээж авсан юм. Хэдхэн хоногийн өмнө Эдийн засгийн байнгын хороогоор энэ тогтоолын төслийг хэлэлцсэн, дэмжигдээгүй. Ард түмнийхээ өмч хөрөнгөтэй байх, төрийн өмч хөрөнгө, байгалийн баялагт ард иргэдийнхээ оролцоог сайжруулъя гэсэн зорилготой энэ тогтоолыг зарим Их Хурлын гишүүд эсэргүүцэж унагаасан. 2016, 2012 оны сонгуулийн үеэр иргэдийнхээ Эрдэнэс Тавантолгойд эзэмшиж байсан 1072 хувьцааны сая гаруй хувьцааг нь төр сонгуулийн өмнө сонгуульд санал өгөх зорилгоор ахмадууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутнуудынхаа хөрөнгө мөнгөгүй байдлыг далимдуулж, мэдээлэлгүй байдлыг далимдуулж зөвхөн сонгуульд зориулж иргэдээс мөнгөжүүлэх зорилгоор энэ хувьцааг нь булаагаад авчихсан байдаг. Энэ ард түмнийхээ байгалийн баялагт эзэн байх, өмч хөрөнгөтэй байх энэ асуудлыг зөвхөн улс төрд зориулж, сонгуульд зориулж хийсэн энэ эрх баригчдын энэ шийдвэртээ бид дүгнэлт хийж энийг засаж залруулах нь Монгол Улсын эрх ашиг, нийт Монголчуудын эрх ашиг, байгалийн баялагт эзэн байх төрийн өмч хөрөнгөд ард иргэдийн оролцоог хангах ийм зорилготой энэ асуудлыг бид өнөөдөр хэлэлцэх гэж байна.

Ард түмний өмч хөрөнгөтэй байх, байгалийн баялагтай олон нийтийн оролцоог хангахгүй байхын эсрэг хэн санал өгөхийг ард түмэн харах болно, харах болно. Энэ тогтоолыг ямар нэгэн сонгуульд, улс төрд зориулж оруулж ирээгүй. Өнөөдөр Эрдэнэс Тавантолгой гэдэг энэ компанийн асуудал Монгол Улс даяар юу болж байна. Энэ ард түмний өмч хөрөнгийг үрэлгэн хулгайлдаг ийм

схем юу болсныг та бид анхааралтай ажиглаж байгаа. Ард түмэнтэйгээ хамт өнөөдөр энэ асуудлыг ярьж хэлэлцэхээр зөвхөн энэ хувьцааны олонх асуудлыг биш хаа хамаагүй юм ярьдаг Уул уурхайн сайд Ганбаатар асуудлаа ойлгодоггүй юм уу, ойлгохыг хичээдэггүй юм уу гөлөг тойруулах юм ярьж байсан. Энэ асуудлыг бид өнөөдөр хэлэлцэнэ.

Хэн өнөөдөр ард түмнээ өмч хөрөнгөтэй байхыг, хэн өнөөдөр ард түмнийхээ байгалийн баялагт эзэн байх ард түмний оролцоог хангахын эсрэг санал өгөхийг харах болно. Энд та бүхэн анхаарлаа хандуулаарай. Энэ ямар нэгэн сонгуульд зориулсан шоу биш шүү. Бид өнөөдөр үнэхээр байгалийн баялгийг, стратегийн ордуудыг ард түмний хяналтыг тогтооё гэдэг ийм сайхан юм ярьдаг. Дээр нь өнөөдөр энэ Эрдэнэс Тавантолгойн ноогдол ашиг гэдэг юм олгохгүй байгаа. 2019 онд дөнгөж 93 мянган төгрөг л өгсөн. Одоо бол авсан мэдээллээр 100 гаруй мянган төгрөгийг нэгж хувьцаанд өгнө гэсэн ийм төсөөлөл байгаа. Энэ ноогдол ашигаа яагаад өгөхгүй байгаа юм бэ? Та нар өнөөдөр хувийн өмч, төрийн өмч гэдэг ийм юм ярьдаг энэ өмчийн чинь ашиг орлогыг нь өгөхгүй бол та нар шүүх, цагдаа болно.

Гэтэл өнөөдөр ард түмнийхээ энэ ноогдол ашигийг нь авах ёстой энэ хувьцааны ашиг, орлогыг өгөхгүй байхад яагаад өнөөдөр дуугардаггүй юм бэ, яагаад төр шийдвэр гаргадаггүй юм бэ? Дээр нь өнөөдөр энэ өмч хөрөнгийн эзэн юм бол тэр өмч хөрөнгө нь ашиг орлогыг авах ёстой шүү дээ. Тэрний өмнөөс захиран зарцуулах эрх нь.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь гишүүн бас хэлэлцэх асуудал дээр холбоотой үг хэллээ. Таны бас хөндөж тавьсан энэ өвөлжилтийн нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлүүдэд, тэдгээрийг аван туулах арга замнал, махны экспорт, үнэ, худалдаа, түлшний хангамж, эрчим

хүчний нөхцөл байдлын талаарх мэдээллүүдийг өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ. Энэ саналыг бас Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн бас өмнөх 7 хоногт энэ асуудлыг бас тавьсан. Ганибал гишүүн, Батсуурь гишүүн эдгээр та бүгдийн тавьсан асуудлуудыг нэгтгээд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсоно. Энэ талаарх мэдээллийг Монгол Улсын Шадар сайд мэдээлэл хийнэ. Үүнтэй холбогдуулан холбогдох сайд нар бүгд оролцоно. Уул уурхайн сайд, Хөдөө аж ахуйн сайд, Эрчим хүчний сайд нар оролцож тодорхой мэдээллүүдийг та бүхэнд өгөх болно гэдгийг хэлье.

Адьяаа гишүүний хувьд таны санаачилсан энэ иргэдээс худалдаж авсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг иргэн бүрд буцаан эзэмшүүлэх тухай тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцсэн. Холбогдох, зохих бэлтгэлийг хангасны дараа нь чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх болно.

Гишүүд үг хэлж дууслаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Х.Баделхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 11 дүгээр

сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд ишлэжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21, 28-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа, Батжаргал, Тэмүүлэн нар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Чинзориг төслийн 19.3.6 дахь заалтыг “тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй, амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмж” гэж өөрчлөх санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Баделхан гишүүнд баярлалаа. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Пүрэвийн Оюунцэцэг, Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Дангаагийн Баярболд, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын Санхүү, даатгалын хэлтсийн дарга Лхагважавын Мөнхицэцэг нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Би юу асуух гээд байна вэ гэхээр зэрэг Байнгын хорооноос асуух гээд байгаа юм. Бид нар бас 2, 3 парламентын бүрэн эрхийн хугацаанд нэлээн ажил болж байж энэ эрүүл мэндийн даатгалаас ард иргэд маань өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өөрийгөө би эрүүл мэндийн хувьд эрүүлжих, чийрэгжих энэ зорилтоор тодорхой хэмжээний Эрүүл мэндийн даатгалд мөнгө төлж байгаа шүү дээ. Эндээсээ тодорхой хэмжээний багахан юмаа авч ашиглаж болохоор тухайлах юм бол, тухайн иргэн эрүүл мэндийг дэмжих фитнес, иог юу байдаг юм ийм клубүүдэд хичээллэх юм бол тэр төлбөрийнх нь тодорхой хувийг нь Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлж байгаа иргэдийн тэрнээс нь олгодог ийм тогтолцоог бид нар оруулж өгсөн юм. Энэ КОВИД-ын үеийн төсөв дагаж орж ирсэн энэ хуулиар энийг маань хүчингүй болгоод хаачихсан.

Гэтэл бол төрийн бодлого юу ярьж байгаа вэ? Ялангуяа Эрүүл мэндийн яам нийгмийн эрүүл мэндийн тухай асуудлыг их тавьж байгаа. Нийгмийн

эрүүл мэндийн хууль хүртэл санаачлаад оруулж ирчихсэн байж байгаа шүү дээ. Гэтэл яг үүнийхээ эсрэг юм яваад байдаг. Энийг өөрчлөх дээр манай Байнгын хорооны гишүүд, Их Хурал маань энэ дээр анхаарч өгөх хэрэгтэй байна. Энэ талаар ер нь яригдаж байгаа ийм зүйл байна уу. Дэлхийн бус улс орнууд чинь бүүр энэ орчин үеийн дижиталд ишилжчихсэн учраас иргэдийн өдөрт 10000 алхах тэр алхалтаа өөрийнхөө эрүүл мэндийг хамгаалахад алхсан алхалт хийх юм бол тэрийг нь тооцоод бонус, урамшуулал олгоод байдаг ийм тогтолцоо руу ишилжчихсэн байна шүү дээ. Гэтэл бид нар жоохон олсон энэ ололтоосоо арагшийгаа эргэж ухраад байх юм.

Дараагийнх нь Нийгмийн бодлогын байнгын хороо ер нь Их Хурлын гишүүддээ анхааруулж анхаарлыг нь хандуулах юм бол энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль орж ирж байгаа. Энэ дээр та бүхэн маань онцгой анхаарч, нэлээн сайн ажиллаж өгөөрэй. Тэгэхгүй бол энэ Эрүүл мэндийн яамыг би буруутгаж байгаа юм биш, манай энэ эрүүл мэндийн салбарынхан чинь бол олон 10 жил зөвхөн өвчлөлтэй, эмнэлгийн анхан шатын тусламж, үйлчилгээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээ талдаа олон 10 жил яваад ирсэн учраас энэ хүн ардыг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ийм үйл ажиллагаа, арга хэмжээтэй холбоотой юман дээр бол үнэхээр хошуун хойрго юм байна шүү. Очсон сайд болгоныг энэ яамны газруудад олон жил болчихсон ийм хүмүүс бол цаад талаас нь нөгөө л хуучирсан хуучны арга барил ийм мэдээллээрээ хангаад байдаг. Тэр чинээгээрээ ингээд бодлого гараад байдаг ийм зүйл байна шүү. Засгийн газар энэ эрүүл мэндийн салбарын талаар авч хэрэгжүүлэх ийм зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ажлын хэсэг байгуулсан. Эхний ажлын хэсгийн хурал дээр бол ер нь ирсэн нэгдсэн том эмнэлгийн дарга нар, эрдэмтэд, мэргэжлийн хүмүүс бол нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр маш

сайхан үнэтэй санал өгдөг юм. Яг яв цав нийлсэн ийм саналууд гаргаж байсан.

Гэтэл дараагийнх нь ажлын хэсгийн хурал дээр би Эрүүл мэндийн яам дээр яваад очсон чинь нөгөөдөх санал, байр суурь бол бүүр 180 градус эргэчихсэн нөгөө байр сууриа илэрхийлж байсан мэргэжлийн хүмүүс, эрдэмтэд хүмүүс маань бүүр таг чиг амандаа ус балгачихсан юм шиг таг чиг сууж байна лээ шүү. Энийг анхаарч өгөөрэй гэж би хэлэх гээд байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүн байр сууриа илэрхийлж үг хэллээ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад одоо Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя. Яах юм хариулах юм уу, хариулт авах юм уу. Байнгын хороо хэн хариулах юм. Чинзориг сайд хариулах юм уу. Содномын Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Би Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулах гээд үзье. Ер нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд таны яриад байгаа тийм заалт байсан юм. Тэрийг бол 2 жилийн өмнө, 3 жилийн өмнө Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиас хасчихсан юм байна лээ. Одоо бид нар салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудал ярьж байгаа. Энэ хүрээндээ Эрүүл мэндийн даатгалын хуульд өөрчлөлт оруулах асуудал яригдаж байгаа. Энэ хүрээндээ таны яриад байгаа саналыг тусгахыг бодно.

Гэхдээ би Бат-Эрдэнэ сайдын яриад байгаа саналтай бол манай яамнаас ялангуяа миний сайд болсноос хойш явуулж байгаа үйл ажиллагаа бол яг Бат-Эрдэнэ сайдын яриад байгаа энэ үйл, бодлого, чиглэлтэй энэ уг нь зарчим нь нэг л чиг рүү яваад байгаа юм л даа. Нэг чиг рүү яваад байгаа атлаа, Бат-Эрдэнэ сайд ойлгоод байгаа атлаа ойлгоогүй юм шиг та нар тийм юм хийхгүй байгаа юм шиг яриад байгаа юм.

Би бол нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг анхаарах ёстой гэдгийг бол маш сайн ойлгож байгаа. Бусад орнууд ч гэсэн тийм л юм байна лээ. Ер нь бол энэ нийгмийн эрүүл мэнд анхан шатны тусламж, үйлчилгээндээ тусламж, үйлчилгээнийхээ 50-70 хувийг нь үзүүлдэг, санхүүжилтийнхээ 50-80 хувийг нь энэ шатанд, энэ үйлчилгээнд өгдөг. Манайх үүний чинь уруу яваад байгаа юм л даа. Нийгмийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд чинь ерөөсөө л тусламж санхүүжилтийнхээ 19 хувийг л өгөөд байгаа юм.

Тийм учраас бол бид нар энэ олон улсын хөгжлийн чиг хандлагын эсрэг яваад байна. Тийм учраас энэ нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай асуудалд анхаарал хандуулах ёстой, салбарын суурь харилцааг зохицуулдаг анхдагч хуультай болохыг зорьж байгаа. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хууль батлагдвал нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чинь тэргүүлэх чиглэлийн нэг нь энэ иргэдийн эрүүл, зөв амьдралын хэв маяг байх юм Бат-Эрдэнэ сайд аа. Энэ эрүүл амьдралын зөв хэв маягийн чинь тэргүүлэх чиглэл нь бидний яриад байгаа, таны яриад байгаа идэвхтэй амьдрал, хөдөлгөөн, дасгал, сургууль, нийтийн биеийн тамирын асуудал энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль батлагдсанаараа энэ гол тэргүүлэх чиглэл болж орж ирэх юм. Энэ тусгай сангийн тухай хуульд ч гэсэн өөрчлөлт орж байгаа асуудал бол яг энэ таны яриад байгаа энэ идэвхт нийгмийн идэвхтэй амьдралтай холбоотой асуудал, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхтэй холбоотой асуудлууд орж байгаа. Бид нар энэ нөлөөллийн асуудлууд энд идэвхтэй амьдралыг бас дэмжих, хэвшүүлэх гээд ийм чиглэлийн асуудлуудад нь энэ эрүүл мэндийг дэмжих сангаас чинь бас санхүүжилт өгөх асуудлууд байгаа.

Хоёр дахь асуудал нь Засгийн газар дээр иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар бас арга хэмжээний тухай тогтоол гаргасан. Бат-Эрдэнэ сайдтай бид нар хамтраад, Боловсролын яам эд нартай хамтраад бас иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар авах арга хэмжээний төлөвлөгөө бас батална. Энэ хүрээндээ Боловсрол, спортын асуудал хариуцсан сайдтай хамтарч ажиллана.

Хоёрдугаарт энэ иргэний эрүүл мэндийн боловсролын төлөвлөгөө батлагдаж байгаатай холбоотойгоор ирэх оны төсөв дээр 5 тэрбум төгрөгийн төсөв тусгасан. Энэ хүрээндээ таны яриад байгаа тэр иргэдийг зөв амьдралын хэв маягт хэвшүүлэх, нийтийн биеийн тамирыг бас хөгжүүлэх асуудалд дэмжлэг үзүүлэх, идэвхтэй хөдөлгөөн бас хэвшүүлэх эд нар гээд ийм бас чиглэлийн асуудлууд хамтраад хийнэ Бат-Эрдэнэ сайд аа. Тийм учраас та бид хоёр бол нэг зүйлийг яриад байгаа юм. Бид хоёр нэг зүг рүү харж байгаа, зарчим нь нэг байгаа, бодлого, чиглэл нь нэг байгаа юм. Харин хамгийн гол нь энэ хөрөнгө санхүүгээсээ энэ нийтийн биеийн тамирыг дэмжих чиглэлээр иргэдийн энэ идэвхтэй амьдралыг дэмжих чиглэлээр хөрөнгө санхүү яг өгөх болохлоороо бас өгөхгүй бас хасчих вий л гэж л Бат-Эрдэнэ сайд болгоомжилж хэлээд байгаа гэдгийг би маш сайн ойлгож байгаа.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

Б.Баттөмөр: Энэ Тусгай сангийн хуулийн энэ холбогдох заалтуудад оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг Монголд нэвтрүүлнэ, ард иргэдээ Монголдоо бүрэн оношлогдож, эмчлэх боломжийг бүрдүүлнэ гээд заачихсан байгаа. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, дэвшилтэд технологийн үйл ажиллагааг Монголд нэвтрүүлэх

ажлыг төрөөс дэмжинэ гэж байгаа юм. Ийм тодорхой зорилтууд байгаа.

Өнөөдөр бол энэ эрүүл мэндийн асуудал, энэ хавдрын асуудал бол үнэхээр Монголын өнөөдөр хамгийн тулгамдсан асуудал болчихсон байгаа шүү. Маши их олон үзүүлэлтүүдээр үнэхээр дэлхийн чихийг дэлдийлгэж байгаа шүү. Энэ Тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулж, ингэж оруулж ирж байгаа нь зүйтэй. Тэгэхдээ бүрэн асуудлыг шийдэж чадаж байна уу, үгүй юу Чинзориг сайд аа. 23 онд гэхэд л 500 тийм, 520 иргэнд 500 сая төгрөг л өгсөн юм байна л даа. Энэ бол чамлалттай байна л даа. 2019 онд эрхтэн шилжүүлэх үйл ажиллагаанд 1 хүнд 79 сая төгрөг оногдож байсан бол өнөөдөр дээд тал нь 700 хүртэл явж байна шүү дээ, 200 мянган доллар тэнд 5 сая төгрөг өгч байгаа байхгүй юу. Мөнгө өгөхдөө биш хамгийн гол нь энийг дотооддоо Монголдоо нутагшуулах энэ ажлыг л хиймээр байгаа байхгүй юу. Үг байдаг шүү дээ дугуйг дахиж зохион бүтээж хэрэггүй дугуйг хийчихсэн гэж. Тэрэнтэй адилхан энэ нэгэнт дэлхийд шинжлэх ухаан, технологи, эрүүл мэндийн шинжлэх ухаан технологид олсон ололтыг Монголд нэвтрүүлэх чиглэлээр би өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид олигтой юм хийж чадсангүй. Манай эмч нар яах вэ одоо элэг болон бусад эрхтнийг шилжүүлэн суулгах ажил дээр бол бас ахиц гаргаж л байгаа. Тэгэхдээ хүлээлтэд ерөөсөө хүрэхгүй байгаад байгаа шүү дээ. Хүлээлт асар их байгаа. Өнөөдөр эрхтэн шилжүүлэх чиглэлээр хүсэлт гаргачихсан зайлиггүй шаардлагатай оношлогдсон бараг 830-аад хүний дараалал байна гэж байгаа шүү дээ. Ингээд үзэхээр бол энэ хамгийн тулгамдсан асуудал болчихоод байна л даа. Энэ өвчлөл гэдэг юм чинь бол тэр ядуурал гэдэг юмыг дэвэргээд байгаа шүү дээ. Өвчилсөн хүн бүх юмаа зараад эмчлүүлээд зарим нь амжилт олно, зарим нь амжилт олохгүй ядуурлын эгнээнд орж шилжиж байгаа шүү дээ. Нэг ядуурлын хавханд орохоор буцаж гарч чаддаггүй.

Ийм учраас энэ эрүүл мэндийн энэ өвчлөл гэдэг юм үнэхээр Монголд ядуурлыг дэвэргээж, дээрээс нь үнэхээр харамсалтай тоо баримтууд гарч байгаа юм л даа. Энэ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар энэ хавдрын өвчлөл тэр нас баралтаас үзэхээр 20 онтой харьцуулахад энэ 24 онд бол 40 он хүртэл бол юу гэхээр энэ 96 хувь, өвчлөл нь 96 хувиар нэмэгдэнэ. Нас баралт нь 107.7 хувиар нэмэгдэнэ гээд гарчихсан байна шүү дээ. Энэ бол аймшигтай тоо шүү дээ. Ийм байж байж бид нар суманд клуб барина, энд тэнд зам барина, жижиг сажиг юм хийнэ гээд хөрөнгө оруулалтаа тарамдуулаад байх хэрэггүй шүү дээ. Хамгийн эхний асуудал бол эрүүл мэндийн асуудал шүү.

Одоо бас гаргасан судалгаа байна л даа. Хөдөлмөрийн чадвар алдалт, энэ элэгний хавдраас хөдөлмөрийн чадвар алдалт дэлхийн дунджаас 20 дахин их, ходоодны хорт хавдар 4 дахин их, архинаас шалтгаалсан өвчин 5.4 дахин их байна гээд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас заачихсан. Бас их сонирхолтой судалгаа байгаа юм л даа. Сонирхолтой ч гэж дээ. Одоо судлах ёстой. Энэ хавдрыг нь судлах шалтгаан нь судлахаар хамгийн бага.../минут дуусав./

Г.Занданшатар: *Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 19, 20 дугаар дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.*

Эрхэм хүндэт төрөлх Баянгол дүүргийнхээ 19, 20 дугаар хорооны иргэдийн төлөөлөлд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Тийм би чинь 77 дугаар сургууль төгссөн юм.

Тэгэхээр Содномын Чинзориг сайд хариулна асуултад. Ажлын хэсэг Содномын Чинзориг.

С.Чинзориг: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тантай санал бол нэг байгаа юм. Манайд энэ дотоодод оношилж эмчилж чадахгүй байна гэсэн 26 төрлийн өвчин байна гэсэн ийм жагсаалт байдаг юм байна. Ер нь бол энэ дотоодод оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнийг оношлох, эмчлэх чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулах зардлыг бас шийдэх зайлиггүй шаардлага байх юм. Ямар практик хэрэгжиж байна вэ гэхлээр тухайн шинэ технологи нэвтрүүлбэл тэр технологи нэвтрүүлэх чиглэлээрээ 50-аас доошгүй удаагийн тохиолдол хийгдсэн байх ёстой. Энэ 50 тохиолдлынхоо зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллага өөрөө хариуцаж хийх ёстой гэсэн ийм журамтай.

Тийм учраас бол эрүүл мэндийн эмнэлэг өөрөө зардлаа хариуцаж, энэ технологи нэвтрүүлэх зардлыг шийдэж байгаа учраас шинэ технологи нэвтрүүлэх ажил дээр нэлээн бас тийм удааиралтай байна гэсэн ийм ойлголттой байгаа юм. Тийм учраас энэ шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулах зардлыг эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлдэг болгоё гэсэн ийм хуулийн өөрчлөлт оруулж ирж байгаа юм. Ингээд энэ хууль батлагдаад хэрэгжээд эхэлбэл бид нар энэ шинэ технологи нэвтрүүлэх зардлыг Эрүүл мэндийг дэмжих сангаасаа олгоод, тэр тодорхой хугацааны дараа тэр олон тэр чинь удаагийн тохиолдол хийгдсэний дараагаар нь салбар зөвлөл нь дүгнэлт гаргаад энэ технологи Монголд нутагшсан байна, нэвтэрсэн гэж үзэж байна гээд дүгнэлт гаргах юм бол дараагийн шат нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт аваад явдаг байх ийм тогтолцоо руу оруулъя.

Ингээж байж бидний энэ иргэдийн гадагшийгаа явж оношилгоо, шинжилгээнд хамрагдах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах гэж мэс засалд, өндөр өртөгтэй мэс засалд орох гэж иргэд маань хувиасаа санхүүгийн асар их энэ дарамтад орж байгаа энэ байдлыг засахад нэлээн бас том түлхэц болох болов уу гэж бодож байгаа.

Хоёр дахь асуудал нь Монгол Улсад нутагшсан технологи байлаа ч гэсэн орон нутгийн нэгдсэн эмнэлгүүд бас энэ төрөлжсөн эмнэлгүүдийн нэгт Монголд нутагшуулчихсан технологийг орон нутагтаа бас нэвтрүүлэх асуудалд нь бас дэмжлэг үзүүлдэг байх ийм чиглэлээр энэ хуульд бол өөрчлөлт оруулсан гэдгийг хэлье.

Ер нь бол манайд хавдрын тохиолдол маш их өндөр байна. Хавдраас шалтгаант нас баралт өндөр байна. Мөн хамгийн нас баралт өндөртэй байгаа тохиолдол энэ зүрх судасны өвчин байгаа юм. Зүрх судасны өвчнөөс шалтгаант нас баралт бол хавдрын өвчлөлийнхөө өмнө нь бас яваад байгаа ийм тохиолдлууд байгаа юм.

Тийм учраас бид нар энэ эрхтэн шилжүүлэн суулгах төвийг барих асуудлыг ирэх жилийн төсөв дээр бас тусгуулж тусгасан, Хавдрын эмнэлгийн бас зохих хэмжээний санхүүжилтийг бас Их Хурал бас шийдэж өгсөн эд нар гээд олон жил бас яригдсан эрүүл мэндийн салбарт хийгдээгүй хөрөнгө оруулалтуудыг 24 оны төсөвт тусгаж, Их Хурал бас шийдэж өгсөнд бас талархалтай байгаа гэдгээ хэлье. Ийм чиглэлийн асуудлууд байна. Хариулъя.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууна, 1 минут.

Б.Баттөмөр: Энэ өвчлөлтэй холбоотой, энэ зүрх судасны өвчин, хавдар гээд энэ бол Монголын нийгмийн хамгийн анхаарлын төвд байх ёстой,

хөрөнгө мөнгө шийдэх ёстой, Монголтой хамтарч ажилладаг энэ улс, гадаад орнуудтай тусламж дэмжлэг авах гадна, дотнын зээл тусламжийг энд төвлөрүүлэх гээд их олон асуудлыг шийдэх шаардлагатай.

Энэ хорт хавдрынхаа шалтгааныг ер нь хэр зэрэг судалдаг юм бол доо. Энэ ийм сонирхолтой судалгаа байна л даа. Энэ Монголд хорт хавдар хамгийн их өвчлөлтэй газар хаана байна гэхээр Дорнод аймаг байдаг юм байна. Хамгийн бага өвчлөлтэй газар Баян-Өлгий аймаг байдаг юм. Энэ ямар учир шалтгаан байна. Энэ удамшил энэ тэртэй холбоотой байдаг юм уу, эсвэл идэж ууж байгаа хоол ундтай холбоотой, уур амьсгалтай холбоотой байдаг юм уу ямар учир шалтгаан байдаг юм бол доо? Энэ дээр хийсэн судалгаа байна уу, үгүй юу хариулж өгөөч.

Г.Занданишатар: Содномын Чинзориг сайд хариулна.

С.Чинзориг: Хавдрын шалтгаан, нөлөөлж байгаа хүчин зүйл гээд бас хийгдсэн судалгаанууд маш олон судалгаанууд бий. Манай газрын дарга нар тодорхой хариулна биз. Надад байгаа мэдээллээр бол хэд хэдэн хүчин зүйл их нөлөөлж байгаа юм байна лээ.

Нэг дэх асуудал нь энэ агаар, хөрсний бохирдлын асуудал бас нөлөөлж байна.

Хоёр дахь асуудал нь бидний энэ амьдралын зөв хэв маяг тогтоогүйтэй холбоотой, буруу дадал зуршилтай холбоотой байна. Ялангуяа энэ тамхи, архины бас хэрэглээ өндөр байна. Энэ бол их нөлөөлж байна.

Гурав дахь асуудал нь бас удамшилын асуудлууд байна.

Дөрөв дэх асуудал нь бас бидний энэ идэвхгүй идэвхгүй бас энэ амьдралын хөдөлгөөний хомсдол бас нөлөөлж байгаа

асуудлууд байна гээд олон ийм шалтгаан, нөхцөлүүд бол байгаа юм. Тэгэхээр энэ шалтгаан, нөхцөлүүдийг арилгахын тулд бидний яриад байгаа тэр иргэний эрүүл мэндийн боловсролын асуудал, нийгмийн эрүүл мэнд.../минут дуусав./

Г.Занданишатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр энэ Монголд эмчлэх боломжгүй өндөр өртөгтэй өвчтөнүүдийн хувьд бас их нааштай шийдийг төр гаргаж өгч байгаа юм. Асар өндөр өртөгтэй манайд эмчлэх боломжгүй ийм тохиолдолд ялангуяа орлого багатай иргэдийн хувьд маш хүнд байдаг. Дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу гэдэг шиг. Ингээд бас тодорхой хэмжээний зардлын хувийг нь бас төрөөс гаргаад өгчих юм бол бас хүний алтан амийг аврах ийм боломж бас олгогдоно гэж ингэж бодож байгаа юм.

Бид нар хэлэлцүүлгийн явцад бас Чинзориг сайдад хэлсэн юмыг би дахиад бас анхаараарай гэж хэлэх гээд байгаа юм. 20 гэдгээ ер нь том хүнд 30 хувь байлгачихвал яасан юм бэ гэж. Бас иргэдийн чинь 3-ны 1 нь ядуу болчихсон энэ үед бол бас ингэх нь зүйтэй байх гэж ингэж бодож байна. Хэрвээ хүний амийг аваръя гэж бодож байгаа.

Хоёрдугаарт энэ орж ирж байгаа энэ донорын хувьд мөнгөн урамшуулал олгох 1 удаагийн тэтгэмж олгох энэ асуудлууд дээр бас би анхааралтай хандаж байх ёстой юм байна гэсэн ийм ойлголт энэ донорын тухай хуулийн бас ажлын хэсэгт ажиллаж байхдаа гадаад улс орнуудын туршилага судалж байхдаа бас мэдсэн юм. Энэ донорын асуудал маш эмзэг асуудал байдаг. Зарим тохиолдолд бол энэ мөнгөний зорилгоор, бизнесийн зорилгоор бол байж болохгүй ийм үйлдлээр ч хийдэг юмнууд гадаадад байдаг юм байна лээ.

Жишээлбэл, бид нар тэр донорын хувьд тэтгэмж олгох гэж байна шүү дээ. Бусад оронд ямар тохиолдлууд гарч байсан гээд тэгэхээр залуувтар хүнийг жишээлбэл энэ тэртээ тэргүй явах болчихсон юм гэсэн байдлаар ханддаг. Эцсийг нь хүртэл эмчилгээг нь хийхгүй байх, эрхтэн донорыг нь авахыг нэн тэргүүнд тавьчих ийм тохиолдол гардаг юм байна лээ.

Ялангуяа манай эрүүл мэндийн системийн нэг том дутагдал байна шүү дээ эмчилгээний явцын хяналт байдаггүй, гадаад оронд бол эмчлэгч эмч байна, хянагч эмч байдаг. Өнөө өглөөний эмчилгээг нь хянаад байж байдаг, өгч байгаа эмийг нь хянаад байж байдаг манайд бол байдаггүй. Нэг эмч л дангаараа тэр хүнийг шийдээд л, хувь заяаг нь л тэгээд дуусдаг. Эмчилгээний хяналт гэж юм Монголд байдаггүй. Үхсэн хойно нь харин зүгээр янз бүрийн асуудал үүсэх юм бол хяналт гэж юм байдаг байх. Тэр нь тэгээд манайх чинь хэцүү шүү дээ багш шавь нар хоорондоо бие биеийгээ хянаад байж чаддаггүй. Тэгэхээр ийм оронд ялангуяа энэ донорын асуудал дээр бид нар их анхааралтай хандах ёстой гэж. Би зүгээр бусад улс орнуудын гашиуун туршлагыг бас сонсож байсан хүний хувьд л хэлж байгаа юм шүү. Тэгнэ гэж муу ёрлож хэлж байгаа юм биш. Тэгэхдээ тийм юм гардаг юм байна лээ.

Тийм учраас ер нь энэ Донорын хууль дээр энэ донорын мөнгөн урамшуулал энэ санхүүжилтийн асуудал энэ тэр дээр их анхааралтай хандахгүй бол болохгүй. Тэр битгий хэл зарим улс оронд ядуу хүн төрөхөд хүүхдийг нь өгөхгүй эндчихсэн гээд гаргаж байсан тохиолдлууд хүртэл байдаг юм байна лээ л дээ.

Тийм учраас энэ донорын асуудал дээр бид нар нэлээн их болгоомжтой хандах ялангуяа энэ мөнгөн дүнгээр урамшуулж байгаа юмны хэмжээ дамжааг бас анхаарч байх ийм юмнууд

бий шүү. Би зүгээр сануулах талаас нь хэлж байгаа шүү. Энэ донорын асуудал дээр. Баярлалаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг сайд хариулъя.

С.Чинзориг: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр одоо манайд ямар журам мөрдөгдөж байна вэ гэхлээр 2017 онд эрүүл мэндийн сайдын тушаал гараад дотооддоо оношилж эмчилж чадахгүй 26 төрлийн өвчин байна гэсэн ийм жагсаалт гаргасан байдаг. Тэгээд энэ дотооддоо оношилж, эмчилж чадахгүй өвчнөөр өвчилж байгаа гадагшийгаа зайлиггүй шаардлагын улмаас гадаад улсад эмчилгээнд явж байгаа иргэдэд ямар тусламж, дэмжлэг үзүүлэх вэ гэхлээр гадагшийгаа эмчилгээнд яваад ирсэн хойно нь төлбөр зардлынх нь 5-хан хувийг л өгч байгаа юм. Төр өөрөө дотооддоо оношилж эмчилж чадахгүй байна гэж шийдвэр гаргачхаад, гадагшийгаа яваад, эмчилгээнд яваад ирэхлээр нь зардал төлбөрийнх нь 5-хан хувийг өгнө гэдэг бол дэндүү бас харамсалтай байна гэж үзэж байгаа юм.

Тийм учраас бол энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулж зайлиггүй шаардлагаар гадагшийгаа эмчилгээнд яваад ирсэн иргэдэд олгож байгаа тэр 5 хувийнх нь төлбөр, зардлынх нь хэмжээг би бол нэмэгдүүлье л гэж. Ялангуяа хүүхдийн тухайд бол гадагшийгаа зайлиггүй шаардлагаар эмчилгээнд яваад ирж байгаа бол төлбөр зардлынх нь 50 хувийг нь өгдөг болгоё, насанд хүрэгчдэд эхний ээлжид 5 хувийг нь 20 хувь болгож үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээ авъя л гэж байгаа юм.

Энэ гадагшийгаа зайлиггүй шаардлагын улмаас гадагшийгаа эмчилгээнд явсан иргэдэд олгох санхүүжилтийн хэмжээ гээд жилд 500 сая төгрөг л Улсын Их Хурал баталдаг. Ирэх жил бол бид нар энэ гадагшийгаа

зайлиггүй шаардлагагүйн улмаас гадагшийгаа эмчилгээнд яваад иргэдэд олгох зардлын хэмжээ гээд 1 тэрбум болгосон. Эрүүл мэндийг дэмжих санд олгогдож байсан хөрөнгийн хэмжээг 2 тэрбум байсныг 10 тэрбум болгосон. Ингээд 11 тэрбум төгрөгийн хүрээнд л би энэ гадагшийгаа эмчилгээнд яваад ирсэн иргэдэд санхүүжилтийн санхүүгийн дэмжлэг олгох, нийгмийн эрүүл мэндийн асуудал, 3 дахь шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулах асуудлаа шийдье л гэж ингэж л ингэж бодож байгаа юм.

Тийм учраас бол би яах вэ журмыг нь Засгийн газар батлах юм Даваасүрэн сайд журам, хэмжээг нь.

Тэгэхээр яг тэр Засгийн газар дээр журам ороод ярих үед нь хүүхдийнх нь 50 хувь байх уу насанд хүрэгчид нь 20 байх уу, 30 байх уу гэдгийг бид нар санхүүгийнхээ тооцоог дахиж авч үзье, тэгээд боломжтой бол 20 байх уу, 30 болгох уу гэдэг асуудлыг шийдье.

Нэг удаагийн цохилтоор бас огцом шийдчих бол санхүүгийн хүндрэлд гарчих болов уу гэж би жоохон болгоомжилж байна. Гэхдээ 5 хувь гэдэг бол арай дэндүү байна. Ер нь бол боломж байдаг бол яваад ирсэн хойно нь өгөх биш, уг нь гадагшийгаа эмчилгээнд явахад нь бас санхүүгийн дэмжлэг үзүүлдэг, урьдчилж өгдөг асуудал баймаар байгаа юм. Салбарынхантайгаа ярихлаар бас урьдчилж өгөх боломж их хязгаарлагдмал. Ялангуяа хүний онош нь очсон хойноо батлагдахгүй юм уу, өөрчлөгдөхөд асуудлууд маш их гардаг.

Тийм учраас урьдчилж явахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж их хязгаарлагдмал. Харин яваад ирсэн хойно нь өгдөг тэр хувь, хэмжээг нь нэмэгдүүлээд явах нь зүйтэй л гэж манай мэргэжлийн улсууд надад бас зөвлөөд байгаа юм гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя 1 минут. Дараа нь санал хураалттай гишүүд. Танилцуулъя.

Ц.Даваасүрэн: Тэр яваад ирсэн хойно нь гэхээр худлаа тэр цаад талын байгууллага чинь тэгж яваад ирсэн хойно нь мөнгийг нь, эмчилсэн хойно нь мөнгийг нь авъя гэхгүй байх. Тэр дэмий байх шүү Чинзориг сайд.

Энэ бас хүний орлого тэр гэр бүлийнх нь орлогын эх үүсвэртэй бас уялдуулахгүй бол болохгүй байж магадгүй шүү. Та тэрийг бас анхаараарай. Яагаад гэвэл одоо ингээд Засгийн газрын нөөцөөс зарим хүнд эмчилгээний зардал шийдэж байхад, харж байхад боломжийн хүн мөртөө ингээд бас мөнгө хүсэж байдаг юм шүү.

Тийм учраас эхний үе шатанд бас энэ тэр гэр бүлийн орлоготой нь бас уялдуулсан байдлаар зохицуулж өгөх ийм шаардлага байж бас магадгүй. Тэгэхгүй бол бас бусад сангууд шиг юм болж хувирч магадгүй шүү. Тийм учраас тэр зохицуулалтыг бас анхаараарай гэж хэлье.

Г.Занданшатар: Үг хэллээ.

Зочид танилцуулъя. Гишүүд суудалтай сууна уу. Санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Төмөр замын татах хэсгийн ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ган замчдын ариун үйлсэд, нөр их хөдөлмөрт нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе. Сайн сайхныг хүсье.

Одоо гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол, Төсвийн байнгын хороо дэмжсэн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 19.3.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.3.6.тэтгэмжийн даатгалын шимтгэл төлөлт нь хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын гэр бүлийн гишүүнд олгох нэг удаагийн тэтгэмж.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг. Санал хураалт явуулъя. Гишүүд суудлаа суугаарай. Санал хураалт.

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд ишлжүүлж байна. Эцсийн хэлэлцүүлэг нь. Дараагийн асуудалд орно.

10.52 цаг

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлөх тухай саналыг уншиж танилцуулъя. Өргөдлийг уншиж танилцуулъя.

Хүний эрх, хүүхдийн эрхтэй холбоотой асуудлыг сүүлийн үед нийгэмд

болон Улсын Их Хурлын чуулганаар олон удаа авч хэлэлцсэн. Хүний эрхийн дэд хороо Хууль зүйн байнгын хороогоор хүний эрхтэй холбоотой асуудлуудыг хэлэлцэж, тодорхой үүрэг даалгавар, чиглэлүүдийг өгч байсан.

Хүний эрхийн Үндэсний Комиссын комиссоос гаргаж байгаа заавар, зөвлөмжүүд заавал гүйцэтгэгч шаардлагын шинж чанартай болсон. Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийг шинэчилж, Хүний эрхийн Үндэсний Комиссын тайланг Улсын Их Хурлаар хэлэлцдэг болсон. Хүний эрх хамгаалагчийн тухай хуулийг баталсан, Хүний эрхийн Комиссын эрх зүй болон чадамжийг дээшлүүлэх чиглэлээр Улсын Их Хурлаас тодорхой анхаарч ажиллаж байгаа. Ингээд Хүний эрхийн Үндэсний Комисстой холбоотой олон асуудлуудтай уялдуулаад Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Хунан өргөдөл ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танаа Миний бие Жаргалсайхан овогтой Хунан 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын албан тушаалд томилогдон ажиллаж байгаа бөгөөд Комиссын гишүүд Комиссын даргын албан тушаалыг цаашид ротацын зарчмаар өсгөх нь зүйтэй гэж санал нэгдсэн тул намайг Комиссын даргын албан тушаалын үүрэгт ажлаас чөлөөлж, дараагийн даргыг томилуулж өгөхийг хүсье. Хүндэтгэсэн Хунан 23 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр гэсэн байна.

Өргөдлийг уншиж танилцууллаа. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Сайн байцаана уу. Ингээд надаар болохоор огцруулсан, чөлөөлсөн тогтоолуудыг уншуулдаг,

өөрсдөө болохоор дандаа томилсон, дэвшсэн юмнуудыг уншуулах юм. Тэгээд уншъя, ярья. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Жаргалсайханы Хунангаас 2023 оны 11 сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын даргад ирүүлсэн тус хорооны даргаас чөлөөлөгдөх хүсэлтийг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 11 сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх нь Жаргалсайханы Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын албан тушаалаас чөлөөлөгдөх нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний эрхийн Комиссын дарга Жаргалсайханы Хунангийн талаарх өргөдлийн талаарх хүсэлтийг хэлэлцсэн Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлт, эрх бүхий албан тушаалтны саналтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Батсуурь гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Энэ бас зөв алхам болж байна гэж бодож байна. Бас саяхан хэдхэн хоногийн өмнө бас энэ Хүний эрхийн Комисстой уялдуулаад Их Хурлын дарга бас тодорхой сануулга өгчхөөд хойноос нь бас хариуцлага тооцож арга хэмжээ авч байгаа нь бол сайн байна.

Би харин нэг зүйлийг сануулъя гэж бодож байна. Эдгээр улсууд томилогдоход манай Их Хурлынхан юу гэж хэлж байсныг сануулах ёстой. Энэ улсуудыг оруулж ирээд одоо олон нийтэд

нээлттэй анх удаагаа хамгийн шударга аргаар энэ улсуудыг томилж байна гэсэн байхгүй юу. Энэ нөхөд бас өөр 2, 3 эмэгтэй байгаа. Би тэд нарыг ёстой гялалзуулаад өгөх юм байна, үнэхээр их зөв аргаа ингээд нээлттэй, олон нийтэд энэ тэр гээд, олон нийтийн саналыг авч энэ тэр, цахимаар гэсэн ийм хуурамч аргууд бий болжээ. Нээх сайхан хүн сонсоход ингээд их аятайхан. Тэгсэн мөртөө тэрний цаадах үр дагавар нь яг бахь байдгаараа магадгүй бүүр дор дор.

Яагаад би ингээд байна вэ гэвэл би Хүний Эрхийн Комисст өнгөрсөн жил энэ хүн бас барьж хориод байгаа асуудлаар үзэл бодлоо илэрхийлж байгаа улсуудыг барьж хориод байгаа асуудлаар, тэднээс ирсэн гомдлыг бас хянаж шалгаач гэдэг хүсэлт тавьсан. 2 ч удаа хүсэлт тавьсан. Тэгэхэд бүүр 2, 3 сарын дараа надад хэлж байгаа юм л даа. Бид нар ингэсэн гэсэн байдалтай. Хүн чинь тэр би тэр хүнийг хэлмэгдүүлж, хоригдож байгаа бол өнөө маргаашгүй тэр хүний асуудлыг шийдэж өгөөч гэж байхад хэдэн сарын дараа хариу өгч байгаа байхгүй юу. Тэгэхээр хүний эрхийн асуудал гэдэг Монголд ер нь туйлын дор болчихсон. Энэ байгууллага нь бол нэр төдий.

Тийм учраас харин дараагийн даргын бүрэлдэхүүнийг нь сонгохдоо нөгөө гоё ганган аргаа хэрэглэх юм уу, яах юм ямар ч гэлээ гэсэн л аятайхан хүн оруулж ирээрэй дээ л гэж би хэлье. Бас жоохон зарчимтайхандуу байгаад байхаар, хатуу байгаад байхаар хүний эрхийн төлөө зогсчихоор ийм байлгахгүй болохгүй нь гэж.

Би зүгээр саяхан нэг юмыг бүүр гайхаж л байлаа. Автобусны хэргээр Их Хурлын гишүүн байсан Батбаяр гэж хүнийг хорилоо шүү дээ. Би бодоод үзэхэд тэр хүн 8 оноос өмнө л тэр ажлыг хийж байсан байгаа байхгүй юу 2008 оноос. Үгүй бодоод үзэхээр хөөн хэлэлцэх хугацаа гэвэл тэр хүн амины хэрэгт орчихсон юм болов уу би гайхлаа. Энэ

чинь 16 жилийн дараа тэр хүнийг буцаагаад барьж байна гэхээр чинь юу гэсэн үг вэ.

Тэгэхээр энэ чинь ерөөсөө хуулийн байгууллагууд бол үзэмжээрээ хуулийг тайлбарлаж, үзэмжээрээ ханддаг болчихсон байна гэсэн үг байхгүй юу. Тэр хүн 8 оноос хойш тийм ажил хийгээгүй автобусны тэр холбогдолтой Нийслэлийн Засаг даргын ажил хийгээгүй. Би зүгээр жишээ авч байна шүү. Ингээд бодоход бол бас ер нь бид нар энэ хууль, хяналтын байгууллагынхан дээр анхаарах, энэ хүний эрхийн асуудал дээр амаараа биш ажил хэрэгч байдлаар энэ Их Хурал анхаарах ёстой шүү дээ. Их Хурал харин энэ дээр ард түмний төлөөллийн хувьд жинхэнэ зогсох ёстой газар нь энэ мөн.

Тийм учраас Хүний эрхийн Комисс Их Хурлын харьяа. Тэгэхээр Хүний эрхийн Комиссын даргыгаа тавихдаа хэдүүлээ маш анхааралтай судалж, зарчимтайгаа хүн тавихад анхаармаар байна. Тэр Энхбаяр сайдын оруулж ирсэн тэр үндэслэлгүй баривчлаад, хориод байдаг тэр асуудлыг цэгцэлье гэсэн хуулийн асуудал энэ тэрийг нь Их Хурал нэн даруй шийдээд өгчих хэрэгтэй. Хүний эрх, хүний эрхийн асуудлыг бас бид нар анхаарч авахгүй бол болохгүй. Тэгэхгүй бол энэ үзэл бодлоо илэрхийлнэ гэдэг юм энэ талбайд чинь байхгүй болох нь байна шүү дээ. Энэ Хүний эрхийн Комисс нь тэдний төлөө явдаггүй.

Г.Занданшатар: Даваасүрэн гишүүн маш чухал зүйл хэллээ. Энийг бас цаашдаа маш сайн анхаарч ажиллах хэрэгтэй байна. Их Хуралд холбогдох Байнгын хороод.

Зочид танилцуулъя. Хаан Банкны Санхүүгийн удирдлагын газрын хамт олон Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. Дандаа бүсгүйчүүд. 20 хувийн квот оруулъя гэж.

Одоо Наянтайн Ганибал гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг хоёр хамт.

Н.Ганибал: Өнөөдөр энэ чухал асуудал хэлэлцэж байна. Яг өргөдлөө өгсөн хүн маань бас энэ дотроо алга байна л даа. Уг нь бас хэд хэдэн асуудал яагаад ер нь өргөдөл өгөх болов гэдэг асуудал хамгийн чухал л даа. Ер нь Хүний эрхийн Комиссын гишүүдийг Их Хуралд томилоод уг нь Засгийн газар хяналт тавих ёстой л доо. Даанч харамсалтай нь Засгийн газрын захиалгат хүмүүсийг Их Хуралд томилдог учраас өнөөдөр энэ Хүний эрхийн Комиссын ажил хүний эрхийг хамгаалах ажил явахгүй байгаа юм.

Уг нь олон улсын жишигээр цөөнх энэ Хүний эрхийн комиссуудыг санал болгож томилуулаад яг хяналтаа эрх баригчдад тавих ёстой. Энэ зарчим нь өөрөө алдагдсан учраас одоо хэн ч томилогдсон эргээд л Засгийн газар, эрх баригч намын даргын даалгаврыг л биелүүлэх байх. Тийм учраас өнөөдөр тэр хүн ажлаа өгч байгаа байх. Улс төрийнхөө тэр шахалт, дарамтыг дийлэхгүй учраас энэ хүн ажлаа өгч байгаа байх. Ер нь Засгийн газрын хийж байгаа алдаатай хүний эрхийг зөрчсөн олон асуудал дээр Хүний эрхийн Комисс дуугараагүй. Магадгүй өнөөдөр өргөдлөө өгч байгаа энэ дарга дуугаруулаагүй. Тийм ч учраас энэ дарамтаасаа болоод ажлаа өгч байгаа гэж ойлгож байгаа.

Засгийн газар нь энэ Хүний эрхийн Комиссын гаргасан илтгэлийг биелүүлдэг биш түүнийгээ дарга нарыг нь тэр өөрсдийгөө өмгөөлүүлж чимээгүй байлгуулдаг энэ зарчмын буруу үйлдлээс болоод энэ хүн ажлаа өгч байгаа гэж ойлгож байгаа. Өнөөдөр эргээд Хүний эрхийн Комиссын энэ дарга бас комиссын гишүүнээрээ үлдэх байх л даа. Тэр дотор 5 хүн дотроо бас л өөрийнхөө байр суурийг хамгаалаад Засгийн газрын хүний эрх зөрчсөн асуудлуудыг өмгөөлөөд

тэр дотроо суух байлгүй. Уг нь өнөөдөр ирсэн бол энэ асуудлуудаа яагаад гэдэг асуудлыг нь л бид нар асуух ёстой. Яагаад, яагаад ажлаа өгөх болсон юм, яагаад энэ хүний эрх зөрчигдөж байгаа олон асуудал дээр Хүний эрхийн Комисс дуугардаггүй байсан юм, яагаад энэ асуудлуудын ард нь ямар буруу байгаа гэдгээ бүгдийг нь ярих байлаа. Харамсалтай нь тэр хүн ирсэнгүй. Уг нь манай Цогтбаатар гишүүн хүний эрхийн асуудал дээр бас олон асуудлыг ярьдаг л даа. Өнөөдрийн байгаа төсөв мөнгө, өөрсдийнхөө гаргасан тэр дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд мэдээлэх тэр санхүүгийн ч тийм боломжгүй ийм комисс бид нар байгуулчхаад маш олон асуудлыг шахдаг нь бас энэ Комиссын үйл ажиллагааг явуулах ийм боломжгүй байгаа гэж ойлгож байгаа.

Тэгэхээр өнөөдрийн өргөдлөө өгсөн дарга бүүр Комиссын гишүүн байх ёс зүйн эрхгүй болж байна л гэж би харж байгаа. Заавал комиссоор Комиссын гишүүн болж буцаж үлдээд, эргээд өнөөдрийн болохгүй чадахгүй байснаа эргээд цааш нь үргэлжлүүлэх вий дээ гэсэн ийм болгоомжлол байна.

Г.Занданшатар: Уг хэллээ. Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиараа гишүүд дотроос нь Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг томилдог журамтай. Хууль дээрээ цөөнхөөс нэр дэвшүүлнэ энэ тэр гэсэн тийм үг, өгүүлбэр байхгүй. Та бүхэн тэр хууль хэлэлцэж байх үед бас саналаа хэлж болох байсан. Хуулийнхаа дагуу л явж байна даа. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар ажиллаж байсан Хунан өргөдлөө өгч байгаад бас харамсаж байна. Ямар утгаараа гэхээр бид нар ажлаа хийх ёстой газрууд нь ажлаа хийхгүй болохоор энэ Хүний эрхийн Үндэсний Комисс нь ажлаа хийхгүй байгаа юм шиг харагдаад байгаа байхгүй юу.

Гэтэл энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын үндсэн чиг үүргийг та нар үзээрэй. Үндсэн чиг үүрэг нь хаана хүний эрх зөрчигдөж байна тэр газар руу, тэр байгууллага руу, албан тушаалтан руу, наана чинь хүний эрх ингээж зөрчигдөөд байна гэдэг санал, зөвлөмжийг л хүргүүлэх үүрэгтэй байгууллага. Улсын Их Хуралд Хүний эрхийн Үндэсний Комисс өөрсдийнхөө 22 дугаар илтгэлийг хангалттай зөв, үнэн, бодит судалгаан дээр үндэслээд гаргаж өгсөн үү гэвэл өгсөн. Маш зузаан материал гаргаж өгсөн. Энийг манай гишүүд харин уншаагүй. Энэ зөвлөмжийг Улсын Их Хурал харин дагаад шаардлагатай хуулиудаа баталж чадсан.

Гэтэл хүний эрхийн зөрчилтэй байгаа тэр байгууллагууд, Засгийн газрын байгууллагууд төрийн байгууллагууд, бусад байгууллагууд чинь энэ хариуцлага алдсан хүмүүс дээрээ ямар ч хариуцлага тооцохгүй байгаа байхгүй юу. Хүүхдийн эрхийн талаар зөндөө зөрчил гарлаа. Хэнд хариуцлага тооцсон юм. Цэргийн талаар зөндөө зөрчил гарлаа. Хэнд хариуцлага тооцсон юм. Засгийн газар бол хариуцлага тооцохдоо зүгээр ганц буруу үг хэлсэн манай эмэгтэйчүүдийг дор нь л сольчихдог. Гэтэл яг энэ хүний эрхийн зөрчил гаргаад энэ Хүний эрхийн Үндэсний Комиссоос өгсөн зөвлөмжийг дагаж биелүүлдэггүй, тэр ажлаа өөрчилдөггүй энэ байгууллага, ажилтнуудад хариуцлага тооцохгүй л байгаа байхгүй юу.

Тэгэхээр чинь Монгол Улсад хүний эрхийн зөрчил дээд цэгтээ хүрэхгүй яах юм. Одоо хүний эрх зөрчигдөөгүй салбар маш бага байна. Бүх салбарт хүний эрх зөрчигдөж байна. Тийм учраас энэ сая Даваасүрэн гишүүн хэллээ шүү дээ. Хүний эрхийн Үндэсний Комисс дээр шүүхийн шийдвэргүйгээр баривчлаад байна шүү гэдгийг бүүр нарийн судалгаагаар гаргаад өгчихсөн Их Хуралд. Их Хурал тэрийг нь хэтэрхий

удааж байгаад л нэг шийдэх гээд л үзэж байна шүү дээ. Тэгэхээр энэ байгууллага тэр зөвлөмж гаргах чиг үүрэгтэй л болохоос хэн нэгэн албан тушаалтанд очоод хариуцлага тооцох ийм ямар ч ийм функц байхгүй юм байгаа юм. Энэ байгууллагын яах вэ би алдааг юун дээр харж байгаа гэхээр энэ зөвлөмж, судалгаагаа ингээд тэр өөрсдийнхөө байгууллага онол дотроо хийгээд байгаа боловч нийгэм рүү гараад тэр зоригтой Засгийн газрыг шүүмжлээд, тэр хүний эрх зөрчиж байгаа байгууллагуудыг шүүмжлээд ингээд зоригтой шүгэл үлээж чадахгүй байгаа учраас л хүмүүс энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комисс ажиллахгүй байгаа юм ишг харагдаад байгаа. Би бол энэ байгууллагад зөндөө хэлдэг. Та нар энэ дээрээ зоригтой дуугараад өгөөч, хараат бус байгаач, энэ Улсын Их Хурал, Засгийн газраас та нар энэ хүний эрхийн талаар зөрчөөд байхад битгий ай, зоригтой дуугарч бай гэдгийг хэлдэг.

Тэгэхээр энэ талаараа эдний байгууллага жоохон дутуу ажиллаж байгаа гэвэл ажиллаж байгаа. Тал талын дарамт шахалт байдаг байх. Тэгэхдээ энэ дарамт шахалтыг даваад хүний эрхийн төлөө зоригтой шүгэл үлээдэг хүмүүс л бид нарт хэрэгтэй байгаа байхгүй юу. Тийм учраас би бол Хунан даргатай олон чиглэлээр ажиллаж байсан, олон чиглэлээр судалгаа гаргуулж авч байсан. Үнэхээр ажлаа сайн мэддэг ийм залуу. Тэгэхээр яагаад гэнэт өргөдлөө өгчих болов гэдэг нь надад сонин байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дарамт шахалтыг дийлэхгүй байна уу эсвэл хүний эрхийн чиглэлээр зөндөө зөвлөмж гаргаад энийг нь биелүүлэхгүй байна уу гэдгийг бол уг нь өөрөө байсан бол би асуух байлаа. Тэгэхээр энэ бас харамсалтай байна.

Ер нь бид нар Хүний эрхийн Үндэсний Комиссын байгууллагаа сайн сонсож, зөвлөмжийг нь сайн биелүүлж, хүний эрх зөрчсөн албан тушаалтанд хариуцлага тооцохгүй энэ Комисс

байгаад ч хэрэггүй гэдгийг л би хэлэх гээд байна.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Өнөөдөр энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлсөн асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэж байна. Энд их гайхаж байна. Энэ Хунан гэдэг дарга бас зарчимтай, хуулиа дээдэлдэг ийм л хүн байсан гэж би ойлгодог юм. Энэ Хүний эрхийн Үндэсний Комисс гэдэг энэ байгууллагад Улсын Их Хурал бол ер нь хавсарга байдлаар хандаж ирсэн. Хөрөнгө мөнгөний хувьд, бодлогын хувьд ер нь илтгэл сонсдог тэнд хүний эрх зөрчих гэж байгаа тухай сонсгол тавьдаг, тэгээд л нөгөө жингийн цуваа явж байна жингэр нохой хуцаж байна гэдэг ийм л байдлаар харьцаж ирсэн шүү дээ. Энэ бол нууц биш. Энд анхаарал хандуулдаггүй гэсэн ийм ойлголттой явдаг юм.

Тэгээд миний гайхаж байгаа асуудал байна. Энэ Монголын төрөөс энэ гаднын уул уурхайн хулгайч нар орж ирж бүүр захиалгаар энэ хүмүүсийг томилдог ийм систем эхэлж байгаа гэсэн ийм хардлага байна надад. Энэ “МоЭнКо”-г Хөшөөтийн бүлэглэл гэж энэ Ховд аймагт, одоо бүүр сүүлд нь энэ зөрчил дутагдлыг нь илрүүлээд шалгаад шаардлага хүргүүлсэн энэ төрийн байгууллагыг захиалгаар харлуулах ийм ажиллагааг зохион байгуулж байгаа юм уу ямар учиртай юм бэ? Энэ “МоЭнКо” Хөшөөт гэдэг энэ Ховд аймгийн Дарви сумд байдаг. Энэ Хөшөөтийн уурхай дээр 100 хувь Хятадын хөрөнгө оруулалттай гэдэг. Энэ компани дээр Хүний эрхийн Үндэсний Комиссоос миний шаардлагаар шалгалт оруулсан. Тэнд хүний эрх зөрчигддөг, нөлөөллийн бүсэд байгаа байгаль орчинд нөлөөлсөн олон Монгол Улсын хуулийг зөрчсөн уландаа гишгэсэн тухай Хүний эрхийн Комиссоос мэдэгдэл гаргасан. Сарын дараа энэ даргыг нь авч хаяж байна шүү дээ. Энэ Монгол Улс

чинь ер нь хууль дээдэлдэг, хуулийн төлөө ажилладаг ийм юм ярихаар энэ гаднын энэ бүлэглэл чинь бүүр энэ төрийн байгууллага руу ороод ирлээ шүү дээ гэж хардаж байна би. Энэ хүний эрх зөрчигдсөн, хууль зөрчсөн, байгаль орчныг сүйтгэсэн ийм олон ноцтой асуудал энэ “МоЭнКо” гээд Хөшөөтийн уурхай дээр байгаа тухай Хүний эрхийн Үндэсний Комисс сая шалгалт хийсэн. Энэ маш их эсэргүүцэлтэй, маш их олон тэр улс төрд хамаарал бүхий этгээдүүдийн зананд орсон юм байна. Энийг би цаашид ер нь эрх бүхий байгууллагад шалгуулах болно. Ингээж болохгүй.

Өнөөдөр энэ өргөдлийг нь өгүүлээд, авхуулаад байдаг нэг шалтгаан нь энэ гэж би хардаж байна. Энэ саяхан энэ хүний эрхийн асуудал, байгаль орчны асуудлаар “МоЭнКо” дээр бүүр Хүний эрхийн Үндэсний Комиссоос маш том шалгалт оруулсан. Олон алдаа дутагдал, завхрал Монгол улсын хуулийг уландаа гишгэдэг, зөвхөн улс төрчид үйлчилдэг, орон нутгийн эрх баригчид үйлчилдэг Монгол Улсын өмнө хийсэн гэрээ хэлэлцээрээ биелүүлдэггүй ийм ноцтой асуудал байгаа. Энийг нь гаргаад ирэхээр даргыг нь авч хаяад тэгээд дараа нь яах юм хэнийг нь авч хаяхын төлөө явах юм бол. Ийм л байр суурьтай байна. Энэ асуудал бол жирийн асуудал биш. Хунан дарга бол зарчимтай, бас шаардлагатай, хийж бүтээх зоригтой, өөрийн байр суурьтай, хууль дээдлэх зарчмыг дээдэлсэн ийм л хүн байсан шүү дээ.

Г.Занданшатар: Ер нь хүний эрх тунхаглалын шинж чанартай байж болохгүй. Хүний эрхийн цогц реформын эрх, үүрэг даалгаврууд хэрэгжихгүй байгаа. Энэ хүний эрхийн зөрчилтэй хуулиуд тогтоомжуудын өөрчлөлтүүдийг оруулж ир гэсэн. Ийм учраас олон асуудлууд байгаа шүү. Нэг асуудлаар ингээж түрүүлж, барьцаалж, зүүдээ ярих гээд хулгайгаа ярьдаг байсан бол, хулгайч нар хулгайгаа ярих гээд зүүдээ ярьдаг болчихсон ийм цаг үед

хүний эрхийн асуудлыг нухацтай хандах ийм шаардлагатай цаг болсон байгаа. Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Яах вэ бид нар Улсын Их Хурал өнөөдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын чөлөөлөгдөх хүсэлтийг хэлэлцэж байна л даа. Үүний цаана ямар асуудал байна вэ гэдэг нь гол байхгүй юу. Нэг хүн чөлөөлөгдөөд л явж л байна. Гэхдээ яах вэ арай бид нар чөлөөлчхөөгүй байна л даа. Уул нь энэ дарга маань байж байгаад учир шалтгаан нь юундаа байна, цаана нь юу болж байна, хэдий хугацаагаар ажиллаад ямар үр дүн хүрэв энэ тэр гээд бас ингээд ард түмэндээ бас бид нарт ч гэсэн бас хэлчихвэл зүгээр байсан юм. Улсын Их Хурал хангалттай хууль тогтоомжуудыг баталсан. Бүх олон улсын тэр шаардлага, стандартад нийцүүлсэн ийм бичиг баримтууд байгаа. Гэвч энэ бол зүгээр цаасан дээр байна. Бид нар өнөөдөр Засгийн газартай ярих ёстой байхгүй юу. Бүх шат шатын байгууллагууд энэ Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргаж байгаа Улсын Их Хурлаас гаргасан энэ хууль тогтоомжуудыг биелүүлэх үүрэгтэй. Энэ байдал маань хаана байна. Өнөөдөр Монгол хүн ямар байдалтай байна, Монгол хүүхдүүд ямар байдалтай байна. Үгүй хар л даа энэ Улаанбаатар улсын нийслэл наад захын наад захын эрүүл, аюулгүй Үндсэн хуульд заасан тэр орчинд амьдрах эрхээ олон жил зөрчүүлээ шүү дээ энэ Монгол Улсын 3 сая 500 мянган иргэний тал нь. Энэ маягаараа л үргэлжлээд байна. Тэгэхэд хар өвлийн хүйтэнд хөхөөн хүйтнээр автобусандаа сууж чадахгүй байна шүү дээ. Авлигачид, луйварчид энэ бүгд үнэхээр энэ Монгол Улсад жаргалын орон болсон. 7, 8 жил хариуцлага ярьсангүй. Тэгээд баахан хууль баталдаг, батлуулдаг, яаралтай горимоор оруулж оруулж ирдэг үр дүн нь харагддаггүй.

Тэгээд нөгөө үгээ хэлдэг, үзэл бодлоо илэрхийлдэг хэдэн залуучуудыг маш богино хугацаанд баривчилж хорьдог. Үгүй яах вэ тухайн үедээ болж

байгаа юм шиг боловч энэ урт хугацаандаа нийгэм яаж ялзардгийг харуулж байгаа байхгүй юу. Нөгөө асуудлууд нь тэр чигээрээ үлддэг. Хар л даа өнөөдөр салбараасаа баян сайд нар ширэн нүүрлээд л ард түмний амьдрал ийм байхад л явж байдаг. Дараалан олонх болчихсон энэ 65, 62 суудалтай байсан нам юу ярих юм. Ийм л байдалтай байгаа. Энэ талаар бид нар хэлдэг, ярьдаг, ерөөсөө тэгээд үр дүн багатай л байгаа. Энэний илрэл, үүрэг хариуцлага, энэ зовлон бүх юмыг ард түмэн л үүрч байгаа шүү дээ Монголын ард түмэн. Ахиад 3 дахиа ийм олонх болохгүй байх. Мэдээж хэрэг шүүдээ зуугаад л ард түмэн тэсэж байх шиг байна. Өмч хөрөнгөө эдэлж хэрэглэж чадахгүй, хүүхдүүд нь олигтой боловсрол олж байгаа юм байхгүй. 1 ангид 40, 50-аар нь чихнэ, цэргийн албанд татагдана. Энэ байгаа хүүхдүүдийн чинь 70, 80 хувь нь эрүүл мэндийн шаардлага хангахгүй болчихсон. Гаднаа нэг ч олигтой сургуулийн биеийн тамир хийх талбай байхгүй. Ер нь хэн ийм.../минут дуусав./

Г.Занданшатар: Маш зөв саналууд байна. Одоо энийг дараагийн хүний эрхийн цогц реформ хийхэд ажлын хэсэгт орж ажиллах хэрэгтэй Ганбат гишүүн. Ер нь хүний эрхийн асуудал зүгээр тунхаглал ярьдаг асуудал биш, хэрэгжүүлдэг хүн хэрэгтэй байна л даа.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Мандалчууд та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Хоёр гишүүн үг хэлсний дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Хүний эрх бол ардчилсан нийгмийн чөлөөт нийгмийн тулгуур үзүүлэлт л дээ. Энэ хүний эрхийг ерөөсөө хангагдахгүй байна гэдэг бол төр данхайсны, төрийн дан дарангуйлал бодитоор бий болсны бодит жишээ гэж харж байгаа юм. Хүний эрх хаана хамгийн их зөрчигддөг вэ гэхлээр тэр коммунист системтэй, социалист системтэй, дарангуйлалтай газруудад л зөрчигддөг. Тэгтэл Монгол Улсын өнөөдөр эх барьж байгаа хүмүүс хүний эрх гэдэг үгийг зүгээр ганга чимэг болгож ярьдаг. Бүх үгийнхээ дан ганц чимэг болж хүний эрх, бодит нөхцөл байдал дээр бүх түвшинд хүний эрх зөрчигдөж байгаа юм. Хүний эрх яагаад зөрчигдөөд байна вэ гэхлээр энэ төрийн байна гэхээр төр данхайсан. Өнөөдөр юу гэж байна вэ гэхлээр 16 оноос хойш энэ 2 удаагийн парламент бол энэ төрийн өмч гэдэг зүйлийг шүтсэн, үүнийг тойрсон авлигал, албан тушаал, командаар явдаг ийм асуудлууд бий болж байна. Тэгэхлээр энэ төр иргэн хоёрын хоорондын зөрчлөөс л хүний эрх зөрчигдөөд байгаа, хүн нь хүнийхээ эрхийг зөрчөөд байгаа зүйл үндсэндээ байхгүй шүү дээ.

Дан ялангуяа хувийн хэвшил дээр хүний эрхийн зөрчил маш бага байгаа маш бага байгаа. Өнөөдөр хүний эрхийн зөрчлийг дагасан гол зүйлүүд бол авлигал, хээл хахууль. Өнөөдөр Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт энэ төрийн өмч түшиглэсэн энэ компаниуд дээр халах, солих асуудлууд хүний энгийн амьдрах зүйлүүдийг зөрчиж байгаа асуудлууд бүүр өдөр, тутам цаг минутад гарч байгаа. Тэгэхгүй бол больчихъё, тэг ингэ гээд. Энэний нэг жишээ нь өнөөдөр бүүр Хүний эрхийн Комиссынх нь дарга нь өөрөө өргөдлөө өгөх хэмжээнд хүрч байна л даа.

Тийм болохлоор энэ асуудлыг зүгээр ийм уриа лоозон биш бодит байдлаар хэрэгжүүлэхэд төр өөрөөсөө эхлэх ёстой. Төрийн өмчийн энэ үйлдвэр, аж ахуйн газруудыг задалж олон

нийтийн хяналтад оруулах ёстой. Авлигын индексээрээ олон улсын хэмжээнд, дэлхийн хэмжээнд байнга л ухраад ухардаг рамдаа хийчихсэн юм шиг л явж байна. Энэ нөхцөл байдал чинь өөрөө хүний эрхтэй шууд холбоотой асуудал. Хүний эрх өнөөдөр утаа түгжрэлээс авхуулаад, төрийн өмчийн хулгайнаас авхуулаад ингээд байнга гараад байгаагийн гол шалтгаан бол төр өөртэйгөө асуудлыг ярих ёстой. Хүний эрхийн Комисс гээд би саяын төсөв дээр 7 тэрбум орчим төгрөг зарцуулагдана гэж орж ирж байсныг санаж байна. Би тэгж харж байсан. 7 тэрбум төгрөгийн бүтэц ажиллуулаад тэр нь хүний эрхийн нөхцөл байдал нь дээрдэхгүй байна гэдэгт төр өөртөө л дүгнэлт хийх ёстой. Төрийн дарангуйлал бодит байдлаар үүссэн байна гэсэн үг.

Тийм учраас үүнээс гарах арга зам бол энэ ойрын хугацаанд энэ төрийг төвлөрүүлдэг, энэ төрийн өмчийг задлах олон нийтийн хяналтад оруулах энэ асуудал дээрээ анхаарах, хувийн хэвшилүүдийг энэ хүний эрхийн асуудлыг нь мөрддөг дүрэм, журам зүйлүүдийг нь чиглэл зөв өгөх ийм л хэмжээнд явах ёстой.

Тэгэхээс шүүхийн шийдвэргүй орон шоронд хорьдог, орон шоронд хориод дээр нь тэнд хууль бус дарангуйллууд бий болгодог энэ нөхцөл байдлыг би хүний эрхтэй холбоотой, энэ хүний эрх нь өөрөө Хүний эрхийн Комисс руугаа ороод ирлээ. Яагаад вэ гэхлээр Хүний эрхийн Комиссын дарга нь ажлаа хийж саяхан л бий болно, чадна, хамгийн сайнаар хийнэ гээд багаараа орж ирж байсан. Ингээд хол явж чадахгүй няцаж байна гэдэг нь хүний эрхийн зөрчил нь өөрөө Хүний эрхийн Комиссыг ажиллах боломжгүй болтол энэ төрийн дарангуйлал байна л гэж ингэж үзэж байгаа. Тийм учраас энэ тал дээр энэ хүний эрхтэй тал дээр хууль, дүрмийн заалтуудыг л маш нарийн болгох ёстой гэж ингэж үзэж байна.

Г.Занданшатар: Үг хэллээ. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр би бол энэ Хүний эрхийн Комиссын дарга өргөдлөө өгөөд чөлөөлөгдөж байгаа юм байна. Би энэ Хүний эрхийн Комисс гэдэг байгууллага ер нь Монгол Улсын хэмжээнд энэ хүний эрхийн нөхцөл байдал ямар байгаа юм бэ гэж. Яах вэ зүгээр цөөнхийн үүргээ гүйцэтгэж байна гэж хэлэх байх л даа. Тэгэхээр бол энэ улс орны засаглалыг ээлжилж барьж байсан, хамтраад барьж байсан энэ 2 улс төрийн нам энэ сонгуулийн үе эхэлчихсэн гээд бие бие рүүгээ юм чулуу шидээд суугаад байж хэрэггүй. Үнэхээр энэ сүүлийн 30 жилийн хугацаанд шинэ нийгмийн харилцаанд шилжсэн энэ 30 жилийн хугацаанд гэхэд л Хүний эрхийн Комиссын асуудал хүний эрхийн нөхцөл байдлын асуудал бол байсаар л байгаа эд шүү дээ. Одоо жишээлэх юм бол тэр Чимгээ, Содномдаржаа гэж хоёр хүний тухай асуудал байна. Тэр Чимгээ гэж эмэгтэй хүнийг тэр хорих мөрдөнд яаж тамлаж хэрцгийгээр эрүүдэн шүүж хэрэг хүлээлгэснийг энэ олон нийт чинь бичлэгээр нь бүүр үзсэн шүү дээ. Энэ хууль хүчний байгууллагынхан хүний эрхийг ноцтойгоор зөрчдөг, шүүхийн шийдвэр байхгүйгээр хорьдог барьдаг олон сар, жилээр байцаалт авахгүйгээр олон сараар түгждэг. Цааш нь ярих юм бол энэ 2, 3 минутын хугацаанд багтаааргүй ийм нөхцөл байдал юмнууд байна шүү дээ.

Дээрээс нь энэ нэг албан тушаалтнуудыг сонгон шалгаруулж, сонсгол хийж ингэж томилж байгаа асуудлаа эргэж үзэхгүй бол төвөгтэй нөхцөл байдлууд байх шиг байгаа юм. Бид нар энэ Их Хурлын баталсан тэр Хянан шалгах хуулийн хүрээнд ч гэсэн хийж байгаа сонсгол юм хумууд дээрээ нэлээн сайн анхаарахгүй бол энэ чинь Их Хурал чинь бол ерөнхийдөө тийм улс төрийн байр суурин дээрээс аливаа асуудалд ханддаг тийм дутагдал байхыг үгүйсгэж болохгүй шүү дээ. Энэ Их Хурлын

түвшинд яригдаж байгаа юмнууд чинь би бол аль болохоор улс төрийн, тэр намын үзэл аль болохоор байхгүй л байхыг хичээдэг ийм зүйл л дээ. Ийм намын үзэл өнцгөөс юм яриад байхаар зэрэг өөрийн эрхгүй хэлэхгүй бол болохгүй ийм байх юм.

Энэ шинэ Хүний эрхийн Комиссын хүмүүсийг сонгон шалгаруулаад энд томилгоо хийж байхад бол би тодорхой бас байр сууриа хэлж байсан. Энэ наад нөхдүүд чинь дандаа их сургуулийн хуулийн нэг ангийн ийм хоорондоо хамаарал, нөлөө бүхий ийм хүмүүс томилогдож байгаа юм биш биз дээ. Энийгээ сайн шалгаж, нягталж үзсэн юм байгаа биз дээ гэдгийг бол би тухайн үед нь нэлээн сайн хэлж байсан. Тэрнээс хойших энэ үйл явдал Хүний эрхийн Комисстой холбоотой үйл явдлуудыг харах юм яг тэр байдлаараа л асуудалд хандаж байгаа юм. Хүний эрх хаана зөрчиж байна тэнд бол зоригтой дуугараад асуудлыг арга хэмжээ аваад ажиллах ёстой Хүний эрхийн Комисс бол таг чиг.

Харин эргээд Их Хурал руугаа Байнгын хороонд юм уу Их Хурал руугаа бичиг цаас шидчихээд тэгээд гараа хумхиад зүгээр суугаад байдаг иймэрхүү л нөхцөл байдалтай явж ирсэн. Тэгэхээр даргыг нь солих бол асуудал цаана нь байгаа. Энэ Их Хурлаас .../минут дуусав./

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Одоо санал хураалтай гишүүд орж ирээд ер нь Хүний эрхийн үндэсний Комисс бол хүний эрхийг хамгаалах, дэмжих үндсэн чиг үүрэгтэй. Ялангуяа хүний эрхийн үндэсний байгууллагуудын эрх зүйн байдлын талаарх зарчим буюу Парисын зарчмын дагуу олон талт байдлыг хангах нийгмийн янз бүрийн бүлгийн хэнийг нь ч орхигдуулахгүй байхад онцгой анхаарах шаардлагатай. Шоронд ч ажиллах ёстой, наранд ч ажиллах ёстой, хаана хүн байна тэнд л Хүний эрхийн Үндэсний

Комисс байх ёстой. Энэ хүрээнд энд Хүний эрхийн Үндэсний Комисс нь нийгмийн янз бүрийн бүлгүүдтэй үр дүнтэй хамтран ажиллах процедуртай. Тэрхүү процедурын дагуу холбогдох шийдвэр гаргаж ажиллах шаардлагатай.

Ийм ч учраас Хүний эрхийн үндэсний Комиссын тухай хуулийг шинэчилсэн, тавигдаж байгаа шаардлага, зөвлөмж нь заавал биелүүлдэг, биелэгддэг байхаар зохицуулалт хийсэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын хууль тогтоомжийг маш сайжруулсан. Гагцхүү энэний манлайлал хэрэгжилт хангалтгүй байгаа. Хүний эрхийн үндэсний байгууллагаас иргэний нийгмийн байгууллагатай харилцах харилцаанд түүний бие даасан олон талт байдлыг хамгаалахад тусалдаг болохыг Парисын зарчмаар хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ талаар иргэний нийгмийн байгууллагуудаас маш олон санал зөвлөмж, шүүмжлэл ирсэн.

Ийм учраас Хүний эрхийн Үндэсний Комиссын нийт бүрэлдэхүүнтэй би уулзаж хүний эрхийн түгээмэл тунхаглал, хүний эрхийн түгээмэл тунхаглалын 75 жилийн ой болох гэж байна. Тодорхой ажил хэрэгжүүлэх даалгавар өгсөн. Энд манлайлж хэрэгжүүлж ажиллах ёстой болох шаардлага тавьсан. Хүний эрхийг хамгаалах цогц реформ хийх ийм асуудлуудыг ярьсан. Хангалттай хэрэгжилт хангалтгүй байгаа. Хүний эрхийн үндэсний Комиссынхон өөрсдөө хуралдаад ротацийн зарчмаар буюу ер нь бид бас энэ өөрчлөлт, шинэчлэлт хийж дотоод, гадаад мэдээллийнхээ урсгалыг нэг болгох, илүү манлайлалтай ажиллах ийм зайлиггүй шаардлага байна гэдэг дүгнэлт гаргаад, энийг үндэслээд Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга өргөдлөө ирүүлсэн. Улсын Их Хурлын тухай хуулийн 14.1.15-д заасны дагуу Улсын Их Хурлын дарга Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын даргыг чөлөөлөх, томилох саналыг Байнгын

хороо Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх ийм эрхтэй. Энэ хүрээнд Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэж энэ саналыг дэмжсэн. Энэ өргөдлийг хэлэлцэхийг дэмжсэн. Ийм учраас энэ хүний эрхийн байгууллагууд Хүний эрхийн Үндэсний Комиссын үүрэг роль, манлайллыг сайжруулахын тулд үндсэндээ Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлөх саналыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна. Тийм учраас хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Одоо ингээд санал хураалт явуулна. Дараа дараагийн асуудлууд дээр яаж хэлэлцэх талаар ажлын хэсэг байгуулж Хүний эрхийн Үндэсний Комисс, хүний эрхийн дэд хороотой хамтарч манай энэ үг хэлээд байгаа гишүүд манлайлж ажиллах хэрэгтэй. Гишүүд өөрсдөө, тэр яриад байгаа гишүүд өөрсдөө манлайлж ажиллах хэрэгтэй. Ярьдаг биш ажилладаг баймаар байна шүү дээ. Хуулиа хэрэгжүүлдэг баймаар байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108.2-т зааснаар нэгдсэн хуралдаан эрх бүхий албан тушаалтны санал холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, нууц санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол батлагдсанд тооцно гэж заасны дагуу Байнгын хорооны саналаар Жаргалсайханы Хунанг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалт. Санал хураалт. Адьшаа гишүүн суудалдаа санал хураалт.

29 гишүүн дэмжиж, 55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Чөлөөлөх саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын

үүрэгт ажлаас чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын хүний Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1.Жаргалсайханы Хунанг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Дараагийн асуудалд орно.

11.30 цаг

Дэг ёсоор Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Саналыг танилцуулъя. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшигчийн танилцуулгыг танилцуулъя.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Лувсандоржийн Өлзийсайхан нь өөр албан тушаалд томилогдсон тул Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг шинээр томилох шаардлагатай болсон. Монгол

Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга хууль зүйн өндөр мэргэжилтэй, төрийн албаны удирдах ажлын албан туршилагатай байх бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурал томилж, чөлөөлнө гэж заасан зохицуулалтын дагуу Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Дамдины Энхбатыг томилуулахаар санал болгож байна. Дамдины Энхбатыг томилуулах санал болгох хоёр үндэслэл нь Улсын Их Хурлын удирдах бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Тамгын газарт хамгийн олон жил ажилласан ийм туршилагатай парламентын ажилтан.

Хоёрдугаарт нь бол доктор цолтой, эрдмийн зэрэг цол болон ажлын туршилага, онол практикийн мэдлэгийг үндэслэн энийг санал болгож байгаа юм.

Дамдины Энхбат нь 1981 онд Улаанбаатар хотод төрсөн, 42 настай, 1997-2001 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн дээд сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2006-2008 онд Удирдлагын академийг Төрийн удирдлагын магистр, 2008-2013 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Их сургуульд докторын зэрэг хамгаалсан. 2009-2013 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн зөвлөх, 2013-2014 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Экспертийн албаны ахлах зөвлөх, 2014-2017 онд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны ахлах зөвлөх, 2017-2018 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газарт Засгийн газрын ахлах референт, 2018-2022 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын салбарын удирдлага зохицуулалтын газарт Засгийн газрын ахлах референт, 2022 онд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга, мөн оноос Улсын Их

Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан газрын даргаар ажиллаж байгаа бөгөөд төрийн албанд 15 жил, үүнээс 12 жил Улсын Их Хурлын Тамгын газарт ажиллаж байгаа дадлага, туршилагатай төрийн албан хаагч юм.

Иймд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад тавигдах хууль зүйн өндөр мэргэжилтэй, төрийн албаны удирдах ажлын туршилагатай байх гэсэн үндсэн шаардлагуудыг хангаж байгаа тул Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад нэр дэвшүүлэх саналыг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т. Ерөнхий нарийн бичгийн дарга Хууль зүйн өндөр мэргэжилтэй, төрийн албаны удирдах ажлын туршилагатай байх бөгөөд түүнийг Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хуралд томилж, чөлөөлнө гэж заасны дагуу Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Дамдины Энхбатыг томилуулах саналыг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийг баримтлан Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлснийг Улсын Их Хурлын дэд дарга Мөнхбаатар танилцуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын даргын уг саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг дэмжиж буйгаа илэрхийлээд Олон улсын парламентын холбоо, Улсын Их Хурлын хамтран хийсэн хүний эрх, жендерийн мэдрэмжтэй парламентын өөрийн үнэлгээний ажлыг цаашид хэрхэн үр дүнтэй үргэлжлүүлэх, парламентын хүний нөөц болон бусад асуудалд хүний эрх, жендерийн мэдрэмжтэй байх чиглэлд ямар ажлуудыг хийх талаар асуулт асууж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, техник, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэхдээ адил тэгш, хүртээмжтэй ажиллах талаар байр сууриа илэрхийлсэн болно.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Дамдины Энхбатыг томилж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Лувсандоржийн Өлзийсайханыг чөлөөлөх саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх асуудлаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Нэр дэвшигч болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, уг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Дараа нь Шүүх байгуулах тухай хуулийг Ерөнхий сайд танилцуулна. Ганибал гишүүн уг хэлэх юм уу. Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Өнөөдөр Их Хурлын Тамгын дарга гэдэг үнэхээр бас чухал ажил гэдгийг бид бүхэн бас цөөнхийн гишүүд яс махнаасаа мэдэрсэн. Шалтгааныг бас нэг асуудал дээр ярья л даа. КОВИД-ын үеийн нээлттэй сонсголыг зохион байгуулах гээд энэ асуудлыг Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагаанаас болоод хийж чадаагүй. Тухайн үед Их Хурлын Тамгын газрын хуульчид нэг байр суурьтай Хуулийн хэлтэс, Байнгын хороо бас өөр байр суурьтай байгаад нээлттэй сонсголыг хийх процессыг хоёр өөр янзаар тайлбарлаж байгаад цаг хугацааны хувьд шахаанд оруулж байгаад КОВИД-ын худалдан авалтын талаарх нээлттэй сонсголыг цөөнхийн бүлгээр санаачлаад энэ нээлттэй сонсголыг хийж чадаагүй байгаа. Тэгэхээр энэ зүгээр нэг шалтгаан, Тамгын газар ямар их үүрэг рольтой вэ гэдгийг харуулсан нэг л ийм шалтаг байгаа.

Тэгэхээрээ цаашид Их Хурлын тухай хууль байна, Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хууль энэ бүх хуулийн зохицуулалтуудыг бас маш тодорхой болгож, гаргасан санал, санаачилгууд маань бас яг хуулийн дагуу явдаг болох тал дээр бас шинээр томилогдож байгаа Тамгын дарга бас анхаарч ажиллаарай гэж хүсье. Тэгээд амжилт хүсье.

Г.Занданшатар: Баярлалаа. Энэ асуудал дээр Улсын Их Хурлын Тамгын газар хамаагүй бөгөөд Улсын Их Хурлын хяналт шалгалтын түр хорооны нээлттэй сонсгол буюу мөрдөн шалгах, нотлох баримтыг үнэлэх сонсгол бол 19

гишүүнээс дээш гишүүн гарын үсэг зурж байж түр хороо байгуулагдаж явагддаг сонсгол. Нээлттэй сонсгол буюу 9 гишүүнээр гарын үсэг зурагдаад явагддаг нээлттэй сонсгол хоёр өөр процедуртай юмыг ингэж хольж ойлгосон асуудал байгаа. 19-өөс дээш болбол тэр нээлттэй мөрдөн шалгах, эксперт томилох, шинжээч томилох, хянан шалгах, томилох тийм эрх, үүргүүд нээгддэг гээд ийм зохицуулалтыг бид бас өөрсдөө гишүүд сайн ойлгох ёстой байгаа шүү. Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Ер нь яах вэ энэ парламентын өдөр тутмын ажлыг та хариуцаж, даргалж хийнэ. Хэн билээ та чинь? Энхбат юм байна. Олонх маань олон жил парламентад олонх болж засгийн эрхийг барьж байгаа. Энэ үеүүддээ бас энэ ард түмэндээ маш хүндэтгэлтэй хандаж парламентын өдөр тутмын ажлыг хийдэг энэ Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг нэлээн сайн хүмүүсийг, өөрсдийнхөө сайн боловсон хүчнийг явуулж, тэргүүлж ажиллуулж байсан. Тухайлбал би Шаравдорж гуай, Төмөр гуай гээд л яривал мэдэх юм байна. Та юу яана, 24 оноос эхлээд нөхцөл байдал өөрчлөгдөнө, өмнөх дарга нар чинь бас гайгүй нэртэй төртэй ажлаа гүйцэтгэсэн гэж би бодож байна. Ялангуяа би Ардчилсан намын бүлгийг 3 жил ахалж ажилласны хувьд. Тэгэхээр нөгөө талаараа таны намтрыг харлаа. Энэ чинь удахгүй 126, одоо 76 энэ гишүүд маань бүх Монгол Улсыг төлөөлөөд энд суудаг.

Ер нь Монгол Улсын тусгаар тогтнолын баталгаа бол би парламент, Улсын Их Хурал гэж үздэг. Ийм ч байгаа. Энэ бол бид нарын энэ хавьдаа энэ Ази, Евроазид ялгарч байгаа ганц энэ 30 жилд бид нарын хийсэн ийм зүйл л дээ Монголын ард түмний. Тэгэхээр энэ бас энэ 18 аймгаа хэр мэдэж байна, энэ ард түмнийхээ амьдрал ахуйг хэр мэдэж байна, тэндээс сонгогдсон гишүүд олон янзын говь, хангай гээд янз бүрийн нөхцөл

байдлыг төлөөлж ажилладаг. Та энд намтрыг нь хараад байхад Улаанбаатарын хүүхэд шиг л байна, Улаанбаатарын залуу шиг л байна, нэг.

Хоёрдугаарт тэр Хятад улсад та докторын зэрэг хамгаалсан юм байна, сурсан юм байна. Юугаар докторын зэрэг хамгаалсан юм, хэр удаан тэнд сурсан юм? Бас парламентын талаар байвал бүүр сайн л байна. Ардчиллын талаар тэнд сайн судлаад ирсэн гэсэн зүйлүүдийг бас тодруулъя. 1 минут байгаа байлгүй дээ.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрам, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сайхан сумын ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт Сэлэнгэчүүд та бүхэндээ, Сайханчууд та бүхэндээ, ахмадууддаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хамгийн сайн сайхан бүхнийг, урт нас, удаан жаргалыг хүсэн ерөөе.

Одоо санал хураалттай гишүүд чуулганы танхимд цуглаарай. 85 Дамдины Энхбат нэр дэвшигч.

Д.Энхбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдэд өглөөний амгаланг айлтгая. Энхбат Ганбат гишүүний асуултад хариулъя. Би Бүгд Найрамдах Хятад Ард Улсад Жилиний Их сургуульд Олон улсын эрх зүйгээр 2002-2004 онд магистрын бүрэн курс төгссөн. 2008-2013 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Улсын Өвөр Монголын Их сургуульд экологийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооны санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар Дамдины Энхбатыг томилж, Улсын Их Хурлын Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас Лувсандоржийн Өлзийсайханыг чөлөөлөх саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

68.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Томилж, чөлөөлөх саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дамдины Энхбатыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2. Лувсандоржийн Өлзийсайханыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Тогтоол батлагдсанд тооцлоо.

Өмнөх Ерөнхий нарийн бичгийн дарга Өлзийсайханыг ч гэсэн Улсын Их Хурлын Тамгын газарт ажиллаж байсан туршилага, удирдах бүрэлдэхүүнд ажиллаж байсан туршилага, докторын

зэрэг, цолыг харгалзаж, мерит зарчмаар ажиллаж байгааг үндэслэж гаднаас биш дотроос нь томилсон.

Энэ удаа ч гэсэн Энхбат, Дамдины Энхбат дарга бол удирдах бүрэлдэхүүнд хамгийн олон жил ажилласан, зэрэг цол, онол практикийн мэдлэг, туршилагыг харгалзаад мерит зарчмаар дотроос нь томилж байгаа гэдгийг тодруулж хэлээд Энхбатыг бас энд Тамгын газрын гал тогооны ажил, хуулийн нарийн ажлуудыг зохион байгуулах ажилд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс амжилт хүсье. Дараагийн асуудалд орно.

11.43 цаг

Шүүх байгуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Манай Засгийн газар байгуулагдсан цагаасаа Монгол Улсын шилжилтийн хэмээх тодотголтой өнгөрсөн 30 жилийн нийгэм, эдийн засгийн явцад бүхэлд нь үнэлэлт, дүгнэлт өгч, шинэ 30 жилийн эхлэлийг зөв тавих суурь реформын асуудалд үндсэн анхаарлаа хандуулсаар ирлээ.

Миний бие Монгол Улсын Ерөнхий сайдаар 2 жил гаруй хугацаанд ажиллахдаа эхний жил хагасыг цар тахлыг даван туулахад, 2 дахь жилийг авлигатай хийх тэмцэлд бүхэлд нь зориуллаа.

21 аймгаар ард иргэдтэйгээ нүүр тулан уулзаж, улс орны 30 жилийн дүгнэлт, өнөөдрийн нөхцөл байдал,

ирээдүйн чиг хандлагын талаар илэн далангүй ярилцлаа. Үг хэлсэн хүмүүсийн дундаж нас 60 байлаа. Нэг үгээр хэлбэл 30 жилийн өмнө тэд 30 гаруй насны залуучууд байжээ. 30 жилийн тэртээ хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулахаар хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөн гарсан нэгэн үеийнхэн өнөөдөр улс төрчид тэдний тойрсон хэдхэн хүн баяжиж, эсрэгээрээ ард иргэдийн амьдрал уруудан доройтсонд бухимдаж байна.

Усны эх нь булингартай бол адаг нь булингартай гэдэгчлэн авлигын голомтыг таслахгүйгээр бид шинэ 30 жилийг цогцлоох боломжгүй гэдгийг тэд илэрхийлж байна. Дунджаар 8-10 цаг үргэлжилсэн уулзалтын үеэр иргэд өмч хувьчлал, газрын наймаа, ашигт малтмалын лиценз олголт зэрэг шударга бусаар хэдхэн хүний хүрээнд явагдсан нь өнөөдрийн нийгмийн тэгш бус байдлын суурь болсон тухай, өнөөдрийн бухимдалд бас эмх цэгцгүй, хуулийн өмнө эрх тэгш бус нийгмийн суурь шалтгаан бүрдсэн гэж үзэж байна.

Нийслэлийн утаа, түгжрэл, газрын наймаа, түүнийг тойрсон стандартгүй барилгажилт зэрэг өнөөдрийн тулгамдаж байгаа асуудал ч гэсэн өөрсдөө баяжихын тулд ард иргэддээ үлдээсэн авлигачдын өв гэдгийг ард иргэд гүнзгий дүгнэсэн байна.

Авлигажсан тогтолцоо тэдний хүсэл мөрөөдлийг хулгайлсныг хэлж байна. Авлигал ард иргэдийн шударгаар хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзлийг мохоосон байна. Гэвч иргэд маань ялангуяа үг хэлсэн 60-аад насныхан өөрсдөө гэхээс илүү үр хүүхдийнхээ амьдрах шинэ 30 жилд илүүтэй төвлөрч үг хэллээ. Авлигын эсрэг тэмцлийн үр дүнд шинэ 30 жил бодитоор эхэлнэ гэдэгт мөн тэд итгэж байгаагаа илэрхийлсэн. Нэг үгээр хэлбэл аалзны тор мэт сүлжилдсэн 30 жилийн авлигын цайзыг нураах ард түмний хүсэл эрмэлзэл үерийн ус мэт тал талаасаа цутгаж

усны түвшин өдрөөс өдөрт дээшилсээр байгааг мөн бидэнд сануулж байна.

30 жилийн тогтолцоо 3 хүрэхгүй жил бүтэн нурахгүй ч авлигыг үл тэвчих үзэл санаа бүрэлдэн бий болж, нийгмийн сэтгэл зүй болон төлөвшиж байгаад Ерөнхий сайдын хувьд сэтгэл хангалуун байна.

Өнгөрсөн хугацаанд авлигын олон асуудлыг Засгийн газар үе шаттай гаргаж тавьсан. Зарим хүмүүс нийгмийг бухимдуулж байна хэмээн надад шүүмжлэлтэй хандаж байгаа. Гэхдээ би зөв зүйлийг хийж байгаа гэдэгтээ итгэл төгс байна. Идээг шахахгүй нууж аргацаасаар байвал нэг л өдөр буглаж ардчилсан Монгол төрийн аминд хүрэх аюултай байсан. Амжилтаасаа илүү алдаагаа ярьж түүнийгээ засаж чаддаг нь нээлттэй ардчилсан нийгмийн амин чухал бас юугаар ч сольшгүй үнэт зүйл юм.

Би энэхүү авлигалын тэмцлийг эхэлж байхдаа авлигатай тэмцэнэ гэдэг бол би, бид журмын нөхөдтэйгөө, өөрөө өөрсөдтэйгөө, нам харгалзахгүй тэмцэнэ гэсэн үг гэж хэлж байсныг та бүхэн санаж байгаа байх гэж бодож байна. Авлигын эсрэг тэмцэл адармаатай ч алхам алхмаар урагшилсаар өнөөдөр шүүхийн шатанд туллаа. Шүүхийн шатанд бүлэглэлийн гар, хөлүүд авлигын асуудлыг хэрхэн гацаан удаашируулж байгааг ч сонгууль хүртэл тэсчихвэл Оюун-Эрдэнэ зайлчихна, бүх зүйл сайхан болно гэж хилийн чанадаас оргон зайлсан шувууд маань томилсон шүүгч нартаа захиж байгааг ч би мэдэж байна.

Гэхдээ үүнийг зөвхөн ордон дотор биш олон нийт ч гярхай олж харсан байна лээ. Малчны хотонд гаанс нэрэн шинжих нүүдэлчин хөх өвгөдийн гярхай нүд, чонон мэдрэмж, хэрсүү зангаас авлигачид та бүхэн удаан бултаж чадахгүй. Тэр мэдрэмжүүдийн нийлбэр нийгмийн нэхэл хатуу дүгнэлт болон төлөвшдөг өө. Энэ л мэдрэмжийг

Санжаасүрэнгийн Зориг “Би Монгол хүний саруул ухаанд итгэдэг” гэж илэрхийлсэн биз. Чамлахаар чанга атга гэдэг шиг авлигын эсрэг тэмцэл үр өгөөжөө өгч эхэлж байна.

Далд эдийн засаг өдрөөс өдөрт ил болсоор байна. Өргүй бол баян, өвчингүй бол жаргал гэж Монголчууд бид ярьдаг. Эдийн засгийн эхний үр дүнг эдийн засгийн өсөлтийн эхний өгөөжийг Засгийн газар удаан хугацаанд баримтлагдсан гадаад өрийг төлөхөд бүхэлд нь зарцуулаа. Өнгөрсөн хугацаанд бид “Мазаалай” бондын 500 сая амдоллар, “Гэрэгэ” бондын 800 сая амдоллар, “Чингис” бондын 1.5 тэрбум ам.долларын өрийг бүтэн төллөө. Хөгжлийн банкны чанаргүй зээлийн эргэн төлөлт 1.5 их наядад хүрч евро бондын 500 сая ам.долларын өрийг саяхан 10 сарын 23-ны өдөр төлж барагдуулаа. Одоо 12 сарын 25-нд үлдэгдэл “Самуурай” бондын 30 тэрбум иен буюу 200 сая орчим ам.долларын өрийг төлснөөр Монгол Улс дампуурлын эрсдэлээс 12 жилийн гинжин хэлхээний дараа ийнхүү гарч байна. Бондуудын төлбөрийн ард валютын нөөц 4 тэрбум ам.доллар хэвээр байх тул хувийн хэвшлийнхэнд санаа зовох шаардлагагүй юм.

Мөн төлбөрийн тэнцэл анх удаа эерэг гарч байна. Улсынхаа нэрээр зээл авч, бүлэглэлийн зарчмаар хувааж, өөрсдөдөө зориулж Өршөөлийн хууль баталсан хариуцлагагүй үйлдэл Монгол төр дахин хэзээ ч гарах ёсгүй. Өрийн гинжин хэлхээнд түлэгдэж авлигын өргөст тороор баглагдсан эдийн засаг одоо л эрүүлжин амьсгал нь жигдэрч байна. Ерөнхий сайд Пунцагийн Жасрай гуай нэгэн цагт “Хонгилын үзүүрт гэрэл харагдаж байна” гэж хэлсэн шиг Монгол Улсын эдийн засагт 2012 оны үед байсан эдийн засгийн огцом өсөлт эргэн ирж байгааг олон улсын судлаачид, эдийн засагчид хэлж байна. Жил гаруйхны өмнө бид нар хил нээх тухай, мөн улс дампуурахгүй байх тухай ярьдаг байвал

байсан бол өнөөдөр парламентын танхимд эдийн засгийн өсөлтийг хэрхэн өрхөд хүртээмжтэй байх тухай мэтгэлцдэг болж. Энэ бол бас дэвшил юм.

Мэдээж эмнэлэгт удаан хэвтсэн хүнийг шууд босгож хүнд тухайтай дасгал хийлгэж болохгүй шиг эдийн засгийн өсөлт өрх бүрийн түвшинд очиход хугацаа авна. Өр тавьж улсаа дампууруулаад өнөөдөр өргүй Монгол хэмээн хэлбэрдэх, шударга ёс ярьчихаад авлигын бүлэглэлийг хоргодох байр болж тэднээс санхүүжиж байгаа улс төрчдийг иргэд ялгаж, салгаж байгаа. Эдийн засгийн макро тэнцвэр бүс нутагт үнэлэгдэж, олон улсын нэр хүнд өсөж, хөрөнгө оруулагчид Монгол Улсыг дахин эергээр харж эхэлж байна. Харин бид 2012 оны боломжийг алдсандаа нийгмээрээ бүх улс төрийн намууд дүгнэлт хийх учиртай. Энэ л агуулгаараа бид Үндсэн хуулийн өөрчлөлт, сонгуулийн холимог тогтолцоог сонгон авсан юм. Худал амлалт, хэт популизмаас Монгол Улс хөгжлийн бодлого эдийн засгийг хамгаалахын төлөө энэ тогтолцоог бид сонгож авсан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Муу нуухаар сайн илчил гэж ярьдаг. Авлигатай хийх тэмцэл эрчимжиж эдийн засгийн тоон үзүүлэлтүүд сэргэж байгаа ч авлигачдад эцсийн хариуцлага тооцох ажил шүүхийн шатад удааширч байгааг би дахин онцолж байна. Энэ байдлыг зөвхөн олон нийт ч биш олон улс ажиглаж, Монгол Улсын гадаад орчны зарим үнэлгээнд сөргөөр нөлөөлсөөр байна. Шүүх засаглалыг бид авлигач, шүүгчдээс нь, тэдний томилсон бүлэглэлээс нь хамгаалж, хараат бус шүүх засаглалыг бүрдүүлэх шударга шүүгчдийг дэмжихэд бүх нийтээрээ дэмжлэг үзүүлэх цаг болсон байна.

Улсад 20 тэрбумын хохирол учруулсан авлигачийг 20 саяар торгоод өнгөрөөнө гэдэг авлигын эсрэг шийтгэл үү, аль эсвэл авлигал авах нь зөв гэдэг урамшуулал уу. Улс орноо дампуурлын ирмэгт аваачсан нөхдүүд шүүхийн гадна баяр тэмдэглэж байгаа нь хариуцлага тооцож байгаа хэлбэр үү, эсвэл авсан зээлээ эргүүлэн төлж болохгүй ч байж болно гэдэг авлигын сэдэл үү. Үзэл бодлоо илэрхийлсэн залууст төмөр нүүр харуулчихаад авлигын хэрэгтнүүдийн даралт ихсэж, тулаан сэдрэхэд улсаараа халаглан шагширч, хүмүүнлэгийн байгууллага шиг хэдий хүртэл бид эрхлүүлсээр байх вэ. Энгийн хэргүүд 3 сар дотор 3 шатын шүүхээр шийдэгдэж байхад дуулиант авлигын хэргүүд анхан шатын шүүх дээр 7 жил гацаж байгааг хэрхэн тайлбарлах вэ. Энэ мэт олон асуудалд ард түмэн эргэлзэж, шударга ёсыг шаардаж байна. Ард түмнээс сонгогдож байгуулагдсан төлөөллийн төв байгууллага парламент энэ асуудлыг нээлттэй ярихгүй бол өөр бид хаана ярих билээ. Бид хэнийг ч хэлмэгдүүлдэггүй, хэнийг ч ял завшуулдаггүй, бас хэрэг албаар дарж цаг хождоггүй, бүлэглэлд үйлчилдэггүй, шударга, мэргэшсэн, хараат бус шүүх засаглалыг төлөвшүүлэх учиртай. Авлигын асуудал шүүхийн шатанд ийнхүү замхарсаар байвал, асуудал энэ хэвээр үргэлжилсээр байвал ард иргэдийн хилэн асаж эрх зүйт төрд эрсдэл учрах нийгмийн бухимдал бодитоор хуралдан бий болсныг Ерөнхий сайдын хувьд Улсын Их Хурлын индэр дээрээс хариуцлагатайгаар илэрхийлж протоколд үлдээе.

Шүүхийн зарим удирдлагууд Ерөнхий сайдыгаа огцруулах санал хураалт хийж, шүүхэд шүүмжлэлтэй хандсан бүхэнд бухимдан хилэгнэхийн оронд өөрөө өөрийгөө шинэчлэх цогц реформыг цаг алдалгүй эхлүүлж, олон улсын түвшинд ёс зүй, ур чадвар, хүний нөөцтэй байх асуудалд анхаарлаа хандуулаасай хэмээн чин сэтгэлээсээ хүсэж байна.

Ард түмний төлөөлөх эрхийн илэрхийлэл болсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Авлигын эсрэг ялын бодлогыг чангатгах Засгийн газрын эрх зүйн цогц реформыг дэмжсээр ирсэнд талархаж байна. Өнгөрсөн хугацаанд та бид хамтдаа авлигал, албан тушаалын гэмт хэргийн ялын дээд хэмжээг 5-12 жил байсныг 12-20 жил болгон нэмэгдүүлсэн. Авлигал албан тушаалын гэмт хэрэгт холбогдож, шүүхээр шийтгэгдсэн этгээдэд аливаа төрлийн өршөөл, уучлал үзүүлэхгүй байхаар хуульчилсан. Авлигал албан тушаалын гэмт хэргийг хялбаршуулсан журам үйлчлэхгүй байхаар мөн эрх зүйн орчинтой болсон. Авлигал албан тушаалын хэрэгт холбогдож шүүхээр шийтгэгдсэн этгээд магадлангаар хугацаанаас өмнө суллагддаггүй болох хуулийг мөн баталсан. Авлигал албан тушаалын гэмт хэрэгт холбогдож шүүхээр шийтгэгдсэн этгээдийн төрийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хассан. Авлигал албан тушаалын гэмт хэрэгт холбогдож шүүхээр шийтгэгдсэн этгээдийн бүх шатын сонгуульд өрсөлдөх эрхийг мөн хассан. Улс төрчид, түүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, хамаарал бүхий этгээдүүд нь төрөөс болон төрийн өмчит компани, төртэй хамтран хэрэгжүүлж буй олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрөөс санхүүжих бүх төрлийн тендерт оролцох боломжийг мөн хуулиар хязгаарласан. Дээрх албан тушаалтнууд тэдний хамаарал бүхий этгээдүүд төрөөс санхүүжих сургалтын тэтгэлэгт хамрагдахыг хориглох зэрэг авлигын гэмт хэргийн болзошгүй эрсдэлүүдийг мөн эрх зүйн түвшинд хааж чадлаа.

Хаврын чуулганыг авлигалын эсрэг хэмээн тодотгож, Засгийн газрын өргөн барьсан хуулийг цогц хэмжээнд дэмжин ажилласан Эрхэм Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар танд болон Монгол Улсын

Их Хурлын гишүүд, парламентад суудалтай улс төрийн намын удирдлагууд гишүүдэд Ерөнхий сайдын хувьд гүн талархал илэрхийлье.

Энэхүү эрх зүйн цоо шинэ шинэчлэл, шинэ улс төрийн соёлыг төлөвшүүлэх эхлэл цэг болж чадна гэдэгт миний бие бүрэн итгэлтэй байна.

Сая Их Хурлын дарга хүний эрхийн талаар асуудлыг хөндлөө. Хүний эрхийн хамгийн том зөрчил бол авлига юм. Хэлбэр биш агуулгын хувьд хүний эрхийн эрх зүйн реформыг ч гэсэн бид хийх ёстой үүн дээр Засгийн газар бүх талаар Их Хуралтайгаа нягт хамтран ажиллах болно гэдгээ илэрхийлье.

Монгол Улсын Засгийн газраас өнөөдөр авлигын эсрэг тэмцлийн хүрээнд Шүүх байгуулах тухай хуулийг өргөн барьж байна. Энэ хууль хараат бус шударга шүүхийг бүрдүүлэх нийгмийн мэтгэлцээний эхлэл цэг байгаасай хэмээн мөн хүсэж байна. Энэ мэтгэлцээн гэм бурууг шүүхдээ биш, харин шүүх байгууллага, институтийн хувьд хэрхэн төгөлдөржүүлэн бэхжүүлэхэд чиглэгдвэл хүний эрх, авлигын тэмцэл зэрэг олон асуудалд чухал хувь нэмэр оруулна хэмээн үзэж байна. 2021 оны 6 дугаар сард Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей чуулганаар Авлигын эсрэг тунхаглал гаргасан байдаг. Тус тунхаглалаар мөнгө завиших, мөнгө угаах, шударга ёсыг тогтооход саад учруулах тохиолдолд эрүүгийн гэмт хэрэгт тооцох амлалтаа хэрэгжүүлэхийн тулд холбогдох хууль тогтоомж, дүрэм журамдаа өөрчлөлт оруулах, авлигалаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нэмэлт арга хэмжээ авахыг гишүүн улс орнууддаа уриалсан билээ.

Мөн системийн авлигал, хил дамнасан мөнгө угаалт зэрэг гэмт хэрэгт олон улсын байгууллагууд цогц байдлаар хамтран ажиллах, мөрдөн шалгах, хууль сахиулах, шүүн таслах, бүх түвшиний байгууллагуудын мэргэшсэн

байдлыг сайжруулах асуудлыг хөндөн хэлэлцсэн байдаг. Улс орон бүрийн эдийн засгийн бүтэц, түүнээс улбаатай авлигын асуудал өөр өөрийн онцлогтой бөгөөд мэргэшсэн бүтэц чадварлаг хүний нөөцийг шаарддаг. Жишээ нь хар тамхи дагнасан авлигын сүлжээ зарим газар эрх зүйт төрөөсөө ч хүчтэй болж дотооддоо уг асуудлыг шийдвэрлэх боломжгүй болж олон улсын эрх зүйн түвшинд өөр улсад хэрэгт нь шилжүүлэх байдлаар асуудлуудаа шийдсэн тохиолдлыг ч бид мэднэ. Зэвсэглэлд орсон лобби бүлгүүд үндэстэн дамнасан улс төрчдийн бүлэглэлүүдийн өмнө олон улсын байгууллагууд тэр чигтээ хүч дутаж байсан түүх ч олон бий. Авлигал гэдэг бол өөрөө хамгийн их эрх мэдэлтэй, хамгийн нөлөө бүхий бүтцийг тойрч ургадаг ургамал юм. Манай Монгол Улсын хувьд экспортын 93 хувийг уул уурхай тэр дундаа нүүрс зэс бүрдүүлж байна. Нийт хүн амын талаас илүү нь нийслэлд амьдарч байна. Энэ нь манай авлигын голомт уул уурхай мөн нүүрс, зэс мөн нийслэлийн газрыг дагаж цэцэглэсэн гэдэг ердийн логик юм. Системийн авлигын улс төр болон эдийн засгийн бүлэглэл, олон улс дамнасан сүлжээний өмнө жирийн шүүгчид маань хүчин мөхөстөж байхыг үгүйсгэхгүй.

Монгол төр энэ дархлааг хамгаалах эрх зүйн орчин тогтолцоог бүрдүүлэх учиртай. Тийм ч учраас Монгол Улсад Авлигын дагнасан шүүхийг байгуулах нь зүйтэй гэж Ерөнхий сайдын хувьд үзэж байгаа юм. Зөвхөн шүүх засаглал ч биш Авилагтай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын Ерөнхий прокурорын газар зэрэг авлигын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын ажилтнуудыг олон улсын түвшинд сурган дадлагажуулах мэргэшсэн экспертүүдтэй олон улсын эрх зүйн хүрээнд хамтран ажиллах, авлигын эсрэг шударгаар ажилласан төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа болон аюулгүй байдлыг насан

туршид нь хангах эрх зүйн цогц реформ бид нарт хэрэгтэй болж байна.

Улс орон бүхэн өөр өөрийн тулгамдсан асуудлаар дагнасан шүүх байгуулдаг нийтлэг жишигтэй. Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр дэлхийн 27 улс авлигын эсрэг дагнасан шүүхийг байгуулсан байна. Өнөөдөр авлигал бидний тулгамдсан асуудал мөн л бол бид нэрэлхэлгүй тулгамдсан асуудлаа шийдвэрлэх л учиртай. Энэ нь шүүхэд итгэж буй итгэл бөгөөд авлигын эсрэг мэргэшсэн бүтцийг өөрсдөө бүрдүүлэх боломж гэж үзэж байна. Мөн шүүх засаглалын цалин хангамжийн асуудлыг аль нэг Улсын Их Хурлын аль нэг Байнгын хороо дангаараа шийддэг байж болохгүй гэсэн зарчмын байр суурьтай байна. Харин итгэлцүүрийн дагуу засаглалууд өөрсдөө шийдвэрлэдэг байх нь олон улсын нийтлэг жишиг юм.

Шүүгчдэдээ аль нэг улс төрч, бизнесийн нөлөө бүхий хүмүүс протоколгүй албан бусаар уулзахыг ч хатуу хуульчлан эрүүгийн хуульд оруулах шаардлагатай байна. Шүүх хууль тогтоох, гүйцэтгэх засаглал байршлын хувьд салангид байх ёстой. Дээд шүүхийн байрыг шударга ёсны ордон хэмээн нэрлэх нь шүүгчдийн ёс зүй хэм хэмжээний асуудал ч гэсэн ёс зүйн хувьд чухал байхыг үгүйсгэх аргагүй юм. Ерөнхий сайдын хувьд шударга ёсны зарчмын хувьд л байр сууриа илэрхийлж байгаа болохоос аль ч шатын ямар ч шүүгчтэй тухайлсан асуудлаар ярилцаж байгаагүй, цаашид ч тийм үйлдэл хэзээ ч гаргахгүй гэдгээ хариуцлагатайгаар илэрхийлье.

Энэ хуулийг хэлэлцэх явцад шүүн таслах үйл ажиллагаа явуулах өрөө тасалгаа, цахимжилт, сургалт судалгаа, хүний нөөцийн асуудлыг олон улсын түвшинд хүргэх зэрэг цогц асуудлуудыг тогтоолд тусган шийдэх нь зүйтэй гэж үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нүүрсний хэргүүд шүүхэд шилжсэн, шинээр илэрсэн нөхцөл байдлуудтай уялдуулсан “Нүүрсний сонсгол”-ын хэлэлцүүлэг ирэх 7 хоногт эрчимжиж эхэлнэ. Шударга ёс ил байна хэмээн амласан Хууль зүй, дотоод хэргийн сайд, шинэ сайд Энхбаяр таны анхны томоохон ажил ийнхүү эхэлж байна. Танд болон түр хорооны гишүүдэд амжилт хүсье.

Иргэдийн мэдэх эрхийг хангаж, цаашид алдаа гаргахгүйн тулд эрх зүйн тогтолцооны шийдэл гаргах нь туйлын чухал байгааг та бүхэн анхааран үзэх нь зүйтэй байх. Олон жил дуншин гацсан дуулиант хэргүүд ийнхүү шүүхийн шатад бүгд шилжлээ. Өнөөдөр өргөн барьж буй энэхүү хуулийн өөрчлөлт улс төрд томоохон донсолгоо үүсгэж, олон талын шүүмжлэл дагуулахыг үгүйсгэхгүй. Системийн авлигын эсрэг тэмцэл аль ч улсад улс төрчдийн чин эрмэлзэл, эр зориг, иргэдийн дэмжлэг, хууль сахиулах болон шүүх засаглалын хамтын ажиллагаанаас үр дүн нь ихээхэн хамаардаг. Монголд шударга ёсны тэмцэл машинаар зүйрлэвэл хүнд араандаа залгаж усаа халаан уухилсаар уулын орой хэсэгт нэлээд ойртлоо. Цаад уулын ч бараа харагдаж эхэлж байна. Мэдээж оргил өөд дөхөх тусам замын бартаа нэмэгдэж, хад чулуу ихсэх нь ойлгомжтой. Даваад ард нь гарах уу эсвэл уулын бэл рүү хүч алдан буцаж өнгөрөх үү гэдэг сонголтын өмнө та бид ирж байна.

Хэрэв энэхүү машин буцаж онхолдвол авлигын эсрэг тэмцэл энэ түвшинд эргэж иртэл нэлээдгүй урт хугацааг туулах дахин бүлэглэлтэй ийм тэмцэл өрнөж чадахгүй ч түвшинд байхыг үгүйсгэх аргагүй юм. Авлигын гинжээ тасалж чадалгүй гадаад өрийн гинжин хэлхээний чөтгөрийн тойрогт орж 50 жил, 100 жил, 150 жил болсон. Одоо ч үр дүн гараагүй байгаа дэлхийн

олон улсын жишээг та бид мэднэ. Улс орон урагшлан хөгжих үү, уруудан доройтох уу гэдгийг гагцхүү авлигатай байх уу, үгүй юү байх гэдэг энэ тэмцэл л шийднэ. Авлигалыг ялж байж бид жам ёсны эрүүл эдийн засгийн тогтолцоог бүрдүүлж чадна. Авлигын далайдаа хэдэн үеэрээ, хэдэн 100 жилээр дарлуулан амьдарч байгаа олон улсын харамсалтай жишээг бид үр хүүхдийнхээ төлөө давтаж болохгүй.

Тиймээс ч бид өвдөж болохгүй, өршөөж болохгүй, бууж өгч болохгүй байгаа юм. Өнөөдөр авлигатай хатуу тэмцэнэ гэдэг бол Монголын ирээдүйн төлөө хайр юм. Энэ цаг үеийн эрхэм түшээд ээ,

Хамтдаа шинэ үеийн удирдагч нартаа хөгжлийн төлөө ажиллах илүү боломжийг үлдээхийн төлөө өнөөдөр та бид энэ бэрхшээлээс шантралгүй, эс үйлдэл хийлгүйгээр авлигалыг ялах учиртай. Тэтгэвэрт хамтдаа гараад зүгээр л гудамжинд ард түмнийхээ дунд инээмсэглэн алхаж чадах эрх чөлөөний төлөө өнөөдөр та бид авлигыг заавал ялах учиртай. Улс төрчид та бүхнийг би үнэн байхыг уриалж байна. Телевизийн камерын өмнө нэг өөр, хөшигний ард өөр байхгүй байх шаардлага байна. Дотоод итгэл үнэмшилдээ чин сэтгэлээсээ авлигын эсрэг тэмцэлд нэгдээсэй гэж хүсэж байна. Энэ бол та бидний ирээдүй үедээ өвлүүлэн үлдээх энэ цаг үеийн хамгийн чухал үүрэг юм.

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа. Дэлгэрэнгүй асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Энхбаяр хариулна. Баярлалаа.

Г.Занданшатар: Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд баярлалаа. Одоо төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Өмнө нь зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэлийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын 57 дугаар сургуулийн 1981 оны төгсөгчдийн төлөөлөл, Хэнтий аймгийн Хэрлэн сумын залуучуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөл батлагдсанаар холбогдон гарах зардлын тооцоог нийт 345 тэрбум 627 сая 250 мянган төгрөг болох тооцоо гарснаас хүний нөөцийн зардал 47 тэрбум 418 сая 750 мянган төгрөг, материалын зардал 297 тэрбум 308 сая 500 мянган төгрөг, бусад зардал 900 сая төгрөг байхаар хууль санаачлагч үзсэн бөгөөд уг хуулийн төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хуулийн төслөөр авлигын хэргийн дагнасан шүүх байгуулж байгаа эсэх, мөн авлигын хэргийг давж заалдах шатын шүүхээр анхан шатын шүүхийн журмаар шийдвэрлэх, хяналтын шатын шүүхээр давж заалдах шатын шүүхийн журмаар шийдвэрлэх нь шүүхийн тогтолцоо

иргэний шүүхээр гэм буруутай эсэхээ тогтоолгох эрхэд нийцэж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат сүүлийн 8 жилийн хугацаанд шүүхийн хуулиудад хэр их өөрчлөлт орсон талаар, Улсын Их Хурлын хараат бус байгууллагуудаас зөвлөмж, дүгнэлт өгсөн эсэх, шүүгч, гэрчийг хамгаалах асуудлыг нь хэрхэн шийдэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир хялбар ажиллагааны анхан шатын шүүх байгуулж байгаатай холбогдуулан тооцоо судалгаа хийсэн эсэх талаар, Авлигын хэргийн дагнасан шүүх байгуулбал гарах ахиц дэвшлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Авлигын хэргийн шүүх байгуулбал тус шүүх нь өөрөө авлигад өртөхгүй гэсэн баталгаа байгаа эсэх, мөн хуулийн төсөлтэй холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссоос санал авсан эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх ажлыг дэмжих хүрээнд уг хуулийн төслийг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг дэмжихгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд авлигын хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллын зохицуулалт нь 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл буюу авлигын хэргийн дагнасан шүүх байгуулагдах хүртэл хугацаанд хэрэгжихээр тусгасан нь анхаарах ёстой асуудал бөгөөд авлигын хэрэг шийдэгдэхгүй нөхцөл байдал руу орох эрсдэл байгаа эсэхийг анхаарах нь зүйтэй талаар тус тус санал хэлсэн болно.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Шүүх байгуулах тухай хууль Шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай, Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Ренчиндоржийн Онончимэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Ганзоригийн Эрдэнэбулган, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Амгалангийн Насандэлгэр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Наранчулууны Отгончимэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Батсүрэнгийн Ундрах, Улсын Ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд

төрийг төлөөлөх хэлтсийн дарга Отгонбаярын Мөнхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга, хурандаа Хүрлээгийн Ариунболд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга Энэбишийн Бадамсамбуу.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Баагаагийн Баттөмөр гишүүн, Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Хүн нэмэхгүйг анхааруулъя. Тогмидын Доржханд гишүүн асуулт асууя.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхлээр авлигатай нам харгалзахгүй тэмцэх учиртай юм. Ийм болохлоор өнөөдрийг хүртэл энэ тэмцэл дээр нь нэг байгаа юм. Оюун-Эрдэнэ Монгол Ардын намын дарга, Ерөнхий сайдын хувьд санаачилгатай байгааг бол дэмжиж байгаа, сайшааж байгаа. Энэ дээрээ зоригтой байх хэрэгтэй. Харин энэ ажлын хүрээнд Хүн намын хувьд бид маш их идэвхтэй байсан, цаашидаа ч байна. Зөв зүйл дээр нь дэмжинэ. Тухайлбал Хөгжлийн банкны сонсгол хийх тэр санаачилга энд сууж байгаа Ганбат гишүүн бид нар анх гаргаад явж байсан юм нэг. Амжилттай болсон, маш сайн болсон. Гэтэл үр дүн хаана байна? Дунд шатын цөөхөн хэдэн албан тушаалтнууд ял авсан. Эрх мэдэлтнүүд ял аваагүй шүү. Өнөөдөр хүртэл үр дүн нь энэ, бодитой л юм.

Хоёрт нь энэ нүүрсний хэрэг байна. 40 их наядын хулгай байна гэдэг тооцооллыг гаргаж ирсэн, танилцуулсан. Орлогоо бид нар хилийн цаана алдсан байна гэдгээ ярьсан. Энэ асуудлын 18-20 их наяд төгрөг нь оффтейк гэрээ байна. Энийгээ ил болго гээд хяналтынхан сонсголыг анх удаа санаачилсан, энийгээ

шаардсан. Тэгээд талбай дээр бас эргэж засах үндэслэл болсон нь үнэн. Энэ дээрээ хав хатуу байгаа.

Гэтэл ингээд бүтэн жилийн хугацаанд шүүх дээр шийдвэрлэсэн зүйл алга. Хууль хяналтын байгууллага дээр мөн үр дүн гарсан зүйл одоогоор бас харагдахгүй байна.

Хоёр түүнээс илүү 7 жил болж байгаа тэр асуудал энэ Эрдэнэтийн 49 хувийн хулгай гэж би бол ингэж харж байгаа. 7 жил анхан шатын шүүхээс буцаад сая 21-нд дахиад шүүх хурал нь хойшилсон байна. Хүн нам байгуулагдсан мөн хувь хүний хувьд улс төрд орсон бас шалтгаан нь энэ юм шүү. Тэр Худалдаа хөгжлийн банкны эзэн сахал хочит Эрдэнэбилиг гэдэг хүн тухайн үед Монголбанк, Сангийн яамны кассын машин шиг ажиллуулж байсан шүү. Бодитой байдал нь тэр. Зөвхөн Засгийн газрын хуралдаанаар оруулаад нууцалсан гэрээнээсээ 1 их наядын хулгай хийсэн байдаг юм шүү. Одоо энийг нь би 2 жил хөөцөлдөж байж нууцаас дөнгөж сая гаргуулчхаад байгаа юм. Жирийн иргэн мөнгө зээлэх болохлоор баталгаа байхгүй.

Гэтэл тухайн хүн болохлоор Засгийн газрын нууц хуралдаанд оруулаад 1 их наядын баталгаа гаргуулдаг. 3 жилийн хугацаанд ханшийнхаа эрсдэлийг Монголбанканд үүрүүлдэг. Өөрөө 1 ч төгрөгийн ханшийн эрсдэл үүрдэггүй. Үр дүнд нь Монголбанк тухайн үед 1 их наядын ханшийн эрсдэл үүссэн байдаг юм шүү. Үр дүнд нь Монгол Улс ханшаа 2 дахин алдсан байдаг. Бизнесүүд ачааг нь үүрсэн байдаг. Энэ бол маш том хулгай. Үр дүнд нь Эрдэнэтийн 49 хулгай бий болсон. Эх үүсвэр нь дандаа хулгайн мөнгөөр явсан байдаг юм шүү. Одоо энэ хэрэг хаана байгаа юм, яагаад шийдэгдэхгүй байгаа юм. 7 жил болж байхад. Энэ байдлаар энэ нүүрсний сонсголын дараа хэргүүд шийдэгдэхгүй юм биш биз дээ. Ийм болохлоор одоо бүгдээрээ энийгээ цэгцлэх нь зүйтэй.

Харин цэгцлэхдээ бас учир байна, асуулт байна. Анхан шат дээрээ буцаагаад байдаг энэ байдлаас болоод 2 шаттай больё гэсэн ийм санал орж ирж байна. Энэ тохиолдолд асуудал нь уг нь олон улсад 3 ийм шат байна, анхан шат байна, давах байна, түүнийг нь хяналтын шат байна. Энэ дотор хэрэг гээгдэхгүй байх, хүнийг хэлмэгдүүлэхгүй байх ийм олон улсын тогтолцоо байна гээд.

Гэтэл манай дээр анхан шатаасаа буцаагаад байна. Хоёрхон шаттай байна гэж оруулж ирж байх шиг байна. Тэгэхлээр энэ дээр та бүгд яг ямар үндэслэлээр 2 шат гэдгээ дахиад тайлбарлаад өгмөөр байна. 2 шат болсноороо хэрэг гээгдэхгүй байх тэр баталгаа нь байна уу. Үүнийг тодорхой асуумаар байна. Хүн хэлмэгдүүлэхгүй гэдэг баталгаа байна уу. Үүнийг бас асуумаар байна. Ингээж 2 шат болсноороо энэ хүлээгдээд байгаа том хэргүүд шийдэгдэх үү. Баталгаа асуумаар байна. Энэ дээр хариулт өгнө үү.

Г.Занданшатар: Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяр хариулна.

Б.Энхбаяр: Өнгөрсөн хугацаанд энэ илэрсэн том хэмжээний авлигачид анхан шатын шүүх дээр таны хэлсэнчлэн 7 жил хождог, цаг хугацаа хождог, улмаар хөөн хэлэлцэх хугацаа дуусгадаг, хэргээ буцаалгадаг, ингээд ял завидаг ийм схем рүү орсон.

Өөрсдөө болохоор бас бид нар 3 шатын шүүхээр шийдүүлэх үндсэн эрхтэй, хянуулдаг байх ёстой гэдэг энэ зүйлийг ярьдаг. Яг энэ юугаар бол анхан шат дээр та хэд маань сүүлийн хэдэн жил сүүлийн үед гарч байгаа хэргүүдэд ял шийтгэж байгаа байдлыг зүгээр л харж байгаа шүү дээ. Тэрбум, их наядын хулгайчид нь хэдэн сая төгрөгөөр торгуулаад л гараад байна шүү дээ. Энийг л больё гэж байгаа юм. Энэ дээр

Монгол Улсын дээд шүүх Монгол Улсын шударга ёсны эцсийн цэг мөн юм бол авлигачдад энэ шударга ёсны нүүр царайгаа ил тод харуул гэж байгаа юм. Тэр анхан шатын 1 шүүгч, 2 шүүгч рүү заачхаад тэр тэгчихсэн юм байна лээ, энэ ингэчихсэн юм байна лээ гээд суугаад баймааргүй байгаад байгаа юм. Парламентаасаа эхлээд, Засгийн газраасаа эхлээд хяналтын сонсголууд хийгээд том том хэргүүд илрээд байдаг. Шүүх дээр очоод иргэд асуугаад байна шүү дээ. Бид нар энэ шүүх байгууллага биш шүү дээ энэ Улсын Их Хурал, парламент гэдэг чинь. Ял оноодог газар биш байхгүй юу.

Хэрэв тэгэх юм бол энэ чинь болохгүй болно шүү дээ. Намын шүүх боллоо гэж шүүмжилнэ, Доржхандын шүүх боллоо гэж шүүмжилнэ, Энхбаярын шүүх боллоо гэж шүүмжилнэ. Бид нарын гол үүрэг бол энэ идсэн, ууссаныг нь илчлэх байхгүй юу. Энэ сонсголуудаар дамжуулж илчлээд байгаа байхгүй юу. Одоо энэ шүүх байгуулах хуулийг хамгийн эсэргүүцэж байгаа нүүрсчид байна лээ шүү дээ. Хэрэг нь оччихсон 49-хөн байна лээ шүү дээ. Мөнгө нь хахаж ядчихсан. 60 машин, одоо 1 нүүрсний тээврийн машин чинь зах зээлийн үнэлгээ нь хамгийн багадаа бүүр хуучин нь 200 гаруй сая, дунджаар 350 сая, шинэ нь 420 сая юм байна лээ шүү дээ. 20 тэрбумын машинтай сэтгүүлч байна шүү дээ. Одоо энэ чинь үүрсний хулгайд бүгд оролцсон байна лээ шүү.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Тэгэхлээр би баталгаа асуугаад байна Энхбаяр сайд аа. Таны оруулж ирсэн энэ хуулийн төслийг бид нар дэмжээд явуулсан тохиолдолд том хэргүүд шийдэгдэх үү, шийдэгдэх боломж нь бүрдэх үү гэдэг асуулт байгаа юм. Одоо энэ Салхитын мөнгөний орд дээр гарсан хулгай гээд Мөнхбаяр гэдэг хүн 1.2 тэрбум

төгрөгийн авлига авчхаад 27 саяар торгуулаад явуулчихсан.

Тэгэхлээр ийм хэргүүд шийдэгдэж чадах уу. Нүүрсний томоохон асуудлууд гарч ирнэ. Томоохон албан тушаалтнуудын асуудлууд гарч ирнэ. Тэрийг яг бодитойгоор шийдэж чадах уу. Зэсийн том пирамидын асуудлуудыг ондоо багтаагаад бид нар шийдэж чадах уу. Та энэ саналуудыг чинь бид нар дэмжсэн тохиолдолд энэ дээр батлаад гаргаж өгөөч гээд байгаа юм. Үр дүн чухал шүү дээ. Тэгэхгүй бол парламент чинь өөрөө зүгээр худлаа ярьдаг газар болчихно. Одоо үр дүн хэрэгтэй. Яг энэ зохицуулалтаа та оруулж ирж чадаж байгаа юу гэдэг дээр.../минут дуусав./

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна.

Б.Энхбаяр: Парламент худлаа ярьдаг газар биш. Яг энд ярьсан, ярьж байгаа зүйлээ хуулийн өмнө, шүүхийн өмнө бас нотолж ярьж чаддаг байх ёстой. Энэ чинь амандаа орсон тоогоо ярьдаг газар биш шүү дээ. Нүүрсний сонсгол дээр Доржханд гишүүн өөрөө түр хорооны гишүүн өөрөө бас гэрчээр оролцох ёстой. Хоёр дахь удаагийнх нь сонсгол дээр өөрөө. Би бол түр хороон даргын хувьд Доржханд гишүүнийгээ гэрчээр дуудна гэсэн бодолтой байгаа. Холбогдох шинжээчийн дүгнэлтүүд гарч таарна. Энэ 40 их наяд гэдэг зүйлээ нотлох ёстой. 40 их наядыг яаж тооцооноо гаргах ёстой. Энд нэг юм ярьчхаад яг өөрөөс нь энэ асуудлыг нь шалгаж тогтоох гээд асуухаар үгүй ээ нэг би I ерөнхийд нь бодчихсон юм гэдэг ийм сураг ажгаар юм уу хүмүүсийг зориуд турхирах гэсэн юм уу ийм дур зоргоороо газар ярьдаг газар байх ёсгүй.

Тийм учраас хэрвээ ийм хуульч нь хуульч шиг, эдийн засагч, банкир нь банкир шигээ тоондоо хариуцлагатай байх ёстой. Ярьж байгаа амнаасаа үг.

Г.Занданшатар: Та сая тодруулчихсан шүү дээ. Ямар асуулт асуусан юм. Ер нь улс төрч нар л баталгаа асуугаад л хүн шүүгээд л энэ шүүхийн танхим ч биш. Ер нь бол тэр 40 их наяд энэ тэр чинь бол зүгээр энэ хяналт шалгалтын түр хороон дээр нийт гаргасан экспортын дүнг л 40 их наяд, 44 их наяд байна гэдгийг цаашаа, наашаа ярьчихсан юм шиг байна лээ шүү дээ. Тийм, тэгэхдээ хариулт хангалтгүй л байна. Тэгэхдээ энэ ер нь бол шүүх ажил шүүх дээр хэрэг удаашираад байгааг Улсын Их Хурал хэлэлцэж болно. Тодорхой хэрэг ярихгүй. Хэрэг бид нар бол ярих эрхгүй. Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн
Жигжидсүрэнгийн Чинбүрэн,
Хүрэлбаатарын Булгантуяа,
Энхтайвангийн Бат-Амгалан нарын
урилгаар Баянзүрх дүүргийн ерөнхий
боловсролын шилдэг сургуулийн 10 а
ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын
үйл ажиллагаатай танилцаж байна.

Эрхэм хүндэт сурагчид та бүхэндээ сурлага, спортын өндөр амжилтыг хүсэн ерөөгөөд сур сур бас дахин сур хэмээн сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг чинь өөртөө тогтоно шүү гэдгийг уламжлан хэлье. Сайн сайхан, сурлагын өндөр амжилт хүсье. Баярлалаа.

Одоо Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна. Одоо холбогдож байгаа асуудлаар Улсын Их Хурлын дарга дараагийн асуудлыг ярина. Асуу. Худлаа мэдээлэл хэлж болохгүй. 40 их наяд гэж. Тэр 40 их наяд гэдгээ тайлбарла. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. Гараад тайлбарла, гараад тайлбарла.

Г.Тэмүүлэн: Би асуултаа асууя. Тэгэхээр өнөөдөр Засгийн газраас энэ Шүүх байгуулах тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг оруулж ирж байна. Өнөөдөр үндсэндээ Монголын нийгэмд бас хамгийн том тулгамдаад байгаа, хамгийн том толгойны өвчин

болоод байгаа асуудал бол энэ авлигал, хээл хахуулийн асуудал, шударга бусын асуудал. Сүүлийн жилүүдэд гарсан нүүрс болоод ногоон автобус, Хөгжлийн банктэй холбоотой, авлигал хээл болоод энэ нийгмийг бухимдуулж байгаа томоохон гэмт хэргийн асуудлууд байгаа.

Тэгэхээр Засгийн газраас хэрэгжүүлж байгаа авлигатай тэмцэх энэ шударга ёстой тэмцэх ажлыг дэмжих үүднээс бол энэ хуулийн төслийг дэмжиж байгаа, дэмжиж байгаа. Бид нар цаашид энэ хууль ёс болоод шударга ёсны асуудлыг нэг мөр шийдэхгүй бол цаашид тогтолцоо болоод засаглалыг нь зөв болгохгүй бол бид нар цаашид энэ иргэдийн итгэх итгэл болоод энэ нийгмийн хамт хамгийн үнэт зүйл болсон энэ шударга ёс болоод хууль ёсны асуудлыг бол бид нар дахиж яриад байх бол боломж, бололцоо бол байхгүй.

Тэгэхээр цаашид Монгол Улсад ерөөсөө хууль цаад хэрэгжих үү, төр шиг төртэй байх уу, үнэт зүйл, зарчим гэдэг зүйл ерөөсөө байх юм уу, үгүй юм уу гэдгийн асуудал бол суурь асуудал бол би энэ гэж харж байгаа. Тэгэхээр бид нар хуулийг яах гэж гаргаж байгаа юм, хуулийг яах гэж мөрдүүлэх гээд байгаа юм гэдэг асуудал бол хэн хүн, хэн байхаас үл хамаарч бол хүн бүр л дагаж мөрдүүлэх үүднээс бол бид нар хуулийг гаргаж байгаа. Хүн бүр тэгш эрхтэй, шударга шүүхийн өмнө шүүлгүүлэх эрх нь бол тэнд бол байх ёстой гэж хараад байгаа юм.

Тэгэхээр хууль мөрддөггүй газар, шударга шүүх байхгүй газар бол хүн хүндээ итгэх итгэл байхгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр бид нар цаашид энэ шүүхээ яаж шударга болгох вэ энэ иргэдийнхээ итгэх итгэлийг яаж нэмэгдүүлэх вэ, ил тод нээлттэй яаж шүүхтэй болгох вэ гэдэг маань бол хамгийн суурь зарчмын асуудал болоод байна. Шүүх өөрөө шударга бусын хонгил болоод бас удаж байгаа. Шүүхийн

шатад хэргүүд уддаг болсон нь бол бас үнэн. Тэгэхээр би нэгд асуух гээд байгаа зүйл нь энэ шүүхийг бид нар шударга байлгахын тулд энэ шүүх өөрөө авлигалаас ангид байх энэ зарчмын асуудлыг бид нар яаж хэрэгжүүлэх вэ. Шүүгч нар авлигад идэгдэхгүй байх энэ асуудлыг бид нар яах вэ. Шүүгч нарын хариуцлага болоод сахилга баттай холбоотой асуудлыг бид нар яах вэ. Шүүх өөрөө авлигад өртөхгүй байх баталгааг бид нар хэрхэн хангах вэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Нэгдүгээрх нь.

Хоёрдугаарт угтаа уг нь бол бид нар энэ авлигалын хэргүүдийг бууруулах, ёстой, авлигатай урьдчилан сэргийлэх ёстой, авлигатай бид нар тэмцэх ёстой. Тэгэхээр авлигатай тэмцэх тусгай чиг үүрэг бүхий бол байгууллага байгаа. Энэнтэй дагнасан хууль ч байгаад байгаа. Тэгэхээр бид нар цаашид энэ авлигатай тэмцэх хууль дээр болоод энэ тусгай чиг үүрэг хэрэгжүүлж байгаа байгууллагууд дээр ч гэсэн анхаарах ёстой юу, үгүй юү эсвэл тодорхой дэмжлэг тусалцаа болоод хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг хийх ёстой юу үгүй юү, чиг үүргүүдийг нь нэмэгдүүлэх ёстой юу үгүй юү? Энэ дээр ер нь яг ямар байр суурьтай байна вэ? Энэ дээр та бас байр сууриа илэрхийлээч гэх гээд байгаа юм.

Би гурав дахь асуудал нь бол шударга бусын энэ хонгилыг нураахтай холбоотой нэг саналыг л хийх гээд байгаа юм. Прокурорын дэргэдэх мөрдөн байсан 2014 онд устгасан, хууль хяналтын байгууллагад тавих хяналт байхгүй болсон, шударга бусын хонгил гарсан. Тэгэхээр одоо прокурорын дэргэдэх мөрдөн байгуулах албыг нь байгуулах ёстой юм биш үү. Энэ дээр Засгийн газар ямар байр суурьтай байгаа юм бэ. Мөрдөн шалгах ажиллагаанд хяналт тавих энэ прокурорын оролцоог нэмэгдүүлэх ёстой юм биш үү. Хөндлөнгөөс нөлөөлдөг энэ дар бага нарынх нь нөлөөг үгүй хийх ёстой юм биш үү. Энэ асуудлууд дээр бас ямар байр

суурьтай байна вэ? Зарчмын хувьд бол энэ хуулийн төслийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа.

Г.Занданшатар: Үг хэлчээв үү. Хэн хариулах вэ? Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Тэмүүлэн гишүүнтэй санал нэг байна. Үнэхээр энэ авлигалын үүр, ёзоорыг бас салъя гэвэл хуулийн аргаар ч тэр, урьдчилан сэргийлэх аргаар тэмцэхээс гадна тогтолцоог том зургаар нь харж байж үр дүн гарна. Таны хэлж байгаа мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх, түүнд хяналт авах, прокурорын хяналт, шүүх гэсэн энэ тэгээд шийдвэр гүйцэтгэл гэсэн ийм гинжин урвалаар нь, том зургаар нь харж байж мэдээж энд үр дүн хүрнэ.

Ялангуяа авлига албан тушаалын гэмт хэргүүд нуугдмал далд аргаар үйлдэгддэг, үндэстэн дамнадаг, эрх мэдэлтэй, мөнгөтэй, хэвлэлтэй, хуулийнхантай ийм болчихсон. Энэ нь аягүй тодорхой Хөгжлийн банкин дээр ч харагдсан, нүүрс дээр бүүр тодорхой харагдах юм байна лээ.

Тийм учраас энийг одоо бидний дараагийн би Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль дээр хэлж байсан. Энэ бол 3, 4 ийм цуврал багц хуулийн төсөл орж ирнэ гэж. Гүйцэтгэх ажлын асуудал байна. Нууц мөрдөн шалгах ажиллагааны асуудал байна. Энийг нотолгоожуулах асуудал байна. Ингэхдээ хүний эрхэд халдахгүй байх асуудлууд байна. Ингэхгүй болохоор далд мэдээллүүдээр дамжиж төмсөгддөг, эсвэл хэвлэлээр зориуд өм цөм гаргаж байгаад шантаажилдаг. Эргээд хуулийнх нь юмнууд нь энийгээ шантайж мөнгө олох арга хэрэгсэл болгочихсон. Тэгээд үүгээрээ дамжуулаад өөрсдөө хулгайчдаа төмсөгдөж байгаад өөрсдөө хамтран хулгайч болчихсон. Нүүрс тээвэр хийчихсэн, мөнгөө хуваадаг авлигынхаа мөнгийг.

Ийм учраас ерөөсөө энийг цогцоор нь авч үзэж энэ ярихгүй бол болохгүй юм байна лээ. Би бол ухрахгүй хатуу байгаа. Ер нь энэ бүх салбарууд энэ хатги шиг болсон энэ хувалзуудаасаа салах ёстой юм байна лээ. Шүүхийн салбар энэ авлигач шүүгчдээсээ салах ёстой юм байна лээ. Би энэ нүүрсний сонсголын дараа энэ хил гаалийн асуудлууд, энэ хууль хяналтын байгууллагуудын хэрэгсэхгүй болгосон өөрийнхөө салбарын хэмжээн дэх энэ хувалзуудаасаа салгана. Энэ хүмүүсээс нь өөрийнхөө хэмжээнд. Шүүх бол шүүхийнхээ асуудлыг энэ ерөнхий зөвлөл ярих ёстой байхгүй юу энэ Сахилгын хороо. Чиглэл чиглэлдээ энэ авлигач улс төрчдөөсөө улс төрийн нам нь өөрөө салах ёстой юм байна лээ. Тийм учраас би хэлээд байгаа шүү дээ. Энэ жинхэнэ энэ мафийн схем гэдэг зүйлүүд ил болно. Ил болгож байгаа чинь энэний өөрөө манлайллаа сая Ерөнхий сайд хэллээ шүү дээ. Маш тодорхой улс төр.../минут дуусав./

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ Монгол Улсад үүсээд байгаа нөхцөл байдал бол үнэхээр туйлын хүнд байгаа. Ялангуяа авлига бол хавтгайрсан, ужгирсан. Өнөөдөр эрх мэдэлд байгаа энэ хүмүүс сүргээрээ байгууллагаараа нийлж ингээд хулгай хийдэг бүүр ийм зүйл тогтчихлоо. Энэ чинь бол Монголд мафи байхгүй л гээд байдаг. Энэ яг мафи байна шүү дээ. Гааль, цагдаа, хил юу байдаг юм Мэргээжлийн хяналт тухай бүгд нийлж байгаад л үг үгсэж байгаад л энэ хулгай хийж байгаа байхгүй юу. Нүүрсний хэрэг чинь тийм л юм байна лээ. Ерөөсөө энэ бүх газар чинь бүүр үнэхээр угжирчихлаа. Мафийн бүүр ийм сүлжээ маягтай болчихсон дэлхийд бол шившиг болж байна шүү дээ. Монгол чинь ямар ядуу орон юм бэ. Одоо Европын үнэлгээгээр Европын орнуудын үнэлгээгээр монголчуудын 90 хувь нь ядуу гэсэн үнэлгээ өнөө өглөө интернэтээр харлаа шүү дээ. Энэ их утаатай, энэ их

ядууралтай, энэ их хавдартай энэ чинь бүгд авлигаас л болж байгаа. Энийг бол ойлгож байна. Ямар ч санал санаачилгыг Ардчилсан нам болон би хувь хүнийхээ хувьд бол дэмжиж ажиллана.

Гэхдээ энэ хэлбэр мөн үү, үгүй юу гэдэг дээр бид нар маш сайн ярих ёстой. Энэ авлигатай тэмцэх дагнасан шүүх байгуулах нэрийн доор улс төрийн өрсөлдөгчөө намнах ийм хэрэгсэл болчих вий. Захиалгаар улс төрчид нэг нэгнээ намнадаг ийм хэрэгсэл болчих вий ийм баталгаа байхгүй гэсэн ийм зүйл гарахгүй гэдэг баталгаа байхгүй. Манай улсад бол энэ авлигатай тэмцдэг байгууллага, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр тэгээд л хууль, дүрэм журам хангалттай их байна шүү дээ. Бид нар энэ гарчихсан хойно нь авлигыг яаж шийдэх вэ гэхээсээ илүү авлигын энэ гараад байгаа шалтгаантай нь тэмцье гэж хэлээд байхад л энэ Их Хурал тэмцэхгүй л байгаа шүү дээ. Энэ олон төрийн өмчит байгууллага дээр чинь хамгийн том хулгай авлига гараад байна л гэхэд эд нарыгаа хамгаалж үлдээд л байгаа. Олон нийтийн нээлттэй хувьцаат компани болгооч ард иргэдийн хяналтыг оруулаач энэ хулгай, авлига чинь хэтэрлээ гээд байхад л энийгээ хэвээр нь ажиллуулаад л байгаа шүү дээ.

Тэгэхээр чинь яаж авлига буурах юм. Би Цагаатгалын комиссын даргаар ажиллаж байгаа тэр 37 он, 39 он тэр их аллага хядлага чинь юунаас болсон юм гэхээр ерөөсөө яг иргэнийхээ эрхээ хамгаалах үе шаттай шүүхээрээ явахгүй Онцгой бүрэн эрхт комисс гэж байгуулаад л 3 хүн өдөрт хэдэн мянгаар нь захиалгаар хурдавчилснаар ингээж хүний эрхийг асар их зөрчиж энэ асуудал чинь л үүссэн. Тэгэхээр энэ авлигатай тэмцэх шүүх байгуулаад энэ авлигатай тэмцэх шүүхийн шүүгчид чинь авлигаас ангид байна гэсэн баталгаа надад харагдахгүй л байгаа.

Яагаад гэхлээр манай энэ сүүлийн үед Хууль зүйн сайдаар ажиллаж байсан

Тэмүүжин бол байнга ярьж байна шүү дээ. Хууль зүйн сайдаар ажиллаж байхдаа энэ бол энэ асуудал байж болохгүй юм. Энэ бол маш аюултай нөхцөл байдлыг үүсгэнэ. Хонгилыг нэг хүний гарт атгуулна, шинэ хонгил үүсэх нөхцөл чинь бүрдэнэ гэдгийг хэлээд байгаа.

Тэгээд энэ улс орнуудын судалгааг бас яриад байгаа шүү дээ. Зимбабве, Афганистан энэ улсууд дагнасан шүүх байгуулаад авлигал нь огт буураагүй гээд байгаа юм. Тэгэхээр би Энхбаяр сайдаас л асуух гээд байна л даа. Бид нар авлигаа бууруулмаар байна. Гэхдээ энэ чинь өөрөө энэ захиалгат шүүх болчих вий дээ. Тэгэхгүй гэх баталгаа Монголд байхгүй шүү. Та өнөөдөр өөрөө сайд байгаад би шударга хүн тэмцэнэ. Таны дараагийн хүн ямар ч сайд гарч ирээд энийг яаж ч захиалгаар яаж ч эргүүлэхийг хэн байг гэх юм. Таныг өөрийг чинь ч гэсэн энэ шүүхээр оруулаад намнахын.../минут дуусав./

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна.

Б.Энхбаяр: Би Одонтуяа гишүүнтэй санал нэг байгаа. Ер нь бид нар энэ хууль, шүүхийн тогтолцоог хийхдээ болзошгүй эрсдэлүүдийг бүгдийг нь тооцож байх ёстой. Танд байгаа болгоомжлол надад ч байгаа. Надад ч гэсэн ийм болгоомжлол байгаа.

2021 онд Шүүхийн хууль юу, 20 оны 8 сард Шүүхийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад орж ирж байхад би бас чуулганы танхимд хэлж байсан. Энэ Монгол Улсын Ерөнхий шүүгчийг шүүхийн хонгилын хаанаар болгочих юм биш биз дээ. Өөрөөр хэлбэл танхим хооронд дураараа сэлгэдэг ийм бүрэн эрхийг өгчихвөл тодорхой хэрэг маргаанууд дээр өөрөө үзэмжээрээ тэрний хэргийг тэрээр шийдүүлнэ тэрний хэргийг тэрээр шийдүүлнэ гэдэг эрх чинь өөрөө бас хонгил угсрагдана гэдэг энэ болгоомжлол надад бас байгаа.

Ер нь өнөөдөр энэ цаг үед харж байхад энэ олон, ялангуяа сүүлийн 20, 30 жилийн хугацаанд гарсан энэ томоохон хэрэг, асуудлууд ер нь эхнээсээ илрээд шүүх дээр очиж байна. Энд ингээд яг шийдвэр гарч байгаа шийдвэрүүдийг харахаар үнэхээр харамсалтай байна. Шүүхийн шийдвэрүүдээ ил тод мэдээлэх дээр тайлбарлах дээр яагаад гэдэг дээр үнэхээр асуудал байна.

Тийм учраас яг энэ Улсын дээд шүүх тодорхой энэ асуудлууд дээрээ ер нь хариуцлага үүрвэл яасан юм бэ гэж байгаа юм. Туршлагын хувьд, тэгээд энэ шүүхийн шударга ёсны ноён оргил юм бол яг ийм ард түмний хамгийн их анхаарал тавьж байгаа энэ асуудлууд дээр тайлбараа хэлбэл ямар вэ гэдэг ийм хувилбар гаргаж байгаа юм. Энэ тодорхой хугацаатай бас байгаа. Та хэрвээ харах юм яг хуульд нь энийг удаан хугацаагаар өгөх юм бол таны хэлж байгаа тэр хонгил үүсэх эрсдэл бодитой байгаа. Энэ дээр би тантай санал нэг байгаа. Санал нэг байгаа юм.

Тийм учраас энэ удаан хугацаагаар энэ Засгийн газар өөрөө энэ олон таван “ш” ажиллагааг хийгээд энэ олон барьж авчирч байгаа хүмүүсийн асуудлууд энэ чинь маш их хөдөлмөр байхгүй юу. Энийг илрүүлж байгаа цаг хугацаа, нотолж байгаа энэ юмнууд битгий талаар болоосой. Ерөөсөө энэ Монгол Улсынхаа шүүх системд энэ итгэх энэ ард түмний итгэл бүр мөсөн баларвал юу болох вэ. Энэний үр дагавар чинь их аюултай байхгүй юу. Энэ чинь дарангуйлсан засаг руу түлхэх улс төрийн үр дагавартай. Ерөнхий сайд ч гэсэн түрүүн хэлсэн. Тийм учраас энэ дээд шүүх дээр.../минут дуусав./

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүнд тодруулъя.

С.Одонтуяа: Энэ Гүрж улсын шинэчлэл хийгээд энэ авлигаас ангижрахын тулд гадаадын хараат бус

шүүгчид авчирч ажиллуулж бас авлигыг их бууруулсан сан гэж ийм юу байгаа. Тэгэхээр ер нь манай улсад ийм боломж нь байдаг юм уу? Энэ талаар та мэргэжлийн хүний хувьд ер нь энэ боломж манайд байна уу? Надад ерөөсөө хэрвээ гадаадын хараат бус ийм шүүгчид байвал энэ авлигаас ангид байж болох юм гэсэн ийм юм зүгээр харагдаж байгаа юм. Манай хэдэн банкнууд чинь тэгсэн шүү дээ. Хэдэн улс төрчид нь захиалгаар захирлуудыг нь яасаар байгаад хамаг банкаа дамнууруулаад, сүүлдээ хэдэн гадаад захирлууд авчирч байж тогтсон. Тэгэхээр манай улсын хууль, эрх зүйн зохицуулалтаар ийм боломж бий юу гэдэг яг тодорхой асуулт асуух гэсэн юм.

Г.Занданшатар: Үг хэллээ. Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Монгол Улсын шүүгч, Монгол Улсын ерөнхий прокурор гэсэн албан тушаалтнуудад тавигдах шаардлага дээр Монгол Улсын иргэн гэж байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд заачихсан бүх шатын шүүгч хүн дээр Монгол Улсын иргэн ажиллана гэж Монгол Улсын Үндсэн хуульд заасан.

Ер нь бол гадаад хүн урьж залтлаа би Монгол төр авлигатайгаа тэмцэж чадахгүй болтлоо доройтчихсон гэж би бодохгүй байгаа. Хууль хяналтын байгууллагуудад ажиллаж байгаа олон шударга залуучууд байгаа. Тэр олж илрүүлж байгаа юмыг нь зардаг, үрдэг хувийн шантайжны зэвсэг болгож хэргийг нь замхруулдаг ийм сүлжээ байгаа нь өөрөө тэр шударга хууль сахиулагчдын итгэлийг бас мохоогоод байгаа юм. Мохоогоод байгаа юм.

Өөрөөр хэлбэл тэр олон жилийн турш ингэж шалгаж илрүүлж байгаа юмыг нь дээд талынх нь дарга нь аваачаад хувийн хөрөнгөжих байдлаар,

эсвэл хүнд хэн нэгэн хүнийг шантайжлах байдлаар зэвсэг болгож ашиглаад байхаар энэ ажиллаж байгаа шударга олон залуучуудын итгэл мохоод байгаа юм. Тийм ч учраас би тэр мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулж болохгүй гэж хууль сахиулагчтайгаа хатуу яриад байгаа нь нөгөө нэг талдаа энэ авлигын янз бүрийн ийм хэргүүдийг шантайж болгож энэ мэдээллийг нуудаг эсрэгээрээ хэргийг нь илрүүлэхгүй болгоход ашигладаг энэ сүлжээг таслан зогсоох гээд байгаа улс төрийн хүсэл эрмэлзэлтэй бас холбоотой юм шүү гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Н.Алтанхуяг: Энэ би Байнгын хорооны 2 ч удаагийн хуралд нь ороогүй. Энэ асуудлыг би ер нь хэлэлцэж болохгүй л гэж ингэж бодож байгаа хүн л дээ. Энхбаяр гишүүн маань сайд болчихсон, бид хэд чинь энэ хонгил гэдэг юмыг ер нь алга болгоё гээд Ардын намын зүгээс ч гэсэн бас санаачилга гаргаад бид нар ажлын хэсэгт ороод, шүүхийнхээ чиглэлийн юмнуудыг овоо болгож байгаа шүү дээ. Уг нь Үндсэн хуулиараа бас шүүгчид хариуцлага тооцдог ийм газар бий болчихсон. Тэгэхээр өнөөдөр заавал энийг ингэж хоёрхон шаттай болгож энэ их том аюулын тохио л доо 2 шаттай болгоно гэдэг бол. Тэгэхээр энэ шүүхийнхээ тогтолцоог эвдэж байгаа дахиад. Одонтуяа гишүүнтэй энэ санал нэг байгаа юм. Энэ бол улс төрийн өшөө хонзон авах зэвсэг болж хувирна.

Ерөөсөө энэ авлигын асуудлыг ингээд АТГ, прокурор, шүүхийн хэдхэн хүн шийддэг болно. Энэ ёстой жинхэнэ ёсны хонгил үүсэж байгаа юм л даа. Тэгээд магадгүй Ардын нам энэ хавар баахан Ардчилсан намынхныг хийх байх. 24 оны сонгуулийн дараа хэд нь гарч ирээд өшөөгөө авна гээд. Энэ ер нь Монгол төрийн тогтолцооны хувьд асар их буруу юм руу аваачиж байгаа юм.

Тэгэхээр эрхэм ухаант олонх маань энийгээ дахин авч үзэж хийгээч. Би сая Ерөнхий сайд орж ирээд хэлж байгаа үгийг нь сонсоход энэ Ерөнхий сайдын хүсэл эрмэлзэл юм шиг байна. Би бол энэ авлигачид авлигыг чинь устгая тэгье энэ бүх юман дээр чинь хамтарч ажиллана. Тэгэхдээ хууль, эрх зүйн хүрээнд, Үндсэн хуулийн хүрээнд гээд явж байгаа шүү дээ. Бид нар ийм юм хийж болохгүй л дээ. Тэр яасан ч бай тэр хүн чинь өөрөө яваад 3 шатынхаа шүүхээр ороод л зөв, буруу нь тогтоогдоод л ял авна. Бид нар авлигачдыг бол нэлээн чангаруулаад өгчихсөн шүү дээ. Бүх нь нөгөө хэрэг хөөн хэлэлцэх хугацаа, жил бүх юм нь ингэчихсэн шүү дээ.

Тэгэхээр энэ бол их тийм буруу юм руу явах нь дээ. Та нар маань анхаарч энийг ер нь зогсоосон нь дээр байхдаа Энхбаяр аа. Энэ их ер нь бол махны машин буцаагаад л эзнээ л тастдаг л ийм л юм л даа. Дагнасан шүүх байгуулах асуудал бүүр байхгүй л дээ. Тэрийг судал гээд яах юм бэ дээ хэрэггүй. Энэ Элбэгдоржийн хэдэн шүүгч нар гарч ирээд л энэ шүүхийг ингээд тийм хүн байдаг бол тэр шүүгчтэй нь ярь л даа. Тэр шүүгчид нь хариуцлага тооцдог арга хэмжээ ав л даа. Тогтолцоо эвдлэн сүйтгэж болохгүй. Би энэ Байнгын хорооны хуралд ороогүй ч гэсэн Байнгын хорооны хурал дээр та нарын хариул ж байгаа энэ тэрийг сонссон. Дээд шүүх засгийн хүсэл эрмэлзэл гэгчихсэн учраас та нар бүгд дуугарахгүй байна лээ. Бид нарт тусгайлсан санал өгөөгүй ч гэх шиг. Ингэж болохгүй. Энэ шүүхийн тогтолцоо эвдэж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн ч энд сууж байгаа. Шүүхийн тогтолцоо эвдэж байгаа ийм юм байж болдоггүй юм.

Тэгэхээр Энхбаяр маань Ерөнхий сайд нь тэг гэсэн болохоор тэгж байх шиг байна гэж би ойлгож байна. Ерөнхий сайд тэнд хүн сонсоход гоё юм ярилаа. Тэгэхдээ амьдрал дээрээ махны машин, хонгил жинхэнэ ёсоор угсрагдах гэж байна. Ерөнхий сайд маань ч гэсэн миний

хэлж байгаа үгийг сонсоосой билээ. Энэ асуудлыгаа бол болиосой билээ. Одоо та ингээд шударга юм ярья гээд ингэжээд нүүрс дээр жишээлэх юм бол жижиг Тавантолгой нь Ардчилсан намын хэдэн нөхдийг үгүй энэ Элбэгдорж бол баахан буруу юм хийсэн л дээ. Тэгэхдээ Элбэгдоржоор толгойлуулсан Ардчилсан намын хэдэн хүнийгээ л ийм л юм руу явж байна шүү дээ. Жинхэнэ нүүрсний хулгайч чинь хаана байгаа юм тэгээд. Тэр нь болоогүй тэр 2 дахь, 3 дахь үзэгдэл дээр гарна гээд ийм байдлаар энийг хандаж болохгүй дээ. Та нар яагаад ийм сонин болчхов. Улсаа нураана шүү, тогтолцоогоо нураана шүү.

Г.Занданшатар: Та дараа нь тодруулчих. Харилцан ярилцвал зүгээр байдаг юм. Одоо Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна. Харилцан асуулт асууна.

Б.Энхбаяр: Алтанхуяг дарга бид нар Шүүхийн хууль дээр 21 онд их хамтарч ажилласан. Зэвсэгт нэгт ахан дүүс гэдэг шиг хонгилыг нураах дээр бид хамт гар гараасаа барьж, нам үл харгалзан зогсож байсан энэ үзэл санаандаа үнэнч байгаа.

Одоо энэ бидний бас тэр Шүүхийн хуульд бүүр тодорхой оруулсан асуудал бол шүүх эрх мэдлээ бид нар энэ гүйцэтгэх эрх мэдэл буюу Засгийн газраасаа ч бас хараат бусаар ингэж хадгалж, хамгаалах ёстой гэж бодож бичиж байсан. Шүүх байгуулах хуулийг хэн санаачлах вэ гэдгийг бүүр деталиар бичсэн. Тэгээд одоо яг заалт нь ийм байхгүй юу. Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүх байгуулах хуулийг боловсруулна. Энэ нь Улсын дээд шүүхтэй зөвшилцсөн саналыг Засгийн газар хэлэлцэнэ. Өөрөөр хэлбэл Засгийн газар Шүүхийн ерөнхий зөвлөл улсын дээд шүүхтэй зөвшилцсөн тэр саналаас өөр ийм хувилбаруудыг өөрөө өөрчлөөд л, нэг шүүхийг татан буулгачихъя, нэг шүүхийг байгуулчихъя гээд хамаагүй шүүхийг бас буужигнуулах тэр хамгаалалтын орон зайг нь Шүүхийн

хууль дээр аягүй сайн бэхжүүлж өгсөн юм.

Яг энэ агуулгаараа Шүүхийн ерөнхий зөвлөлийн Улсын дээд шүүхийнтэй зөвшилцсөн санал дээр авлигын бие даасан дагнасан шүүхийн асуудал байхгүй байгаад байгаа юм. Тийм учраас Засгийн газар яг энэ шүүхийн хуулийнхаа дагуу өөрөө ингээд шууд шийдчих боломж нь Шүүхийн хуулиар бас байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас тэр дагаж байгаа тогтоол дээр энэ асуудлыг оруулж ирээд, хууль тогтоогч Засгийн газар бол ийм улс төрийн хүсэл эрмэлзэлтэй байна гэдгээ илэрхийлж байгаа юм. Хууль тогтоогч энэ асуудал дээр шийдэх эрх нь бол цэвэр Улсын Их Хурлын хууль тогтоох байгууллагын бүрэн эрхийн хэмжээний ийм асуудал байгаа юм.

Тийм учраас Улсын Их Хурал дээр энэ асуудал бас их олон талаас нь яригдаж би бол шийдэгдэх байх гэсэн ийм бодолтой байгаа.

Хоёр дахь асуудлын хувьд тэр нүүрсний сонсгол дээр тэгэх намаар нь ангилаад дуудаад байгаа юм ерөөсөө байхгүй. 2 сонсгол маань 2 үе шаттай явагдах юм. Өмнө нь ч гэсэн 3 үе шаттай явж байсан шүү дээ Хөгжлийн банк. Одоо нүүрсний сонсгол чинь 2 үе шаттай явагдана. Жижиг Тавантолгой, том Тавантолгой гэсэн 2 компаниараа тус тусдаа. Жижиг Тавантолгой нь төрийн өмчийг 1999 онд энэ Улсын Их Хурлаас Өмнөговь аймгийн Иргэдийн хуралд өгчихсөн юм байна лээ анх. Ер нь хамгийн том хулгай хуулиар хийгддэг гэж үнэн л юм байна лээ. Хуриц гэж нөхөр хилийн тагнуулын албыг энэ буюу хилээр гарч байгаа нүд энэ чих юмыг хилийн тагнуулаас нь аваад хаячихсан юм байна лээ. Одоо бодоход энэ бүх юмнууд нэлээн сонсгол дээр тодорхой болох байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Норовын Алтанхуяг гишүүн тодруулж асууя. 1 минут.

Н.Алтанхуяг: Одоо яамаар юм бэ дээ Энхбаяр гишүүн, сайд минь. Энэ Ерөнхий сайдтай би бас уулзаж нэг юм зөвлөх юм уу. Энэ арай болохгүй. Энэ тогтолцоо эвдэж байгаа байхгүй юу. Аймаар том хонгил үүсэж байгаа байхгүй юу. Одоо ингээд та нар амьдрал дээр энгийн бод доо. Авлигатай тэмцэхийн даргыг чинь Монгол Улсын Ерөнхий сайд санал болгодог болчихсон. Тэдний мэдэлд гэсэн үг. Ерөнхий сайдын мэдэлд. Прокурор босоо бүтэцтэй, цаана нь 3 шатын шүүх байхад тэрийг 2 болгоно гэдэг бол энэ хурдавчилсан хонгил үүсэх гэж байна. Маши эмгэнэлтэй байна. Яана даа энийг зогсоох л хэрэгтэй байна даа. Энэ улс орон ер нь эзэн байна уу. Энэ гаднын гар хөл болоод дуусах вий дээ. Ийм юм чинь Монголын тусгаар тогтнолд л их аюул занал учруулдаг юм л даа. Ийм тогтолцоо эвдсэн, үзэмжээр шийдсэн, хэтэрхий их үсэргэсэн, маш муу.../минут дуусав./

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Алтанхуяг дарга ер нь хамгийн их зовлон үзсэнд хамгийн удаан Монголын түүхэнд хонгилоор чирэгдсэн Ерөнхий сайд гэж би бас өмнө нь хэлж байсан. Тийм учраас энэ ярьж байгаа үг, асуудал бол зүгээр сэтгэлийн хөөрлөөр ярихгүй байгаа. Би бол энэ Шүүхийн хууль дээр бас Алтанхуяг даргатай хамтарч ажиллаж байсан хүн, ажлын хэсгийн ахлагч гишүүнээр ингээж ажиллаж байсны хувьд хүний хувьд их ажил хэрэгч энэ асуудал болгон дээр бас алсыг харж байгаа гэж бодож байгаа юм. Тийм.

Тийм учраас энэ ярьж хэлж байгаа асуудлуудыг энэ хэлэлцүүлгийн шатад хууль тогтоогчид бас анхаарах ёстой. Алтанхуяг дарга өөрөө бас энэ хуулийн ажлын хэсэгт орж ажиллаасай

гэж би бас хүсэж байна. Энэ ярьж байгаа асуудлыг бас ажлын хэсэг дээр бас анхаарч гишүүд олон талаас нь ярих байлгүй дээ гэж үзэж байна.

Г.Занданшатар: Ер нь ажлын хэсэг дээр нэлээн ярих шаардлага гарна. Энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль бусад хууль тогтоомж дахь уялдаа энэ процессууд яаж явагдах юм. 1 жилийн хугацаатай процесс ч гэж байхгүй, 1 жилийн хугацаатай тогтолцоо ч гэж байхгүй. Энэ бол буруу ойлголт өгнө. Тийм учраас энэ асуудлуудаа нарийвчлан ярилцаж ажлын хэсэг дээр нэлээн л ажиллах шаардлага гарах байх. Процессууд уялдахгүй бол наадах чинь ... детальд байдаг учраас бүүр тэр улс орнуудын жишээ ч гэсэн бас яг амжилтад хүрсэн олигтой улсуудын жишээ аль нь байгаа юм. Авлигын индексээрээ харгалзаад үзэх юм бол сайн жишгийг нь л авахыг эрмэлзэх нь зүйтэй байх. Ер нь түрүүн бас асуугаад байсан тэр Тэмүүлэн гишүүн тэр шүүхийн сахилгын, дөнгөж тогтолцоо бүр институт болох гэж эхэлж байна шүү дээ. Шүүхийн ерөнхий зөвлөл хараат бус бие даасан байдлыг хангах ёстой. Шүүхийн сахилгын хороо, тэр хариуцлага, шүүхийн тэр хууль хэрэглээний болон сахилга, зөрчлийн асуудлуудыг хянан шалгадаг байгууллагууд болоод төлөвших гэж эхэлж байна. Энэ чинь 4 жил, 8 жил болж байж хэдэн жил болж 2 жил болж байж дороо бий болчихгүй. Тэгэхдээ 2, 3 жилийн дотор улам сайжирчихна. Энэ тэгээд цогцоор нь харахгүй бол, системээр нь харахгүй бол системээ нэг судас л өвчлүүлчихдэг тохиолдол байдаг гэж байгаа шүү дээ. Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Гэмт хэрэгтэй тэмцэх нь Засгийн газрын чиг үүрэг. Засгийн газар өөрөө тодорхой хэргүүд дээр Хөгжлийн банк, нүүрсний гэх тодотголтой хэргүүд дээр шүгэл үлээгээд олны анхааралд оруулсан.

Цагдаа, Авилагтай тэмцэх газар, тагнуулын байгууллагууд ажилласан. Асар их цаг хугацаа, хөрөнгө хүч гаргаж ажилласан. Яллах дүгнэлт үйлдүүлсэн, прокурорт шилжсэн. Гагцхүү харамсалтай нь өнөөдөр ингээд шүүх дээр ирээд таг гацаж байна. Асар их цаг хугацаа хожиж байна. Хөөн хэлэлцэх хугацааг дуусгахыг хүлээж байна, ял завишхыг хүсэж байна.

Тийм учраас аргаа барахдаа Засгийн газар дагнасан авлигын шүүх байгуулах асуудлыг оруулж ирж байна. Оруулж ирэхээр чиг үүргийг Засгийн газарт өгөхөөр ингэж явж байна. Тийм учраас манай улсыг муухай харагдуулж байгаа, хөгжлөөс хойш татаж байгаа, ард иргэдийн ирээдүйн хүүхэд залуучуудын боломжийг хулгайлж байгаа энэ авлигын гэмт хэрэгтэй энд сууж байгаа 76 гишүүн тангараг өргөж нийгэмд шударга ёсыг тогтоож шударга бус байдлыг таслан зогсоох ийм л тангараг өргөж орж ирсэн гэж ойлгож байгаа. Би ч энэ үүднээсээ ийм хүсэл эрмэлзэлтэй орж ирсэн гэж ойлгож байгаа. Авлига хээл хахуультай ямар ч аргаар тэмцэж байсан энэ тэмцэлтэй хөл гараа нийлүүлээд зүтгэнэ л гэж ойлгож байгаа юм.

Гэтэл амьдрал дээр иргэдийн дунд хүлээлт байна уу байна. Итгэл алдарч байна уу гэвэл алдарч байна. Хоосон ярьсан парламент, хоосон ярьсан Засгийн газар болж хувираад байна. Үр дүн гарахгүй байна, хариуцлага хүлээхгүй байна, хариуцлага нэхэж байна л гэж ярьж байгаа. Тийм учраас цаашидаа үнэхээр авлигыг ахиад шинэ шатанд гаргахын тулд, шударга ёсыг бий болгохын тулд үнэхээр ахиц өөрчлөлт гарна гэж үзэж байгаа авлигын шүүхийг байгуулахыг нь бол хоёр гараа өргөөд дэмжихэд бэлэн байна, бэлэн байна.

Хэлэлцэх эсэх дээр шүүхийнхний саналыг сонссон ямар нэгэн Үндсэн хууль болоод бусад хууль тогтоомжид харшлах зүйл байхгүй гэж үзэж байгаа

юм. Тайлбараа өгч байсан. Нэлээд олон тэрбум төгрөгийн асуудал яригдах юм байна. Энийг гаргаад шүүхийг байгуулаад ингээд үр дүн гарч байвал энэнээс илүү мөнгөөр хэмжигдэхгүй ийм үр ашигтай ач холбогдол гарна л гэж үзэж байгаа юм. Тийм учраас би бол энэ дагасан тогтоолоор байгуулж байгаа хийх гэж байгаа энэ авлигын шүүх байгуулах энэ чиг үүргийг бушуухан Засгийн газарт нь өгөөд энэ асуудлыг нь шийдээд тэр ямар хонгил байгуулна уу, үгүй юү энэ чинь мэдээж энэ асуудлыг ярихаар л нэг хэсэг нь өөрсдийгөө өмгөөлж л гарч ирнэ шүү дээ. Би авлига авсан гээд гараа өргөөд гүйхгүй нь мэдээж.

Тийм учраас энийг булзааруулах гэж, бүдгэрүүлэх гэж, нэг хонгил байгуулах гэж байна гэж, нэг хэсэг хүмүүсийг хэлмэгдүүлэх гэж байна гэж ингэж ярьж байгаа бол биш юм. Тийм учраас энэ асуудлаа хурдан яаралтай шийдээд явах нь зүйтэй л гэж би хувьдаа үзэж байгаа.

Харин Шүүх байгуулах тухай хууль дээр хялбар ажиллагааны маргаан хэрэг маргааныг нийслэлийн хэмжээнд нэг байгуулах, давахыг нь улсын хэмжээнд нэг байгуулахаар оруулж ирж байгаа юм. Энэ төрлийн зөрчил, хэрэг маргаанууд чинь бол нийт шүүгч нарын хэргийн ачаалал дээр асар их.../минут дуусав./

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулах уу. Шүүхийн ерөнхий зөвлөл Онончимэг, Ренчиндоржийн Онончимэг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга 81.

Р.Онончимэг: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Онончимэг байна. Хялбар ажиллагааны шүүхийг нийслэлийн хэмжээнд 1 дагнуулж байгуулахаар, Давж заалдах шатыг бол Хялбар ажиллагааны шүүх гэж байгуулахгүй. Ийм зохион байгуулалтаар оруулж ирсэн. Сандаг-Очир гишүүн

Байнгын хорооны хурал дээр алслагдсан дүүргийн хувьд бол бас харьяаллыг нь анзаарч хараач гэсэн ийм саналыг хэлсэн. Энийг бол ажлын хэсэг дээр яриад явах бүрэн боломжтой байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг юуны өмнө дэмжиж байгаагаа илэрхийлье. Тэгээд бас сая Ерөнхий сайд маань хэлсэн үгэндээ бид нар ирээдүй хойч үеэ авлигын асуудлаас ангид байлгах, бид хойч үедээ нүүр бардам алхах тэр ирээдүйг нь бий болгохын төлөө энэ авлигатай холбоотой асуудлыг шийдвэрлэдэг байх, авлигаас ангид байх тэр бүхий л алхмуудыг хийх ёстой гэдэг үгийг бас онцлон хэлснийг би бас дахиж дурдмаар байна. Бас энэ хуулийг өргөн барьсан Хууль зүйн яам болон Засгийн газрын гишүүддээ бас талархлаа илэрхийлье. Улсын Их Хурлын энэ танхимд өшөө авлигалын асуудлыг бид нар эрчтэйгээр шийдвэрлэх тэр хүсэл сонирхлоор бас сууж байгаа гэдгийг бас гишүүд маань удаа дараа хэлж байна. Түүний нэгэн адилаар энэ шүүх байгуулах асуудлыг бас дэмжиж байна.

Ер нь яг өнөөдөр шүүхийн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн ажлуудыг үгүйсгэх аргагүй. Шүүх нээлттэй байх, ил тод байх, иргэдийн төлөөллийг оролцуулах, шүүхийн мэдээлэл, хурлын мэдээллийг хэрэгт холбогдсон болон бусад бүхий л өмгөөлөгч хамаатай бүхий л иргэдэд нээлттэй байлгах тэр боломжийг шүүх бас хангаж өгч байгаа гэж ойлгож байгаа.

Гэхдээ яг өнөөдөр шүүхийн үйл ажиллагаанд бас асуудлууд байгаа гэвэл байгаа. Бид нар сая 2024 оны төсвийг хэлэлцэх явцдаа ч гэсэн ер нь шүүхийг илүүтэй цахимжуулах, орон байртай

болгох шүүх бүрэлдэхүүний ажиллах тэр боломжийг нь бий болгоход ер нь яаж анхаарах вэ гэдэг дээр бас төсвийн асуудлыг хэлэлцэж байсан. Яг өнөөдрийн байдлаар орж ирж байгаа энэ хууль дээр шүүхийн бүтцийн тодорхой хэмжээний өөрчлөлт орж байна гэж бодож байна.

Өөрөөр хэлэх юм бол тойргийн бүсчлэлтэй байсан шүүхийн асуудлыг аймаг, орон нутагт бүхэлдээ бие даан шийдвэрлэх тэр боломжийг нь нээж өгч байгаа юм байна. Шүүгчдийн хүний нөөцийн асуудал ер нь ямар хэмжээнд байгаа юм бол. Аливаа асуудлыг тойргийн журмаар шийдвэрлэх тэр цаг мөчид нэг хэргээс нөгөө хэрэг рүү очих шүүх хуралдааныхаа явцад унаа машины зардлаас авхуулаад л цүнхээ барьчхаад л хэргийн материалаа бараг замдаа унидаг хэмжээний шүүгч нарын маань нөөц, боломж хомс байдаг гэдэг ийм мэдээллийг сонсож байсан. Шүүгчдийн цалин их л өндөр юм шиг ярьдаг боловчиг яг өнөөдөр шүүгч нарын шүүгчдийн гар дээрээ авч байгаа цалин бас тийм өндөр биш гэдэг мэдээллийг бас шүүгчид өгдөг. Хүний нөөцийн асуудал болон цалин мөнгөтэй асуудал ер нь яаж шийдвэрлэгдэж байгаа юм бэ гэдэг зүйлийг асуух гэсэн юм.

Нөгөө талаар аливаа шүүх маргааныг эцэслэн шийдвэрлэх энэ явцад хэрэгт холбогдогч болон яллагдагч, сэжигтэн, саатуулагдаж байгаа иргэдийг иүүд хорих байрнаас гэдэг юм уу, саатуулах байрнаас шүүх хуралдаанд оролцуулах тэр цахим технологи өнөөдөр хөгжсөн үү үгүй, юү. Энэ дээр ер нь ямар боломж байна вэ гэдэг дээр бас нэг зүйлийг асууя.

Хоёрдугаарт шүүхийн байрны асуудал хүндрэлтэй байдаг. Коридорт бараг шүүх хурлаа явуулах нь холгүй, хэрэгт хамаатай сэжигтэн этгээдээ дэргэдээ суулгаж байгаад л алх цохих хэмжээний ийм байрт нь асуудал ер нь аливаа шүүхийн асуудал дээр яригдаж байдаг. Энэ асуудлыг бид шийдвэрлэж

чадах уу. Төсөв мөнгөний асуудал ер нь ямар хэмжээнд орж ирж байгаа юм. Олон нийтэд бас мэдээлэл өгөөч.

Нөгөөтээгүүр Гэр бүлийн тухай хууль хэлэлцэгдэж байгаа энэ цаг мөчид гэр бүлийн шүүх Давж заалдах шатын шүүх Улаанбаатар хотод ганцхан байна гэдэг зүйл орж ирж байна. Шүүгчид маань мэргэисэн байх. Энэ асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл болон бусад байгууллагууд ер нь хэрхэн яаж авч үздэг юм бэ. Гэр бүлийн маргаан нь ямар нэгэн байдлаар хүүхэдтэй холбоотой асуудал давж задаллаа гэхэд заавал нийслэл хотод ирэх ийм асуудал үүсэж байгаа юм шиг байна. Энэ дээр бас тайлбар өгөөч ээ. Асуултууддаа хариулт авчхаад тодруулъя.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна. Ерөнхий зөвлөлийн дарга Ренчиндоржийн Онончимэг 81.

Р.Онончимэг: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Шүүх байгууллагатай холбоотой хамгийн тулгамдсан асуултуудыг бас хөндөж асууж байна гэж бодож байна. Шүүхийн хүний нөөцийн асуудал шүүгчийн орон тооны асуудал бол нэлээн их тулгамдсан. Хэдийгээр 2016 онд 699 шүүгчтэй байхаар Улсын Их Хурлаас тоог тогтоож байсан боловч өнөөдрийг хүртэл бүрэн орон тоогоороо ажиллаж чадаагүй. Ингээд шүүгчийн ачаалал бол нийслэлийн хэмжээнд их өндөр болчихсон яг явж байгаа.

Шүүх байгуулах хуулиар бид нийт 739 шүүхтэй байхаар тооцоолж орж ирсэн. Энэ нь яагаад 699-өөсөө нэмэгдсэн бэ гэхээр орон нутгийн Давж заалдах шатын шүүхүүдээ бид нар хуучин хэвээрээ байхаар Засгийн газар тооцоолж бас саналыг хэлсэн. Ингээд бид нар тооцооллуудыг хийхээр орон нутгийн Давж заалдах шатын шүүхүүд ер нь орон нутгийн шүүхүүд дээр ийшээ тийшээ томилолтоор явахгүй, бүрэн

бүрэлдэхүүнтэй байх зорилгоор энэ орон тоог бас нэмж оруулж ирсэн байгаа. 2024 оны төсөвт 600 шүүгчийн орон тоотой байхаар тусгасан. Гэсэн хэдий ч 5 дахь удаагийн сонгон шалгаруулалт явж байна. Шүүгчийн орон тоог нөхөх байдал бас нэлээн их хүндрэлтэй байна. Энэ ачаалал, цалин хангамжтай холбоотой гэдгийг бас шүүхийн төсөв ярьж байхад удаа дараа хэлсэн.

Дараачийн нэг асуудал бол шүүхийн цахимжилт байгаа. 10 хэдэн жилийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжилтын ийм түүхүүд эрүү, иргэн, захиргааны хэрэг дээр явж байна. Гэсэн хэдий ч энэ системүүд маань хоорондоо уялдаа холбоо байхгүй, байнгын төсөв жил болгоны төсөв дээр тавигдаж ирээгүйгээсээ болоод шаардлага хангах иргэн талаасаа үйлчилгээ авах ийм боломж, нөхцөл бол хангалтгүй байсан. 2024 оны төсөв дээр Их Хурлаас Засгийн газар, Их Хурлаас шүүхийн цахимжуулалтын талаар нэлээн сайн хангалттай төсөвт тавьж өгсөн. Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн зүгээс 24 онд энийг зохион байгуулж, бүрэн энийг шийдэх зорилгоор төлөвлөж ажиллаж байна.

Гуравдугаарт шүүхийн байрны асуудал шүүх нийслэлийн хэмжээнд тойргийн баруун, зүүн бүс гэж эрүү, иргэний хэргээр тойроглож байгаа. Тэгэхээр энэ шүүхийн байрны асуудлыг нэн яаралтай шийдэхгүй бол хэд хэдэн байр дээр энэ шүүхийн тойроглолт тавигдахаар эргээд л эргэн талаасаа харах юм бол олон байр руу иргэд чирэгддэг энэ байдал маань угаасаа үүснэ. Тэгэхээр хуулийн төсөл дээр төр хувийн хэвшлийн түншилэл гэж орж ирж байгаа. Энэний төсөвжилтийг нь Засгийн газар газарт шийд гэсэн чиглэлийг бас тогтоолын төсөлтэй орж ирж байна. Гэсэн хэдий ч энэ 25 оны төсөв дээр сууж байж энэ хэрэгжих ийм боломжтой байгаа. Тэгэхээр Шүүх байгуулах тухай хуулийг хэрэгжих хугацаан дээр бас анхаарч бас ажлын

хэсэг гарахад яг ярих байх гэж бодож байна.

Гэр бүлийн шүүхийн тухайд нийслэлийн хэмжээнд бид дагнасан шүүхээр, Давж заалдах шатаа улсын хэмжээнд байхаар ингэж оруулж ирсэн. Энэ жишиг өмнө нь захиргааны хэргийн дагнасан шүүх дээр байсан. Одоо.../минут дуусав./

Г.Занданшатар: Болсон. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас Шүүх байгуулах тухай хуулийг Улсын Их Хурал өргөн мэдүүлж хэлэлцэж байна. Оюун-Эрдэнийн Засгийн газар авлигатай тэмцэх энэ 30 жилийн хугацаанд энэ Монголын төрд авлигажсан энэ төрийн өмч хөрөнгийг хулгайлдаг, луйварддаг, энэ асуудалтай нэлээн тэмцэл хийж бас тодорхой асуудал шийдэхийн төлөө бас хичээл зүтгэл гаргаж ажиллаж байгаа гэдгийг үгүйсгэх арга байхгүй. Энийг бид дэмжээд, шийдээд явах ёстой гэсэн ийм асуудал байна.

Тийм учраас энэ авлигатай тэмцэх, авлигын хэргийг шийдэх энэ шүүх эрх мэдлийг шударга байлгах, шүүх эрх мэдэл, хууль дээдлэх зарчмын хүрээнд энэ авлигачдыг өмгөөлдөг, хамгаалдаг, лоббинд хутгалдсан, авлигад хутгалдсан ийм асуудал байж болзошгүй гэдгийг энэ иргэд өнөөдөр Засгийн газрын энэ байр суурь бол бас зарим талаар бас зөв дүгнэлтээ гэсэн ийм байр суурьтай байна.

Тэгэхдээ бид бол өнөөдөр энэ Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийн байгууллага бол Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд бид батлагдах уу, аль эсхүл энэ цаг үед тулгарсан асуудлыг шийдэх шийдлийн хүрээнд Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд зөрчилдсөн асуудал шийдэх үү гэдэг ийм салаа замын үзүүрт ирсэн

ийм байдал харагдаж байна гэж миний бие бодож байна.

Хүний эрх эрх чөлөө давж заалдах эрхээр хангах асуудал Үндсэн хуульд суусан байгаа. Энэ асуудал чинь одоо яг хөндөгдөж байна. Энхбаяр сайд бид бол Монгол Улсын шүүхийн тухай хуулийг батлахад бас парламентын зарчмын хүрээнд итгэл үнэмшил үзэл бодлоо маргаж шийдэж байсан. Энхбаяр сайд бол Дээд шүүх бол хэрэг маргаан шийдэхгүй, онол судалгааны шүүх байна гэдэг ийм асуудлыг шүүхийн хуулийн хэлэлцүүлгийн хувьд үндэслэлтэйгээр тайлбарлаж, энийг бол хамгаалж байсан энэ асуудал өнөөдөр Улсын Их Хурлын хууль хэлэлцсэн түүхэн баримтад байгаа.

Гэтэл өнөөдөр яагаад заавал Давж заалдах шатын шүүх хяналтын шатын шүүх хэрэг маргааныг шийдэх энэ асуудал гарсан гэдэг асуудал байна. Нөгөө талаасаа энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд энэ авлигын хэргийг шийдвэрлэх тийм тусгай журам гэдэг ийм юм оруулж ирсэн байна. Энэ журам гэдэг чинь юу гэж ойлгох вэ. Хуулийн асуудлыг журмаар шийдвэрлэж болох уу. Аливаа нийгэмд гарсан тэр авлигатай тэмцэх зөв. Тэгэхдээ энэ журмаар шийдвэрлэнэ, 1 жилийн хугацаатай шийдвэрлэнэ гэдэг энэ чинь ямар асуудал вэ. Энд ямар бодлогын үүднээс, ямар хууль, эрх зүйн үүднээс ийм асуудал оруулж ирж байна гэдэг талаар бас тайлбар авах шаардлага гарсан байна гэж ойлгож байна.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Энэ шүүх байгуулах хууль бол Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд орж ирж байгаа. Улсын дээд шүүх нь хуулиар харьяалуулсан тодорхой хэрэг маргааныг давж заалдах шатын журмаар шийдвэрлэж болно гэдэг заалт Үндсэн хуульд байгаа. Тийм учраас энэ

дээр Үндсэн хуулийн зөрчил нэгдүгээрт үүсэхгүй гэж үзэж байгаа. Шүүх байгуулах шүүхийг зөвхөн хуулиар байгуулна гэж мөн Монгол Улсын Үндсэн хуульд байгаа.

Тийм учраас бид хуулийн төсөл оруулж ирж байгаа. Шүүх байгуулах хууль маань уг нь бол Монгол Улсын их олон шүүхийн асуудлыг л зохицуулсан өөрчлөлт орж ирж байгаа юм л даа. Ингээд цочдог юм уу, яадаг юм, ерөөсөө авлигын шүүхийг нь л яриад байгаа юм. Энэ анхан шатын шүүх жишээлбэл хөдөө аймгуудад бол Эрүүгийн хэргийн шүүх, Иргэний хэргийн шүүх байгаа байхгүй юу. Энийг бид нэгтгээд анхан шатын 90 шүүхтэй байгааг бид 61 шүүхтэй болохоор бас оруулж ирж байгаа. Гэр бүл хүүхдийн шүүхийг тойргийн журмаар Нийслэл Улаанбаатар хотод байгуулъя гэж байгаа. Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатын шүүхийг бас байгуулъя гэдэг ийм өөрчлөлтийг оруулж ирж байгаа. Тойргийн журмаар байгуулах дээр мөн Орхон-Уул, Дархан-Уул аймгийн шүүх, Эрүү иргэний бие даасан шүүхүүдийг нэгтгээд 1 шүүх болгоод энэ болгон маань бас шүүхэд байгаа тодорхой хэмжээний ерөнхий шүүгчдийн тоо буурах юм байгаа юм. Шүүх бол ингээд томрох биш эсрэгээрээ ингэж нэгтгээд тэр шүүх болгонд байсан Тамгын дарга нарын чинь орон тоо жишээлбэл 2 дахин шууд буураад явчих байхгүй юу.

Тийм учраас энэ шүүхийн зардал мөнгөтэй холбоотой асуудлыг ярихдаа бид нар бас ийм зохих ийм данхар байдал дээр нь бас багасгах ийм хувилбаруудыг бас оруулж ирсэн байгаа юм. Таны тэр хөндөж байгаа тусгай журам үгүй үгүй тэр хүн айгаад байх тийм журам биш. Тэр нөгөө 30, түрүүн ч бас зарим гишүүд хэлээд байсан. Энэ тусгай журам гэдэг юмыг нь болохоор энэ чинь Эрүүгийн процессын хуульд байгаа журмаа л хэлээд байгаа юм. Хуулиас халиад ийм яг авлигачдыг нь тусдаа нэг ийм лифтэнд

орлуулаад л, тусдаа ингээд гудам гаргаад л ингээд л шийдэх гээд байна л гэж бодоод байх шиг байгаа юм даа. Энэ ерөөсөө тийм юм байхгүй байгаа юм шүү дээ уг нь хуульд нь.

Г.Занданшатар:

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууя.

Ш.Адьшаа: Энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гээд энэ 5 дугаар зүйл дээр нь ингэж байгаа байхгүй юу. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т заасан буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17 дугаар бүлгийн 2 дугаар дэд бүлэгт заасан авлигын хэрэг хянан шийдвэрлэх тусгай журамтай холбоотой зохицуулалтыг 2024 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд 25 оны 1 сарын 1-ний өдөр хүртэл буюу авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэхэд тухай дагнасан шүүх байгуулагдах хүртэл хугацаанд үйлчилнэ л гээд энэ нь яагаад ингэж 1 жилийн хугацаанд ийм юм яагаад байгаа юм бэ гэдэг асуудлыг л би асуугаад байгаа юм. Тэрнээс биш энэ чинь 1 жилийн хугацаатай ч юм уу ийм асуудал байж болдог юм уу энэ эрүүгийн хэрэг, энэ эрүүгийн холбоотой асуудал чинь. Эрүүгийн шүүх тогтолцооны асуудал байна шүү дээ. Энэ дээр л би хариулт авъя л гээд байгаа юм л даа Энхбаяр сайд.

Г.Занданшатар: Баттөмөрийн

Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Энийг Их Хурал дээр бас ажлын хэсэг гараад ярилцъя гээд түрүүн Их Хурлын дарга ч бас хэлж байна. Ер нь манай олон гишүүд ярьж байна. Би ч гэсэн бас тэгж сайн ярих нь зүйтэй л гэж бодож байгаа. Тэх олон талаас нь сайн ярих хэрэгтэй гэж л ингэж үзэж байгаа. Хууль тогтоогч эцсийн шийдвэр гаргана.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхийдөө орж ирж байгаа төслийг дэмжиж байгаа. Энэ авлига, авлигын хэрэг шийдэгддэггүй энэ ард иргэд бухимддаг, гарч байгаа шийдвэрүүд нь бас итгэл үнэмшил муутай. Хэдэн их наяд тэрбумаараа олдсон, асгасан юм ярьдаг. Торгууль нь 10, 20 сая төгрөг гээд жишээ бол олон бий. Ер нь зүгээр энэ шүүхийн цаашидаа энэ системийг шинэчлэх реформ хийх энэ алхмууд хийж эхэлж байгаа юм байна гэж ингэж ойлгож байгаа. Энэ зөв үү Энхбаяр сайд аа. Ер нь цаашидаагаа жишээлбэл бид нар энэ дагнасан шүүхүүд бий болгож ялангуяа энэ яг гэрээ хэлэлцээтэй холбоотой хэрэг дээр ер нь ялангуяа энэ бизнесийн гэрээ хэлэлцээтэй холбоотой дээр бас нарийн мэргэшсэн шүүгчид их шаардлагатай байдаг юм шиг байна лээ.

Дээрээс нь энэ хэргүүд бол овоорчихсон ард түмэн бол ард иргэд энэ хэрэг нь удаж байгаа энд их хөнддөг учраас энэ шүүгчид маань тооны хувьд ер нь бас аргагүй цөөдөөд байгаа юм тал байдаг байх. Тэгэх дээр энэ дээр бас энэ алхам алхмаар энэ шүүгчдийнхээ тоог нэмэх, цаашидаа энэ чиглэл чиглэлээрээ мэргэших энэ чиглэл рүү нь бол бас харж хандаж ажиллаж байгаа байх гэж бодож байна.

Ер нь цаашидаа энэ авлигалын хэрэг гэдэг асуудал өөрөө санхүүгийн нарийн мэдлэг шаардлагатай, нарийн арга баригдахгүйн тулд, ялангуяа энэ авлига авч байгаа нөхдүүд бол санхүүгийн янз бүрийн арга хэрэгсэл хэрэглэдэг. Тэгэхээр энэ чиглэлээр бол хангалттай мэргэшсэн ийм шүүгчид байдаг юм уу манайд хангалттай юу энэ тал дээр нэгдүгээрт нэг ийм асуулт байна.

Хоёр дахь нь бүүр яг тодорхой асуулт. Хөдөө орон нутагт энэ анхан шатын шүүхүүдээ жоохон цөөхөн тоо

яригдаж байгаа юм байна. Бараг 30-аад шүүх цөөлөх юм уу тэгээд. Энэ газар зүйн байрлалын хувьд бол энэ алслагдсан хөдөө орон нутагт харьяалагддаг энэ шүүхүүдийн байршил, газар орон нутгийнхаа хэмжээнээс зам, төв замынхаа байрлал энэ тэрийг харж бодолцож байгаа юу гэж. Энэ ялангуяа манай Завхан аймаг бол их газар нутаг томтой, энэ дээр энэ сум дундын шүүх, тэгээд анхан шатын ялангуяа шүүхүүдийн байрлал их бас газар нутгийнхаа хэмжээтэй, бас хэмжээг нь харгалзаж үзэж бас та бүхэн тогтоож байгаа байх гэж бодож байна. Тэгэхээр одоогоор яг Завхан аймагт байрлаж байгаа шүүх дээр ямар өөрчлөлтүүд гарч байгаа юм. Энэ дээр та тодорхой хариулт өгөх үү энэ ажлын хэсгээс ийм л асуулт байна.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг хэн хариулах вэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Ренчиндоржийн Онончимэг, 81.

Р.Онончимэг: Бизнесийн хэрэг маргааныг, Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Бизнесийн гэрээ хэлцлийг шийдэх хэрэг удааширдаг, овоордог байдал арилах уу гэсэн асуулт эхнийх тавигдаж байна.

Ер нь нийслэлийн хэмжээнд хялбар ажиллагааны шүүх маань өөрөө иргэний, эрүүгийн гэсэн харьяалалтай байгаа. Иргэний хэрэг нь 11 сая төгрөг хүртлээ үнийн дүнтэй хэргүүдээ хялбар ажиллагааны шүүх дээрээ шийддэг байя. Тэгвэл нийслэлийн иргэний хэргийн шүүхүүдийн маань ачаалал нь 50 хувь буураад явчихаар бизнесийн гэрээ хэлцлүүд бусад шүүхүүд дээрээ ачаалал багасаад шийдэх бүрэн боломжтой гэж бид хэд харж байгаа. Ирэх 10 жил шүүхэд хэрэгжүүлэх ийм бодлогын баримт бичиг Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Энэ дээр ер нь шүүхийг цаашид дагнуулъя, мэргэшүүлье гэсэн ийм бодлогууд орж ирж байгаа. Тэгэхээр цаашидаагаа бас дагнасан, мэргэшсэн ийм

шүүхүүд бас байгуулах ийм бүрэн боломжтой болох байх.

Завхан аймгийн шүүхийн тухайд зүгээр зохион байгуулалтын хувьд ингээд байшин дотор Эрүүгийн хэргийн анхан шатын шүүх, Иргэний хэргийн анхан шатын шүүх, Захиргааны хэргийн анхан шатын шүүх гээд олон шүүх олон нэртэй шүүх л уг нь ажиллаад байгаа юм. Тэгэхээр иргэнд ойлгомжтой байх үүднээс илүү зохион байгуулалт нь илүү хялбар болгож иргэнд эрүү, иргэний ердийн шүүх дотроо танхимын зохион байгуулалтаар байх ийм зохион байгуулалтыг бид нар зөвшилцөж оруулж ирсэн байгаа. Энэ талаар бас ажлын хэсэг дээр ярих байх. Тоо ямар нэгэн байдлаар шүүх нь өөрчлөгдсөн, байршил өөрчлөгдсөн зүйл байхгүй. Тосонцэнгэлд өөрчлөлт байхгүй тийм. Тосонцэнгэлд өөрчлөлт байхгүй тийм хэвээрээ байгаа байгаа. Яг хэвээрээ байгаа.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна хаслаа. Сандагийн Бямбацогт гишүүн, хаслаа. Дашидондогийн Ганбат гишүүн хаслаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн хаслаа. Энэ 13 цаг болчихсон байна. 1.20 болчихсон байдаг. Цагаанхүүгийн Идэрбат алга байна. Жамбын Батсуурь алга байна. Жигжидийн Батжаргал дарга алга байна. Нямаагийн Энхболд алга байна.

Чуулганыг 14 цагт үргэлжлүүлэе. Тэгэхдээ ер нь гишүүд чуулганы ажиллагаанд идэвхтэй оролцоорой. Ер нь бол энэ авлигатай хийх тэмцлийг эрчимжүүлж эдийн засгийн тоон үзүүлэлтүүд сэргээж байгаа ч гэсэн энэ авлигатай эцэслэн хариуцлага тооцох асуудал удааширч байгааг нийтээрээ онцолж байна. Хэргийг бүрэн дүүрэн нэг мөр шалгаж цэгцлэхээс авхуулаад нотлох баримтыг бүрдүүлэх эцсийн шатад шүүхээр шийдвэрлэх хүртэл энэ бүх асуудал хамаарна. Энэ байдлыг олон улс олон нийт онцолж байгаа. Монгол Улсын

энэ авлигатай тэмцэх үнэлгээнд ч гэсэн нөлөөлж байгаа.

Ийм учраас Шүүхийн тухай хуулийг нухацтай хэлэлцэж батлах хэрэгтэй. Улсын Их Хурал авлигалын эсрэг эрх зүйн орчны шинэчлэлийг эрчимжүүлнэ гэж онцолсон. Энэ ч хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудыг баталж ялын бодлогыг чангатгасан. Өршөөл, уучлал үзүүлэхээс авхуулаад авлигалын хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгаж 12-оос 10 жилтэй эх орноосоо урвах ялтай үндсэндээ дүйцүүлж ялын бодлогыг чангатгасан. Өршөөл, уучлалд хамруулахгүй болсон.

Ер нь авлига албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа. Үүнээсээ илүү хамгийн гол нь Улсын Их Хурал өөрөө олон түмний хяналттай, ил тод байх багц хуулиудыг баталсан. Энүүгээрээ авлигал гэнэт гараад ирчихсэн юм биш, 30 жил бугшсан авлигал, хээл хахуулиуд илчлэгдэж байгаа. Энэ бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 28.1-д оруулсан нийтийн эрх ашгийг хөндсөн тодорхой асуудлуудаар Улсын Их Хурал мөрдөн шалгах буюу хяналт шалгалтын түр хороо байгуулж, нээлттэй сонгог зохион байгуулж, нотлох баримтыг үнэлж, дүгнэж, холбогдох байгууллагуудад шилжүүлэх ийм эрх зүйн зохицуулалтыг хийсэн. Үүний дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг анх Мөрдөн шалгах тухай хууль гэж баталсан юм. Улсын Их Хурлын мөрдөн шалгах тухай хууль гэж баталсан, санаачилсан. Хэлэлцүүлгийн явцад Хяналт шалгалтын тухай хууль болсон. Хяналт шалгалтын тухай хуулиар энэ батлагдаж эхлээд л 21 оны 12 сарын 24-ний өдөр батлагдаж эхлээд л 22 оны 1 сарын 1-нээс мөрдөгдөж эхлээд л энэ Хөгжлийн банкны ажлын хэсэг байгуулагдсан, энэ дуулиан дэгдсэн. Нүүрсний гэх асуудал Хөгжлийн банкны

асуудлаар түр хороо байгуулагдаж нотлох баримтыг үнэлэх нээлттэй сонсгол зохион байгуулсан. Энэ нүүрсний гэх асуудлаар 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Хяналт шалгалтын түр хороо байгуулагдсан юм шүү дээ. Тэнд л хянан шалгагч, мөрдөгч, эксперт томилж энэ нүүрсний экспортын хэмжээ гааль гарсан хэмжээнүүдийн хооронд зөрүү байгааг тогтоогоод, тэн дээр л нийтдээ 44 их наядын нүүрс экспортсон байна, олборлосон нүүрсний хооронд зөрүү байна. Энэ учраас хулгай байна гэсэн анхны дүгнэлт гараад л тэгээд л төсөв 22 оны 9, 10 сард төсөв хэлэлцэх үед энэ асуудлууд яригдаад л оффтейкийн гэрээг ил тод болгоё гэж яригдаад л. Их Хурал дээрээс л энэ асуудлууд ил тод байдлаар гарч ирсэн.

Харамсалтай нь энийг бас буруу, зөрүү тайлбарласан асуудал бий. Ингээд одоо л нүүрсний сонсгол энэ дунд нь саад учраад ингэж явсаар байгаад одоо нүүрсний сонсгол энэ 12 сард зохион байгуулагдах гэж байна. Үүгээр тэр үед яригдаж байсан бүх тоо баримтууд яригдана. Энэ бүхэн ингээд Улсын Их Хурал, Засгийн газрын хамтын тэмцлийн үр дүнд авлигатай хийх тэмцэл эрчимжиж олон жил бугшсан идээ бээрүүд шахагдаж илүү тод болж үүний үр дүнд эдийн засгийн тоо үзүүлэлтүүд сайжирч байна. Энийгээ эцсийн үр дүнд хүргэхийг ард түмэн шаардаж байна.

Ийм учраас энэ хэргүүдийг 3 шатын шүүхээр шийдэгдэж байгаа. Энэ асуудлуудыг тэгэхдээ Үндсэн хуульд эрх зүйнхээ энэ зарчимтай нийцүүлээд олон асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай. Энэ дотор эрүү, иргэнийг нийлүүлчихээр орон тоо хэмнэж байгаа юм шиг боловч энэ танхимууд нь тусдаа байх юм уу? 1 жилийн хугацаатай процесс маань Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, одоо энэ байгаа хэрэг анхан шатын шүүх дээр байгаа хэрэг энэ тэрийгээ яах юм гэх мэтчилэн олон асуултын тэмдгүүд гарч байгаа.

Тийм учраас нуухыг нь аваад, нүдийг нь сохолж болохгүй. Ялаа алах гэж байгаад гэрээ шатааж болохгүй. Тийм учраас энэ авлигатай тэмцэх тэмцлийг илүү үр дүнд хүргэх олон улсын шахалт шаардлага бол энэ иргэний нийгэм, олон түмнийг хяналтад оруулах л явдал байгаа. Бүх мэдээллийг хувийн, Нийт мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг баталсан. Ингэснээр бүх мэдээлэл ил тод болсон. Одоо төрийн санхүүгийн цогц реформ хийж төрийн оролцоог багасгаж, энэ элдэв сангуудын ард түмнийг хяналтад оруулж байж энэ ажлууд сайжирна.

Тэгэхээр авлигатай тэмцэх тэмцлийн хамгийн гол үр дүн энэ төр түмэн нүдтэй гэдэг чинь ард түмэн түмэн нүдтэй, энэ ил тод байдлыг бий болгож Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Түр хорооны хууль ийм олон асуудлуудаар энэ зохицуулалтуудыг хэрэгжүүлж байгаа шүү дээ. Ингэж байж бид энэ авлигатай тэмцэх амжилтад хүрнэ. Ийм учраас Засгийн газар, Ерөнхий сайдын авлигатай хийх тэмцлийг бид нийгмийн идээ бээр гэж үзэж, бүрэн дүүрэн дамжиж ажиллана. Энэ хэлэлцүүлэгтээ идэвхтэй оролцох хэрэгтэй. Тийм учраас 14 цаг хүртэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг завсарлуулж байна.

13.25 цаг

Пүрэв гараг 30 Арваннэгдүгээр сар 2023
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 09 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Сая гишүүдийг хүлээж байлаа.
Ажлын хэсгийг оруулъя. Одоо

Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна. Дараа нь Дашидондогийн Ганбат гишүүн асууна. Ажлын хэсгийг оруулсан уу. Батжаргал гишүүн ажлын хэсгээс асуух уу, сайдаас асуух уу. Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсэг яасан. Үдээс хойших нэгдсэн хуралдааныг эхлүүлчихсэн байгаа.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар цаг үеийн шинжтэй мэдээлэл сонсох байсныг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу маргааш өглөө хүртэл хойшлуулахаар албан бичиг, саналууд ирсний дагуу маргааш өглөө хүртэл хойшлуулсныг мэдэгдье. Маргааш 10 цагаас цаг үеийн шинжтэй мэдээлэл сонсоно. Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаар өвөлжилтийн асуудлаар маргааш 10 цагаас мэдээлэл сонсоно.

Одоо хэлэлцэх асуудлаа үргэлжлүүлнэ Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна. Асуулт, хариулт үргэлжилж байгаа.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр Шүүх байгуулах тухай хуулийн төсөл орж ирж байгаа. Үүн дээр үзэл баримтлалынх нь хувьд дэмжиж байна гэж. Ер нь бид энэ шүүхийн хараат бус бие даасан байдлыг хангах, шүүхийг шударга ёсны хүсэмжлэлд нийцэж ажиллах талаар нэлээн олон ийм жил ярьцаагаад Шүүхийн хуулийн шинэчилсэн найруулга батлагдаад, шүүх шүүгчдийн хараат бус байдал, хамтын удирдлагын тогтолцоо, Ёс зүйн хороо энэ тэр гээд дотоод хяналтынх нь чиглэлтэй асуудлуудыг эрх зүйн хувьд зохицуулж өгсөн. Энэ хүрээнд манай шүүхийн байгууллага дээр ер нь эрх зүйн хувьдаа хэр үйл ажиллагаа явуулахад нийцтэй ийм бололцоо, боломж бүрдсэн юм гэдэг асуудал байгаад байгаа юм. Олон жил яригдсан энэ их дуулиантай хулгай, авлига, албан тушаалын гэмт хэргүүд шийдэгдэхгүй байх, цаг хугацаа их авч байгаа явдал энэ чухам яг юунаас

болоод байгаа юм бэ. Хууль зүйн сайд юу гэж дүгнэж байгаа юм. Энэ манай шүүхийн байгууллагынхан юу гэж дүгнэж байгаа юм бэ. Энэ юунаасаа болоод болохгүй байгаад байгаа юм. Энэ дээрээ тодорхой хариулт тайлбар өгөөч гэж. Нийгмийн сэтгэл зүй, хүсэмжлэл бол энэ болж бүтэхгүй байгаад байгаа юмнуудынхаа уг үндсийг тастах тухай л ярьж байгаа. Тэгэхээр эрх зүйн орчны тухай асуудал байгаад байна.

Дараагийн нэг зүйл нь тэр гэм буруутай нөхдүүдэд таарсан ял зэмийг нь оногдуулах тухай асуудал яригдаад байгаа юм.

Гурав дахь ярьж байгаа зүйл бол энэ улс, нийгэмд учруулсан хохирлыг нь төлүүлэх тухай л асуудал яригдаж байгаа юм. Тэгэхээр энэ хүрээнд л бид нэлээн анхаарал хандуулж ажиллах зайлигүй шаардлага байгаад байгаа. Тэгэхээр энэ авлигал бас тодорхой хулгай нүүрэлдсэн салбар юмнууд их тодорхой байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр үүний дээр тулгуурлаад тэр гараад байгаа гэмт хэрэг эл элдэв бусын юмнуудыг арилгая гэвэл цаад эрх зүйн үндэс нь өөрөө их зөв болох ёстой юм.

Тийм учраас миний ойлгож байгаагаар тэр Өмчийн тухай хууль төрийн өмчийн тухай хууль, энэ Худалдан авах ажиллагааны тухай хууль, энэ хил гаалийн чинь тухай асуудал ер нь энэ төрийн өөрийнх нь шилэн тунгалаг байх тухай л асуудал байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр үүнийг ер нь Хууль зүйн сайдын хувьд ер нь юу гэж ойлгож, энэ эрх зүйн шинэтгэлийн асуудлыг ер нь хэзээ, яаж оруулж ирж шийдлүүдийг нь гаргуулах ёстой юм бэ. Үүний цаана дахиад ярихаар зэрэг заяагдмал баялаг дээр тулгуурлагдсан хуулийн этгээдүүд тэрийг тойрсон хулгай зэлгий, шахаа янз бүрийн юмнууд яригддаг. Тэгвэл үүнээс гардаг ийм ард түмний хяналт оролцооны тухай асуудал нэг, нөгөө талдаа үр өгөөжөө дээшлүүлэхийн төлөө оролцогч талууд хамтдаа зөв

менежмент, өртөг зардал бууруулахын тухай л асуудал яригддаг. Тэгэхээр энэ тал дээр ер нь ямар бодол юу байна. Энийг би бас нэлээн их хүлээгээд байгаа юм. Энэ болж өгөхгүй байна. Энэ юунд байгаад байгаа юм гэж.

Дараагийн нэг зүйл эрх мэдлийг өгч болдог. Тэр хамаагүй болно. Хамгийн гол нь энэ эрх мэдэл хуваарилалт дээр хяналт тэнцлийн тухай л асуу.../минут дуусав./

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн, сайд.

Б.Энхбаяр: Батжаргал гишүүний хөндөж тавьж байгаа энэ эрх мэдлийг хуваарилахад “чекс энд баланс”-ын /checks and balances/ зарчим маш чухал. Энийг хууль тогтоомжоор их нарийн процесстой хуульчлах ёстой. Бид өнөөдөр бол яг шүүх байгуулах хуулийг ярьж байгаа. Шүүх эрх мэдэл гэж ярих юм бол энэ өөрөө их өргөн агуулгатай болно. Өөрөөр хэлбэл их олон оролцогчтой. Мөрдөх алба, түүнийг хяналт тавьж нотолгоожуулах ажлыг шүүхийн өмнө аваачиж байгаа прокурорын тогтолцоо, хяналттай холбоотой асуудлууд, шүүхийн гаргаж байгаа шийдвэрийн асуудлууд, шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудлууд гээд их өргөн цар хүрээнд асуудал яригдана.

Тийм учраас яг энэ агуулгаар нь эрх зүйн шинэтгэлийг цогц харж хийх ёстой гэдэгтэй би санал нэг байдаг. Ер нь бол ийм үе шаттай л энэ асуудлуудыг оруулж ирье гэсэн бодолтой байгаад байгаа юм. Яагаад гэхээр нэг амьсгаагаар хийхээр систем өөрөө өөрийгөө бас хамгаалдаг систем бодитойгоор оршоод байгаа юм. Тэгэхээр нэгэн зэрэг ийм олон дайсан босгоод, дайснууд чинь бол зовлон дээрээ нэгдчихдэг нэг зовлонтой болчихно.

Тэгээд энэ аливаа шинэтгэл, реформуудыг нураах, үгүйсгэх, зогсоох, гацаах ийм асуудал үүсдэг Тийм учраас

би бас өмнө нь Эрүүгийн процессын хууль дээр хэлж байсан. Энийг би үе шаттай 3, 4 хувааж оруулж ирэх бодолтой байгаа гэж яриад байгаагийн цаад нюанс бол бас энэ байгаа юм. Гэмт хэргийг илрүүлэх гэдэг нь илээр ч илрүүлнэ, нууц далд аргаар ч илрүүлнэ. Энийг нотлох баримтын хэмжээнд үнэлэх энэ түвшиндээ хүний эрх зөрчигдөхгүй байх гээд их олон асуудалтай холбогдоно л доо.

Жишээлбэл Англи-Саксоны эрх зүйн тогтолцоотой улсуудад та асууж байна. Энэ шүүх хурлууд яагаад их удаан хойшлоод байгаа юм бэ гэж. Англи-Саксоны тогтолцоотой улсууд жишээлбэл анхан шат давах, хяналтын шатны шүүхүүдэд хэргийг өмгөөлдөг өмгөөлөгчид нь тус тусдаа байдаг. Жишээлбэл А гэж өмгөөлөгч байлаа гэхэд анхан шатан дээр явж байгаа хэргүүдийг л өмгөөлнө. Б гэдэг хүн бол давж заалдах шатны явж байгаа хэргүүдийг өмгөөлнө. Нэг шүүгч анхан, давах, хяналтын шатанд 3 үе шатанд гурвууланд нь хэрэг өмгөөлдөггүй ийм тогтолцоотой улс байна. Энэ нь өөрөө хэрэг шуурхай шийдвэрлэхэд нөлөөлнө. Одоо жишээлбэл би ганцхан жишээ хэлэхэд энэ нүүрсний хэрэг дээр хойшлоод байгаа хэрэг дээр гэхэд 1 хүн нь 20 хэдэн өмгөөлөгчтэй байгаа байхгүй юу. 20 хэдэн өмгөөлөгч нэг дор цуглана гэж ингэж аягүй хэцүү. Хурал хойшлоод байдаг.

Г.Занданшатар: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хойшлуулдаг заалтуудыг ярьж байна. Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Өнөөдөр энэ шүүхийн талаар бид нар ярилцаж байна. Үүний цаана авлига байгаа юм. Авлигаараа ямар шуухан байдалд орсон бэ гэдгийг бүгдээрээ бид нар мэдэж байгаа л даа. Энэнтэйгээ 8 жил тэмцээд амжилт олсонгүй. Энэ дагнасан шүүхийг байгуулж болно. Байгуулж байгаа ямаршуухан орнууд байгаа билээ. Дайн

байлдаантай Европын ганц нэг орон байгаа байх. Тэгээд Исламын шашинтай орнууд гэх мэтчилний ийм хэдхэн орон байгаа. Байгууллаа гэж бодоход үр дүнтэй ажиллах ёстой. Хууль зүйн байнгын хороон дээр бид нар ярьсан. Энэ авах ёстой байгууллагуудаас саналыг нь авсан уу, үгүй юу. Засгийн газар маань, энэ олонх маань авлигатай тэмцэнэ гэсэн ийм эр зориг байгаад маш их баярлаж байна. Бид нар бараг та бүхний энэ ярьж байгаа цогтой цогтой үгсийг маш удаан хугацаанд сонслоо. Улсын Их Хурал энэ Засгийн газрын хүссэн хууль болгоныг баталж өгч байгаа. Сонсголыг ч үр дүнтэй чанартай сайн хийж байгаа.

Гэвч энэ авлигын асуудал өдий болтол яг л байдгаараа хараат бус байгууллагын дүгнэлтээр бол байнга л ухарч байгаа. Шүүхэд асуудал байгаа юу гэвэл байгаа. Гэхдээ манай Хууль зүйн сайд бас “чекс энд баланс” /checks and balances/ гээд хэлчих шиг боллоо. Өнөөдөр хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал хоёр бараг ялгарахаа байсан. Ардчиллын үндсийн үндэс. Ингээд Шүүх байгуулах хуулийг Засгийн газраас оруулж ирж байна. Энэ Шүүх засаглал маань хэр зөв зүйтэй юм бэ. Ингэж орж ирээд ингэж ярих н. Үүний үр дүнд авлигатай тэмцээд үр дүн гаргавал сайн л байна. Та нар маань нөөц бололцоогоо ашигласан уу? Та нарын хүссэн хууль болгоныг Засгийн газар баталж өгч байгаа. Авлига авсан, өгсөн хоёрын өгснийг нь яагаад чөлөөлж болдоггүй юм бэ хариуцлагаас. Хамтран ажилласан, тэр хөрөнгийг нь ил болгож өгсөн тийм хүмүүстээ 5 хувь, 10 хувь ялыг нь багасгахаар ийм нөхцөл байдлыг оруулж өгч болно. Бодвол би Ерөнхий сайдыг байсан бол асуух гээд байгаа юм л даа. Хэн нэгэн нь төлөөлөөд хариулах л байлгүй. Сингапурт бид нар очдог Ерөнхий сайд очсон байх авлигатай тэмцэнэ гэдэг амар хялбар зүйл биш. Ерөнхий сайд бол итгэл төгс байх шиг байна. Өөрийнхөө найзаас, өөрийнхөө намын нөхдөөс л эхлэх ёстой. Тэгээд бас өөрсдийнхөө зөвлөхөөс эхлэх ёстой,

өөрийнхөө хамаатан садныг Ли Куан Ю чинь өөрийнхөө хамаатан садан, найз нөхөд, зөвлөх 2, 3 хүнийг шоронд явуулж байж Ли Куан Ю-ын хүү одоо хүртэл тэр нам нь засаг барьж байгаа шүү дээ. Ийм үлгэр дуурайлал үзүүлэх боломж байна уу. Энэ хяналтын юу нь байхгүй болчих юм байна. Давах дээр Улсын дээд шүүх дээр мэргэжсэн ийм шүүгч нар байгаа юм байна. Маш сайн. Үгүй ер нь бид нар заавал 2 шат байлгаж яадаг юм. Хүсээд байвал 1 шат болгоод өгье л дөө. Хурдан түргэн сайн шийдээд өг. Яах гэж заавал 2 шат батлах гээд байгаа юм бэ. Энийгээ бүүр сайн хийхийн тулд шалгарсан 1 л шаттай больё. Энийг эсэргүүцэж болохгүй шүү та нар. Нэгмөсөн л хийе л дээ хэдүүлээ. Тэгээд ардчилсан засаглал гэдэг маань жоохон хүлээж л байг. Бид.../минут дуусав./

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяа, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Энхтайвангийн Бат-Амгалан нарын урилгаар Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын өндөр амжилт хүсье. Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс.

Хэн хариулах вэ. Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн бид хоёр Хөгжлийн банкны сонсгол дээр бас мөр зэрэгцэж явсан.Одоо нүүрсний сонсгол дээр бас хаа ч явсан цуг ингээд явж байгаа. Олон шинэтгэлийн асуудлууд дээр хамт явж байгаа. Яах вэ хуулиас болж байгаа хүчин зүйлүүд байгаа. Хуулиас хамаарахгүй хүнээс хамаарч байгаа хүчин зүйлүүд ч байгаа. Жишээлбэл энэ хээл хахууль өгсөн хүнийг нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлдөг болчихъё гээд. Энийг л шийдчихвэл авлига байхгүй болно гэж манай Ганбат гишүүн

их ярьдаг л даа. Энэ угаасаа хуульд байгаа байхгүй юу. Эрүүгийн хуулийн хээл хахууль авах авах гэмт хэргийн тайлбарт хээл хахууль өгснөө сайн дураар илчилсэн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө гэдэг заалт одоо ч хүчин төгөлдөр байгаа. Тэгэхээр байгаа, одоо хүчинтэй байгаа заалтыг хуульд байхгүй мэтээр иргэд, олон нийтэд мэдээлэл өгөөд баймааргүй байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт яах вэ зүгээр Сингапурын жишигийг авлигаас их сайн жишээ тооцдог. Сингапур бол, анх ер нь Авлигын эсрэг хуулийг 1996 онд батлахад Сингапурын бас туршлагыг судалж байсан, тэнд Мөрдөх албаны даргаар ажиллаж байсан хүн манай улсад бас ирж зөвлөгөө өгч байсан байдаг юм байна лээ. Гол тэр үед тухайн хүний би илтгэл Монгол Улсад өгсөн зөвлөмжийг нь бас уншиж байсан юм. Монгол Улсад авлигатай тэмцэхэд хамгийн саад болж болзошгүй нэг хүчин зүйл байна гэж тэр хүний дүгнэлт дээр байсан юм. Тэр нь Монголчууд гэр бүлсэг, жоохон хүн амтай, бие биетэйгээ хамаатан болдог. Нэг үг байсан нь надад их сонирхол татсан. Бие биедээ бэлэг өгдөг уламжлалтай гэж. Бие биедээ бэлэг өгдөг ийм уламжлалтай ард түмэн юм байна. Энэ нь өөрөө авлигад бас их тэмцэхэд бас саад болох нэг хүчин зүйл юм байна гээд дүгнэсэн байсан. Энэ авлигыг үл тэвчих, авлигатай тэмцэх үзэл санаа бол мэдэгдэхүйц сэрж байгаа. Бид бас хамтдаа ард түмнийхээ нүдийг нээж байгаа. Урьд нь мэддэггүй байсан том хулгайг яаж хуулийн аргаар хийдэг байсан юм бэ гэдэг олон юм өнөөдөр ил болоод байгаа юм, гэрэл цохуулаад байгаа юм, нээлттэй болоод байгаа юм, ардчилсан болоод байгаа юм. Энэ бол бидний бас хамтын хүчин чармайлт зүтгэлийн үр дүн гэж ойлгож.../минут дуусав./

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулъя. 1 минут.

Д.Ганбат: Засгийн газарт нэлээн их нөөц боломж байгаа гэж би үзэж байгаа. Авлигатай тэмцэх газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь томилох энэ эрх мэдэл нь бол Засгийн газарт байгаа. Энэ хэдэн шүүгч нарыг бас тусгай субъект гээд шалгах эрх нь бас Авлигатай тэмцэх газарт байгаа. Энэ янз бүрийн ял торгох энэ тэр илэрхий юман дээр ингэж өгөөд байгаа илэрхий мянганы, зууны хулгайч, хуульч гээд нэрлэгдээд байгаа энэ цагдаа нь шалгахгүй бүх юм нь шалгахгүй байхад энэ дээр тэр Авлигатай тэмцэх газрын энэ субъектүүд ажиллаж чадаж байгаа юу, ажилласан уу? Шүүх нь ч бай энэ эрх бүхий байгууллагууд нь.

Нөгөө талаар өгсөн хүн шийтгүүлдэг нь хэвээрээ шүү. Авлига өгсөн гээд эрүүгийн ял авдаг шүү энэ больчихсон юм уу? Авлига өгсөн хүнийг шийтгэж л байгаа шүү дээ. Яах вэ өөрийгөө илчилбэл хөнгөлөх л ийм л журамтай байгаа.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр сайд хариулна.

Б.Энхбаяр: Авлига өгснөө, хахууль өгснөө сайн дураар илчлэх юм бол хариуцлага хүлээхгүй гэдэг Эрүүгийн хуультай. Харин хахууль өгснөө нууж байгаад хуулийн байгууллага илрүүлсний дараа үгүй ээ би өөрийгөө илчиллээ гэж эрүүгийн хариуцлагаас зугтах гэж байгаа бол тийм этгээдэд боломж олгож болохгүй. Энэ чинь ялгаатай ойлголт байна шүү дээ. Хахууль өгсөн, авсан хоёулаа л гэмт хэрэгтэн. Сайн дураараа шахаанд ороод, дарамтад ороод авлига өгөхөөс өөр гарцаагүй, аргагүй байдалд ороод ингээд өгчхөөд энийг ингэж өглөө шүү гэдгийгээ өөрөө хуулийн байгууллагад хандах юм бол тэр хүнд эрүүгийн хариуцлага ноогдуулахгүй, ноогдуулахгүй.

Харин өөрөө нуугаад, тэр тендерт ялах гээд, ашиг хонжоо олох гээд нуугаад, хахууль аваад, өгөөд байгаа хүнийг яахаараа хариуцлагаас чөлөөлөх

ёстой юм. Гэмт хэрэгтэн шүү дээ тэр чинь. Туйлиурч хандмааргүй байгаа байхгүй юу. Хууль ухаалаг байх ёстой. Хууль өөрөө энэ чинь. Криминологийн шинжлэх ухаан гэдэг чинь өөрөө тухайн асуудлыг тодорхой тохиолдол гэхээсээ илүүтэй гэмт үзэгдэл, үйл явц гэдэг талаас нь хараад энд урьдчилан сэргийлэх хүрээнд хуулийн механизм яаж ажиллах вэ, ял шийтгэлийн хүрээнд яаж ажиллах вэ гэдэг ийм цогц бодлого л яваад байгаа юм л даа. Тийм учраас бол энэ авлига өгсөн бүх хүмүүсийг чөлөөлчихье гэдэг ийм юм бол байхгүй. Би бас ноднин жил ч хэлж байсан юм шүү дээ. Тодорхой улс төрийн намыг сонгуульд оруулахгүй байх зорилгоор улс төрчид хахууль өгөх операцад зориуд хийж байсан хүн танай нам дотор чинь байгаа шүү гэж би хэлж байсан шүү дээ. Ийм улс төрийн зорилготой операцыг хүлээн дэмжээд байх хэрэггүй байхгүй юу.

Г.Занданшатар: Сахилгын хороо юу. Тусгай субъектийн хяналт прокурорт байсан. Одоо мөрдөх байгууллагууд бие биеийгээ л хянаж байгаа л даа. АТГ дээр, Засгийн газар, АТГ хариулахгүй л дээ. Прокурор, тэгэхдээ энэ шүү яг Шүүхийн хуультай хамаагүй л дээ. Ер нь I шатаар шүүхээр шийднэ энэ тэр гэдэг чинь та хэд, та ардчилсан Үндсэн хуульд хүний эрхийн тухай заалтад шударга шүүхээр шүүлгэх, давж заалдах эрхтэй гээд заачихсан. Өөрөөр хэлбэл шударга шүүх гэдэг чинь шударга бус шүүх байна гэсэн үг биш шүү дээ. Шүүхийн процесс шударга байна буюу дю процесс/due process/ буюу тэр бүх үйл ажиллагаа нь. Давж заалдах эрхтэй гээд Үндсэн хуульд байгаа шүү дээ. Та давж заалдах эрхгүй болгочих юм бол. Үгүй үгүй Үндсэн хуульд байгаа заалтыг л би ярьж байгаа юм.Наянтайн Ганибал гишүүн асуул асууя.

Н.Ганибал: Энэ хуулийн асуудал ч ер нь зүгээр нийгэмд их л талцал үүсэх ийм л цаг хугацааны хувьд оруулаад ирлээ л дээ. Ер нь энэ I удаагийн үйлчлэлтэй,

тодорхой хугацаатай ийм хууль цаашид хугацаа нь сунгагдах, үгүйг бид нар бас мэдэхгүй л дээ. Ер нь энэ хууль цаашаа сунгагдаад явах маш их магадлалтай. Өмнө ч Их Хурлын практикт I удаагийн үйлчлэлтэй хууль гаргаад тэрийгээ сунгасаар байгаад бүрэн эрхийнхээ хуудсаар хүртэл оруулж байсан ийм КОВИД-ын тухай хууль гээд бид нар саяхан л цуцалсан. Өвчин дуусчхаад байхад тэр хуулиар өнөөдрийг хүртэл үйлчлээд яваад байдагтай яг адилхан сонгуулийн дараах үр дүнгээр эргээд энэ хуулийг цааш нь үргэлжлүүлээд явах магадлал их байгаа шүү.

Тэгэхдээ хэний нам, хэн ялах нь дараагийн асуудал байх. Зарчмын гол асуудлууд нь болохоор өнөөдөр бид нар шүүх рүүгээ дэндүү их дайрлаа. Үнэхээр ардчиллын тулганы 3 чулууныхаа нэгийг Засгийн газар нь Их Хуралтайгаа нийлж байгаад бүүр байхгүй болгохын төлөө л бараг явж байна л даа. Энэ шүүх энэ тогтолцоогоо бид нар сайжруулах тал дээрээ яг юу хийх юм бэ. Саяхан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулаад Сахилгын хороо гээд л байгууллаа. Тэр Сахилгын хороо энэ яриад байгаа энэ шүүгч нарынхаа асуудлыг цэгцэлж чадахгүй байгаа юм уу. Энэ Шүүхийн ерөнхий зөвлөл шинээр зохион байгуулагдсан. Энэ хариуцлагагүй шүүгч нартаа хариуцлага тооцуулаад энэ хийх ёстой ажлыг нь хийлгэж болохгүй байгаа юм уу.

Ер нь сүүлийн үед шүүгчээр ажиллах хүн олдохгүй байгаа гэсэн би мэдээлэл аваад байгаа. Уг нь шүүгч нарын бие даасан байдал, авлигаас ангид байх, нэн ялангуяа улс төрөөс ангид байх асуудлыг бид нар яаж сайжруулах юм бэ. I удаагийн энэ ийм шүүх байгуулж байна гэдэг чинь энэ бүх хүмүүстээ шүүхийнхээ тогтолцоонд үл итгэх итгэлийг итгэхээ байлаа гэсэн үгтэй яг адилтгал юм руу орж байна. Өнөөдөр шүүгч хийх хүн олдохгүй бүгдээрээ өмгөөлөгч болж байгаа гэж сонсож байгаа. Мэдээж тэнд цалин, эдийн засгийн баталгаа,

нийгмийн баталгаа нь байхгүй учраас шүүгч нар ажил хийх сонирхолгүй болж байгаа. Өмгөөлөгч болох сонирхолтой болж байгаа. Үүнтэй уялдуулаад хийж байгаа ямар ажлууд байгаа юм бэ, ямар ажлууд хийх юм бэ.

Ер нь энэ Шүүхийн ерөнхий зөвлөл энэ Сахилгын хорооныхон байгаа байх гэж бодож байна. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа шүү Монголын улс төрийн түүхэнд хэн нэгэн Монгол ардын намаас сонгогдсон Ерөнхийлөгч сонгогдохоор тэр хүмүүст маш их эрх мэдлийг өгдөг, сүүлдээ дийлэхээ байдаг. Тэгээд сөрөг хүчинтэйгээ нийлж байгаад, бүгдээрээ нийлж байгаад нөгөөдхийгөө огцруулдаг ийм практик хэд хэд гарсан. Намбарын Энхбаяр гэдэг хүн дээр бас гарч байсныг бүгдээрээ мэдэж байгаа. Манай намынхан ялаагүй, танай намынхан ялагдуулж байсан байхгүй юу. Тэгж байж тэр өгсөн эрх мэдлээ буцааж авч байсан ийм тохиолдол ч байдаг.

Ер нь энэ ардчиллын энэ тогтолцоонд энэ ардчиллынхаа энэ мөн чанарыг хадгалж авч үлдье гэж байгаа бол шүүх тогтолцоогоо улам сайжруулах нь л зөв байх. Өнөөдрийн гараад байгаа гажгуудыг нь засах ёстой. Ингэж явж байж л бид нар өнөөдөр үнэн мөнхийг олох болохоос 1 удаагийн өөрчлөлттэй хууль гаргаад, хэдэн хүнд зориулаад хууль гаргаад тэр хүмүүсийг яллаж харагдуулаад өнөөдөр шүүх засаглал маань зөв болно гэдэгт итгэхгүй байна.

Г.Занданшатар: Үг хэлчихлээ.

Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан, Цэдэндамбын Цэрэнпунцаг нарын урилгаар Завхан аймгийн Социал демократ Монголын оюутны холбооны гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сайн сайхныг хүсье.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Одоо Хууль зүйн байнгын

хорооны хурал байх учраас Мөнхбаатар дарга та хурал ахалчих. Хэлэхгүй хэлэхгүй.

Д.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ оруулж ирж байгаа хуулийн төслийг бол бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Би бас Байнгын хорооноос хандаж асуух гээд байгаа юм. Энэ хуулийн төслийг хэлэлцүүлэх явцад та бүхэн маань энэ яг авлигалын энэ дагнасан шүүх байгуулахтай холбоотой өнөөдөр яг тодорхой ямар шийдвэртэй орж ирж байна. Миний ойлгож байгаагаар бол энэ 2024 онд энэ авлигалын шүүх байгуулах асуудлыг судалж үзнэ гэсэн ийм хэмжээнд орж ирж байна уу, эсвэл цаг хугацаа алдахгүй авлигалын дагнасан шүүхийг байгуулахаар орж ирж байна уу. Энэ дээр тодорхой хариулт өгөөч гэж.

Ер нь улс орны нийгмийн хэмжээнд өнөөдрийн уналт, доройтол улс орон хөгжихгүй байгаа, нийгэмд баян, хоосны ялгаа туйлдаа хүрсэн ард түмний аж байдал, нийгмийн шударга ёсны, үнэлэмж ийм хэмжээнд унана гэдэг бол эцсийн дүндээ л дээрээ эрх мэдэлд байж байгаа хүмүүсээс л шалтгаалж байгаа эд. Энэ сүүлийн 30 жилийн хугацааны л үр дагавар. Шүүх рүү ч юм уу, эсвэл хэн нэгэн рүү чичлэх юм байхгүй. Энэ хамгийн өндөр эрх мэдэлд байсан төрийн тамгыг түшиж байсан энэ хууль тогтоох дээд эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа энэ Их Хуралд сууж байсан үе үеийн хүмүүсийн хариуцлагагүй, ёс зүйгүй, амин хувиа хичээсэн, авлигал ашиг сонирхолд бүүр бүр мөсөн автсан явж ирсний л хорттой үр дагавар. Энэ үе үеийн парламентын гишүүдийг би бүгдийг нь хэлж байгаа юм биш. Нэг үхрийн эвэр доргивол цөөхөн хэдэн хүмүүс. Энийг би 5 удаа Улсын Их Хуралд сууж ажиллахдаа энэ асуудлыг л тавьж, аливаа авлига, ашиг сонирхлоор ангид байхыг өөрийн биеэр үлгэрлэж аминдаа л хичээж ингэж ажиллаж ирлээ. Энд байж байгаа улсууд ямар нэгэн юмнаас л хол байх хэрэгтэй. Элдвийн

томилгооноос өөрийнхөө үр хүүхдүүд, эхнэр, нөхрөө ажил албан тушаалд томилдог, төрийн албыг төрлийн алба болгодог, төсөл, тендер, концесс юу байдаг юм энэ боломж болгоныг өөрийнхөө компаниудаар авдаг ийм улсууд чинь бол завшаад хууль шүүхийн байгууллага энэ эрх мэдэл, шийдвэр гаргах түвшинд хүмүүстэй ингээд сүлжилдээд нөлөөлчихсөн ийм л байдалтай явж ирлээ шүү дээ. Энэ бол эргээд шүүхийн, хуулийн байгууллага бусад улсуудад нөлөөгөө тусгаад нөгөө шүүхийн хонгил угсрах. Энэ чинь Алтанхуяг Ерөнхий сайдыг байж байхад яригдсан ажил шүү дээ энэ чинь. Алтанхуяг Ерөнхий сайд өөрийнхөө биеэр туулаад үүний ар талд арай гэж би гарч ирлээ. Элбэгдоржийн угсарсан шүүхийн хонгилоор чирэгдээд бүүр үйлээ үзэж байж арай гэж амь гарч ирлээ гээд ингээд яриад байж байсан эд шүү дээ энэ чинь. Би барин тавин ийм зүйлүүдийг хэлж байгаа шүү дээ. Одоо шүүхийн улсууд энэ хууль хяналтынхантай холбогдоод өмгөөлөгч энэ бусад улсуудтай холбогдоод ямар асуудлууд гаарав. Би эхнийх нь уг үндэс нь хаанаас гарав. Одоо байж байгаа байдал чинь ингээд шүүхийн байгууллагад итгэх итгэл энэ чинь бодитойгоор ард иргэдийн дунд суларчхаад байна шүү дээ. Тэгээд аргаа бараад энэ авлигал, хээл хахууль гэж энэ улс орныг мөхөөж байгаа энэ нийгмийн хорт хавдрыг тэмцэхийн тулд бол энэ Дээд шүүхэд л ганц итгэл найдвараа.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Хариулсны дараа тодруулж асууж болно. Хэн хариулах вэ, хэн хариулах вэ? Асуултад хариулах уу, хэн хариулах юм? Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Онончимэг хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

Р.Онончимэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Авлигын дагнасан шүүх байгуулах асуудал гэж Шүүхийн тухай хуульд зааснаар

Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх байгуулах саналыг судалгааны үндсэн дээр Улсын дээд шүүхтэй зөвшилцөж Засгийн газарт хүргүүлдэг ийм процесстой байгаа. Яг энэ процессоор авлигын дагнасан шүүх байгуулах асуудал бол судлагдаагүй, орж ирээгүй байгаа. Засгийн газар бол хууль санаачлагчийн хувьд Их Хуралд авлигын шүүх байгуулах асуудлыг судлаач гэсэн ийм тогтоолын төслийг оруулж ирсэн байгаа. Энэ асуудал өнөөдөр яригдаж байна гэж ингэж ойлгож байна. Улсын Их Хурал тогтоол батлаад судлах чиг үүргийг өгөх юм бол Шүүхийн ерөнхий зөвлөл мэдээж хуульд заасан хүрээндээ судалж танилцуулах болно гэсэн ийм хариулт өгье.

Л.Мөнхбаатар: Тодруулж асуух уу? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя. Дараагийнх нь би хариултыг нь өгчихье. Бат-Эрдэнэ гишүүний дараа.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр бол авлигатай авлигалын энэ дагнасан шүүх байгуулахгүй нь тодорхой байна шүү дээ энэ хариултаас бол тийм ээ. Судалж үзэхээр тогтоол батлагдах юм бол цаашаа явах нь гэж. Тэгэхээр энэ авлигалын энэ угсраа олон хэргүүд шийдэгдэхгүй эхнийх нь бараг 10-аад жил болж байгаа энэ асуудлуудыг яах юм бэ. Одоо ерөөсөө шийдэж чаддаггүй. Одоо ингээд яваад байх юм уу энэ чинь? Байгаа байдалд бодитой байдлууд нь тодорхой байдаг. Сая Хөгжлийн банктай холбоотой асуудлыг ярья л даа. Бид нар ажлын хэсэг байгуул гэж энэ Их Хурлын танхимаас шаардаж байгаад ажлын хэсэг байгуулаад, Баттөмөр ахлаад, бид ороод 56 хоног ажиллаад, үргэлжлүүлээд 2 ч түр хорооны дарга солигдоод ингээд нийтийн сонсгол хийгээд тэгээд шүүх рүү асуудал нь шийдэгдээд явж явж явж явж явж тэгээд ерөөсөө асуудал шийдэгдээгүй. Хэдхэн улсуудад хариуцлага тооцсон болоод л бүгдийг нь суллаад тавьчихсан юм шүү дээ. Одоо харин прокурор

эсэргүүцэл биччихсэн байгаа юм шиг байна. Яг ийм маягаар.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүн ерөнхийдөө бас саналаа хэлж байна тийм ээ. Яах вэ ер нь энэ Шүүх байгуулах тухай энэ хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам дээр Дээд шүүхийн 3 танхимын тэргүүн, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо, Хууль зүйн байнгын хорооны гишүүд цуглаж бас саналаа нэгтгээд ер нь нэгтгэсэн ийм төсөл байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын дээд шүүхийн саналыг аваад ингээд оруулж ирж байгаа ийм төсөл байгаа юм. Энэ дээр авлигалын дагнасан шүүх дээр бас сая Бат-Эрдэнэ гишүүн сая асууж байна. Энэ хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай гээд энэ дагасан тогтоол гарах юм. Энэ дээр болохоороо энэ авлигын дагнасан шүүх байгуулах тухай асуудлуудыг энэ дээр оруулж ирсэн. Энэ нь ямар заалт байна гэхээр авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах тодорхой саналаа холбогдох тооцоолол, эх үүсвэрийн хамт 2024 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэх гэсэн ийм заалт орж байгаа. Үүний дагуу энэ тогтоол батлагдах юм бол нь холбогдох энэ тооцоолол саналуудаа, эх үүсвэрүүдээ гаргаад байгуулах асуудал руугаа орох юм. Ийм зүйлүүд байгаа юм. Та яах юм ахиад тодруулах юм уу?

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ: Тийм би тэгэхээр хариулт авмаар байгаа юм л даа. Авлигалын энэ тодорхой хэрэг асуудлуудыг яагаад ингэж шийддэг юм бэ. Улсын хөдөлмөрийн баатар болсон хүн жишээлэх юм бол 2.7 тэрбум төгрөгийн хахууль аваад, 27 сая төгрөгөөр торгуулаад сул тавигдаж байдаг. Багануурын уурхайн захирал байсан хүн хэчнээн тэрбумын чинь хахууль аваад бас мөн 20 сая төгрөгөөр

торгуулаад гарчихдаг ерөөсөө асуудал нь шийдэгддэггүй. Би Хөгжлийн банкны асуудлыг ярилаа. Одоо нүүрсний хэрэг асуудал гээд хүлээлттэй байдаг. Үүнийг бол магадгүй бүгдэд нь хар будаг түрхээд гол улсууддаа ямар ч хариуцлага тооцохгүй ингээд л тавиад, өгөөд яваад байна шүү дээ. Энэ чинь яагаад ийм байдалтай байдаг юм бэ? Эсвэл хууль нь ийм байдаг юм уу, эсвэл шүүгчид нь ийм байдаг юм уу, ямар учиртай юм бэ? Энэ дээр тодорхой хариулт өгөх бололцоо байх уу, үгүй юу? Хэрвээ дагнасан шүүх байгуулах юм бол бүүр ирж ирж байгаад энэ олон 100 шүүгч дотроос шударга хүн олдмоор юм. Дээрээс нь энэ ардын төлөөлөл.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Сайд хариулах уу. Баттөмөрийн Энхбаяр сайд хариулах юм уу. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс нэмж хариулах юм байгаа юм уу. Онончимэг, ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

Р.Онончимэг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хэрэг шийдвэрлэхгүй уддаг гэдэг асуудал дээр бас хариулт авахыг хүсэж байх шиг байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүрэг бол шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах, хуульчаас шүүгчийг шилж олох ажлыг хэрэгжүүлдэг байгаа. Тэгэхээр шүүн таслах ажиллагааг Монгол Улсад гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Шүүх хуулийн хүрээнд л шийдвэрлэдэг байгаа гэсэн ийм хариултыг өгье.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ гишүүн чинь Хууль зүйн байнгын хороо биш бил үү? Хууль зүйн байнгын хорооны өөр гишүүн байна уу? Хөөн хэлэлцэх хугацаа дууссан байна. Дараагийн хүн асуусан. Ийм хурдан өгч байгаа юм уу. 87.

Р.Онончимэг: Ганибал гишүүний асуултад хариулъя Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн Отгончимэг. Ганибал гишүүн 2 асуулт асуусан.

Нэгдүгээрт ер нь энэ хариуцлагагүй ажиллаж байгаа шүүгч нартай хариуцлага тооцох тал дээр Шүүхийн ерөнхий зөвлөл ер нь юу хийж байгаа вэ гээд. Яг 2019 онд Үндсэн хуульд өөрчлөлт орж Шүүхийн сахилгын хороо гэдэг ийм институт байгууллага байгуулагдсан. Үндсэн чиг үүрэг нь бол шүүгчийн сахилга хариуцлагын асуудлыг авч шийддэг ийм байгууллага байгаа. Энэ бол Ерөнхий зөвлөлийн чиг үүрэгт хамаарагддаггүй ийм асуудал байгаа учир дэлгэрэнгүй хариулах боломжгүй байна.

Хоёр дахь нь ер нь бол шүүгчээр ажиллах хүн олдохгүй байна уу гэж байна. Энэ бол яг үнэн. Өнөөдөр одоогийн байдлаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн энэ шинэ бүрэлдэхүүн ажиллаад 2 жил яг болж байна. Энэ хугацаанд 5 удаагийн сонгон шалгаруулалт хийсэн. Тэгэхээр 1 удаагийн сонгон шалгаруулалтад ойролцоогоор 150 орчим хүн бүртгүүлдэг юм хуульч нар. Үүнээс ердөө 15 орчим хувь нь дунджаар сонгон шалгаруулалтад тэнцэж байна. Бид нар 1 удаагийн сонгон шалгаруулалтдаа бол 30-60 орон тоо зарлаж байгаа шүүгчийн. Ингэхэд бол хамгийн дээд тал нь 10 гаруй орон тоо нь л ингэж нөхөгдөж явж байгаа байдалтай байна. Үүний бол хэд хэдэн шалтгаан байна гэж бид нар харж байна. Нэгдүгээрт бол мэдээж хэрэг хувь хүний бэлтгэл, хууль зүйн мэдлэг, чадварын асуудал сөхөгдөнө.

Хоёрдугаарт бол хуулийн бас өөрчлөлттэй холбоотой өмнөх Шүүхийн тухай хуулийн зохицуулалтаар бол 100 ононы системээр явж байсан. Ингэхэд бол 60 хувийг авбал тэнцдэг байсан. Тэр шалгалт нь, бичгийн шалгалт нь. Тэгвэл 21 оны Шүүхийн тухай хуулиар бол 100 ононы системээр явж байгаа. Гэхдээ 70

хувийг авбал ингээд шалгалтад тэнцсэнээр.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Сахилгын хорооноос бүрэлдэхүүн байхгүй тээ. Ажлын хэсэгт байхгүй байгаа юу. Сахилгын хорооноос яах вэ дараа бас холбогдох мэдээлэл өгүүлбэ. Одоо Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Баярсайхан: Баярлалаа. “Монгол Улсын алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын эхний 10 жилийн зорилтод хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг арилгана гэсэн ийм зорилттой бид нар явж байгаа. Тэгэхлээр Монгол Улсын хөгжлийг Засгийн газар хязгаарлаж байгаа хүчин зүйлс бол яахын аргагүй энэ авлигын асуудал байгаа. Бид нар энэ авлигатай тэмцэж байж авлигыг багасгаж байж бид нар хөгжил дэвшил ярина. Сүүлийн 30 жилд бас энэ бугисан энэ авлигатай яг энэ үеийн Улсын Их Хурал, Засгийн газар тэмцэж байгаа нь маш сайн байгаа. Энэ ажлын үр дүнг бас ирэх жилүүдэд бид нар харна гэж бодож байгаа. Өнөөдөр нийгмийн бухимдал дээд цэгтээ хүрч байгаа ч гэсэн өнөөдөр энэ Их Хурал дээр баталж байгаа хууль, Засгийн газрын энэ авлигатай тэмцэж байгаа тэмцлийн үр дүн бол ирэх жилүүдэд нэлээн сайн гарах байх гэсэн ийм итгэл найдвар байна.

Өнөөдрийн хувьд бол авлига үнэхээр буураагүй, төрийн албаны шат шатад салбар болгонд энэ авлига ёс зүйн асуудал бол шигшсэн гэдгийг бүх Монгол хүмүүс мэдэж байгаа. Ингээд өнөөдрийн энэ авлигын эсрэг дагнасан шүүх байгуулах энэ ажил нь хэр оновчтой гэж манай энэ ажлын хэсэг нэгдүгээрт харж байна. Монгол Улсад хууль хяналтын байгууллага, шүүхэд итгэх итгэл, иргэдийн итгэл бас тодорхой хэмжээнд алдагдсан байгаа. Тэгэхлээр авлигын эсрэг энэ том тэмцэлд энэ дагнасан шүүх байгуулгахыг дэмжих боловч энэ нь эргүүлээд дахиад энэ улс төрчдийн гар,

хөл болсон авлигыг улам цааш нь энэ хуулийн байгууллагад нүүрлэх ийм асуудал бас гарч болох уу гэдэг нэгдүгээр асуудал байна.

Хоёрдугаар асуудал бол ажлын хэсгээс асууя. Миний хамгийн олон удаа асуудаг, бухимддаг зүйл бол энэ авлига, албан тушаалын хэрэгт холбогдчихоод ажлаа өгсөн л түүнийг хариуцлага тооцсон юм шигээр хүлээж авдаг ийм нийгмийн соёл тогтоод удаж байна. Ажлаа өгөөд явж байгаа хүнийг араас нь өшиглөөд яах вэ дээ ч гэх шиг. Ажлаа өгчихсөн юм чинь хариуцлагаа хүлээчихсэн юм шүү дээ, огцорсон юм чинь хариуцлагаа хүлээчихсэн юм шүү дээ гэж ойлгоод байна шүү дээ. Тэгвэл энэ цаашид энэ хүний тэр гаргасан хохирол, энэ улс орныг хохироосон, хөгжлийг хохироосон, ард түмнийг хохироосон энэ хохирлыг яаж барагдуулах юм бэ. Энэ олон сая тэрбум төгрөгийн хохирлыг яаж барагдуулах юм бэ гэдэг асуудал өнөөдрийг хүртэл Монгол Улсын хэмжээнд өнөөдөр мөрдөгдөж байгаа хуулийн дагуу хэрэгжихгүй байгаад байна шүү дээ. Одоо олон нийтийн сүлжээнд харахад өчнөөн тэрбумаар л авлига аваагүй бараг жижиг мөнгөн дүнг яривал бараг тоохгүй янзтай болж байна шүү дээ ард түмэн нь хүртэл.

Тэгтэл харамсалтай нь авлига хүүхдийн салбарт хүртэл нүүрлэсэн гэдгийг би маш олон удаа хэлж байгаа. Тэгэхлээр энэ хариуцлагын тогтолцоо энэ шүүх байгуулснаараа яаж орж ирэх юм бол гэдэг ийм асуултад хариулт өгөөч. Өнөөдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд заасан авлига, албан тушаалын гэмт хэргүүдийн шүүхэд шилжсэн шийдвэрлэгдсэн тоо ер нь ямархуу түвшинд байдаг юм бэ? Цаашид авлига албан тушаалын гэмт хэргүүдийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр өнөөдөр энэ манай улсад орчин үеийн дэвшилтэт техник, технологи арга аргачлалыг нэвтрүүлэх талаар ямар ажлууд хийгдэж байгаа юм бэ? Мөнгө угаах гэмт хэргийн илрүүлэлт, мөшигөлт

ямар түвшинд байгаа юм бэ. Хамгийн гол нь энэ үндэслэлгүй хөрөнгөжөөд байгаа хүмүүсийн энэ асуудал дээр шүүх, хууль хяналтын байгууллагууд яаж ажиллаж байгаа юм бэ гээд энэ асуудлуудад та бүхэн маань тодорхой хэмжээгээр хариулт өгөөч. Шаардлагатай бол нэмж тодруулъя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Шүүх байгуулах хууль хэлэлцэж байгаа шүү дээ тийм ээ. Шүүх байгуулахтай холбоотой асуудалд хэн хариулах юм. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Онончимэг хариулъя.

Р.Онончимэг: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Тоо, статистик асууж байна. Сүүлийн 5 жилийн байдлаар 2018 онд эрүүгийн хэргийн авлига албан тушаалын хэрэг 28 шийдэгдэж байсан бол 19 онд 47, 20 онд 116, 21 онд 155, 22 онд 182 гээд авлига, албан тушаалын хэргүүд өсөж байна. Яг авлигын шүүх байгуулаад ямар үр дүнтэй юм бэ, оновчтой юм бэ гэдэг асуудал дээр тухайлж бид нар судлаагүй учраас одоохондоо хариулт өгөх ямар нэгэн боломжгүй байна. Улсын Их Хурлаас энэ талаар судлаад танилцуул, тооцоо үндэслэлээ танилцуул гэж тогтоол батлагдвал эргэж судалж, танилцуулах бүрэн боломжтой байна.

Бусад урьдчилан сэргийлэх хариуцлагын асуудал дээр бол Шүүхийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бас хариулт өгсөн нь зохимжтой байх гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Хариултаа авч байж тодруулах юм уу? Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас асуучхаж байгаа юм уу, үгүй юү? Тодруулж асууя. Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Баярсайхан: Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх байгууллагаас асуух шаардлагагүй. Би шүүхээс асууж

байгаа юм. Ингээж асуугаад байгаа юм. Хариуцлага тооцох гэдэг нь ажил, албан тушаалаас огцроод л болох юм уу, эсвэл улсад энэ мөнгөн болоод хөгжлийн хувьд, хүний эрхийн хувьд энэ хохирол учруулсан хүмүүст тэр зохих хариуцлагыг нь шүүхээр хүлээлгэж байгаа асуудал ямар хэмжээнд байгаа юм бэ? Тэгж хариуцлага тооцох ёстой биз дээ? Ямар нэгэн ажил, алба албан тушаал эрхэлж байсан хүмүүс ажлаасаа огцроод л үүнийгээ хариуцлага хүлээж байна гэж ойлгоод байна шүү дээ. Ийм ойлголтоос чинь болоод өнөөдөр Монгол Улсад богинохон хэмжээнд ажиллаад, идэж уугаад зүгээр ажлаасаа огцорсон болгоод завшаад байгаа хүмүүс олон байна шүү дээ. Тэгэхлээр өнөөдөр мөрдөгдөж байгаа хуулиар энэ хариуцлагын тогтолцоо гэдгийг та нар маань яаж хариуцлага хүлээлгэх, шүүхийн шийдвэрүүд яаж гарч байгаа юм бэ л гэж би асууж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Өнөөдөр бол Шүүх байгуулах тухай хууль хэлэлцэж байна. Саяын асуултад энд хариулах хүн байгаа юм уу. Шүүхийн ерөнхий зөвлөл ерөнхийд нь хариулъя. Шүүн таслахтай холбоотой асуудал асуугаад байна шүү дээ. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

Р.Онончимэг: Баярсайхан гишүүний асуулт асуултад хариулъя. Шүүхийн ерөнхий зөвлөл бол шүүн таслах ажиллагаанд оролцох ийм эрхтэй субъект бол биш. Гагцхүү шүүхийн бие даасан байдал, хараат бус байдал, хуульчаас шүүгчийг шилж олох илүү захиргааны менежментийн ийм байгууллага байгаа. Тийм.

Л.Мөнхбаатар: Одоо Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Одоо өнөөдрийн энэ Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа асуудлыг ер нь улс даяараа л харж байгаа юм

билээ дээ. Үнэхээр энэ орон нутагт явж байхад энэ Улсын Их Хурал, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа энэ Эрүүгийн хуулийн өөрчлөлт, энэ ашиг сонирхлын хууль гээд 30 жил замбараагүй явж ирсэн энэ зүйлүүд хаалт хийгдээд явж байгааг их сайшааж байна лээ. Сайн байна. Гагцхүү одоо та нарын л илрүүлээ барилаа янз бүр яриад байсан юмнууд чинь үр дүн нь хаана байгаа юм бэ. Зүгээр л худлаа хий яриад байгаа юм биш үү гэдэг ийм зүйлийг бол сум болгон дээр л ярьж байна. Тийм. Тэр битгий хэл сум дээр ажиллаж байгаа төрийн албан хаагч энэ авлигалын энэ асуудлуудынхаа нэг талд гарахгүй бол энэ төрийн албан хаагч ажлаа хийхэд хэцүү боллоо гэдэг зүйлийг ярьж байна шүү дээ. Сумын нэг байцаагч очоод л иргэнтэй очоод уулзахад хулгай зэлгийгээ цэгцэлчхээд төр хулгай хийдэггүй болчихоод ирээд надтай уулз, юмаа хий, хийлгээрэй, юмаа нэхээрэй гээд. Тэгэхээр энэ чинь цаагуураа бол төрийн нэр хүнд, олон зүйл дээр бас сөрөг нөлөө үзүүлээд байгаа юм байна лээ.

Тийм учраас энэ авлигалын хэргийн энэ шүүх байгуулна гэдэг чинь бүгдийг нь аваачаад хийчихнэ ч гэж ерөөсөө ойлгохгүй байна. Зөв, бурууг нь дэнсэлье. Процессыг нь жоохон хурдалъя л гэж байгаа юм байна лээ шүү дээ. Тийм учраас энэ асуудлыг бол дэмжиж байгаа гэдгийг би хэлэхийг хүсэж байгаа юм.

Энэ дээр бас Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн ер нь энэ шүүхтэй холбоотой энэ тойргийн шүүх олон асуудлууд яригдаж байгаа. Энэ бол бас Монголын энэ хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчин олдохгүй байгаагийн бас нэг гол томоохон хүчин зүйл ч байж магадгүй. Ялангуяа орон нутгуудад хийгдэж байгаа энэ тендер, ажилд Улаанбаатар хотоос баахан компаниуд очоод хийдэг, эргээд цалингийн маргаан үүсдэг. Ажил хийлгээд цалинг нь өгдөггүй. Шүүхэд хандаарай чи гэхчээд яваад өгдөг. Шүүхэд хандахаар заавал Улаанбаатар руу ирэх болдог. Тэгэхээр

энэ харьяалал иргэний хэргийн энэ харьяаллыг заавал Улаанбаатарт тэр компани бүртгэлтэй байснаараа наашаа ирэх үү, орон нутагт нь шийдүүлэх ийм зүйлийг бас би ярьж болох уу гэж ингэж бас асуух гээд байгаа юм. Яахлаараа иргэнийг хохироож байгаа магадгүй энэ хуулиар зохицуулагдсан зохицуулалтыг өөртөө давуу байдал олгож шүүх дээрээ чи шүүхдээ хандаарай чи гээд яваад өгч байгаа энэ нөхдүүдэд хууль илүү тийм боломжтой хувилбарыг нь гаргаж өгч байгаа юм бэ. Тухайн орон нутагт болсон үйл явц тэнд байгаа шүүх дээр энэ асуудлыг шийдүүлж болохгүй юу гэдэг зүйлийг олон иргэд ярьдаг юм. Би өнөөдөр шүүхтэй холбоотой асуудал дээр, авлигатай холбоотой асуудал дээр дэмжинэ.

Дээрээс нь энэ шүүх яригдаж байгаа учраас энэ дээр би бас нэг ямархуу зохицуулалтууд явж байгаа вэ, өөрчлөх бололцоо байгаа юу гэж бас нэмэлтээр асууя гэж ингэж бодож байгаа юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр хариулъя. Дараа нь ажлын хэсэгт нэмээд хариулъя.

Б.Энхбаяр: Шүүх бол нэг талаасаа үйлчилгээний байгууллага, өөрөөр хэлбэл таны хэлсэнчлэн иргэндээ ойр анхан шатдаа байж бага иргэдэд зардал чирэгдэл багатайгаар төрийн үйлчилгээг тэр дотроо шударга ёсны үйлчилгээг үзүүлэх учиртай. Зарим тодорхой асуудлууд дээр жишээлбэл шүүхийг тойргийн журмаар байгуулах шаардлага бол байгаа гэдэгтэй би бол санал нийлдэг. Энэ удаагийн шүүх байгуулах хууль дээр шүүхийг тойргийн журмаар, ялангуяа давж заалдах шатын шүүхийг эрүү, иргэний хэрэг дээр байгуулах санал санаачилга Шүүхийн ерөнхий зөвлөл болон Улсын дээд шүүхээс гарсан. Энэ санал бол Засгийн газар дээр яригдаад Их Хурал дээр орж ирүүлээгүй байгаа. Яагаад гэхээр яг энэ удаагийн

парламент гэхэд 3-ны 2 нь аймгуудаас сонгогдсон төлөөлөлтэй. Тэгэхээр Их Хурал битгий хэл Засгийн газар дээр л Засгийн газрын гишүүд яахаараа төв нь энэ аймагт байдаг юм, манай аймагт байдаггүй юм гээд л эхэлж байна лээ. Засгийнхаа энэ босгыг ч давахад ийм бэрхшээлтэй асуудал би парламентын дээр ороод бөөн гал болох юм байна даа гэж ингэж бодсон юм.

Нөгөө талаараа бас сая Монгол Улсад ажилласан Нэгдсэн Үндэстний Байгууллагын НҮБ-ын тусгай шинжээч ер нь шүүхийн үйлчилгээ иргэдэд бас ойр байх ёстой шүү, чирэгдэл багатай байх ёстой шүү гэдгийг бас Нэгдсэн Үндэстний Байгууллага талаас дүгнэж анхааруулсан учраас энэ удаа хөндөөгүй. Хэрэгцээ, шаардлага байгаа юу гэвэл байгаа. Тухайлбал энэ өөрөө ирэх 7 хоногийн нүүрсний сонсгол дээр шууд харагдана. Шууд. Яагаад ийм том хэмжээний хулгай жишээлбэл нүүрстэй аймаг Өмнөговь аймагт болоод байж байхад тэр аймгийн хууль, шүүх юу хийж байсан юм бэ гэдэг асуудал зүгээр л харагдана. Хэрвээ тойргийн журмаар эд нар байгуулагдсан байсан бол арай ч тэгж өмчлөгдөж болохгүй байх байсан байх. Хуульгүй болчихсон, шүүхгүй болчихсон ийм зургууд тийм байгаа.

Ер нь байна шүү дээ би ингэж бодоод байгаа юм. Өмнөговь бол яг баялгийн хараал хүрчихсэн юм байна лээ жинхэнээрээ. Яг ийм хараал яг байдаг юм байна. Хууль байхгүй, улс дотор улс тусдаа. Тэнд Монгол Улсын хууль үйлчилдэггүй, цагдаа байхгүй, шүүх байхгүй, аудит байхгүй, юу ч байхгүй. Тэгэхээр энийг чинь жишээлбэл яаж хамгаалах вэ гэхээр тэр шүүхээс нь ангид яг аймагт нь харьяалуулахгүй тойргийн журмаа байгуулж байж л салгана л даа. Тэгэхээр энэ цаашидаа дараа дараагийн парламентад шийдэгдэх байх гэсэн би бол ийм бодолтой байгаа юм.

Л.Мөнхбаатар: Яах вэ нэмж харуулах уу. Өмнөговьд ерөөсөө шүүх

байхгүй, прокурор байхгүй, цагдаа байхгүй, бүүр юу ч байхгүй л гэж байна шүү дээ. Ажлын хэсэг нэмж хариулъя. Ажлын хэсгийн 85 уу? Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

Б.Ундрах: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүн Ундрах байна. Саяын асуусан асуултад хариулъя. Харьяалалтай холбоотой асуулт асуулаа. Шүүх байгуулах тухай хуультай хуульд яг энэ харьяаллын асуудал яригдахгүй нэгдүгээрт тусгагдаагүй байгаа.

Хоёрт харьяаллын асуудал бол өөрөө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. Тийм болохоор яг Шүүхийн ерөнхий зөвлөлийн өмнөөс энэ асуудалд хариулах ийм боломжгүй байна. Яг асуусан асуулттай холбогдуулаад хуульд ямар зохицуулалт байдаг вэ гэдгийг хэлье. Саяын дурдсан агуулгаар бол нэхэмжлэлийн шаардлага хариуцагчаа дагаж явдаг хариуцагчийн харьяаллаар нэхэмжлэлээ гаргадаг ийм л асуудал байгаа. Нэхэмжлэлийн шаардлагаасаа хамаараад хариуцагч өөрийнхөө хаягаар эсвэл харилцан тохиролцоод тохиролцсон газрынхаа шүүхээр шийдүүлдэг ийм нэхэмжлэлийн тохиолдол бий.

Мөн ямар нэгэн асуудал хүндрэл үүслээ гэхэд энийг бас цахимжилтын асуудлаар шийдэж болно. Тэгэхээр шүүх дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах энэ асуудал явж байгаа. Тэгэхээр аяа яваандаа процесс ажиллагаанд өөрчлөлт орох юм бол энэ асуудал хүндрэлгүй шийдэгдэх байх гэж харж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Тогмидын Доржхандын урилгаар “Залуу хүн” клубийн Чингэлтэй дүүргийн гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний ажил, хөдөлмөрт өндөр амжилт, сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Энэ бүх хулгай бүгдээрээ төрийн өмчийн компани дээр гарч байгаа. Мэдээж энэ олон жил засагласан 2 нам дээр бас янз янзын үл бүтэх улсууд байдаг. Тэд нарын үрээр энэ нийтээрээ энэ төрийг үзэн ядах, ийм дургүйцэх ийм хандлага руу явж байгаа. Энэ хулгай нь бол хэрээс хэтэрсэн. Энэ дээр Ерөнхий сайд сая мэдээлэл хийхдээ ер нь бол яах вэ тэр Сайханбилиг 49 хувийн хувьцаа гадна явж байгаа шувуу энэ тэрийг бас ярьж байх шиг байна. Би бол энэ дээр тэд нар ирэх ёстой. Энд Монголынхоо шударга шүүхээр шүүлгэх ёстой л гэж би бодож байгаа. Энэнээс болж Ардчилсан намын өнөөдөр энд зүтгэж яваа тэр хүмүүс тэрнээс нь болж муу нэрээ дуудуулах нь утгагүй л гэж би үздэг.

Тэгэхээр энэ олон олон хулгай гарч байгаа. ЖДҮ, Хөгжлийн банк, нүүрсний хулгай, төмөр замын хулгай, боловсролын зээлийн сангийн хулгай энэ тэр гээд янз янзын хулгайнууд гарч байгаа. Энэ хулгайнууд 2016 оноос хойш засаглаж байгаа өнөөдрийн эрх баригчтай маш их холбоотой. Бүх зам Ром ордог гэдэг шиг өнөөдрийн гарч байгаа энэ бүх хулгай бүгдээрээ Монгол Ардын намын цагаан байр руу очно.

Тийм учраас энэ аль алинаар нь энэ хулгайг цэгцлэх талаар бас аль алиных нь хүчин зүтгэл байх ёстой л гэж би үзэж байгаа юм. Нүүрсний хулгай ярья л даа. 40 их наяд нь үнэн шүү дээ. Би гаргаад өгч чадна. Нүүрсний хулгай чинь тээврийн хулгай байхгүй юу. 2018 оноос өмнө 29-хөн километр газарт 3 сая төгрөгөөр тээвэр хийж байсныгаа 120 сая төгрөг болгоод л тэндээсээ хулгайлчихсан байхгүй юу даа. Амных нь үнэ 60 доллар. 120 доллар байж байхад 60 доллар амнаас нь зардаг байсан. 600 доллар болоод дунджаар ер нь 450 доллар байж байхад л 60 доллароор зарсан. Тэрний дундах мөнгийг нь хаана

хулгайлсан юм бэ гэх дээр тэр 29-хөн километр газарт Цагаан хаднаас Ганц модны боомт хүртэл тэр хооронд л хулгайлчихсан байхгүй юу. Энэ бүх би түрүүн Идэрбат гишүүн хэлж байна ард иргэд очих дээр хариуцлага тооцооч гэж яриад. Хариуцлага тооцох боломж нь хэцүү байгаа шүү дээ. Нэг нэгэндээ барьцаалагдсанд энэ өнөөдрийн эрх баригч нар нөгөөдөө хариуцлагад ерөөсөө тооцож чадахгүй байгаад л гол учир байгаа байхгүй юу даа.

Тийм учраас энэ 2 тэрбум төгрөгийн авлигал авчхаад 20 сая төгрөгөөр торгуулаад гаргаад байх дээр чинь хэн шүүхэд найдах юм бэ. Тийм учраас энэ авлигалын энэ асуудлыг бас тодорхой хэмжээгээр хурдан шуурхай шийдэх иймэрхүү асуудал бас гарч байх шиг байна. Тэгэхдээ нэг зүйлийг хэлье. Шүүх бол үнэн мөнийг тогтоох л үүрэгтэй шүү. Бусдаар хурдан шийдэх тухай асуудал ерөөсөө байх ёсгүй. Тийм учраас энд энд ийм асуудлаа хэлэлцэж шийдэж явах гэж байхдаа хүний эрхийг ноцтой зөрчих ийм зүйл гарах вий гэдэгт би эмзэглэж байгаа. Би түрүүн хэлсэн бүх зам Ром ордог. Тэрэнтэй адилхан бүх хулгайнууд Монгол ардын нам руу чиглэж байгаа шүү. Тийм учраас ард түмэн тодорхой хэмжээгээр энэ 24 оны сонгуулиар тодорхой.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Та шүүх байгууллагатай холбоотой, хуультай холбоотой асуудлаа л ярья. Байр сууриа илэрхийлж үг хэллээ Пүрэвдорж гишүүн. Асуулт ямар асуулт байна, хэн хариулах юм. Хууль зүй, дотоод хэргийн сайд сайд Энхбаяр хариулья.

Б.Энхбаяр: Уг нь энэ нүүрсний түр хороонд яг Пүрэвдорж гишүүн л байх ёстой юм байгаад байгаа юм даа. Нам нь ерөөсөө түр хороонд л оруулахгүй л байгаад байгаа юм шиг байгаа юм. Би тэгж л бодоод байгаа юм. Хөгжлийн банкин дээр ч оруулаагүй Пүрэвдорж гишүүнийг, нүүрс дээр ч оруулсангүй. Энэ чинь тодорхой бүүр ханиш яриад байгаа

байхгүй юу. Би ер нь Пүрэвдорж гишүүний эсвэл гэрчээр дуудмаар юм уу. Энэ чинь тодорхой авлигын тоо яриад байгаа байхгүй юу. “Си” зөвшөөрөл дээр яг хэдэн төгрөгийн авлигатай байж байгаад тэд болчихсон энэ тэр гээд яг хажууд нь лаа асаагаад харж байсан юм шиг яриад байгаа байхгүй юу. Бид түр хорооны хяналт шалгалтын явцад жишээлбэл энэ “Си” зөвшөөрлийг олгож байгаа байдлыг яах вэ дээ энэ бүртгэл хяналт муутай, материал ирүүлэхгүй байгаад байгаа юм?

Би сая нэг дэх өдөр түр хорооны гэрч нарыг дуудахдаа хяналт шалгалтын хүрээнд ямар хүндрэл гарч байгаа вэ гэдэг дотор энэ Авто тээврийн үндэсний төвийнхөн “Си” зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл ирүүлэхгүй байгаа гэдэг талаар зориуд хэлсэн. Энэ манай намын засгийн үеийн томилгоотой хүмүүс байгаа. Тэгээд эзэн нь хамгаалаад байдаг юм уу, эсвэл эрдээд байдаг юм уу ирүүлэхгүй байх? Би бол бодит байдлыг хэлж байгаа. Бүгдийг нь гэрчээр дуудна. Таны хэлж байгаа яах вэ манай Улсын Их Хурал дахь Ардчилсан намын гишүүдээс удаа дараа л асуугаад байгаа л даа. Эхний сонсгол нь жижиг Тавантолгойн асуудал яригдаад байгаа байхгүй юу. Хоёр дахь сонсгол нь том Тавантолгойтой холбоотой асуудал. Тэгэнгүүт жижиг Тавантолгой дээр дуудагдаж байгаа хүмүүс нь улс төрийн харьяаллын хувьд Ардчилсан намынхан их болонгуут энэ намаар нь ялгалаа гээд байгаа юм.

Хоёр дахь сонсгол дээр бараг Ардчилсан намынхан өөрсдөө гайхах байх даа. Харин битгий болиорой гэж хэлээрэй. Манай намынхан олноороо дуудагдана, олноороо. Харин манай намынхныг битгий хамгаалаарай. Их холбоотой юмнууд байгаа юм байна лээ. Энэ нам дамжиж хамгаалж, эсвэл нам дамжиж хулгай хийдгээ бас аль аль намынхан болих ёстой юм байна лээ ер нь бол.

Л.Мөнхбаатар: Улс төрийн асуулт асуугаад улс төрийн хариулт авлаа. Одоо хуулиа хэлэлцэж эхэлье дээ хэдүүлээ. Хуулийнхаа төслийг хэлэлцье. Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Үнэхээр энэ авлигалын асуудал нийгмийн асуудал болж хувирч, ард түмний дургүйцэл, бухимдал ямар түвшинд байгааг бүгдээрээ л мэдэж байгаа л даа. Тэр тусмаа ерөөсөө л энэ авлигалын асуудал гэдэг чинь төрийн өмчит компаниудын томролт, төсвийн томролт хоёр дээр л байгаа. Төсөв нь 4 жилийн дотор 2, 3 дахин нэмэгдчихдэг төрийн өмчит компаниуд нь эдийн засгийнхаа дийлэнхийг эзэлчихдэг, тэдгээр нь бүгд хаалттай томилгоогоор явдаг, хаалттай худалдан авалтаар явдаг. Угаасаа л энэ авлига гарах нь зүгээр цаг хугацааны л асуудал. Энэ тов тодорхой л зүйл.

Тэгэхээр энийг шийдэх асуудал дээр удаан хойрго байна, ял хөнгөдөж байна гэдэг олон асуудал яригдаж байгаа бас үнэн. Гэхдээ эдгээрийг шийдэхийн төлөө шүүхийн хажуугаар шүүх байгуулъя, ер нь онцгой комисс ишг ажиллая, дахиад жинхэнэ тэр төрөлжсөн шүүхүүдээ байгуулдаг байгаа юм биз. Шүүх байгуултал ингээд шийдчихье. Тухайн иргэн давж заалдахгүй, гомдол эсэргүүцэл гаргах эрхгүйгээр асуудлыг шийдээд алх цохиод явчихъя гэдэг энэ үнэхээр өмнө нь хуулийн салбарт хонгилын тухай яриа явдаг байсан. Энэ яг хууль ёсны хонгилын тухай л яриа энд ингээд явагдаад байна л даа. Энхбаяр сайд та яг хувь хүнийхээ итгэл, үнэмшлийн хувьд, хууль зүйн салбарынхаа тэр үнэт зүйлийн хувьд та яг энэтэйгээ өөрөө ер нь зөв гэж бодож байгаа юу. Авлигатай тэмцэх тэмцэл хийж байгааг бүгдээрээ л чадах явахаараа, эрвийх дэрвийхээрээ дэмжиж байгаа. Угаасаа ард иргэдийн санаа бодол ийм байгаа.

Тэгэхдээ та яг үнэт зүйлийнхээ хувьд энийг ер нь зөв гэж бодож байна уу. Нэг юмыг шийдтэлээ түр шийдчихье. Тэрэнд хүний эрх хохирвол хохирог, нөгөө зорилго нь аргаа зөвтгөхгүй гэдэг социализмын үед социализм, коммунизм байгуулахад хэдэн мянган иргэн яах вэ тэр 30, 40 мянгаар нь буудаад алчихъя тэр улсын их тусгаар тогтнолын төлөө тэр байдаг л юм гэдэг энэ ийм үзэл суртал үүний цаана ханхлаад байна л даа нэгдүгээрт.

Хоёрт нь тэр шүүх ял завишуулаад байна, хөнгөн ял өгөөд байна гэдэг асуудал энд яригдаад байна л даа. Энэ тэгэхээр тэр шүүгчид чинь хуулиас гадуур тийм ял өгөөд байх боломж шүүгчдэд байдаг юм уу. Хуулиас гадуур. Цагаан дээр хараа биччихсэн хуулийг өөрөөр хэрэглээд байгаа юм уу тэд нар. Яг энэ дээр тодорхой хариулт энэ ажлын хэсэг нь байна уу, Хууль зүйн сайд бас мэдээлэл өгмөөр байна. Яг хэдэн шүүгч, ямар хуулийг яг хууль дээр ийм ял өгөх ёстой гэгчихсэн байсныг хэдэн 10 тэрбумаар нь өгчихсөнийг авлигалын асуудал дээр хөнгөн ял яг яагаад өгчихсөн юм? Энэ дээр хэдэн хэрэг шалгагдаж байгаа юм, хэдэн шүүгч? Тэр сахилгын хороон дээр нь байна уу тэр харьяалах субъект дээр нь байна уу, ямар мэдээлэл байгаа юм. Энэ чинь энэний цаана хууль үнэхээр ял завишуулж байгаа учраас шүүхийн гадуур шүүх байгуулчихъя л гэж байна л даа.

Тэгэхээр үнэхээр цаад талд нь тэгвэл хууль зөрччихсөн шүүгчид байх ёстой биз дээ. Дорж, Дондог ингээд ийм ялыг энэ дээр тэдэн шүүгч шалгагдаж байгаа, тэдэн шүүгч буруу шийдсэн нь нотлогдсон. Энэ хуулийг буруу хэрэглэсэн нь нотлогдсон. Дахиад л хэн нэгэн хүнийг шүүгч ч бай бас хүн. Энэ хүмүүсийг чинь шүүхээр шийдэгдээгүй байхад нь бас буруутайгаар шууд ингэж зарлаад байж болдог юм уу? Шүүх ерөөсөө буруу шийдчихсэн. Тэгэхээр энэ дээр тодорхой тоотой, нэртэй устай зүйл ярмаар байна. Тэгэхгүйгээр шүүх буруу шийдээд байгаа учраас өөр шүүх байгуулъя, энэ нь

төвлөрсөн байя, ерөөсөө энэ бараг захиалгатайгаар гялс явдаг, хялбаршуулсан журмаар явдаг ийм байя гэдэг чинь өөрөө наадах чинь ийм шударга ёсны зарчим энэ хүний эрх, ардчилсан үнэт зүйл гэдгээс чинь тэс эсрэг л ийм зүйл яваад байна.

Хоёрдугаарт нь тэр энэ Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асуулт байна л даа. Энэ Эрүүгийн хянан шийдвэрлэх хууль дээр авлигын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэдэг дээр та нар саналаа өгсөн үү. Яг одоо энэ давж заалдах эрхгүйгээр ингэж ингэж шийднэ, уг тогтоолд гомдол, эсэргүүцэл гаргах эрхгүй гээд энэ гол зүйлүүд яваад байна шүү дээ. Энэ дээр Шүүхийн ерөнхий зөвлөл.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Хууль зүй, дотоод хэргийн сайд Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Би Монголын нийт ард түмний бүтээл Монгол Улсын Үндсэн хуульд үнэнч байдаг. Ийм үнэнч хүн байгаа. Монгол Улсын Үндсэн хуулиар эрх мэдлийг 3 хуваарилсан. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх. Шүүх эрх мэдэл бол үндсэн хуульчлагдсан, бие даасан, хараат бус ийм эрх мэдэл байгаа. Би энэ шүүхийн бие даасан байдал шүүгчийн хараат бус байдалд хүндэтгэлтэй ханддаг. Хүндэтгэлтэй ханддаг ч гэдэг утгаараа шүүхийн хуулийн ажлын хэсэгт ажиллаад шүүхийн хууль батлагдсанаас хойш шүүхээр хэрэг хянан шийдвэрлэгдэж байгаа нэг ч хэрэг учралын талаар би урьдчилсан байр суурь огт илэрхийлэхээс түдгэлздэг. Би тодорхой хэрэг учралын талаар ерөөсөө байр суурь илэрхийлдэггүй. Илэрхийлэхээс шууд татгалздаг.

Яагаад гэхээр нэгэнт хууль тогтоогч одоо бол тэр тусмаа Хууль зүйн сайдын хувьд хэрэг маргаанд хөндлөнгөөс нөлөөлсөн хэрэгт шууд би өөрөө бас манлайлаад байж болохгүй

гэдэг утгаар түдгэлздэг. Тэгэхдээ энэ нь би итгэл үнэмшилгүй, дутагдлын хажуугаар дуугай суугаад байдаг гэсэн үг бас биш байхгүй юу. Илтэд ойлгомжтой, ял шийтгэлийн хувьд олны анхааралд орчихсон ийм том том хэмжээний авлигын хэргийг яаж шийдээд байна вэ гэдгийг ард түмнээрээ хараад байгаад байна шүү дээ. Энэ шийдвэр нь шударга биш байна гэж Монголын ард түмэн үзээд байна шүү дээ. Би дүгнээд, би дуугүй байгаад байгаа юм. Монголын ард түмэн энэ чинь ийм том авлигын хэрэг дээр 20 сая төгрөгөөр торгоод явуулчихдаг байж болох юм уу гээд байна шүү дээ.

Тэгээд энэ авлигач шүүгчийг юуг нь хамгаалаад байгаа юм. Тодорхой хэрэг учралуудыг хэрэгсэхгүй болгосон, нөлөөлсөн ийм зөндөө л асуудал байна. Жишээлбэл энэ нүүрсний сонсгол дээр гэхэд чинь Монголын хилийн тагнуулын албыг хилээс нь аваад хаячихсан. Нүд, чихийг нь. Ингээд судлаад үзвэл энэ чинь бас хамгийн том хулгайг би хуулиар хийдэг гэж түрүүн зүгээр яриагүй байхгүй юу. Сэм оруулаад л улсын нүд, чих болсон ийм юмнуудыг нь бүгдийг нь таглаад л, сохлоод л, чичилж байгаад л дараа нь дандаа том хулгайнууд явсан байгаа байхгүй юу. Тэгэхээр уг үндэс, шалтгааныг нь бол ёстой хууль.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Тэгье ажлын хэсгээс нэмээд хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Онончимэг хариулъя.

Р.Онончимэг: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ Шүүх байгуулах тухай хууль болон түүнийг дагаж орж ирж байгаа процессын хоёр хуулиуд дээр тодруулга авч байна гэж ойлгож байна. Хуулиараа бол шүүх байгуулах тухай хуулийн төслийг боловсруулах, Дээд шүүхтэй зөвшилцөх энэ хэр эрх хэмжээ Шүүхийн ерөнхий зөвлөлд байж байгаа хуулиараа. Дагаж

орж ирж байгаа процессын хуулиудын өөрчлөлт бол хууль санаачлагчид байж байгаа. Энэ дээр яг тухайлж тэр таны сонирхож асуугаад байгаа хэсэг дээр бид нар тухайлан санал өгөөгүй, аваагүй гэж ойлгож болно. Шүүх байгуулах хуулиа бид нар зөвшилцөн оруулж ирсэн.

Л.Мөнхбаатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Энхбаяр Хууль зүйн сайд та бас ингэж хамаагүй ярьж болохгүй байх. Үнэхээр би танаас тодорхой л асуулт асууна. Шүүгчид буруу шийдээд байгаа бол цагаан дээр хараар бичсэн хуулийг буруугаар ашиглаад байгаа бол шүүгчдийн буруу. Тийм учраас тэр тодорхой нэр бүхий шүүгчдийг та нар олон нийтэд зарладаг юм уу, арга хэмжээ авдаг юм уу, шүүхээрээ ордог юм уу энэ асуудал тэгж байж энэ шүүгч чинь буруутгах ёстой. Үнэхээр тэр цагаан дээр хараар биччихсэн хууль нь өөрөө сул байвал хууль нь өөрөө тийм боломж олгоод байвал Улсын Их Хурал энэ хуулиа засах ёстой, өөрчлөх ёстой, чангаруулах ёстой. Энэ дээр тодорхой нэртэй устай шүүгчтэй тоо баримттай зүйл яриад ийм учраас шинэ шүүхийн асуудал яригдаж байна гэвэл энэ энэ яриа чинь үндэслэлтэй болох гээд байна л даа. Ер нь ийм хэвлэлээр тийм юм гарч байгаа гэсэн юм Хууль зүйн сайд нь яриад олон нийтэд ийм зүйл яриад сууж байж болохгүй шүү дээ энэ чинь. Та чинь өөрөө Монгол Улсын Хууль зүйн сайд шүү дээ.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариул хариулъя. Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Монгол Улсад ажиллаж байгаа 560 гаруй шүүгчийн 75 хувь нь Элбэгдорж, Баттулга гэсэн хоёр ардчилсан ерөнхийлөгчийн томилсон шүүгчид байгаа. Нүүрсний энэ олон өмнө илэрч байсан хэргүүд урьд нь Ардчилсан намын дарга байсан Монгол Улсын Ерөнхий прокурор Дорлигжавын үед хэрэгсэхгүй болсон байна лээ. Маш олон

хэргүүд хаагдсан байна лээ. Өөрсдийнх нь хамаарал бүхий хүмүүс нүүрсний гэрээ байгуулж ажилладаг гэдэг нь тогтоогдож байгаа. Учир шалтгааны бүх асуудлууд ер нь зангилаа нь тодорхой болж байгаа.

Тийм учраас би хэлээд байгаа шүү дээ. Энэний дараа, энэ сонсголын дараа олон юм ил болсны дараа би Хууль зүйн сайдын хувьд энэ бохир хуулийнхнаасаа салах ажлыг манлайлж хийнэ. Би шүүхийг чадахгүй шүү дээ. Харин энэ Шүүхийн сахилгын хороо гарснаас хойш бид нар хавар тайланг нь сонсож авч үзэхэд шүүхийн шинэ байгуулагдсан Сахилгын хороо сүүлийн 1 жилийн хугацаанд өмнөх 10 жилийн хугацаанд шүүгч нартай хариуцлага ярьж байсан дүйх хэмжээний хариуцлагыг 1 жилийн дотор тооцсон байна лээ. Энэ юу гэсэн үг вэ. Өнгөрсөн 10 жилд шүүгч нартай огт хариуцлага тооцдоггүй байсан гэсэн үг шүү дээ. Толгойг нь илдэг байсан гэсэн үг шүү дээ. Сайн цаг ирж байгаа. Бид маш их хулгай ярьж байгаа, мэдэж байгаа. Тэгэхдээ олон зүйл ил болж байгаа. Тэр хэрээр бид энэ бүх буглаануудаасаа, хувалзуудаасаа салж, сайн цагийг авчирна.

Л.Мөнхбаатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя. 1 минут.

О.Цогтгэрэл: Түрүүн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хариулсан л даа. Тэр дагаж орж ирж байгаа яг энэ авлигын хэргийг шийдвэрлэх саяын тэр хэлбэршүүлсэн онцгой комисс шиг энэ хууль зүйн заалт дээр Шүүхийн ерөнхий зөвлөл тусгайлан санал өгөөгүй. Санал өгөөгүй гэж байна л даа. Тэгэхээр энэ шүүх байгуулах асуудлыг шүүх нь өөрөө Шүүхийн ерөнхий зөвлөл нь санал өгөхгүйгээр Засгийн газар түрүүн энэ Хууль зүйн сайдын үгэнд гардаг Засгийн газар гүйцэтгэх байгууллага нь шүүх байгууллага руугаа шууд халдаад, шүүх байгууллагыгаа шүүхийн гадуур шүүх байгуулъя гэдгийг Засгийн газар ингэж

бие даасан байдал руу нь шүүхийнхээс санал авахгүй орж ирэхэд чинь энэ чинь өөрөө дахиад хуульд нийцэж байгаа билүү. Шүүхийн асуудлыг Засгийн газар Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг л авч орж ирэх ёстой биз дээ. Дээд шүүхийн байна уу?

Гэтэл ямар ч саналгүйгээр харилцан хяналт тавих ёстой хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглал бие биеийнхээ эрх рүү шууд ингэж энэ халдах нь өөрөө Үндсэн хуульд нийцэх үү энэ ер нь? Үндсэн хуулийн үзэл санаанд яг ийм байх.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Энэ яах вэ. Таны хэлж байгаа чинь энэ шүүх байгуулах хууль өөрөө тодорхой процессын дагуу явдаг, процедурын дагуу явдаг. Тэрийг дагалдуулаад дагалдуулаад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулж байгаа нэмэлт, өөрчлөлт байгаад байгаа шүү дээ тээ. Энэ дээр сайд тодруулаад хариулчихъя даа. Энэ ялгаатай зүйл байгаад байгаа шүү дээ. Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хууль санаачлах 3 этгээд байгаа Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар. Шүүхийн ерөнхий зөвлөл болон Улсын дээд шүүх нь хууль санаачилдаггүй. Үндсэн хууль ёсоор хууль санаачлах эрх эдэлдэггүй. Тэгэхээр Шүүхийн тухай хуульд зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулна, Улсын дээд шүүхтэй зөвшилцөнө. Тэгээд Засгийн газартай хэлэлцээд энэ Шүүх байгуулах тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барьж байгаа юм. Засгийн газар бол хууль санаачлагч, хууль санаачлагч. Шүүхийн ерөнхий зөвлөл хууль санаачлагч биш.

Тэгэхээр та ингээд санаач Засгийн газар ерөөсөө ийм юм ярих ёсгүй юм шиг яриад байх юм. Үндсэн хуульд чинь үгүй үгүй Ерөнхий зөвлөл боловсруулна, Засгийн газар хууль санаачилна гээд байна шүү дээ. Тийм Улсын дээд

шүүхтэй зөвшилцсөн саналыг авна гэж байна. Тийм, хууль санаачлах, хууль санаачлах бүрэн эрхтэй байна шүү дээ. Хууль тогтоогч энэ асуудлыг ажлын хэсэг гаргаад өргөн хүрээнд ярих, эцсийн шийдвэр гаргах нь хууль тогтоогчид байгаа байхгүй юу. Тийм. Нэг авлигач прокурорыг хамгаалаад л, ямар ч холбоотой юм. Мөнгө угаадаг, дээрэмдсэн газар дээр нь орон сууц барьдаг бусдаас. Ийм холбоотнуудаа хамгаалаад байх хэрэггүй.

Л.Мөнхбаатар: Энэ хоёр ялгаатай ойлголт байгаа шүү дээ. Шүүх байгуулах тухай хууль өөрөө Улсын дээд шүүхийн саналыг үндэслээд Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулаад явуулдаг процесс. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал бол хууль санаачлагч буюу Засгийн газрын өөрийнх нь бас бүрэн эрхийн асуудал байгаа. Ийм хоёр ялгаатай ойлголт байгаа гэдгийг гишүүдэд хэлье. Одоо Цогтгэрэл, Энхбаяр хоёр чимээгүй бай. Хуралдаан явуулахыг битгий хэрэлдээд бай та хоёр. Та хоёр битгий хэрэлдээд бай. Хуралдаан явуулах боломжоор ханга. Чинбатын Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Иргэдийн шүүхэд итгэх итгэл маш бага байна. Одоо та хэд гараад л захын хүнээс асуугаад та шүүхэд итгэж байна уу гээд шударга шүүнэ гэж итгэж байна уу гэж асуух юм бол ихэнх нь итгэхгүй байна гэж хэлнэ. 2020, 2021 онд бид нар шүүхийн реформ гээд л хуулиа хэлэлцээд баталсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулаад, Сахилга хариуцлага, ёс зүйн хороо хажууд нь байгуулаад шүүх нь өөрөө өөрийгөө цэвэршүүлээд явна гээд маш их итгэл энэ надад хүртэл төрж байсан тухайн үед.

Өнөөдөр бид нар 2023 он дуусах гээд дахиад л шүүхэд итгэх итгэл бага байна. Бид нарын өмнө боловсруулж баталсан хууль маань хангалттай биш байсан юм уу. Тийм учраас энэ хуй хууль

орж ирж байгаа юм уу. Өнгөрсөн хугацаанд харахаар авлига, албан тушаалын хэрэг арай л дэндэж байна. Энийг хууль санаачлагч ч хэлж байна, бүгд хэлж байна. Жирийн ард иргэдийн асуудлыг 3 сар дотор шүүчихдэг. Авлига, албан тушаалын гэмт хэргийг 7 жил гацаадаг гэж сая Ерөнхий сайд хэлж байна шүү дээ. Шүүхэд итгэхгүй байгаа учраас энэ авлигачид чинь хүртэл гаараад байна шүү дээ. Энэ авлигачид би мултарч чадах учраас гэж итгэлтэй байгаа учраас энэ үйл ажиллагаагаа явуулаад байна шүү дээ. Авлига, албан тушаалын гэмт хэрэг хийчхээд цаана нь ард түмэн хохироод, ард түмнээс хулгай хийчхээд, ард түмний боломжийг хулгайлчихаад миний хэрэгт хохирогч байхгүй гээд тийм юм шүүх дээрээ яриад явж байна шүү дээ. Энэ авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй хүмүүс.

Тэгэхээр өнөөдөр энэ хууль орж ирснээр энэ асуудал яг шийдэгдэх үү? 2020, 2021 онд шүүхийн реформ хийж байхад шийдэгдэнэ гээд бид нар ярьж байсан бол өнөөдөр шийдэгдэхгүй байна гээд энэ асуудал орж ирж байна. Тэгэхээр авлига, албан тушаалын гэмт хэрэг энийг баталснаар шийдэгдэх үү, энд хэр итгэлтэй байна вэ гэдэг ийм асуудал асуулт байна.

Дараагийн нэг асуудал нь энэ иргэний маргаан гэж хэлэлцэгддэг компани хоорондын асуудал байна. Компаниуд нэг нэгнээ ерөөсөө хуурдаг, хулхиддаг. Бүүр энэ хууль хүчний байгууллагуудтай эвсэн нэгдэж байгаад дээрэмддэг энэ асуудлууд гаарч байна. Компани хоорондоо мөнгийг нь авчхаад, хагас мөнгийг нь төлчхөөд ажлаа хийлгэхээд үлдсэнийг нь шүүхдээд аваарай чи гээд сууж байдаг болсон байна. Эсвэл гүйцэтгэх захирал нь компаниасаа хулгай хийчхээд чи шүүхдээд олоод аваарай гээд нөгөө хулгайлсан мөнгөөрөө эргээд шүүх, хууль хяналтын байгууллагуудаа авлигадаад явдаг болсон байна. Ийм үед хувийн хэвшил чинь хүртэл цаашид энэ улсад

бизнес хийхэд ямар ч баталгаа байхгүй болсон байна шүү дээ. Хөрөнгөө гадаад руу аваад явсан нь илүү шударга нийгэмд очоод хөрөнгө оруулсан нь дээр болох гээд байна шүү дээ. Энэ асуудлыг ер нь яаж шийдвэрлэх ёстой юм бэ. Энийг энэ асуудал хэлэлцэгдэж байгаа үед би ер нь асуух ёстой гэж бодоод асууж байна.

Шүүхийн ёс зүй, сахилга хариуцлагын хороо ер нь өнгөрсөн хугацаанд хэдэн шүүгчийн асуудлыг хэлэлцээд хариуцлага тооцсон байдаг юм бэ. Энэ Ёс зүй, сахилга хариуцлагын хороо чинь ажлаа хэр хийж байна. Хараат бусаар, нөлөөнд автахгүйгээр хийж чадаж байна уу, үгүй юү. Тэр олон авлигач шүүгч байгаад байна гээд байна шүү дээ. Эд нарыгаа олж авч илрүүлж чадаж байгаа юм уу, яг юу хийсэн юм, ямар тайлан байгаа юм. Сонсмоор байна.

Л.Мөнхбаатар: Ер нь нэлээн эмоцтой асуугаад байна. Асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр хариулъя. Тэр шүүгчийн Сахилгын хороотой холбоотой асуусан асуулт байна шүү дээ хэдэн шүүгчид хариуцлага тооцсон бэ гээд байгаа. Тэн дээр нь Шүүхийн ерөнхий зөвлөл хариулчихъя. Баттөмөрийн Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Яг Ундрам гишүүний яг асуултад хариулах ёстой байгууллага нь бол энэ танхимд байхгүй байгаа юм. Тэр нь Шүүхийн сахилгын хороо байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл болохоор юу шүү дээ шүүгчийг сонгон шалгаруулах, шүүхийн хараат бус байдлыг эдийн засгийн бие даасан байдлыг хангах ийм байгууллага нь Шүүхийн ерөнхий зөвлөл. Шүүгч нартай хариуцлага тооцох газрыг нь бид нар чинь 19 онд Үндсэн хуулийн өөрчлөлт хийгээд Шүүхийн сахилгын хороо гээд бие даасан байгууллага гаргачихсан шүү дээ. Энэ бас бие даасан байгууллага байгаад байгаа юм. Би сая хэллээ Хууль зүйн байнгын хороо бол энэ оны хаврын чуулганаар Шүүхийн

сахилгын хорооны хийсэн 1 жилийн ажлын тайланг бол сонссон Байнгын хороон дээрээ. Ундрaм гишүүний юу яасан ер нь юу л яах ёстой юм байна л даа. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн чуулган дээр энэ ирэх жил бол энэ Шүүхийн сахилгын хорооны тайлан сонсгож баймаар юм байна.

Тэгэхгүй болохоор зөвхөн Байнгын хороон дээр сонсоод өнгөрчихөөр бас Хууль зүйн байнгын хороонд харьяалагддаггүй гишүүд маань бас асуулт асуух, байр сууриа илэрхийлэх энэ боломж юмыг нь бас хязгаарлаад байгаа юм болов уу даа гэж би зүгээр сая бодож байлаа. Энэ тайланг сонсож байхад Шүүхийн сахилгын хороонд зүгээр тоон үзүүлэлтээр бол би сая хэлсэн Цогтгэрэл гишүүний асуултад хариулахдаа. Сүүлийн 10 жилд шүүгч нарт хариуцлага тооцож байсантай дүйх хэмжээний хариуцлагыг сүүлийн 1 жилд Шүүхийн сахилгын хороо шинээр байгуулагдаад тооцчихсон байна лээ. Тоон статистикаараа.

Тэгэхээр энэ бол механизм бол ямар ч байсан ажиллаж эхэлж байна гэсэн үг. Ажиллаад эхэлчихсэн байна гэсэн үг. Энийг яах вэ хоёр талтай л байх ёстой. Нөөгөө талдаа шүүхийн сахилгын хороог бас шүүгч нарыг дарамталдаг, дарамталж байгаад шийдвэр гаргуулдаг бас давхар дабл/double/ хонгил болгочхож бас болохгүй. Шүүгчийг нь Шүүхийн сахилгын хорооноос нь хүртэл нөлөөлөхгүй байх тэр баталгаа маань бас бид боддог байх ёстой. Тэгэхгүй бол бас ялих шалихгүй юмаар шүүгчийг төмсөгдөөд шийдвэр гаргахад нөлөөлүүлдэг, захиалга өгдөг ийм хонгил угсрагдах эрсдэл бол байдаг. Энэ аль ч улсад байдаг гэдгийг бодох ёстой.

Ер нь их олон хүчин зүйл нөлөөлж байгаа юм. Жишээлбэл сая Хөгжлийн банкны шийдвэр гэхэд чинь 1300 хуудас шийдвэр байгаа байхгүй юу. 1300 хуудас. Хэргийн оролцогчид нь хувилж хүргэх гэхэд л тэнд гарч байгаа зардлууд, хүн

хүч, тэр чинь 1 шүүгч 1 туслахтайгаа л үзээд байгаа шүү дээ. Шийдвэрээ гаргах гээд. Тэгэхээр энэ ажлын ачаалал гэдэг юм уу, энэ онцлог юмнуудыг нь аль алийг нь бас бодож байж л байх ёстой юм байна лээ л дээ.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

Б.Баттөмөр: Шүүх байгуулах саналыг оруулж ирж байгаа судалгаа тооцооны үндсэн дээр оруулж ирсэн гэж ингэж ойлгож байгаа. Яах вэ дээ Монгол чинь бол Монгол Улсын хөгжлийн энэ мухардлыг ингээд судлаад үзэхээр зэрэг юу гэхлээр Монголын хөгжлийн мухардал Монгол хүнтэйгээ холбоотой гэж. Төрийн байгууллага бол цөөдөөгүй Монголд. Шүүх ч ялгаа байхгүй.

Тийм учраас энэ дээрээ бодож ажиллацгаана биз дээ гэж ингэж үзэж байгаа юм. Яах вэ шүүхийн холбоотой хэд хэдэн зүйл ярья гэж бодож байгаа юм. Ер нь өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монголчууд Монголын төрөө, Монгол Улсаа, газрын баялгаа, хүмүүсийн бий болгочихсон баялгийг л тонож амьдарлаа шүү дээ. Ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн 30 жилийн хамгийн анх эхэлж Монголбанкинд байсан 500 сая доллартой тэнцэх хэмжээний баялгийг алт дилерийн хэрэг гээд алга болсон. Хэн ч хариуцлага тооцоогүй. Дараа нь өмч хувьчлал 8136 объектыг хувьчилсан байдаг. 1830 орчим үнэтэй цэнтэй объектыг хувьчлал нэртэй авцгаасан. Үүнээс ядуурал, ажилгүйдэл үүссэн. Хэн ч хариуцлага тооцоогүй.

Цаашаа бүүр газар тойрсон асуудал байна, ашигт малтмал тойрсон асуудал. 6236 лицензийг л хоорондоо шилжүүлээд худалдчихсан байгаа шүү дээ. 100, 100 сая доллароор лиценз худалдсан байж байдаг, баялгийг. Хэнтэй ч хариуцлага тооцоогүй. Тэгээд цаашаа сангууд байна, Хөгжлийн банкны асуудал байна, нийслэл тойрсон асуудал

хэнтэй ч хариуцлага тооцохгүй л байгаад байгаа юм. Сая Хөгжлийн банкны асуудлыг шүүх дээр шийдлээ харамсалтай л байгаа. Энэ бүгд бол юу гэхлээр зэрэг л энэ манай шүүгч нарын хувьд маш сайн ажиллаж байгаа шүүгч нар байгаа, маш муу ажиллаж байгаа шүүгч нар бас байгаа. Томилогдсон, томилсон хүнийхээ эрх ашгийг хамгаалдаг бас хувийн сонирхолтой ийм хүмүүс байдаг гэж ингэж ярьдаг. Надад бол тийм судалгаа алга.

Тийм учраас энэ хөгжлийн ёс зүй гэж байдагтай адилхан шүүгчийн ёс зүй ёс суртахууны асуудлыг бол гаргаж ирж тавихгүй бол ерөөсөө болохгүй. Бид хүнтэйгээ л ажиллах ёстой. Энэ манлайллын мэргэжилтэн Жон Максвилл гэж хүн байдаг. Тэр хүн хэлсэн байгаа шүү дээ. Ерөөсөө хөгжсө гэвэл удирдагчаа зөв сонго, манлайлагчаа олж сонго, чадахгүйг нь соль, маш хурдан соль гэж. Энэ бол яг бидэнд зориулаад л хэлчихсэн үг байх. Тийм учраас энэ дээр анхаарч ажиллах ийм шаардлага бол байна гэж ингэж үзэж байгаа юм. Асуудал томрох тутам, эрх мэдэлтнүүд оролцох тутам шүүх дээр асуудал бүдгэрдэг. Тэр Анод банкны хэрэг гээд 10 хэдэн жил явлаа шүү дээ. Энэ чинь яаж ч явж зарим улсууд нь замд нь үхэж нас бараад ийм л байдалтай явж байгаа байхгүй юу.

Ер нь бол их төвөгтэй статистик бий дээ. Энэ 4-хөн минутын хугацаанд бол ярих боломж их бага. Дагнасан шүүх байгуулж болно. Тэгэхдээ шүүгч нарынхаа ёс зүй, ёс суртахуун, мэдлэг боловсрол, шилж сонголт. Энийг ярихгүйгээр шүүх цаашаа шударга шүүх тогтоно гэж байхгүй. Тийм учраас энд нэг асуулт байна л даа. Хамгийн сүүлчийн асуулт энэ шүүгч нарын мэдлэгийг, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шилж сонгох, тэр ажилд нь үнэлэлт дүгнэлт өгөх, шударга ажиллаж байгаа шүүгч нарыг дэмждэг, урамшуулдаг, шударга бишийг нь сольдог ийм юмнууд ямархуу хийгдэж байна. Сая

тэр сайдын үгэнд Сахилгын хороо их сайн ажиллаж байгаа л юм байна. Ер нь цаашидаа ямар бодлого авч хэрэгжүүлэх вэ гэсэн ийм асуултад хариулт асуултад хариулъя.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Онончимэг хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье.

Р.Онончимэг: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Шүүгчийг шилжүүлэх шударга шүүх гэсэн асуудлыг тавьж байна. Ер нь 19 оны Үндсэн хуулийн өөрчлөлт, 21 оны шүүхийн хууль, яг шүүхийн хууль баталсан ирэх 10 жил хэрэгжих шүүх эрх мэдлийн бодлого, өнөөдөр бас шүүх байгууллага хууль эд нар яг шинэчлэлийн дагуу, хуулийнхаа дагуу орж ирж байгаа ийм процесс байгаа.

Ер нь бол бид хэд бас энэ 2 жилийн өмнө бас яг энэ парламентаас нээлттэй сонсголоор томилогдоод явж байсан. Энэ шүүхийн асуудал бол шударга шүүх, энэ шүүх өөрөө олон нийтийн итгэлийг хүлээхийн тулд ерөөсөө эдийн засгийн хувьд хараат бус байх, төсвийн бие даасан байдал бол үнэхээр чухал гэдгийг удаа дараа бас төсвийн асуудал ярихад ярьсан. Бодлого дээр бид нар энэ асуудлыг тусгаж оруулж ирж байгаа. Энэ шүүх байгуулах хууль хэрэгжих процессыг ч гэсэн төсөв, эдийн засаггүйгээр шийдэх ямар ч боломж байхгүй. Тэгэхээр шударга шүүх, шударга ёсон дээрээ бид нар ямар хэмжээний мөнгө тавьж байна вэ гэдэг дээр Их Хурлын гишүүд маань анхаараад энэ ирэх 10 жилийн бодлого болон Шүүх байгуулах хуулийг хэрэгжихтэй холбоотой төсвийн асуудал дээр, шүүх эрх мэдэл өөрөө хараат бус байх асуудал дээр эдийн засгийн баталгааны асуудал дээр анхаарч бас шийдвэрүүдээ гаргаж өгөөсэй гэж хүсэж байна.

Сонгон шалгаруулалт дээр бас асуулт асуусан. Сонгон шалгаруулалтын

хувьд бас түрүүн бид хэд хариулсан. Нийт 5 дахь удаагийн сонгон шалгаруулалт явж байна. Бид нар нэлээдгүй сая 60-аад орон тоон дээр орон тоо зарлахад бол 120 гаран хүн бүртгүүллээ. Одоогийн байдлаар 20 гаран хүн тэнцэлтэй явж байна.

Нэгдүгээрт, түрүүн манай гишүүн хариулсан мэдээж тухайн хувь хүний бэлтгэл байна.

Хоёрдугаарт, шүүхийн ачаалал нэлээдгүй байна, их хуримтлагдчихсан юм байна лээ.

Гуравдугаарт, шүүхийн цалин хангамж маш багатай байна, өрсөлдөхүйц биш байна. Сүүлийн 8, 9 жил энэ шүүхийн цалин хангамжийн асуудлыг бас өөрчлөх талаар огт яригдаагүй. Энэ асуудал маань өөрөө шүүгчийн албан тушаалыг бас өрсөлдөхүйц байх нөхцөлийг бас бүрдүүлж чадахгүй байна гэдэг энэ асуудлыг тавьж танилцуулж байгаа. Их Хурал маань шүүгчийн цалин, орон тооны асуудлыг шийднэ. Бодлого дээр бас ирэх 10 жилийн бодлого дээр энэ талаас тусгагдсан явж байгаа дэмжээрэй гэж хэлье.

Л.Мөнхбаатар: Багаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

Б.Баттөмөр: Манай Их Хурлаас бол энэ авлигатай тэмцэх чиглэлд Эрүүгийн хуульд, холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж өгч байгаа. Нэлээн сайн өөрчлөлт оруулсан гэж ингэж бодож байна. Ер нь бол энэ хөгжлийн энэ авлига гэдэг зүйл Монголыг хөгжлийг хавханд оруулчихсан байгаа шүү. Авлигалаас үүдэлтэй ядуурал үүссэн. Ядуурлыг хавханд бас оруулчихсан.

Дээрээс нь хүмүүсийн итгэл үнэмшил байхгүй болсон. Монгол Улс хөгжье гэвэл авлигатай л тэмцэх ёстой. Хамгийн эхний асуудал. Энэ дунд түвшинд бол үнэхээр аймшигтай

болчихсон байна шүү дээ. Ерөөсөө юу хийхээс ч буцах юм байхгүй. Тодорхой амьдралаа эндээс дээшлүүлье гэсэн хүмүүс ордог болчихсон. Сайхан залуучууд ажиллаж байна. Ерөөсөө л авлигал. Гарыг нь хүндрүүлэхгүй бол ерөөсөө асуудал хийдэггүй. Нөөгөө л хэдэн баялаг бүтээгч юм хийе гээд очихоор урдаас нь авлигал нэхдэг. Авлигатай, авлигалыг ялахгүйгээр Монгол хөгжихгүй. Тийм учраас энд бол шударга.../минут дуусав./

Л.Мөнхбаатар: Байр сууриа илэрхийлж үг хэллээ.одоо Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд асуултаа асууя.

Н.Энхболд: Засгийн газраас оруулж ирсэн энэ шүүхтэй холбоотой, биеэ даасан шүүхтэй холбоотой хуулийн төслүүдийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Зарчмын хувьд. Энэ дээр олон гишүүн хэлж байгаа нэг л зүйл байгаа. Энийгээ ашиглаад хүний эрх зөрчигдөх вий тийм ээ, янз бүрийн улс төрийн шалтгаанаар хүнийг хэлмэгдүүлэх вий ийм л юм ярьж байна. Түүнээс энэ дотор авлигын эсрэг тэмцэхгүй гэсэн хүн байхгүй байгаа байх л даа.

Тэгэхээр энэ хуулийн зохицуулалт дотор ингээд энэ шүүхийг байгуултал түр ажиллахад, байгуулсан хойно хүмүүсийг хэлмэгдүүлэхгүй гэсэн баталгаа яг аль заалт, зүйл дээр нь бид нар ойлгох вэ? Энэ хууль дотор тодорхой юмнууд байна уу? Байхгүй бол бусад хуулийн ямар зүйлээр зохицуулах вэ. Үүнийг нэгдүгээрт хариулмаар байна.

Хоёрт яг хуультай холбоотой нэг ийм тодорхой асуудал байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай ийм заалт байж байгаа. Шүүхийн шийдвэрт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүрэлцэн ирээгүй нь шүүхийн шийдвэрийг хүлээн авах эрүүгийн шийдвэр гүйцэтгэх

ажиллагааны хэрэг үүсгэхэд саад болохгүй гэсэн томъёололтой юм байна. Энийг яагаад жишээ нь хүрэлцэн ирээгүй бол шийдвэрийг хүлээн авах эрүүгийн хэрэг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэг үүсгэх үндэс болно гээд биччихээж болдоггүй юм шууд. Үүсгэхэд саад болохгүй энэ тэр гээд л тойруулсан тийм битүү утгатай ч юм шиг юм байгаад байх юм. Ийм үндэс болно. Ингээд биччихлээ гэж бодъё.

Тэгвэл ингээд хэрэг үүсгэчихсэн байхад шүүхээр шийтгүүлчхээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар ирэхгүй байгаа хүний ял нэмэгдэх үү? Зүгээр л хайгаад л дэмий л хайгаад л яваад байдаг юм уу, эс үгүй бол бариад ирсэн хойноо тэр ялыг нь нэмдэггүй юм уу. Энэнтэй уялдаад гурав дахь асуудал гарч байна. Ойлгохгүй байна. Би энэ тайлбар дээр ийм юм биччихсэн байх юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүчин төгөлдөр болсон шүүхийн зарим шийдвэрүүдийг хүлээлгэн өгч чадахгүйгээс болоод 158 хүний холбогдох талууд биелэгдэхгүйд хүрч байна гэж байна. Шүүхийн зарим шийдвэрийг хүлээлгэн өгч чадахгүй байгаа гэдэг нь яг юу гэсэн үг вэ. Энгийн үгээр бол энгийн хүн ойлговол. Яагаад хүлээлгэж өгч болдоггүй юм тэрийг чинь. Дахиад үүнтэй уялдаад 20 онд гарсан билүү би оныг нь санахгүй байна. Шийдвэр, хүн хоёроо хамт хүлээлгэж өгөхгүй бол болохгүй байна гэж баахан ярьж ярьж байгаад тийм хууль гаргачихсан. Одоо тэрийгээ үүгээр хүчингүй болгож байгаа юм уу тээ? Шийдвэрээ явуулчихаад л болно шүүх. Тэгсэн мөртөө энэ дээр шийдвэрээ хүлээлгэж өгч чадахгүй байна гээд биччихсэн байгаа юм. Ийм хоорондоо би лав уншаад үүнийг ойлгохгүй нь. Энэ дээр тайлбар өгөөч хэн нь байдаг юм. Тэгээд би нэмж асууя. 4, 5 асуулт асуучихлаа шүү.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье. Ундрах гишүүн хариулъя.

Б.Ундрах: Баярлалаа. Асуултад хариулъя. Шүүх байгуулах тухай хуультай холбогдуулаад шүүхийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах ийм заалт байгаа. Энэ бол зөвхөн цэвэр шууд шүүх хууль хэрэглээтэй холбоотой зохицуулалтыг нэгмөр болгох ийм асуудал байгаа юм. Судалгаанаас үзэх юм бол торгох ялтай 174 хүн. Торгуулийн хэмжээ болохоор 141 сая 76 мянган 89 төгрөг, нийтэд тустай хөдөлмөрийн 58 мянга 709 цагийн ажил хийх 151 хүн, тэнссэн 55, зорчих эрхийг хязгаарласан 47, нийт 427 хүний буюу хорихоос өөр төрлийн ялтай хүний шүү шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бид нар тогтоолыг нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны байгууллагад хүлээлгэж өгөх чадахгүй ийм нөхцөл байдал байгаа.

Яагаад ийм байгаа вэ гэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн шийдвэр гарснаас хойш буюу шүүх хэргээ эцэслэн шийдвэрлэснээс хойш 5 хоногийн дараа шүүхийнхээ шийдвэрийг шийдвэр гүйцэтгэх байгууллагад хүргэж өгдөг. Хорихоос өөр төрлийн ял авсан хүн аль нэг газар очиж эрхээ хязгаарлуулахгүй гэр рүүгээ явна гэсэн үг. Тэгээд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болоод нөгөөдхөө аваачиж өгөх үед тэр хүнтэй нь аваачиж өгөөрэй гэсэн ийм л заалт. Шийдвэр гүйцэтгэлийн тухай хуульд хүнтэй нь авна гэсэн ийм заалт байгаа.

Тэгэхээр тэр хүн ерөөсөө буцаж ирдэггүй ийм л асуудал байгаа. Шүүхэд хэргийг эцэслэн шийдвэрлэснээс хойш буюу Анхан шатын шүүхийн шийдвэр гарснаас хойш шүүх ямар нэгэн эрхийн акт гаргах зохицуулалт хуульд байхгүй. Өөрөөр хэлэх юм бол шүүгч захирамж гаргаад тэр ирэхгүй байгаа хүнийг албадан авчрах, эрэн сурвалжлах захирамж хуульд нь байхгүй. Ийм асуудал байхгүй байгаа учраас бид нар хүнээ олоод аваачиж өгч чадахгүй байгаа. Шийдвэр гүйцэтгэлийн байгууллага бол хүнтэй нь авах энэ

хуулийн заалтаас болоод хүн нь байхгүй байгаа учраас авч чадахгүй ийм л асуудал байгаа юм.

Тэгэхээр цэвэр хууль хэрэглээний хувьд энийг зохицуулах ёстой. Яагаад тэр ял Шүүхийн тухай хуультай, Шүүх байгуулах тухай хуультай хамт орж ирээд байгаа юм бэ гэхээр шүүх дээр энэ ажиллагаа дуусчхаж байгаа, шийдвэр гүйцэтгэл дээр эхлээгүй байгаа гээд дунд нь хорихоос өөр төрлийн ял авсан хүн завсардаж байна л гэж ингэж ойлгож байгаа. Тийм учраас энийг зохицуулах зайлшгүй шаардлагатай байгаа учраас энэ саналыг энэ хуультай хамт оруулж ирсэн.

Л.Мөнхбаатар: Нямаагийн Энхболд гишүүн тодруулж асууя.

Н.Энхболд: Болдоггүй юм уу, юу нь болдоггүй юм? Миний хугацаа яваад дууслаа.

Г.Занданшатар: 89.

Х.Ариунболд: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга хурандаа Ариунболд илтгэж байна. Тухайн үеийн 2017 оны тухайн үеийн парламентын гишүүдээр энэ шүүхийн шийдвэр биелүүлэхэд хорихоос өөр төрлийн ял албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг хүлээж аваад, авахад хүндрэл гараад байна. Оргон зайлсан асуудал улсын хэмжээгээр тоо 400 даваад байна гэсэн асуудлыг үндэслэлтэй гаргаж ир гээд тухайн үеийн Монгол Улсын Их Хурлаас үүрэг өгсөн. Үүргийн дагуу үндэслэлийг нь гаргаж ирсэн. 2019 онд 403 ялтан этгээд оргосон байсан. Энэ үндэслэлээ гаргаж ирээд хуучин хуульд бол 185.1 нь албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг гүйцэтгэх хуудас албадлагын арга хэмжээ авагдсан этгээдтэй цуг байна гэсэн байсан. Энэ дээрээ нэмээд 153.1 дээрээ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульдаа хорихоос өөр төрлийн ялаар шийдэгдсэн этгээдийг гүйцэтгэх хуудас, шийдвэрийн

хамт хүлээж авна гэж оруулснаар улсын хэмжээнд хорихоос өөр төрлийн ял албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийн оргон зайлах асуудал таслан зогсоогдсон гэж үзсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бол энэ зүйл, заалт бол хэвээрээ явах боломжтой. Шүүхийн ерөнхий зөвлөл Монгол Улсын шүүхтэйгээ ойлголцоод ажлын хэсэг дээр яриад явчих боломжтой. Заавал хуульдаа өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн тодруулъя. Дараа нь санал хураалттай гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Н.Энхболд: Түрүүчийн асуултад саад болох үндэслэл болохгүй гэдэг дээр нэгдүгээрт тэрэнд.

Хоёрдугаарт, тэр юу байна шүү дээ. Хэрэв тийм бол заавал энд өөрчлөлт оруулахгүйгээр ерөөсөө хууль нь тэгээд болохгүй байгаа юм бол Шүүхийн шийдвэр хэрэгжүүлэх газраас шүүхдээ эргэж мэдэгдээд, танай тогтоол ирчихсэн чинь хүн чинь алга болчихлоо, ирэхгүй байна хугацаандаа. Тийм учраас шууд автоматаар тэн дээр нь дахиад хэрэг нээгээд, шүүхийн шийдвэр хэрэгжүүлэхгүй байна гэдэг хэрэг нээгээд, анхааруулаад, дараа нь ялыг нь нэмээд явчих явцыг ийм зохицуулалт хийчхэж болдоггүй юм уу? Тэгвэл илүү амархан л баймаар байна. Тэгвэл би очихгүй бол болохгүй шүү дээ гээд бушуухан очиж ялаа эдэлдэг байна уу, мөнгөө төлдөг байна уу, нийгмийн тустай хөдөлмөр хийдэг юмаа байна уу хийх юмнууд нь боломжтой шүү дээ. Тэгэхээр энэ 2 замын аль нь эвтэйхэн юм бэ тэрийг та нар. Би бол санал болгож байна. Ажлын хэсэг дээрээ үүнийг та нар их сайн яриарай. Ярьж байж.../минут дуусав./

Г.Занданшатар: 85 хариулъя.

Б.Ундрах: Тэгэхээр энд цэвэр хууль хэрэглээний асуудал байгаа юм. Хэзээ сайн дураар биелүүлэх асуудал эхлэх вэ гэхээр тэр хүний тогтоол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад очсоноос хойш сайн дураараа биелүүлэх хугацаа тоологдоно. Тэгэхээр тэнд очоогүй байгаа тохиолдолд процесс ажиллагаа эхлэхгүй. Шүүх дээр дуусчихсан шийдвэр гүйцэтгэл дээр эхлээгүй байгаа тохиолдолд бид нар сайн дураараа биелүүлэх хугацааг тоолохгүй. Тэгэхээр бид нар хүний эрхийг хангах үүднээс хуулийн байгууллага хуулийн хүрээнд ажиллах ёстой учраас хуульд нь заалт оруулах зайлиггүй шаардлагатай байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энийг одоо шууд үүсгэж болохгүй юу гэж асуугаад байна. Энэ бол боломжтой. Ямар тохиолдол вэ гэхээр хүнгүйгээр тогтоолоо л явуулах асуудал энд байгаа. Харин бид нар өмнө нь нөгөө хүнтэй нь аваачна гэсэн энэ заалт байгаа учраас эхлээд ялт ч байхгүй хүн нь хүрээд ирвэл тэр бичиг баримттай буюу тогтоолтой нь аваачаад өгчихье. Ирэхгүй байгаа тохиолдлыг нь хуульд зохицуулаагүй байгаа учраас ирэхгүй тохиолдлыг нь нэмэлтээр зохицуулчихъя гээд оруулсан асуудал энэ байгаа юм. Тэгж бол болохгүй. Яагаад гэвэл тэр хүнийг эхлээд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд, шийдвэр гүйцэтгэлийн байгууллагад аваачиж байж сайн дураараа биелүүлэх хугацааг нь тоолоод, тэр хугацаа өнгөрсний дараа дараагийн асуудал яригдах ёстой.

Гэтэл өнөөдөр энэ процесс орхигдчихсон байхгүй юу. Шүүх аваачиж өгч чаддаггүй, шийдвэр гүйцэтгэл дээр процесс нь эхэлдэггүй ийм л асуудал байгаа.

Г.Занданшатар: Энэ тэгэхдээ 2 талтай асуудал шүү.

Б.Ундрах: Үгүй аваачиж өгөх, хүнтэй нь аваад ир гэхчхэн заалт байгаа учраас бид нар хүнээ олохгүй. Шийдвэр гарснаас хойш ямар нэгэн эрхийн акт гаргах заалт процессын хуульд байхгүй. Одоо шүүхэд тийм чиг үүрэг байхгүй. Тогтоол.../минут дуусав./

Г.Занданшатар: Үгүй энэ шүүх, прокурор хоёр өөр байр суурьтай байх ёстой. Прокуророос Мөнхбаатар төрийг төлөөлөх хэлтсийн, 86. Хүнтэйгээ өгөх ёстой байхгүй юу. Харин тэрийг хүчингүй болгох гээд байна.

О.Мөнхбаатар: Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд шүүхээс хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг хүнтэй нь хүлээлгэж өгөх ёстой. Хүнтэй хүлээлгэж өгч байгаа шалтгаан, нөхцөл нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа бол тухайн ялтанд эрх, үүргийг нь танилцуулаад, гарын үсэг тэмдэглэлд зурснаар үйл ажиллагаа эхэлдэг учраас хүнтэй нь авах ийм шаардлага хуулийн шаардлага, зохицуулалт орсон. Одоо энэ Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэрийн ерөнхий газраас бас тал талын бас санал гаргаж, зовлон яриад байгаа юм.

Гэхдээ яг энэ өөрчлөлт, хуулийн төслийн зохицуулалтаар энэ асуудлыг нэг талд нь шийдэж чадахгүй байгаа. Тэгэхээр бас хэлэлцүүлгийнхээ явцад энийг яг хаана нь хуулийн өөрчлөлт оруулж энийг шийдвэрлэх вэ гэдэг нарийн зохицуулалт оруулж өгөхгүй бол одоо энэ хуулийн төслөөрөө энэ хүндрэл, бэрхшээл шийдэгдэхгүй.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Энэ яг хууль хэрэглээн дээрээ прокурор талынх нь бараг зөв байж магадгүй. Яагаад гэхээр хүнтэйгээ өгөхгүй бол нөгөө хүмүүс нь оргон зайлчхаад, тэрний араас шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хэчнээн хүн оргон зайлчихсан байна, оргон зайлчихсан асуудлууд дээр ямар

асуудлууд гарч байгаа билээ үгд практик амьдрал дээр мэдэж байгаа шүү дээ. Ингээд хэлэлцүүлгийн явцад тэгэхдээ яах вэ хоёр талаас нь харах хэрэгтэй.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу. Мөнхбаатар гишүүнээр тасаллаа. Лхагваагийн Мөнхбаатар, Лхагвын Мөнхбаатар гишүүн үг хэлнэ. Дараа нь санал хураалттай гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Л.Мөнхбаатар: Шүүх байгуулах тухай хуулийн төслийг хэлэлцэж байна. Бас дагалдах хэд хэдэн хуулиуд Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Үүгээр бол тодорхой шүүхүүдийг байгуулах, тойргийн шүүх байгуулах, дагнасан шүүх байгуулах гэсэн ийм хэд хэдэн асуудлууд орж ирж байгаа. Аймгуудад байгаа шүүх бол эрүү, иргэдийнхээ хэргүүдийг нэгтгээд хэлэлцээд явах нь байна. Захиргааныхан бол хуучин тогтолцоогоороо.

Үүнээс гадна дагнасан хэд хэдэн шүүхийн асуудал яригдаж байна. Гэр бүл, хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэдэг шүүх, түүнээс гадна эрүү, иргэний хялбар ажиллагааны буюу бага үнийн дүнтэй одоо бас процессын хууль нь явж байгаа шүү дээ. 11 саяас доош үнийн дүнтэй хэргүүдийг хялбаршуулсан журмаар шийддэг ийм шүүхийн асуудлууд орж ирж байна. Байгуулах асуудал нь, процессын асуудал нь бол хуулиар бас эцсийн хэлэлцүүлэг хийгдчихсэн байж байгаа юм.

Үүнээс гадна Улсын Их Хурлын тогтоолоор бол авлигалын тэр хэргийг хянан шийдвэрлэдэг дагнасан шүүх байгуулах асуудал бас мөн ингээд яригдаж байгаа. Эдгээр ийм зүйлүүд яригдаж байгаа. Энэ дээр хэлэлцүүлгийн явцад цаашидаа та нөхөд маань бас анхаарчих хэд хэдэн зүйлүүд бас байна. Яагаад вэ гэхээр ерөөсөө л энэ шүүх байгуулж байгаа энэ гол үндсэн зарчим

маань бол нь иргэдэд ойр байх, чирэгдэлгүй байх, хүртээмжтэй байх гэсэн л үндсэн том зарчмууд байгаа шүү дээ. Энийгээ их сайн барих хэрэгтэй.

Яагаад вэ гэхээр одоо ингэх нь байна л даа дагнасан шүүхүүдийн хувьд. Гэр бүл, иргэний хэргийн шүүх гээд бодоход аймаг, сум дундаараа шийдчихнэ. Тэгэнгүүт аймагт байхгүй учраас нийслэлд шийдэх нь байна тийм ээ. Нийслэлд шийдэх нь. Нийслэлд Давж заалдах шүүх нь. Хуучин бол Хөвсгөл аймгийн анхан шатаараа шийдүүлээд, давж заалдаад тэндээ шийдчихдэг байсан бол одоо Улаанбаатарт буюу нийслэлд ... харагдаж байна. Нийслэлд ирж хэргээ шийдүүлэх нь. Тэгэхээр уул нь ойрхон байх, хүртээмжтэй байх гэдэг асуудал маань ямар хэмжээнд очих вэ гэдэг ийм асуудал байгаа. Бүгд л өөрийн биеэр оролцох ёстой салалт гэдэг юм уу, гэр бүлийн гээд ийм асуудлууд байна. Ийм зүйлүүд энийг бас дахин авч үзэх хэрэгтэй байж байна.

Хоёрдугаарт, энэ шүүхийн хувьд ер нь дагнасан шүүх байгуулах юм бол нэг л зарчим барих хэрэгтэй. Анхан шат, давах, хяналт гэдэг гурвыг нэг мөр л байлгаж зохицуулах хэрэгтэй. Тэгэхгүй бол зарим дагнасан шүүх нь бол давж заалдах шатны шүүх нь анхан шатны журмаар хэргийг нь хэлэлцээд явдаг, хяналтын шатад нь болохоор давж заалдахаар шийдээд тэрийгээ эцсийн шийдвэр гэж үзэж болохгүй. Болохгүй. Энэ бол өөрөө Үндсэн хуульд заасан давах, анхан шатны болоод давж заалдах, хяналтын шат гэсэн энэ гурван шатлалаараа л явна. Авлигалын хэрэг дээр ч ялгаагүй энэ хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулж болно. Үндсэн хуулиар ер нь бол нээлттэй байгаа юм.

Гэхдээ энэ тохиолдолд ч гэсэн мөн адил л гурван шатаараа явж байж, тухайн хүний эрхийг хангана. Үндсэн хуулийнхаа үндсэн суурь зарчимд нийцнэ. Нөгөөдөх нь ер нь нэмж байгуулж байгаа

дагнасан шүүхүүдийг яг нэг ижил хэмжээнд байж байж энэ чинь өөрөө цогц болж, төлөвшиж хөгжинө гэдгийг хэлэх нь зүйтэй. Ийм зүйлүүдийг бас та бүхэн маань хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг байгуулаад нэлээн харах нь зүйтэй байх гэж би би бодож байна.

Ер нь одоо ингээд Сум дундын шүүхээр шийдчихсэн 8 сум дундын шүүх байгаа. Сум дундын 8 шүүхээр шийдчихсэн хэргүүд аймаг алгасах нь байна шүү дээ. Тэгээд Улаанбаатарт ирж шийдвэр хэргээ шийдвэрлүүлэх ийм зүйлүүд бас байж байна гэх мэтчилэн. Энэ зүйлүүдийгээ л бүх бид нар яг хүртээмжтэй байх, иргэдэд ойрхон байх гэсэн зарчимтайгаа нийцүүлэх талаас нь олон талаас нь сайн харах хэрэгтэй шүү гэдгийг бас хэлье. Ажлын хэсгийн бол хэлэлцүүлгийн явцад анхаарах өөр ч бас цөөнгүй зүйлүүд байна. Гишүүдийн өнөөдрийн ерөнхийдөө дагнасан шүүх, авлигатай тэмцэх шүүхийг тойрсон яриа руугаа түлхүү явчихлаа. Энд бол яг иргэн бүрийн тухайн тойргийн иргэдийн эрх ашигтаа хөндөгдсөн гол асуудлууд маань бол бас нэлээн анхаарлын гадна явчихлаа. Манай гишүүд бас анхны хэлэлцүүлгүүд дээр нь бас нэлээн анхааралтай харж, хуулиа сайн судлаад, ер нь иргэд тойргийнхоо иргэдийг төлөөлж байгаагийнхаа хувьд Их Хурлын гишүүнийхээ хувьд энэ дээр нэлээн нухуур ханд, нухацтай хандах шаардлага байгаа гэдгийг хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ. Нээлттэй байна шүү дээ. Пүрэвдорж гишүүн микрофон чинь нээлттэй байна.

Дэг зөрчих юм байхгүй томоотой байцгаа. Санал хураалт явуулна. Тэрний өмнө гишүүдийг дуудаж, гишүүдээ дууд. Цөөнхийн бүлгийн дарга Пүрэвдорж гишүүн ээ бүлгийн даргаа дууд. Энэ Ардчилсан намын бүлгийн гишүүдээр үг хэлүүлэх ёстой байсан юм. Ингээд үгийг нь хязгаарлаад байх юм зайлуул. Санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар Шүүх байгуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Шүүх байгуулах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Шүүх байгуулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, 3-д Монгол Улсын шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлд. Санал хураалт.

68.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Засгийн газраас өргөн барьсан хуулийн төслийг Борхүүгийн Дэлгэрсайхан сайд эсэргүүцэж санал өгсөн байна. Тийм. Чинзориг сайд бас эсэргүүцэж санал өгсөн байна. Ийм учраас энийг бас хууль зүйн дүгнэлт гаргах эрхтэй. Энэ хууль зүйн зөрчлүүдийнх нь талаар Шүүхийн тухай хуультайгаа бусад органик хуулиудтайгаа нийцэж байгаа эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргах эрхтэй юм байна. Сайдүүд нь ингэж эсэргүүцэж байгаа учраас. Ингээд төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

16.05 цаг

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Өвөлжилтийн бэлтгэл ажлын нөхцөл, өвөлжилтийн нөхцөл байдлын талаар цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээлэл сонсохоор төлөвлөсөн. Гэвч өнөөдрийн энэ хэлэлцээж байгаа асуудалтай холбогдуулаад Засгийн газраас өнөөдрийн мэдээллийн цагийг хойшлуулж маргааш өглөө 10 цагаас болгохоор Монгол Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 11 дүгээр сарын 30-ны нэгдсэн хуралдаанд хийх Өвөлжилтийн нөхцөл байдал, бэлтгэл ч биш юм даа өвөлжилт болчихоод байхад чинь бэлтгэл хангах гэж байгаа өвөлжилтийн нөхцөл байдал бэлтгэл хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийн товгыг хойшлуулж 23 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн нэгдсэн хуралдаанд хийх зохицуулалтын арга хэмжээг авч өгөхийг хүсье гэсэн Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан даргаас ийм бичиг ирсэн байгаа учраас маргааш 10 цагаас энэ Өвөлжилтийн нөхцөл байдлын талаар мэдээлэл сонсохоор хойшлуулж байна.

Нийслэлийн хуулийг бол Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг өнөөдөр анхны хэлэлцүүлгийг явуулна.

Бидний баталсан төсвийг нийслэл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 12 дугаар сарын 5-ны өдөр хэлэлцээж аймаг, нийслэлүүд төсвөө баталдаг байгаа. Тийм учраас Нийслэл хотоос 12 сарын 5-наас өмнө төслөө батлах ёстой. Хоригийн хугацаа, албажих хугацаа гээд олон цаг хугацааны тов дарааллыг тооцож үзэхэд энэ 7 хоногтоо энэ хуулийг батлах шаардлагатай байгаа. Ийм учраас өнөөдөр энэ хуулийг хэлэлцсэний дараа Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж эцсийн хэлэлцүүлгийг явуулах шаардлагатай гэсэн ийм санал, хүсэлтийг нь Засгийн

газраас Ерөнхий сайд бас тавьж байгаа. Нийслэл Улаанбаатар хотоос бас ийм асуудал тавьсан юм байна лээ. Тийм учраас энэ бас 72 санал хураалттай нэлээн том хуулийн төсөл байгаа.

Ингээд өнөөдөр бас Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцсэний хэлэлцээж шийдвэрлэсний дагуу өнөөдрийн хуралдаанаар Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг чөлөөлөх, томилох тухай асуудлыг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Ингээд сарын эцэс болж байгаа цалин хөлсөнд гарын үсэг зурах, байгууллагын удирдлагыг томилох ийм шаардлагууд гарч байгаа учраас өнөөдөр одоо бас энэний өмнө Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг шинээр сонгох асуудлыг хэлэлцэнэ. Хууль зүйн байнгын хороо хэлэлцээж санал, дүгнэлтээ гаргасан байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

Нэр дэвшигч ирж амжих нь уу, маргааш өглөө болох уу? Орж ирж байна уу? Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргыг томилох тухай асуудлыг танилцуулъя. Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан илтгэлийг сонсож хэлэлцээд хүний эрх, эрх чөлөөг хангах, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр тодорхой заалт бүхий үүрэг, даалгавруудыг өгч хэрэгжүүлж байгаа. Ингээд Монгол Улсын Их Хурлаас хүний эрхийн цогц реформыг хэрэгжүүлэх зорилтыг тавьсан. Энэ хүрээнд харамсалтай нь хүний эрхийн нөхцөл байдлын талаар иргэний нийгмийн байгууллагуудын санал, шүүмжлэл, сүүлийн үед гарч байгаа хэрэг явдлууд Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаанд бас байгаа асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн. Хүний эрхийн Үндэсний Комиссын нийт гишүүдтэй уулзалт зохион байгуулж, хүний эрх, эрх чөлөөг хангах, хүүхдийн

эрх болон хүний эрхийн асуудлуудаар байгаа нөхцөл байдлын талаар мэдээллийг сонсож ярилцсан. Үүнд нэгдүгээрт, хүний эрхийн зөрчилтэй хууль тогтоомжууд үнэлэлт, дүгнэлт өгөх асуудал үүрэг даалгавар өгөгдөөд 2 жил болж байна. Мөн хүний эрхийн асуудлаарх энэ мэдээллийн дотоод, гадаад урсгалыг нэгтгэх, гарч байгаа хэрэг явдлуудад үнэн бодит байдлын талаар мэдээлэл өгч байх, гаргасан Хүний эрхийн Үндэсний Комиссоос гаргасан шийдвэрүүдийнхээ зөвлөмж, албан даалгавруудынхаа хэрэгжилтийг бүрэн хангуулах талаар санаачилгатай ажиллаж байгаа зэргийн талаар хэлэлцсэн.

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд хуралдаад Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын асуудлыг ротацын зарчмаар хэрэгжүүлж байх ийм саналыг гаргаж, ингээд бас ротацын зарчмаар хэрэгжүүлж байгаа учраас энэ зарчимтай нийцүүлээд Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга өргөдлөө өгсөн. Өнөөдөр бид чөлөөлж шийдвэрлэсэн. Энэ бүх нөхцөл байдалд үндэслээд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос гишүүд, хамтын удирдлагын байгууллага, хамтын удирдлагын байгууллага маань нийт гишүүдээрээ хэлэлцээд дотроосоо Дугарын Сүнжидийн нэрийг дэвшүүлсэн.

Хамтын удирдлагын байгууллага нэгдсэнийг хамтын удирдлагын зарчмаар ажиллаж энд тавьсан зорилтоо хэрэгжүүлэх шаардлагыг үндэслэж тодорхой санал санаачилгууд, тухайлбал эрүү шүүлтийн эсрэг механизмыг бодитой хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх бодитой арга хэмжээнүүд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах гэж байгаа шаардлага зэргүүдээ үндэслээд энэ саналыг гаргасан байна. Санал нэгтэй Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдийн гаргасан саналыг үндэслээд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай

хуулийн 13 дугаар зүйлийн 13 дугаар хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14.1.15 дахь заалтыг үндэслэн Дугарын Сүнжидийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилуулах саналыг танилцуулж байна. Зохих журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Дугарын Сүнжид 1977 онд төрсөн. 1993 онд Хэнтий аймгийн Өндөрхаан хотын 1 дүгээр дунд сургуулийг төгссөн. 1998 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр төгссөн. 1998-99 онд Монгол Улсын Хууль зүйн сургуулийн Хууль зүйн ухааны магистр, 2002 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Людвиг Максимилианы Их Сургуульд Олон улсын харьцуулсан эрх зүйн магистр, 2006-2009 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Людвиг Максимилианы Их Сургуульд Хууль зүйн ухааны докторын зэргийг тус тус хамгаалсан.

Ажилласан байдлыг танилцуулбал 2002-2003 онд Шинжлэх ухаан академийн Философи, социологи, хүний эрхийн хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн судлаачаар, 2003-2012 онд Нийслэлийн Өмгөөлөгчдийн Зөвлөлийн гишүүн өмгөөлөгчөөр, 2005-2012 онд Хөгжлийн төлөө төв ТББ-ын гүйцэтгэх захирлаар, 2009-2014 онд Хууль зүйн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит газрын даргаар, 2014-2015 онд Хууль зүйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар, 2015-2017 онд Ерөнхийлөгчийн Тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлагийн Иргэдийн оролцоо төслийн зохицуулагчаар, 1998 оноос одоог хүртэл Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн багш, ахлах багш, дэд профессороор, 2017 оноос Хууль зүй, дотоод хэргийн яаманд Швейцарын хэрэглэлийн агентлагийн хамтарсан Иргэдийн оролцоо-II төслийн зохицуулагчаар, 2020 оноос Хүний эрхийн

Үндэсний Комиссын гишүүнээр ажиллаж байна.

Дугарын Сүнжидийн онол, практик мэдлэгийг үндэслэлийг харгалзан үзэж Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар нэр дэвшүүлж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Нэр дэвшигчийн талаар гаргасан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Оройн мэнд хүргэе. Өнөөдөр өглөө намайг огируулдаг, чөлөөлдөг дүгнэлтийг дандаа уншуулдаг гэж шүүмжилснийг манай Байнгын хорооны дарга Цогтбаатар маш хурдан шуурхай шийдвэрлэж, хүний эрхийг дээдэлдэг хүн учраас шүүмжлэлийг хүлээн авч томилсон дүгнэлт уншуулж байгаад баярлалаа. Албан ёсоор уншиж өгнө.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатаргаас 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргад нэр дэвшүүлэх саналыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх уг саналыг дэмжиж Дугарын Сүнжидийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилох нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын даргаас ирүүлсэн Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргад нэр дэвшүүлэх саналын талаарх Хууль зүйн

байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлт эрх бүхий албан тушаалтны санал болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Бадарчийн Жаргалмаа гишүүнээр тасаллаа. Өнөөдөр хугацаа сунгаж хуралдах нь байна шүү. Тамгын газар сайн анхаараарай. Энэ Нийслэлийн 72 саналтай хууль, дараа нь ахиад хоёрдугаар, эцсийн хэлэлцүүлгээ эхэлж явуулна. Ингээд Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Даваасүрэн: Нэр дэвшигчийн хувьд бол би сайн мэдэхгүй байна. Зүгээр яах вэ анкет сонсоход бол бас нэлээн туршилага хуримтлуулсан юм шиг байна. Тэгэхдээ өмнө нь бид нар ингэж байгаад л тавьсан шүү дээ. Энэ одоогийн энэ орж ирж байгаа улс хүн байна. Ер нь гялалзуулаад өгнө л гэсэн байхгүй юу. Ямар ч өөрчлөлт гараагүй. Тийм учраас би зүгээр ер нь бушуу туулай борвиндоо баастай гэдэг ингэж хурдан томилох хэрэг байсан уу, үгүй юү гэж.

Миний санал юу байна гэвэл энэ хүн яг юу хийж байж вэ, сая энэ Хүний эрхийн Комисст ажиллах хугацаандаа ямар ямар асуудлууд дээр яаж ажиллаж байж вэ гэдгийг нь уг нь бас танилцаад комиссарынх нь хувьд бас тайлантай нь танилцаад ингээд итгэл, үнэмшил болж байж уг нь томилмоор л байгаа юм л даа. Би яагаад энэ Хүний эрхийн Комиссын юун дээр ингэж анхаараад байна вэ гэвэл манайд чинь бол хэний эрх зөрчигдөж байна вэ гэж иргэдийн эрх. Тэрнээс биш энэ албан тушаал, мөнгө төгрөгтэй, энэ авлигал, янз бүрийн томоохон хэргүүд холбогдож байгаа улсууд бол үгүй шүү дээ. Тэд нар бол эрх нь тэгж хэлмэгдээд байгаа юм бол харьцангуй бага. Хөөрхий ямар ч хамгаалалтгүй байгаа иргэд л хэлмэгдээд байгаа байхгүй юу. Тэд нарыг яаж

барьж аваачаад гэдэг юм уу, ямар байдлаар хүний эрхийг хэлмэгдүүлж байхад яаж ч чадахгүй. Тухайн үед нь би бас иргэдийн сейфт нь янз бүрийн гүйцэтгэх ажлаар юм хийчхээд барьчихлаа гэж гомдол гаргахаар нь би шалгаад надад танилцуулаа ч гэсэн байхгүй. Хэрвээ тийм юм байдаг бол тэр чинь муухай шүү дээ. Гүйцэтгэх ажлын шугамаар хүний сейф рүү юм хийчхээд зэвсэглэж байсан байна гээд хүнийг барьж хорьдог бол энэ чинь муухай шүү дээ. Энийг нь тодруулаад надад өгчхөөч гэхээр өгөөгүй. Ийм л Хүний эрхийн Комисс байгаа юм. Тэр Их Хурлын даргын хувьд, миний би зүгээр хувь хүнийх нь хувьд бол мэдэхгүй учраас энэ Цогтбаатар Байнгын хорооны дарга ч гэсэндээ энэ дээр жоохон хариуцлагатай хандах байсан юм шүү дээ. Хэр судалсан юм би Байнгын хорооны даргаас асууя. Ямар ямар хэргүүд дээр яаж яаж ажиллаж байсан байна, яг юугаар итгэл үнэмшил болов. Би одоо энэ хүний тайланг сонсож байж, бүүр итгэл үнэмшил болж байж энэ арай бусдаасаа онцгой ажилласан юм байна гэж байвал даргаар нь тавимаар байна. Тэрнээс биш ингээд зүгээр л нэг дарга нэг хүн шидээд л оруулж байдаг ийм байдлаар яваад байвал энэ чинь ерөөсөө болохгүй. Яг л хэвээрээ яг л хэвээрээ байгаа байхгүй юу. Би зүгээр хувь хүний чинь хувьд тэгж байгаа юм биш шүү. Энэ байдал чинь өөрчлөгдөхгүй байгаа учраас би тэгээд байгаа юм. Хүний эрх дээр би хэлээд байна шүү жирийн иргэдийн эрх нь л илүү зөрчигдөөд байдаг байхгүй юу даа. Ямар хамгаалалтгүй тээ, эрх мэдэлгүй улсуудын эрх нь илүү зөрчигдөөд байдаг учраас би та нарыг хамгаалаач гэж ингээд байхгүй юу даа. Үгүй ер нь янз бүрийн юм сонсож байхад аймшигтай аймшигтай л зөрчлүүд энэ янз бүрийн энэ хууль хяналтын байгууллагууд явж байгаа процесс чинь болдог юм байна шүү дээ одоо.

Тийм учраас би энэ хүний эрхийн асуудал дээр энэ байгууллага нь ажилдаа эзэн болоосой гэж бодсондоо тэгээд

байгаа юм. Тэгэхгүй бол иргэдийн эрхийг хэн ч хамгаалахгүй. Тэдэнд мөнгө байхгүй, тэдэнд албан тушаал байхгүй, эрх мэдэл байхгүй. Та нар л үнэн ч ажиллаж өгөхгүй юм бол хэн үнэнч ажиллаж өгөх юм. Харин томчуудынх нь төлөө эрх ашигийнх нь төлөө гүйлдээд байх юм бол энэ чинь болохгүй шүү дээ. Тийм учраас би уг нь Их Хурлын даргад бид нарын итгэл үнэмшил болтол нь энэ хүний тайланг ажил хийсэн байдлыг нь ингээд танилцуулаад томилооч л гэж хүсмээр байна. Тэрнээс биш яг өмнөх процесс дахин давтаг.../минут дуусав./

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Энхбаярын Батшугар, Ням-Осорын Учрал, Пүрэв-Очирын Анужин нарын урилгаар Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 12, 105 дугаар сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт багш сурагчдадаа сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе. Ди парламентаар уу. Ди парламент дээр хамгийн өндөр санал авсан ийм сурагчид юм байна. Мах сайн байна e-mongolia, d.parliament цахим Монгол Улсыг бүтээх ирээдүй нь та нар шүү. Та бүхэндээ энийг л үлдээх ёстой.

Цогтбаатар дарга хариулах уу. Дамдины Цогтбаатар дарга эхлээд хариулъя.

Д.Цогтбаатар: Энэ хуулиараа хамтын удирдлагын байгууллага эд нар өөрсдөө хуралдаад дотроосоо хүнээ дэвшүүлэх ёстой. Тэрийгээ л оруулж ирж байгаа. Яг хуулийнхаа дагуу өөрсдөө хийж байгаа. Зүгээр энэ Сүнжид гуайн хувьд би бас хүний эрхийн асуудлаар олон жил хамтарч ажиллаж байгаа. Энэ дээр тэр Германд харьцуулсан улс төр судлал эрх зүйн судлалаар үгүй үгүй Хүний эрхийн Комиссын бүх хүмүүсийг би үнэхээр өөрөө яг хувь хүний хувьд алийг

нь ч бүгдийг нь сайн танина. Тийм учраас надаа энэ дээр бол юу гэдэг юм хүний эрхийн чиглэлээр ажиллаж байгаа ТББ-ынхныг ч би бүгд бүгдийг нь сайн танина.

Ялангуяа эрх зүйн чиглэлээр хүний эрхийн чиглэлээр яг судалгааны ажлууд онолын ажлууд эд нарыг харин хийсэн хүн шүү Сүнжид гуай. Тэр талаас нь би энэ дээр бас итгэл үнэмшилтэйгээр ярьж чадна. Харин таны хэлсэн нэг юман дээр би санал нэг байна. Эд нарын дуу хоолой зөөлдөөд байгаа юм.

Тэгээд би өмнөх дарга нарыг нь тавигдаж байхад ч нэг л юм хэлж байсан. Нэг ч даргаас битгий айгаарай. Та нар энд ирж дуудагдаж загнуулдаг хүмүүс биш харин гаднаас төрийг юмаа дутуу хийж байна гэж та нар загнадаг хүмүүс шүү. Тэгэхгүй байраа олохгүй андуурцаагаад энэ Хүний эрхийн Комиссынхныгоо энд авчраад загнаад дарга гээд өөрсдийгөө бодоод суугаад байдаг ийм харьцаа байхгүй шүү. Энэ чинь томилогдсоныхоо дараа хараат бус байгууллага.

Тэгэхлээр ротацийн шинэ зарчим, шинэ соёл нэвтрүүлж байгаа юм. Би энийг их зөв гэж бодож байгаа юм. Тэгээд одоо нэгэнт ийм ротацийн юм чинь Сүнжид дарга бол айхгүйгээр одоо урд байгаа яг энэ хийж байгаа үедээ л асуудлуудыг харин зоригтой гаргаж тавьж ажиллаарай гээд. Саяын жишээлбэл энэ цэргийн асуудлаар яг сонин юм хүмүүс ингээд анзаарахгүй байж магадгүй. Хэнээс ч асуухгүйгээр Хүний эрхийн Комиссынхоо аль хэдийн цэргийн ангиуд дээр очоод 2 жилийн өмнө судалгаа хийгээд дүгнэлтүүдээ гаргаад өгчихсөн байгаа юм. Сая тэр цэрэг нас барахад эд нар бүүр түрүүлж очоод яг тэр газар дээр нь аль хэдийн судалгаагаа хийчихсэн байсан юм байна лээ гэх мэт ажиллаж байгаа. Гэхдээ эд нарын дуу сулдаад байгаа, зарим юман дээр айгаад байх шиг байгаа юм. Битгий ай нэг ч даргад та нар өргүй шүү,

зоригтой ажиллаарай л гэж хэлмээр байгаа юм.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Сая хэлэлцүүлэг дээр гишүүдийн хэлсэн үнэн байхгүй юу. Энэ өмнө нь байгаа энэ бүх комиссаруудыг 1 удаа бид нар бүгдийг нь зөвхөн дарга солиод өнгөрөх гэж байсан байхгүй юу. Энэ чинь хамтын байгууллага юм бол хамтаараа хариуцлага хүлээлгэх ёстой шүү дээ. Өөрийн чинь хэлж байгаагаар бол тийм үү. Тэгэхгүй 1 хүнийг нь шийтгэхээд дараагийн хүнийг нь оруулж ирэхээр бидэнд итгэл үнэмшил төрүүлэхгүй байна шүү дээ. Тэр асуудлыг би яриад байгаа юм.

Ер нь бол онолын хувьд би сайн ажиллаж байна гэж бодож байна. Гэхдээ лав л миний тавьсан асуудлуудад Хүний эрхийн хороо хангалтгүй хандсан байхгүй юу. Үл хүндэтгэсэн, хариу өгөөгүй удаасан. Би хүний эрхийн асуудлаар л хандсан болохоос биш өөрийнхөө талаар хандаагүй шүү дээ. Тэр гаргаж байгаа иргэдийн эрх ашгийн төлөө би хандахад та нар зүгээр хаалга нь цоожтой юм шиг байсан байхгүй юу. Тэгэхээр надад ингэж хандаж байгаа юм чинь иргэдэд та нар бол бүүр хэдэн давхар түгжээтэй хаалга шиг л байдаг байж таараа. Тийм учраас би хэлээд байгаа. Уг нь бол бид нар нэлээн нухацтай хандаж байж сая

Г.Занданшатар: Ер нь энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиараа одоо байгаа Хүний эрхийн Үндэсний Комиссын 5 гишүүн, эрүү шүүлтийн 1 комиссар гишүүн ингээд л энэ 6 хүн дотроосоо л одоо Комиссын даргыг томилно. Энэ 5-ыг ялгаатай нь бид 5 хүнийг хэнийг нь ч танихгүй, манай Хууль зүйн байнгын хороо нэг нутаг ус ч юм уу, хамтарч ажиллаж байгаагүй гэсэн үг л дээ. Тэгэхдээ Хууль зүйн байнгын хороо нээлттэй сонсголоор

сонгон шалгаруулаад л, сонгон шалгаруулалтын комисс ажиллаад л нэр дэвшүүлээд л тэгээд сонгосон 5, 6 хүн хамгийн шилдэг нь гээд л энэ Хууль зүйн байнгын хорооны үе үеийн дарга, гишүүд оролцоод л энэ 5 гишүүнийг сонгосон. Энэ 5 дотроосоо дотроо хуралдаад санал нэгтгэйгээр 100 хувийн саналаар Сүнжидийг нэр дэвшүүлсэн. 5 хүнээ манлайлж ажиллах тэр 5 хүнийг нь сайн л гээд Их Хуралд та бүхэн л сонгосон. Хууль зүйн байнгын хороо нэр дэвшүүлж сонгож шилж шийдсэн тэгээд л тэр дотроос л шийдэж байгаа хэрэг шүү дээ.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар, Цэндийн Мөнх-Оргил, Цэрэнжамцын Мөнхцэцэг нарын урилгаар Сүхбаатар дүүргийн 8, 11 дүгээр хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхныг хүсэн ерөөе.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.
Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр яг сүүлийн үед энэ хүний эрхийн нөхцөл байдал нэлээн дордож байгаа. Ялангуяа уг хэлэх эрх чөлөө, хэвлэн нийтлэх эрх чөлөөний энэ асуудал маш дор түвшинд очсон. Ер нь бол нэг зүйлийг л хэлж байгаа шүү дээ. Энэ Их Хурлын гишүүн болно, сайд, дарга болно гэдэг бол олны өмнө өөрсдийгөө бүх зүйлээ л ил тавина л гэсэн үг байхгүй юу даа. Тийм учраас тэр Их Хурлын гишүүн болно гэдэг хүн болгонд өөрөө ямарваа нэгэн байдлаар энэ Монгол Улсын энэ ард иргэдийн амьдарч байгаа хэв маяг энэ бүх зүйлийн өмнө л хариуцлага хүлээнэ гэсэн ийм л хүмүүс байхгүй юу даа.

Гэтэл энэ энэ хүмүүс гомдох дээрээ энэ хэвлэн нийтлэх эрх чөлөөний талын эсрэг, үг хэлэх эрх чөлөөний эсрэг ийм зүйлийг ярьдаг. Энэ танхимаас бас

энэ яг энэ хүний эрхийн асуудал бол бас гараад явдаг ийм зүйл байгаад байгаа шүү. Тийм учраас ер нь Их Хурлын гишүүн хүн бол ялангуяа хэвлэн нийтлэх, нийтэлсэн үг хэлэх эрх эрх чөлөөний төлөө эсрэг шүүхэд хэн нэгэн иргэн хэвлэлийн байгууллагыг өгнө гэдэг байж болшигүй зүйл л гэж би боддог.

Тийм ч учраас энэ хэвлэлийнхний хэчнээн намайг янз янзаар хэлсэн ч би тэдний эсрэг хэн хэн нэгэн хэвлэлийн хүнийг шүүхэд өгөхгүй гэдэг амаа өгөөд 16 оноос хойш ажиллаад явж байгаа. Тэгэхээр энэ хэвлэн нийтлэх эрх чөлөөний нэг сайн тал нь энэ нийгмийн бүх муу муухай бүх зүйлийг л ил гаргаж ирдэгтээ л хамгийн гол асуудал байгаа байхгүй юу. Өнөөдөр сошиал ертөнц хамгийн өндөр түвшинд оччихсон байгаа. Ялангуяа сонгогдсон албан тушаалтан бол хазгай гишгэх ямар ч боломжгүй болсон. Тийм учраас энэ бүх зүйлийн, энэ ялангуяа авлига, албан тушаал, бусад хэргүүд дандаа далд явагддаг. Тэрийг ил гаргаж ирж байгаа тэр хүмүүсийн эсрэг албан тушаалтан янз янзын гомдол гаргана гэдэг буруу л гэж би үзэж байгаа.

Тийм ч учраас сонгууль дөхөж байгаа. Ялангуяа энэ хүний эрхийн асуудал улам дордоно. Тийм учраас жагсаал цуглаан маш их болно. 1 сард болно, 4 сард болно. Энэ үеэр хүний эрхийн асуудал улам их дордох учраас өнөөдөр тэр Хунан гэдэг хүн бушуухан шиг явж байгаа байх. Тийм учраас өнөөдөр Сүнжид дарга танд хариуцлага маш том хариуцлага ирж байгаа. Би таныг мэднэ. 2012-оос 14 оны хооронд энэ Хууль зүйн сайдын хийж байсан хүмүүсийн дотроос хамгийн их хүний эрхийн мэдрэмжтэй, өнөөдөр ч Монголын ард хүний эрхийн талаар хамгийн сайн мэдлэг боловсролтой, хийж байсан ажлын туршилагатай гэж үздэг Тэмүүжин сайдын доор та ажиллаж байсан учраас яг энэ ажлаа илүү сайн хийж чадна. Тэгэхдээ танд онол, туршилага бүх зүйл байгаа. Хамгийн гол

нь удирдах. Тэр тал дээрээ маш тийм хариуцлагатай байгаарай.

Хоёрдугаарт нь зоригтой байгаарай. Энэ Хүний эрхийн Комиссын гишүүн чинь энэ хүний эрхийг дордуулаад байгаа тэр бүх хүний эсрэг маш хатуу зоригтой, хэзээ ч нугаршгүй тийм л байж байж энэ хүний эрхийн асуудал чинь илүү сайн түвшинд очно л гэдгийг би танд хэлэх байна. Амжилт хүсье.

Г.Занданшатар: Үг хэллээ. Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Ямар ч байсан шинэ дарга орж ирж байна. Тэгээд хуучин даргынхаа алдааг давтахгүй байх ёстой байх л даа. Ер нь Хүний эрхийн Комисс дуугарахыг иргэд маш их хүлээдэг. Тийм ч учраас өнөөдөр бас өмнөх дарга чинь тэр хүлээлтийг биелүүлж чадаагүй учраас өргөдлөө өгөөд ажлаа өгсөн байх гэж бодож байгаа. Аливаа асуудал дээр нийгмийн сэтгэл зүйд яг хүний эрхийн зөрчил гарсан үгийг цаг тухайд нь дүгнэж, дүгнэлтээ өгөөд, тухайн Засгийн газрын тухайн байгууллагуудад шаардлагаа хүргүүлээд засаж залруулах алдаа дутагдлыг нь цаг тухайд нь хэлж ойлгуулж явбал Хүний эрхийн Комиссын бас нэг зорилго биелэх байх. Тэрнээс Хүний эрхийн Комисс бүх асуудалд оролцоод сайн, мууг нь ялгаж салгаад байх юм бол та бүхнийг бас ажлаа хийж байна гэж ойлгох байх.

Тэгээд шинэ дарга өмнө нь бас туршлагатай юм байна. Тэгээд энэ нийгмийн хүсэлт өнөөдрийн энэ гишүүдийн яриад байгаа энэ бүх үүрэг, даалгавруудыг л та бүхэн маань шаардлагыг нь хангаж ажиллаарай. Ер нь Монгол Улсад хүний эрхийн зөрчлүүд хаа сайгүй байгаа. Шоронд хоригдож байгаа хоригдол дээр ч гарч байна, энгийн иргэд дээр ч гарч байна, төрийн албан хаагч дээр гарч байна. Мөн гэр бүлийн тэр эрх зөрчигдөж байгаа зөндөө асуудлууд байгаа. Энэ болгон дээр зөвхөн I удаагийн илтгэл бичээд түүнийхээ

төлөө хамаг цагаа зарцуулах биш, гаргасан илтгэлийнхээ хэрэгжилт дээр бас та бүхэн маань араас нь хөөцөлдөж ажиллаарай гэж хүсэж байна. Амжилт хүсье.

Г.Занданшатар: Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Сайнбуяны Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Багануур дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе.

Б.Баярсайхан: Одоо Балжиннямын Баярсайхан гишүүн.

Монгол Улс хүний эрхийг дээдэлсэн улс орон ялгаварлан гадуурхалгүй хүний эрх дээдлэгдсэн улс орон болохын төлөө нэг алхам хийсэн нь Хүний эрхийн үндэсний Комиссыг 5 гишүүнтэй болгож шижигнэсэн сайхан 5 ийм гишүүнтэй Хүний эрхийн үндэсний Комиссыг байгуулсан. Энэ хугацаанд үлдсэн, өнгөрсөн 2 жилийн хугацаанд манай Сүнжид дарга бол гишүүн нийгмийн асуудлыг хариуцаж ажиллаж байсан гэж би бодож байна. Сүнжид гишүүний мэргэжил, ур чадвар, эзэмисэн мэргэжил, мэдлэг боловсролын хувьд хуульчийн хувьд надад эргэлзэх зүйл алга.

Гэхдээ хүний эрхийн төлөө дуугарна, тэмцэнэ гэдэг нь зүрхэндээ хүнийг хайрласан, хүний төлөө гэсэн өгөгдөл суусан хүний ажил байдаг гэдгийг өнгөрсөн жилүүдэд бол харж байна. Хэчнээн мэдлэг боловсролтой, хэчнээн сайхан сургууль соёл төгсөөд, хэчнээн мундаг хуульч байлаа гээд чин үнэн сэтгэлээсээ хүүхдийн төлөө, хүний төлөө, зүрх сэтгэлд нь энэ үр суугаагүй л бол энэ зүгээр тийм элсэн ийм ажил болоод байх юм гэдгийг бас харж байна.

Тэгэхлээр өнгөрсөн 2 жилд нийгмийн асуудлаа хариуцан ажиллахдаа таны гаргасан үр дүн, яг ажил дээр гарсан үр дүн юу байна. Энэ хүүхдийн хүчирхийлэл улам их нэмэгдэж байна 10-16 настай хүүхдүүдийн абортод орж байгаа асуудал байна. Энэ эрүүл мэндийн салбарт, олон салбарт хүүхдийн эрх зөрчигдөж байна, хүний эрх зөрчигдөж байна. Нийгмийн асуудал хариуцсан, хариуцсан 2 жил ажилласан гишүүний хувьд танд яг энэ Комиссыг улсын хэмжээнд даргалаад явахад цаашаа ер нь ямар үр дүн харагдаж байна вэ гэдэг дээр л асуулт асуумаар байна даа.

Дугарын Сүнжид нэр дэвшигч хариулъя. 89.

Д.Сүнжид: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, нийгэм соёлын эрхээ хариуцаж байсан. Энэ хүрээнд эхний жил илүү корона вирус цар тахлын цар тахлын үе дэх хөдөлмөрлөх эрх, аж ахуй эрхлэх эрх, боловсрох эрх, сурч боловсрох эрхтэй холбоотой асуудлууд дээр гомдол их ирсэн. Мөн вакцинтай холбоотой асуудлууд дээр энэ вакцины талаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах корона вирус цар тахлын үед гээд ийм асуудлууд дээр эхний жил 2020 оны 11 сараас хойш бол 1 жилийн хугацаанд илүү төвлөрч ажилласан. Энэ дээр бас дүгнэлт, зөвлөмж, илтгэлүүд гарч байсанб

Хоёр дахь 21 онд бид нар илтгэлдээ хөдөлмөрлөх эрхийн хүрээнд 2 асуудлыг тусгасан. Таны манлайлж оролцсон Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга дахь асуудал байгаа. Ажлын байран дахь буюу ажил эрхлэлт хөдөлмөрийн харилцаан дахь дарамт, хүчирхийллийн асуудал, ялгаварлан гадуурхалтыг зогсооно гэдгийг хуулийн шинэчилсэн найруулга дээр оруулж өгсөн. Энэ хүрээндээ бид нар тусдаа 2 янзын судалгаа хийсэн бөгөөд үүний нөлөөлөх арга замыг хэрэгжүүлье Үндэсний хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын

түвшинд ер нь дарамт хүчирхийлэл ямар байдаг вэ гэдэг тийм нэгдсэн дүр зурагтай болсон.

Хоёр дахь нь төрийн албан хаагчдын дунд ялангуяа эмэгтэйчүүдийн дунд бэлгийн дарамтын ойлголт энэ ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны хүрээнд ямар байгаа вэ гэдэг ийм нэгдсэн судалгаатай болоод, үүний мөрөөр юу авч авч хэрэгжүүлэх вэ гэдэг дээр дагалдах дүрэм, журмуудыг гаргасан. Өмнө нь дарга ахлаад бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гурван талт хороодоор зөвшилцөөд ийм үлгэрчилсэн журам гэж гаргаад энийг бүх ажил олгогчид бас дагаж мөрдүүлээч гээд ийм эрх зүйн баримт бичгийг боловсруулах ажил дээр ажилласан.

Мөн үүний мөрөөр сургалтыг байнга зохион байгуулсан. Одоо дараагийн ажил нь Хүний эрхийн Үндэсний Комисст ирж байгаа нийт гомдлын 1000 орчим гомдол ирдэг. Корона вирус цар тахлын үед арай илүү 1200 орчим гомдол ирсэн. Энэний ихэнх хэсгийг хөдөлмөрлөх эрхийг нь энэтэй холбоотой гомдлууд ирдэг. Тэн дундаа ялангуяа энэ ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, ялгаварлан гадуурхалт байна гэдэг асуудлаар ирээд байгаа учраас нөлөөллийн ажил, урьдчилан сэргийлэх ажил, ар гэрийн тэнцвэр хангах ажил гээд энэ рүү тэр модулийг бэлтгээд энэ жилээс бас ажил олгогчдоо төрийн болон хувийн хэвшил аль алинд нь гүйцэтгэх болон удирдах түвшинд нь санал болгохоор бэлдээд явж байгаагийн зэрэгцээд 21 дэх илтгэл дээр бас нэг тусгасан асуудал бол хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгааны асуудал байсан.

Үүнтэй холбоотой ер нь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр Монголд байна уу гэхээр байна. Энэ талаар бид нар хууль тогтоомжийнхоо хувьд Эрүүгийн хууль дээр оруулах хэрэг байдаг юм байна. Ажил олгогчийн хүлээж байгаа хариуцлага төдийлөн үр дүнтэй,

үр нөлөөгөө өгч чадахгүй санцтай байна гэж дүгнээд. Мөн энэ насанд хүрээгүй хүмүүсийн ажлын байрны жагсаалтыг шинэчлэн гаргахгүй бол хөдөө аж ахуйн, мал аж ахуй дээр ажиллаж байгаа хүүхдүүдийн бас хөдөлмөрийн нөхцөл байдал тодорхойгүй. Тэгснээрээ эрх нь хохирох бас нөхцөл үүсээд байгаа юм байна гэдгийг дүгнэсэн. Энэ илтгэлийн мөрөөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хөдөлмөрийн тухай хуульд заасанд нийцүүлээд насанд хүрээгүй хүмүүсийн эрхлэх ажлын байрны жагсаалтыг бас батлан гаргасан. Одоо түүний мөрөөр дараагийн ийм нөлөөллийн ажлууд нь хийгдээд явж байгаа юм.

22 дахь илтгэлийн тухайд төрийн үйлчилгээний уул нь төрийн захиргааны албан хаагчдын төрийн үйлчилгээ төрийн тусгай албан хаагчдын хөдөлмөрлөх эрхийн нөхцөл байдлыг бүхэлд нь авч дүгнэсэн. Тэгээд энэ хүрээндээ бол цалин хөлсний асуудал, нийгмийн баталгааны асуудал, тэгээд хот суурин газар болон хөдөө орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдын эрх зүйн байдлыг баталгаажуулах асуудлыг энэ илтгэлүүдээрээ хөндсөн. Үүний мөрөөр бол бас цалин хөлстэй нийгмийн баталгаатай холбоотой шийдвэрлэх асуудлууд бас үе шаттайгаар Засгийн газраас төлөвлөөд үйл ажиллагаагаа явж байгаа. Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын стратеги төлөвлөгөө гэж гаргасан юм. 2020 онд дууссан учраас дараагийнх нь 5-6 жилд баримтлах стратеги юу байх вэ гээд энэ.../минут дуусав./

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулъя. 1 минут.

Б.Баярсайхан: Мэдээж та нар маань ингээд завгүй чөлөөгүй л ажиллаж л байгаа байх л даа. Гэхдээ ядарсны төлөө амаа нээх гэж, эрх нь зөрчигдөж байгаа хүмүүсийг өмгөөлөх гэж ингэж ийм том байгууллагыг ажиллаж байгаа

хүмүүсийн хувьд та нар маань жоохон зоригтой ажиллаад, зөвхөн цаасан дээр биш нийгэмд дуу хоолой хүргэхэд зоригтой ажиллаж өгөөч, зоригтой дуу хоолойгоо хүргэж өгөөч, нийгэм дээр бодитой ажил хийгээч. Энэ цаасан дээр хийсэн ажлаа хэрэгжихэд өөрсдөө зоригтой манлайлж ажиллаач, Хүний эрхийн Үндэсний Комисс гэхэд бидний хамгаалагч юм шиг хүний эрх нь зөрчигдөж байгаа хүмүүсийн хувьд аврал тусламж нь болж ингэж зоригтой ажиллаач гэж хүсэж байна Сүнжид даргаа. Дотроосоо нэгэнт таныг даргаар сонгоод бид нарыг манлайлна гээд сонгож байгаа. Танд амжилт хүсье. Илүү зоригтой, бодитой, үр дүнтэй ажиллахыг хүсье.

Г.Занданшатар: Үг хэллээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Бид нар бас хүнийг бодитоороо үнэлж, зөв мэдээлэл энэ тэртэй байх нь чухал байгаа. Би Сүнжид гишүүнийг тэр хүмүүс дотроосоо даргаар нэр дэвшээд орж ирж байгааг 2 гараа өргөөд дэмжиж байна. Яагаад гэвэл би Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар ажиллаж байхдаа Хүний эрхийн Үндэсний Комисст хэд хэдэн асуудал дээр нэлээд нь тулж ажиллаж байсан юм. Нэгэнт бид Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай хууль гаргах үедээ энэ хөдөлмөрийн харилцаан дээр, ажлын байран дээрх бэлгийн дарамт ер нь энэ нөхцөл байдал яг ямар байна та нар бодитоор судалгаа хийгээд үнэхээр үнэн зөв судалгаа статистик гаргаад ир гээд явуулсан. Эд нар маань энэ энэ тал дээр маш сайн судалгаанууд гаргаж ирээд Нийгмийн бодлогын байнгын хороон дээр танилцуулсан. Дараа нь хууль батлагдахад энэ сайн үндэс болж өгсөн нэг кэйс энэ байна.

Хоёр дахь зүйл нь хүүхэд хамгааллын төсөв хөрөнгө яг энэ хүүхэд хамгаалалдаа зарцуулагдахгүй байна гэсэн шүүмжлэл өнгөрсөн 4 жилд асар их

гарсан шүү дээ. Бид нар 300 сая-хан төгрөгийн төсөвтэй байхад 11 тэрбум болгож өсгөхөд бид Хүний эрхийн Үндэсний Комиссоос энэ хүүхэд хамгааллын ажилтны хүний нөөц, санхүүжилт, хөдөө орон нутагт яг ямар байна та бүхэн бас хүний эрх хаана нь юу нь зөрчигдөж байна судалгаа хийгээд ир гээд Байнгын хороотойгоо хамтраад бид нар бас судалгаа хийлгэж явуулсан. Яг энэ дээр хүүхэд хамгааллын мөнгө чинь өвсөнд, өөр зүйлд зарцуулагдчихдаг юм байна. Орон нутагт аймгийн засаг дарга энэ тэртэй бол яг хүүхэд хамгаалалттай холбоотой тэр хүний нөөц боловсон хүчин 200, 300 ажил давхар хийдэг гээд яг бидэнтэй нийлсэн Азийн хөгжлийн банк энэ манай Хүний эрхийн Үндэсний Комисс тэр дундаа Сүнжид дарга нэлээд манлайлж тэнд оролцож ийм сайн судалгаанууд бас Нийгмийн бодлогын байнгын хороотой хамтарч гаргаж ирсэн. Энэний үр дүнд бид өнөөдөр бас энэ хүүхэд хамгааллын төсөв хөрөнгө, хүний нөөцийг бас шийдэхэд энэ судалгаа энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын хийсэн энэ ажлууд бас тус болсон юм. Одоо 2021 онд бас нэг цэрэг залуу амь насаа алдсан хэрэг гарахад бас л бид нар Хүний эрхийн дэд хороотой хамтраад Хүний эрхийн Комиссынхон ажлаа хийв та нар явж энэ судал, бодит байдлыг харж ир гэсэн. Эд нар бас сайн дүгнэлтүүд хийж ирсэн. Тэнд бас Сүнжид нэлээд манлайлалтай сайн оролцсон.

Тэгэхээр бол энэ бүхнийгээ гарсан энэ зөрчлүүдийг та нар маань сайн гаргаж ирээд харин энийгээ шүгэл үлээж олон нийтэд хүргэх ийм байгаад байна энийг зогсоох ёстой гэдэг дээр Улсын Их Хуралтайгаа хамтраад та бүхний гол томилдог байгууллага Их Хуралдаа мэдээллээ өгөөд бас зоригтой ажиллах гэдэг дээр харин сайн ажиллаарай Сүнжид дарга. Тэрнээс та бүхэн маань аягүй сайн ажилладаг би бол мэддэг юм тэрийг.

Гэхдээ хүний нөөц бас цөөхөн. Дээрээс нь шүдгүй арслан гэдэг шиг нэг дарга том дуугарчихаар юм уу эсвэл юу болохоор эсвэл өөр улс төрийн хүчний янз бүрийн нөлөө сүлжээнд автаад байхгүйгээр та нар маань яг энэ гаргасан судалгаануудаа бодитоор дүгнэж үнэлээд, шаардлагатай юм бол та нар маань хэвлэлийн бага хурал хийх, шүгэл үлээх ёстой хүмүүс шүү дээ. Хүний эрхийн хамгаалагч нар гэдэг бол хамгийн нэр хүндтэй, хамгийн итгэл найдвар хүлээсэн хүмүүс байдаг.

Тийм учраас та нар маань энэ ажлаа сайн хийж, олон нийтэд хандах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах зэрэг тэр өөрсдийнхөө хийсэн ажил, тэр судалгааг хүмүүст хүргэх, энэ болохгүй байгаа юмыг таслан зогсооход маш хариуцлагатай, зоригтой, сайн ажиллах хэрэгтэй байгаа шүү гэдгийг хэлье. Амжилт хүсье. Сүнжид даргадаа.

Г.Занданшатар: Үг хэллээ. Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Хунан даргыг ажилдаа өгөхийн өмнө Сүнжид дарга орж ирэх байх гэж бодсон л доо. Яг л Сүнжид гуай орж ирж байна. Танд юуны өмнө бас амжилт хүсье.

Би бас сая парламентад хүний эрхийн болон жендерийн нөлөөг дүгнэх үнэлгээний хэлэлцүүлэгт бас оролцсон. Яг Хүний эрхийн Үндэсний Комиссын бас тайлан, мэдээллийг бас сонссон. Өнгөрсөн хугацаанд 3 жилийн хугацаанд бид нар хүний эрх, хүүхдийн эрх, ахмад настны эрх, аливаа алагчлах хэлбэрээс ангид байлгах гээд бүхий л чиглэлээр бас тодорхой хэмжээний ажлуудыг хийж байгаа боловчиг үр дүн бас тодорхой бодит биеллээ олохгүй байна гэдэг шүүмжлэлийг би байнга тавьж байгаа. Үнэхээр 2022 оны Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн дүн шинжилгээ, иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл,

түүний мөрөөр болон Комиссын гишүүний санаачилгаар хийсэн хяналт шалгалт, төрийн байгууллагуудын албан ёсны мэдээллийг олон улсын бодлогоос хийсэн судалгаа тайлан дүгнэлтэд үндэслэн 22 дахь илтгэлээ, бас тайлангаа тавьсан байгаа. Хүний эрхийн Үндэсний Комисс тэн дээр юу байсан бэ гэвэл яг Улсын Их Хурлын дэргэдэх байгууллагын хувьд Улсын Их Хуралд ийм хууль, эрх зүйн орчин шаардлагатай байна гэдэг дээр санал, санаачилгуудаа өгсөн боловчиг эргээд түүн дээрээ дүгнэлт хийх тэр ажил нь жоохон хойрго, дутмаг юм болов уу гэж би хардаг юм.

Өөрөөр хэлэх юм бол эрх зүйн хувьд ийм ийм хуульд ийм зүйл заалт оруулах шаардлагатай байна. Жишээ нь иргэний оролцооны эрх зүйн зохицуулалтаар хэвлэл мэдээллийн хараат бус, олон ургалч, ил тод хариуцлагатай байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг оруулж өг гэдэг ийм саналаа тавьчхаад үр дүн нь байна уу, үгүй юү гэдэг дээр эргэх шаардах энэ ажил нь жоохон хомс санагддаг.

Нөгөөтээгүүр зөвхөн гаргасан кэйс гэдэг юм уу Хүний эрхийн Үндэсний Комисст өргөдөл, гомдол гаргасан иргэний өргөдлийн мөрөөр ажиллахаас илүүтэйгээр нийгэмд хүний эрх гэдэг чинь ийм аливаа алагчлах хэлбэрээс ангид байхын тулд иргэн та ийм эрх зүйн мэдлэг мэдээлэлтэй байх ёстой, хуулийн зохицуулалтад ийм байна гэдэг иргэдэд мэдээлэл хүргэх, нөлөөлөх энэ нөлөөллийн ажил хомс байна уу гэдэг зүйлийг бас ярьсан юм.

Ер нь Хүний эрхийн Үндэсний Комиссын төсөв мөнгө ч гэсэн бас тодорхой хэмжээнд дутмаг байдгийг бид нар бүгдээрээ хууль баталж байгаа улсууд бүгдээрээ мэдэж байгаа. Тэгвэл яг энэ чиглэл рүү төсөв мөнгө тусгасан уу, үгүй юү гэвэл үгүй байдаг. Монгол Улс ардчилал хүний эрхийн эрх чөлөөгөөрөө хангагдсан улс орны дунд хувьд азидаа хэдийгээр тэргүүлдэг ч гэлээ бид нарыг

хүний эрхийн зөрчлийг арилгах тал дээр эргээд эрхийн төлөө тэмцэх, эрхийн төлөө дуугарах, хэвлэл мэдээллийнхээ эрхийг хангах, хамгаалах асуудал дээр бас дутагдалтай ажиллаж байгаа гэдэг дээр та бас санал нийлэх байх гэж бодож байна. Зөвхөн тайлан гаргаад өнгөрөх бус, зөвхөн чиглэл өгөөд буцах бус, эргээд түүн дээрээ дүгнэлт хийгээд шаарддаг тэр эрх, үүргийг Хүний эрхийн Үндэсний Комиссын ажил үйлчилгээний эрх үүрэгт нь тусгах ёстой юм болов уу гэж би боддог юм. Өнөөдөр төрийн ордны гадаа бүтэн 3, 4 сар жагссан суудалд хийсэн эмэгтэй байна. Магадгүй тэр шүүхээр үйл явц нь явж байгаа гэдгийг Хөдөө аж ахуйн сайдтай би бас танилцуулж энэ эмэгтэй дээр арга хэмжээ аваач гэсэн боловчиг хуулийн шатанд явагдаж байгаа гэсэн.

Тэгтэл тэр ямар нэгэн байдлаар тэр иргэн хэдийгээр өөрийнхөө эрхийн төлөө тэмцэж байгаа боловчиг эмэгтэй хүний хувьд гадаа хүйтэн нойтонд бүтэн 190-ээд хоног сууж байгаа. Яг энэ дээр гомдол гарахгүй бол Хүний эрхийн Үндэсний Комисс очиж шалгахгүй юу. Хүний эрхийн Үндэсний Комисс Тэр эмэгтэйн өмнөөс яаманд, Их Хуралд, Засгийн газарт ямар нэгэн хүсэлт тавих эрхгүй юу. Одоо хорих ангид хоригдож байгаа хүүхдүүдийн асуудал байна. Хорих ангийн байр нь ямар билээ тэднээс суралцах орчин эргээд энэ нийгэмд гарах хорих байр нь хоригдоод ялаа эдлээ гарч ирж байгаа боловч тэр хүн байх хүнлэг байх тэр сургалт суурь Боловсролыг олгох тэр ажил хийгдэж байгаа юу, үгүй юү. Яг энэ мэт юман дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын ажил дутмаг байдаг. Хунан даргыг яагаад ажлаа өгснийг өнөөдөр үнэхээр мэдсэнгүй. Ямар нэгэн шаардлага байсан уу, хувь хүний юу байсан уу? Гэхдээ өнөөдөр Хүний эрхийн Үндэсний Комисс ийм ийм ажил хийх шаардлагатай байна. Жишээ нь 22 дугаар илтгэлээс хойш, ямар дүгнэлтээсээ хойш ямар ажил хийж чадав гэдгийг.../минут дуусав./

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Санал хэлсэн байх. Санал хураалтад бэлэн байна уу. Санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108.2-т заасны дагуу Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Санал хураалт.

64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилогдохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулж томилох саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Дугарын Сүнжидийг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилсугай.

Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Юуны өмнө энэ хариуцлагатай цаг үед Хүний эрхийн Үндэсний Комиссын

даргаар томилогдож, нийт гишүүдийн дэмжлэгийг авч Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар сонгогдсон, томилогдсон Дугарын Сүнжид танд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Хүний эрхийг хамгаалах ажил амаргүй ажил. Яагаад гэвэл хүний эрхийг хэнээс хамгаалдаг юм бэ гэхээр эрх мэдэлтнүүдээс, төрөөс жирийн иргэн хүний эрхийг хамгаалдаг ийм ажил. Ийм ч учраас хүний эрхийн, хүний эрхийг хамгаалах ажлын хүний эрх, эрх чөлөөг хамгаалах ажлын, хүүхдийн эрх, эрх чөлөөг хамгаалах ажил бол ардчилсан нийгмийн анхаарлын төвд ямагт байх ёстой асуудал. Мааш олон асуудлууд яригддаг боловч тодорхой хариуцлууд байдаггүй. Ганцхан жишээ дурдахад л одоо сүүлийн үед хэрэг явдал болж байгаа хүүхдүүдийн асуудал байна. Хүүхдийн эрхийн асуудал байна. Бид нар хүүхдийн асрамжийн газруудаар яваад л зөндөө л үүрэг, даалгаврууд өгч байсан. Бодитой үр дүн харагддаггүй. Жишээлбэл өнөөдөр гэхэд олон нийтийн дунд олон нийтийн сүлжээнд хоригдож байгаа Мөнх-Эрдэнэтэй холбоотой, Даваагийн Мөнх-Эрдэнэтэй холбоотой асуудал хөндөгдөж яригдаж байна. Би өмнө нь энэ асуудалд Хүний эрхийн Үндэсний Комиссын даргад хяналт шалгалт хийж тайлагнах үүрэг өгсөн. Хариу байхгүй. Өөрөө мэдээлэл хийгээрэй. Үнэн, зөв хоёрын аль нэгийг нь мэдээлж байх хэрэгтэй байгаа юм л даа.

Гэтэл тэр иргэн олон нийтэд хандаж захидал хүртэл бичсэн байна. Эсвэл шаардлагатай та нар айгаад, эмээгээд байдаг юм бол би хүртэл хамт очъё. Та нарыг дагуулаад хамт очъё. Ийм тодорхой ажлуудаас энэ Хүний эрхийн Комиссын хамгаалах ажлууд чинь эхэлнэ шүү дээ. Хаана ч байлаа гэсэн хүн гэдэг эрхэм чанарыг нь бид хүндэлж байх ёстой. Ингээд энэ чиглэлээр идэвх санаачилгатай, дайчин, манлайлалтай ажиллахыг хүсэн ерөөе. Сүнжид даргадаа амжилт хүсье. Дараагийн асуудалд орно.

16.50 цаг

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2023 оны 11 дүгээр сарын 6-ны өдрийн 174 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшинээр ахлуулан Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Ц.Мөнх-Оргил, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Д.Цогтбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр төслийг чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа

үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажилласан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэгт заасны дагуу Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Төсвийн байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэж анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Байнгын хороонд ирүүлсэн. Хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.paliament.mn цахим системээр дамжуулан олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан санал авахад нэр бүхий иргэдээс 77 санал ирүүлснийг ажлын хэсэгт танилцуулсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаараа дээрх хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу хууль, тогтоолын төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Ажлын хэсгийн дэмжсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлд нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тээврийн хэрэгслийн дугаарын хязгаарлалт хийх, авто зогсоолын зохицуулалт, стандарт тогтоох ажлыг нэн тэргүүнд хийхээр тусгаж, эдийн засгийн буюу татварын бодлогын хөшүүргийг ашиглан замын хөдөлгөөний төлбөртэй бүс тогтоох, төлбөр хураамж авах зохицуулалтыг төслөөс

хасах. Мөн түүнчлэн хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах зэрэг нийт 68 зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Ажлын хэсгийн дэмжсэн нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар албадан чөлөөлөх шийдвэрийг гаргахад тухайн төсөл, арга хэмжээний нөлөөлөлд өртөж байгаа газар өмчлөгч газар эзэмших эрхтэй этгээд улсын бүртгэлд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч хуулийн этгээдийн 65-аас доошгүй гэснийг 70-аас доошгүй хувийн дэмжлэгийг авсан байх гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн түүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар гэснийг тухайн шатын Засаг даргаар гэж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэснийг Засаг дарга гэснийг хасах, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөлд цахилгаан тэжээлт автомашиныг нэмж, татварын хувь хэмжээг тогтоох зарчмын зөрүүтэй

санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс гарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд хаалттай болон төлбөртэй авто зогсоолуудыг нээлттэй болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан авто зогсоолтой холбоотой зохицуулалтууд нь Авто тээврийн тухай хуульд тусгагдсан ба нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд хамаарах тул хуульчлах шаардлагатай эсэх мөн дэд төвтэй холбоотой хуулийн заалтууд хязгаарлагдмал байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг газар чөлөөлөхтэй холбоотой харилцааг Засгийн газраас баталсан журмаар бус хуулиар нарийвчлан зохицуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хуулийн төслийн 4 дүгээр бүлгийг дэмжихгүй байгаагаа илэрхийлээд газар албадан чөлөөлөхтэй холбоотой асуудлыг зайлиггүй хуульчлах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн иргэн, хуулийн этгээд замын хөдөлгөөний түгжрэлийн нөлөөллийг бууруулах эрх, үүргийг хуулийн төслөөс хасахгүй байх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, С.Амарсайхан нар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй холбогдох асуудлыг Засаг даргад шилжүүлэх шаардлагагүй талаар асуулт асууж, байр сууриа илэрхийлсэн болно.

Байнгын хороо ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол болон анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэндээ хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд
ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Борхуугийн Дэлгэрсайхан Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Хишигээгийн Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Пүрэвийн Сайнзориг, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн. Тэлмүүн яагаад энд суухгүй тэнд суугаад л, энд суугаад л, тэнүүчлээд л, компьютер дээрээ тоглоод л, чат бичээд суугаад байна уу. Ийшээ сууна шүү. Та Улсын Их Хуралд хүндэтгэлгүй хандаж байгаа учраас танд Бямбарагчаагийн Тэлмүүнд сануулаа. Хуулийн хариуцлагатай шүү дээ. Түүрүүнээс хойш тойроод л зугтаасаар байгаад л нэг хүүхэд гүйлгэхээд өөрөө тэнчээ очоод, компьютероор тоглоод суучих юм. Тийшээ урагшаа ирж суу чи. Тэнд сандал нэмж тавьж өг Тэлмүүнд.

Зам, тээврийн яамны Автотээврийн бодлогын зохицуулалтын газрын дарга Энхтайваны Мөнхнасан, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Дорждэрэмийн Цолмон, Газар зохион

байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хууль, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Дэндэвийн Энхтуяа, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Хуулийн хэлтсийн дарга Жаргалсайханы Ичинноров, Нийслэлийн Орон сууцын бодлогын газрын дарга Ганбатын Ганхүү, Хот байгуулалт хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Доржготовын Хан-Уул, Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч Дангаагийн Авирмэд, Нийслэлийн орон сууцны корпорац ХК-ийн гүйцэтгэх захирал Маньбазарын Говьсайхан, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-ын Гэрээ эрх зүйн мэргэжилтэн Мөнхбаярын Уранбилиг.

Тэлмүүн дарга та энд суумаар байгаа юм уу. Улсын Их Хуралд та удаа дараа хүндэтгэлгүй хандаж байгаа учраас Тэлмүүнд хариуцлага тооцохыг холбогдох байгууллагад чиглэл болгосугай. Бямбарагчаагийн Тэлмүүнд. Энд мэргэжилтнийг суулгачхаад хойшоо суугаад байх юм.

Одоо Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын нэгдсэн төсөв батлагдсан байгаа. Улсын төсвийн тухай хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн дагуу 12 дугаар сарын 5-ны дотор нийслэл, аймгууд төсвөө батлах ёстой. Орон нутгийн төсвөө батлах ёстой.

Тийм учраас энэ хууль төсөв батлагдахаас өмнө батлагдаж, ёсчлогдож, хоригийн болон бүх хугацаа, процедурьг давах ёстой. Тийм учраас өнөөдөртөө багтааж бид анхны хэлэлцүүлгийг бас Байнгын хороо хэлэлцүүлгийг маргааш өглөө,

өнөөдөртөө ажиллаад ажиллах нэлээн шаардлагууд байгаа юм. Тийм учраас анхаарч ажиллахыг хүсье.

d.parliament, d-petition цахим өргөдлийн системүүдээр дамжуулж ирсэн иргэдийн санал, гишүүдийн саналыг харгалзаж үзээд ард иргэдийн зүгээс санал, шүүмжлэлтэй байгаа асуудлуудыг бүгдийг нь үндсэндээ шийдвэрлэсэн. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хасагдаж, тухайлбал төлбөртэй бүсийн асуудал, төлбөрийн хураамжийн асуудал гэх мэт асуудлууд үндсэндээ хуулийн хэлэлцүүлгээс авсан учраас одоо бол цөмөөрөө энэ хуулиа бас нэлээн ажил хэрэгч батлаад, замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах талаар бас боломжийг нь олгож, шуурхай шийдвэрлэх ийм саналтай байна.

Тийм учраас энэ асуулт хариултаа *er* нь аль болох товчилбол яасан юм бэ. Үгүй юу гэх юм бол өнөөдөр бид нар 12 цаг хүртэл хуралдана. Хоёр бүлгийн дарга энийг анхаарч ярилцана уу. Тогтохсүрэн даргаа.

Хаянгаагийн Болорчулуун гишүүн татлаа. Оюунчимэг гишүүн нэрээ татлаа. Пүрэвдорж, Ганибал хоёр гишүүн татчихгүй юм уу? Саранчимэг гишүүн нэрээ татлаа. Баярлалаа. Дашдондогийн Ганбат, Ням-Осорын Учрал сайд татлаа, баярлалаа. Монгол ардын намын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал гишүүн татлаа юу. Татлаа. Бадарчийн Жаргалмаа гишүүн татлаа. Ингээд 4 гишүүнээр тасаллаа. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Энэ Автотээврийн тухай хуульд өөрчлөлт оруулж такси үйлчилгээгээ тусгай зөвшөөрөлтэй болгох тухай асуудал яригдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор Зөрчлийн тухай хуулийн 6.30.4 дэх хэсэгт зөвшөөрөлгүй такси эрхлэх юм бол 3 сая төгрөгөөр торгох тухай асуудал орж ирж.

Тэгэхлээр өнөөдөр шар дугаартай, симфорттой нийтдээ 200-хан такси байна. Энд бол яагаад ч энэ хотын үйлчилгээнд хангалттай биш. Тийм учраас *e-helping* гээд өөрөөр хэлбэл цахим платформоор бүртгэл хийгээд нийтдээ *UB cab* гэхэд 40000 жолооч энд бүртгэгдчихсэн байна. Хэрэглэж байгаа тэр такси, хөлсөлж байгаа тэр хэрэглэгч нь 900000 болчихсон байж байгаа. Үндсэндээ Улаанбаатар хотын такси үйлчилгээг хувийн хэвилийн хувийн автомашинтай тэр хүмүүс л бүгдийг нь гүйцэтгээд явж байгаа.

Тэгэхээр энэ заалтын дагуу чинь тэр хүмүүсийг торгох болчихоод байна л даа. Өөрөөр хэлбэл тэр зөвшөөрөлгүй явсан, симфор байхгүй байна, шар дугаар аваагүй байна гэдэг энэ асуудлаар энэ хүмүүсийг торгох болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр наадах нийтийн тээвэр чинь яг энэ автобус энэ тэр чинь хангалттай сайн үйлчилгээнд гаргаагүй тохиолдолд энэ такси үйлчилгээг хязгаарлаад хаячих юм бол наадах түгжрэл чинь улам аюултай гацах түвшинд очно.

Хууль тогтоомжийн тухай хууль байгаа. Хуулийн зүйл, заалт яг хоёрдмол агуулгагүй, яг тав байна гэсэн ийм заалттай. Энэ хүрээндээ энэ хүмүүсийг торгоод унах юм бол энэ чинь маш том энэ чинь 3 саяар торгоно гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Энэ чинь айхтар өндөр торгууль байхгүй юу даа. Энэ энэ чинь яг энэ нийтийн тээвэр чинь бас нэлээн тийм том асуудал үүсэх юм байна. Тийм учраас энэ асуултаа хариу авъя, авчхаад би нэг зүйлийг Их Хурлын даргад бас хэлмээр байна.

Яг энэ Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу бол яг хууль ямар ч хоёрдмол агуулгагүй. Энэ чинь бас торгох тухай л заалт ороод ирж байна. Тэгэхээр энэ яг энэ хууль хэрэглэх явцад энэ хүмүүсийг торгоод байх юм уу? Яг энийгээ бас тодорхой яг энэ протоколд тэмдэглэснээр бас тодорхой хэмжээний

хууль хэрэглэх явцад энэ асуудлыг протокол үзэж бас ишидэж болдог. Энэ дээр тодорхой хариулт өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: 85 Хишгээгийн Нямбаатар Нийслэл Улаанбаатар хотын Засаг дарга бөгөөд захирагч.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Энэ UB cab-ын үйлчилгээ бол таксины үйлчилгээний төрөлд хамаарахгүй. Энэ дэлхий нийтээрээ “car sharing” гэдэг ийм үйлчилгээг нэвтрүүлж байгаа. Ер нь дэлхий нийтээрээ өөрсдийнхөө илүүдэлтэй хэрэгцээг дундаа хуваадаг ийм үйлчилгээний соёл, хэлбэрүүд нэвтрээд удаж байгаа. Үүний нэг төрөл, хэлбэр бол Монголд UB cab, дэлхийн бусад улс орнуудад “Uber” гэдэг ийм аппликэйшнүүд хөгжүүлэлт хийгдээд, хэн нэг хүн өөрөө завтай, чөлөөтэй үедээ уг аппликэйшнаар хэн хүн зорчигч тээвэрлүүлэхийг хүссэн тохиолдолд тээвэрлэлтийн харилцаа үүсэж явдаг үйлчилгээг “car sharing” үйлчилгээ гэж байгаа юм.

Энэ харилцаа одоогийн энэ Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд заасан таксины үйлчилгээ, тусгай зөвшөөрөлтэй байна гэдэг энэ үйлчилгээний төрөл хэлбэрт хамаарахгүй. Энэ үйлчилгээг Зам, тээврийн сайдын зорчигч тээврийн дүрмээр зохицуулагдах ийм харилцаа байгаа. Бямбацогт сайд бид хэд энэ асуудлаар ярьсан. Энэ хууль батлагдсаны дараа хууль хэрэгжүүлэхтэй холбоотой олон дүрэм, журмууд батлагдаж, шинэчлэгдэх явцад энэ UB cab-ынхны санаа зовоод байгаа энэ “car sharing” үйлчилгээг зорчигч тээврийн энэ дүрэмд тодорхой тусгаж өгөхөөр бас ажлын хэсэг дээр яриад тохирсон. Таны бас асууж байгаа нь их зөв. Энэ протоколд өөрөө бас хуулийн хувийн хэрэг болж үлдэж байгаа.

Харин таксины тусгай зөвшөөрлийг хэдийд олгох вэ гэхээр бид төр, хувийн хэвшлийн түншилэлийн хууль энэ 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ. Энэ тохиолдолд тухайн хотын нүүр царай, өнгө царай болсон хотын дүрэмд нийцсэн ийм тусгай симпортой таксины үйлчилгээ эрхлэхийг хүсэгчдэдээ нийслэл, төр, хувийн хэвшлийн түншилэлийн хүрээнд хамтарч ажиллаж тусгай зөвшөөрөл олгох ийм үйл ажиллагааг хийнэ гэдэг ийм зохицуулалттайгаар энэ хууль хэлэлцүүлгийн шатад тохирсон. Ирэх оны 10 дугаар сарын 1-нээс энэ тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ нэвтэрнэ.

Энэ тохиолдолд одоогийн хувиараа такси үйлчилгээ эрхэлж байгаа хүмүүс энэ “car sharing” үйлчилгээнд нэгдэх боломжтойгоос гадна тодорхой нөхцөл, болзлыг хангасан, тодорхой сургалтад суусан тохиолдолд тэр тусгай зөвшөөрөл бүхий тусгай зориулалтын тоноглолтой, таксины симпортой ийм таксины үйлчилгээ эрхлэх ийм шилжилтийг хийхээр бас бид нар бас давхар зохицуулалтууд хийж байгаа гэдгийг хэлье.

Таны хэлж байгаа тэр 83000 хүний хувьд өдөр тутамдаа, цаг тутамдаа таксины үйлчилгээ эрхлэхгүй байгаа. Энэ хүмүүсийн тухайд бол тодорхой ажлынхаа зав зай, ажлаас гэр рүүгээ харих замдаа ч гэдэг юм уу ийм байдлаар ихэнх нь үйлчилгээ эрхэлж байгаа гэдэг ийм судалгаа гарсан гэдгийг нэмж хэлье.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууна.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр миний асуусан хотын даргын хариулсан хоёр яг протоколд тэмдэглэж үлдэгдэх ёстой. Тэгэхээр дээрээс нь энэ Автотээврийн тухай хууль, энэ Зөрчлийн тухай хуульдаа яг энэ тодорхой яг энэ цахим платформуур бүртгэгдээд такси

үйлчилгээ хийж байгаа тэр хувийн автомашинтай хүмүүс болон үйлчлүүлэгч нарын асуудлыг тодорхой тусгах ийм гүйцээн боловсруулах чиглэлийг Их Хурлын дарга өгчхөөч. Хэрвээ энэ мэдээж боловсруулбал бол тэр биз, болохгүй бол протоколоор явъя гэсэн ийм л саналтай байна. Та гүйцээн боловсруулах чиглэл өгөөч.

Г.Занданшатар: Тухайн асуудлыг хэлэлцэх үед нь, тухайн заалт дээр нь ярь, тухайн санал хураалт дээр нь ярь.Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Монголын хүн амын тэн хагас нь амьдардаг нийслэлийн чухал асуудлыг хэлэлцэх гэж байна. Шөнө орой болж байна. Сая нийслэлээс сонгогдсон гишүүд маань хамгийн сүүлчийн нийслэлийн иргэдийн Хурлын төсөв хэлэлцэж байгаа энэ цаг хугацаанд өөрсдийнхөө Их Хуралд нэр дэвшихдээ гарч ирсэн тэр амлалтуудаа нийслэлийнхээ даргад сануулах гэж аягүй үг авсан байх л даа. Харамсалтай нь дарга бас тэрийг Занданшатар дарга маань тэрийг нь болиулчихлаа. Би өнөөдөр бол энэ хууль яах вэ зүгээр л хууль батлах юм байна. 20 онд та бүхэн Их Хуралд нэр дэвшихдээ ямар амлалт өгч байсныг бас сануулна. Энд 2030 оныг хүртэл мастер төлөвлөгөө зохион хийнэ гэж байна.

Тэгээд Нийслэлийн замын эвдрэл, гэмтлийг бүрэн засварлаад, уулзвар гарцыг нэвтрэх чадварыг сайжруулан зам, дэд бүтцийн өргөтгөлийг шинэчлэлийн ажлыг хийнэ. Хотын төвийн бүсэд төмөр зам дагасан авто зам, төмөр замын нүхэн болон гүүрэн 8 гарцыг шаардлагатай байришлд бас давхар замыг барина гээд. Дугуйн зам хөтөлбөрийг үргэлжлүүлж, стандартын дагуу тохижилт, гэрэлтүүлэг бүхий 150 км дугуйн замын шинэ сүлжээ байгуулж, дугуйн зогсоолын дэд бүтцийг өргөжүүлнэ. Нийслэлийн ерөнхий боловсролын бүх сургуулийн сурагчдыг аюулгүй, найдвартай зорчих сургуулийн

автобус төслийг үргэлжлүүлнэ. Улаанбаатар хотын гэрлэн дохионы удирдлага, менежментийг ухаалаг системд бүрэн шилжүүлнэ гээд олон түгжэрэлгүй Улаанбаатар гээд ийм бүхэл бүтэн заалт бүхий амлалтыг авч байсан. Тэрнээс өнөөдрийн бид хэд бид та бүхний яриад байгаа тэр метроны ТЭЗҮ төслийг боловсруулна гэсэн заалт энэ дотор алга л байна. Магадгүй энэ хуулийг бий болгож, хууль санаачилна гэсэн ийм заалт бас алга л байна л даа.

Тэгэхээр 230 хоног сонгууль болоход 200 гаруй хоног үлдсэн энэ хоногт та бүхэн энэ амласан энэ амлалтуудаа ер нь биелүүлж чадах юм уу. Зөвхөн энэ хуулийг баталж бид нар ийм хууль санаачлаад хуулийг батлуулчихлаа, үүнийхээ дагуу бид нар ажлаа хийнэ гэж хэлэх юм уу. Мөн тэр Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт татварыг нэмэгдүүлэхгүй гэсэн. Өнөөдөр нийслэлийн иргэдийн Хурлаар автомашины татварыг 2 дахин нэмэгдүүлж байгаа юм шиг байна. Энэ асуудал бас хэлэлцэж байгаа юм байна. Энэ дээр яг бас яг нарийн мэдээллийг бас иргэдэд өгөөч. Мэдээж энэ богино хугацаанд хийх ажлуудаа нийслэлийн иргэдийн Хурал өнөөдөр хамгийн сүүлийнхээ төсвийг энэ 4 жилийн бүрэн эрхийн хугацааны төсвийг хэлэлцэж байгаа энэ үед энэ амлалтуудыг чинь бас анхааруулж байгаа юм. Тэгэхээр та бүхэн бас энэ нийслэлийнхээ иргэдийн Хурлын төсвийг батлахдаа энэ амласан амлалтуудынхаа асуудлыг бас оруулаарай гэж хэлье.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулъя 85.

Х.Нямбаатар: Би Ганибал гишүүний асуултад хариулъя. Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний боловсруулах ажил Барилга, хот байгуулалтын яам болон Нийслэлээс байгуулагдсан ажлын хэсэг боловсруулалтын ажил үндсэндээ

дууссан. Саяхан Барилга, хот байгуулалтын сайд бид бас хамтарсан хуралдаанаар энэ 2040-ийг гаднын экспертүүдээр хэлэлцүүлэг зохион байгуулъя гэдэг. Үүнтэй холбоотой 5.2 тэрбум төгрөгийн төсвийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж өгсөн. Үүний дагуу тендер нь энэ 7 хоногт зарлагдаж байна. Гаднын зөвлөхүүд энэ дээр шалгараад зөвлөгөө өгвөл 2040 удахгүй Их Хуралд бид нар өргөн барина Засгийн газраар уламжлаад. Энэ хаврын чуулганаар батлуулбал маш их сайн байна гэдгийг бас сануулсанд их баярлалаа.

Зам өргөсгөх, холбоос замууд нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр бид нар өнгөрсөн жилүүдэд хийгдсэн ажлуудаас гадна энэ 2024 онд хийгдэх ажлуудын нийт нийлбэр нь Улаанбаатар хотын холбоос болон тойрог замуудын тэр нэвтрүүлэх чадварыг бид нар 20 гаруй хувиар нэмэгдүүлэх энэ ажлууд хийгдэж байгаа. Тухайлах юм бол Ард Аюушийн өргөн чөлөөг Толгойтын гудамжтай, 1 дүгээр хорооллыг Яармагтай холбох зэрэг энэ томоохон ийм магистрал замуудаас гадна Цайзын уулзварыг Шар хадтай холбох, Нарантуулын уулзвараас зүүн тийш нь Улиастайн хурдны зам хүртэл холбох энэ холбоос замын ажлууд ирэх жилүүдэд хийгдэж байгаа.

8 гарц, нүхэн гарц хийж чадсангүй. Зүгээр ирэх жил 6 сарын 20-доос өмнө 3 нүхэн гарц ашиглалтад орохоор барилга угсралтын ажил эд дундаа явагдаж байна.

Дугуйн замын хувьд би дараа нь танд мэдээлэл өгье. Концептын хувьд өвлийн улиралд дугуйн зам тавих болно, боломжгүй гэсэн ийм 2 талтай зүйлүүд ярь гэж байгаа.

Сургуулийн автобуснуудыг бүхэлд нь сургуулиудыг автобусаар хангасан. Автобус ашиглалттай холбоотой асуудлыг Нийслэлийн Нийтийн тээврийн

газар зардалтай нь бүрэн шилжүүлж байгаа. Тоог бас он гараад нэмэгдүүлнэ.

Тэр замын хөдөлгөөний уулзваруудыг ухаалаг системд нэвтрүүлэх, замын хөдөлгөөнтэй холбоотой энэ системийн тендер удахгүй зарлагдаж байгаа. Энэ ирэх жилийн 6 сараас өмнө бас шийдэгдчих байх гэж бодож байна. Авто зам, дугуйн замтай холбоотой асуудал дээр эргэж би танд хариулъя нэг.

Автомашины татвар нэмэх асуудал иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дээр огт яригдаагүй гэдгийг хэлье. Би хариулж дууслаа дарга.

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Энэ Улаанбаатар хот ч дэлхийн хамгийн адгийн 10 хотын нэг болсон л доо. Маргааш өглөө унтаад бид нар сэрэх юм уу, үгүй юм уу бүү мэд. Үхлийн хөндийд л амьдарч байгаа. Энхийг бүгдээрээ дэлхий нийтээрээ л гайхаж байгаа байх. Ийм хүнд нөхцөлд яах вэ хотын дарга очсон. Хотын даргаас би өнөөдөр юм асуумааргүй асуумааргүй байна. Яах вэ хот очоод чадлаараа л ажиллаж байна. Бас хэдэн сарын дараа асуусан нь дээр байх.

Энэ 8 жилд юу хийв та нар маань. Тэгээд нөгөө талаараа Монгол ардын нам засаглаж байхдаа ямар ч татвар нэмэхгүй л гэсэн. Хотын татвар гээд 1 хувь байсныг тэрийг 2 хувь болгож байгаа юм уу, яаж байгаа юм энэ чинь. Та нар чинь засаглаж байгаа юм чинь та нарт хамаарахгүй юу. Инфляцаар ард түмнээ сорохоос гадна хажуугаар татвар нэмж сорно. Одоо энэ хуулийг батлаад яах юм, юу өөрчлөгдөх юм, 1 сарын дараа юу өөр болох юм, 2 сарын дараа юу өөр болох юм. Нөгөө автобуснууд чинь хаана байна. Ямар автобус орж ирэх юм. Бас ногоон, улаан гээд. Ямар өнгө нь ч сонин биш байна л даа. Битгий цэнхрээр буцчихаарай тийм.

Хэзээ энэ хотын иргэд чинь автобустай болох юм бэ. Хамгийн муу, хамгийн чанаргүй юм аваад ирэв дээ энүүхэн энэ Хятадаас. Хоёрдугаарт анхааруулчихъя. Та нарын үрж байгаа мөнгөөр Тесла, Бенц унахаар болчихсон шүү дээ Улаанбаатарын иргэд. Тийм байж байж эд нарыг тэр унаанаас нь гаргана, тэр Приусээс нь салгана.

Нөгөө талаар та бүхэн хөдөө орон нутаг ямар байгааг мэднэ. Цаг агаарын хүндрэл бий болно, ажилгүй, төрөлгүй хүмүүс бэлчээр бага байна. Тэгээд хэдэн жолооч нар хотын залуучууд нь бүгд Улаанбаатараас дүрвээд явчихсан. Орж ирээд такси бариад явах гэдэг хөдөөгийн хэдэн золбин юм гэж битгий хэлээрэй дээ. Дэлгэрсайхан сайд тэгж хэлэхгүй би яг мэдэж байна. Хөдөөгөөс сонгогдсон болохоор гэх мэтчилэн.

Манай Нямбаатар дарга бол сайн ажиллаж байгаа. Хамгийн анхны цаснаар шөнөжингөө яваад л, ард түмэнтэйгээ их ойрхон ажиллаж байна лээ. Их зөв байна. Одоо Улаанбаатар хотын хэдэн хөөрхөн дүү нартай тэнд нөгөө талын удирдлагыг, удирдлага ч гэж дээ чи хоолойгоо сайхан зас, цээжээ төв байлга, тэгвэл чи дарга болно гээд л. Нөгөөдөх нь ч тэр заалтыг нь аваад явахаараа дарга болчихдог л юм шиг байна гэх мэтчилний ийм ажлууд бий. Таны ажлыг бол хэдэн сарын дараа дүгнэнэ. Өөрөө Хууль зүйн сайд байж байхдаа нэлээн сайн зүйл ярьж байсан. Ажил болсон бол ямар байгааг бол бүгдээрээ хараад сууж байгаа. Хууль гэдэг чинь хэдэн жилийн дараа хэрэгжээд, үр дүнгээ үзүүлээд ингэдэг. Одоохондоо бас тэрийг дүгнэхэд хэцүү. Их л ядарч байгаа юм байна, сайхан нүдний шил зүүчихсэн байна, өдөр шөнөгүй ажиллаад нүд нь ч яаж байгаа байх, их ухаалаг дүр төрхтэй байна. Угаасаа ч ухаалаг хүн дээ. Таны ажлыг манай Их Хурал ингэж дэмжиж ингэж ажиллаж байна. Бид нар бас эндээсээ сайн гишүүн тийш нь явуулчихсан. Бас

хотыг хамгийн Дэлгэрсайхан дарга та хоёр тэгээд ганц найдвар нь болчихож дээ Ардын намынхны. Хотоос мэдэхгүй сонгох сонгогч үлдэх юм уу ийм угаартай, ийм атаатай ийм үед. Хот руу сонгогдох гэж очих уу Ардын намаас. Би л очихгүй дээ. Би бол аль тойрогт ч очсон болж байна танайхны. Тийм, тийм л байгаа шүү дээ юм бол. Нямбаатар дарга хариулаад хэрэггүй. Юу хариулахыг нь би мэдэж байна.

Г.Занданшатар: 85 Нямбаатар сайд. Асуухаа больчихож байгаа юм уу. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Би Ардчилсан намаас нийслэлд сонгогдсон цорын ганц гишүүн байгаа. Тэгэхээр энэ Нийслэлтэй холбоотой энэ бүх асуудлыг бол яг бүрэн эрхийнх нь хугацаа дуусах үед энэ Монгол ардын намын мөрийн хөтөлбөрийн биелэлтээ танилцуулах байх. Нямбаатар сайдаас нэг зүйлийг аминчлан гуймаар байна. Баянгол дүүрэг Засаг даргагүй 8 сар болчихлоо, Монгол ардын нам тэнд олонх байгаа. Сураг сонсоход дотроо Монгол ардын нам дотроо 2 хуваагдаад тэрнээсээ болоод Засаг даргаа огцруулчихсан. Би дүүргийн Засаг дарга хийж байхдаа 8 сар байтугай бараг 8 хоног ч ер нь ийш тийшээ томилолт ч юм уу, эмнэлэгт хэвтэхэд л хэцүү л байдаг шүү дээ. Үнэхээр хэцүү. Ерөөсөө өдөр, шөнөгүй асуудлууд нь гарна. Сая би очсон хогтоо дарагдчихсан, эзэнгүй айл шиг л байна лээ. Тэгэхээр та энийг Баянгол дүүргийн Засаг дарга дээр онцгой анхаарч, энийг яаралтай томилох хэрэгтэй байна.

Өнөөдөр Алтай хотхон дээр очсон баярлалаа. Энэ бол 8000 гаруй өрхтэй, 1 ч сургуульгүй, 1 ч цэцэрлэггүй хотхон байгаа. Би Энх-Амгалан сайдад нэг санал хэлсэн юм. Түгжрэлийг бууруулах нэг чухал хэрэгсэл бол энэ том хотхонуудад бага сургуулиудыг нь байгуулчихаад, улсын сургуулийн харьяа болгочих. Тэгвэл түгжрэл буурна. Энд ганцхан багш заадаг. Энх-Амгалан сайд энийг харин

хүлээж аваад Алтай хотхонд бага сургууль байгуулсан.

Тэгэхээр би бусад ийм том том хотхонуудад ийм бага сургуулиудыг байгуулаад өгөөч ээ, хамаагүй түрээсийн гэрээгээр ингэчих юм бол түгжрэл буурна. Хүүхдүүд бага насны хүүхдүүд бас хол явахгүй, аюулгүй байдалд нь бас чухал байгаа.

Энэ хуулийн хүрээнд тавьж байгаа асуудлыг би дэмжиж байгаа. Мэдээж бүгд л түгжрэлээ бууруулья, гэр хорооллын асуудлыг шийдье гэж байгаа. Гэхдээ би зүгээр энэ хэлбэрийн хувьд гайхаад байна л даа. Ийм бие даасан хууль гаргах нь хэр зохимжтой юм. Жишээлэхэд Хууль тогтоомжийн тухай хуулиар бид нар чинь аливаа зүйлийг давхардуулахгүй хуульчилж өгдөг. Татварын хууль бол татвартай холбоотой юм татвар. Гэтэл энд чинь Нийслэлийн хоёрхон асуудлыг нийлүүлээд нэг ингээд хууль болгочхож байгаа юм л даа.

Тэгэхээр цаашидаа бид нар Нийслэлийн асуудал болгон дээр хууль оруулах юм уу? Нийслэлийн жорлонгийн асуудал гээд оруулах юм уу, нийслэлийн хөрсний бохирдол гээд оруулах юм уу, эсвэл энэ Өвөрхангай аймгийн утааны асуудал гээд тус тус тусдаа ийм хууль оруулж ирэх юм уу, яах юм? Уг нь бол Нийслэлийн юу гэдэг юм эрх зүйн байдлын хууль байдаг юм уу өөр хуулиудад оруулаад мэдээж холбогдох энэ Газрын тухай хууль, Барилгын тухай хууль гээд оруулбал тохиромжтой байсан юм биш үү? Би бол энэ Хууль тогтоомжийн хуулийн дагуу жоохон тийм зохимжгүй л санагдаж байна.

Тэр 9.6-д та ингэсэн байна л даа. Авто зогсоолын менежментийн нэгдсэн системийг Нийслэлийн Засаг дарга хариуцна гээд. Тэгэхээр энэ Засаг даргын хариуцах ажил мөн үү? Таны ажил маш их ачаалалтай. Үүнийг тэр Хотын

тээврийн удирдах газар нь хийгээд байж болдоггүй юм уу гэсэн асуулт байна.

Сүүлийн асуулт бол энэ гэр хорооллын иргэдээс судалгаа авахад ер нь 60-70 хувь нь орон сууцанд орох дургүй байдаг юм Нямбаатар сайдаа. Юу гэдэг вэ гэхээр бид нар манай Баянгол дүүрэг дээр орон сууцжуулна гээд 1 компани гэрээ хийсэн. 10 жил болж байна. Одоо хэрүүл нь 10 жил тасрахгүй. Нийслэл нь юмаа гаргаж өгөхгүй, иргэд нь байраа авч чадахгүй, нүүчихсэн ёстой бүүр үнэхээр уулзалт болгон дээр энэ асуудал яригддаг байхгүй юу “Хөх Сувд” гээд компани 10 жил. Тэгэхээр бүгдийг нь орон сууцжуулах юм уу, эсвэл бас тэр байгаа газар нь зарим хороонуудыг дэд бүтэцжүүлэх юм уу энэ асуудал дээр ер нь ямар юм баримталж байгаа юм гэдгийг асууя. Миний тэр хэлсэн хотхонууд дээр бага сургуулийг дэмжиж өгөх ажлыг бас онцгой анхаарч өгөөрэй гэж хэлмээр байна.

Г.Занданшатар: Хишигээгийн Нямбаатар сайд хариулна уу.

Х.Нямбаатар: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Баянгол дүүргийн Засаг даргыг ажилд нь томилоод яг 1 сар болж байгаа Одноо даргаа. Ажилдаа ороод 1 сар болчихсон шүү. Тийм Сумъяабаатар.

Хоёрдугаарт Алтай хотхон дээр сургууль барих асуудлаар өнөөдөр би газар дээр нь очиж ажиллаад хуучин нөгөө мебелийн үйлдвэрийн урд талын 1 га газрыг аж ахуй нэгжтэй нь тохиролцож тэн дээр улсын 960 хүүхдийн сургууль барих асуудлаар үндсэндээ ойлголцолд хүрсэн. Одоо тэнд байгаа инженерийн шугам сүлжээг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудлаар ирэх 7 хоногт зэргэлдээх аж ахуй нэгжтэй нь хэлэлцээр хийхээр ийм шийдэлд хүрээд байгаа. Тантай 100 хувь санал нэг байна. Бид нар ер нь хэд хэдэн томоохон ийм түгжрэлийн голомт болсон хорооллууд байгаа юм. Түүний нэг

нь Алтай хотхон, нөгөөх нь Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Их Монгол, Баян Монгол, Олимп гэх мэт энэ хорооллуудыг бид нар дандаа бүтэн ийм тойрог эргэлттэй замуудтай болгож магистрал руу нь оруулах чиглэлээр ийм тодорхой ажлууд ярьж байгаа.

Өнөөдөр Улаанбаатар төмөр замын дарга Хэрлэн захиралтай ярьсан. Бид нар хэрвээ хуучин Монро мебелийн хойд талаар тэр замын тойрог эргэлт үүсгэх юм бол шууд нарны зам руу бүтэн ороож гарч ирэх ийм хөдөлгөөн зохицуулалт хийж чадах юм бол тэр хавийн төв хөдөлгөөний эрчмийг бид нар бууруулна гэж тооцож байгаа.

Зогсоолтой холбоотой асуудал дээр Нийслэлийн Засаг дарга гэж бичсэн нь түүний харьяа байгууллагууд, тэр дотроо Улаанбаатар хөгжлийн корпорац дээр бид нар бие даасан авто зогсоолын үйл ажиллагаа, түүний нэгдсэн менежментийг хийх ийм чиг үүргийг хариуцуулж байгаа. Өөрөөр хэлбэл зарим зогсоолууд дээр өнөөдөр төр хувийн хэвшлийн түншлэлийн харилцаагаар зарим зогсоолуудыг өөрсдийнхөө мэдэлд эзэмшээд, түүнтэй холбоотой харуул хамгаалалт ашиглалтыг хийж байгаа бол зарим нь нийтийн зогсоол байдалтай байгаа. Зарим нь аж ахуй нэгжүүдийн нэр дээр байгаа.

Тэгэхээр бид нар цаашид Улаанбаатар хотын авто зогсоолын нэгдсэн судалгааг хийгээд, авто зогсоолын нэгдсэн менежмент, нэгдсэн системийг нэвтрүүлэхээр энэ хуулиар ийм эрхийг Нийслэлийн Засаг дарга авч байгаа. Тэрнээс биш Засаг дарга нь хийх гээд байгаа зүйл биш гэдгийг хэлье. Түрүүн Ганбат гишүүн асууж байсан автобустай холбоотой. Өнөөдөр Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас автобусны тендерийн үнэлгээг хийж дуусгасан байгаа. 5 үйлдвэрлэгч оролцоноос 1 аж ахуй нэгж буюу Хятадын Юутонг /Yutong/ брэндийн автобус өнөөдөр тендерт шалгарсан

гэдэг ийм мэдээллийг би албаныхнаас авсан. Маргааш олон нийтэд мэдээлэл хийнэ.

Мөн гэрээ байгуулах, эрх олгох мэдэгдлээ хүргүүлэхээр шийдсэн гэдгийг хэлье. Дэлхийд хамгийн 1 номер борлуулалттай евро стандартын ийм брэнд шалгарсан гэдгийг бас та бүхэнд хэлье. Барууны брэндийг шууд яагаад шалгаруулж болдоггүй юм бэ гэдэг асуудал ярьдаг. Барууны ялангуяа Герман Европын автобуснууд бол нэг бүрийнх нь үнэ ойролцоогоор 300-350 мянган еврогоор үнэлэгддэг. Энэ нь автобус ойролцоогоор 1 тэрбумаас дээш үнэтэй байдаг. Одоо энэ тендерт шалгарсан аж ахуй нэгжүүдийг 60 хэдэн мянган доллароор шалгарсан гэсэн ийм урьдчилсан байдлаар үнэ авсан.

Орон сууцтай холбоотой асуудал дээр энэ 12 дугаар сард Нийслэлийн иргэдийн Төлөөлөл дээр Нийслэлийн Засаг даргаас Улаанбаатар хотыг орон сууцжуулах нэгдсэн бодлого, хөтөлбөрөө танилцуулахаар бэлтгэгдэж байгаа. Таны тэр хэлсэн байрилууд дээр бид нар анхаарна. Одоо энэ хууль батлагдсаны гол үндсэн агуулга нь төр газар чөлөөлөлтийг хийх харилцаанд өөрөө оролцож, нэгдсэн байдлаар төлөвлөлт хийж байж аж ахуй нэгжүүдэд барилга барих тэр боломж, дэд бүтцийг нь татаж өгөх замаар орон сууцжих бодлого явуулах гээд л энэ хуулийг оруулж ирж байгаа шүү гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 72 санал байна. Гишүүд чуулганы танхимд. Санал хураалт явуулна.

Нийслэл Улаанбаатар хотын замын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал

хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй нийт 72 санал байгаа.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төрөл, хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахад орино.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин, Энхтайвангийн Бат-Амгалан, Жадамбын Бат-Эрдэнэ, Хассуурийн Ганхуяг, Цэндийн Мөнх-Оргил, Мөнхөөгийн Оюунчимэг, Даваажанцангийн Сарангэрэл, Дамдины Цогтбаатар цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт.

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “авто замаар” гэсний өмнө “замын хөдөлгөөний эрчим буурч,” гэж нэмж, мөн заалтын “цагаас доош буурч” гэснийг “цагт хүрэхгүй” гэж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтын “Орон сууцны тухай хуулийн 3.1.3-т заасан орон сууц хөгжүүлэх” гэснийг “гэр хорооллыг барилгажуулах” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 4.1.4 дэх заалтыг, мөн зүйлийн 4.1.8 дахь заалтын “энэ хуулийн 14.2-т заасан” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.9. “автотээврийн хэрэгсэл” гэж Автотээврийн тухай хуулийн 3.1.1-д заасныг.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн “ХОЁРДУГААР БҮЛЭГ”-ийн гарчгийн “ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТӨЛБӨРТЭЙ БҮС, АВТО ЗОГСООЛ” гэснийг “НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭР, АВТО ЗОГСООЛ” гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн дараа шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 6 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Төслийн 7 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 8 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5 дахь хэсгийн “шалтгаалан” гэснийг “хамааран” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг хасах. Санал гарсан ажлын хэсэг. Санал хураалт.

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Төслийн **“ГУРАВДУГААР БҮЛЭГ” “НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВЭР, ТҮҮНИЙ ЗОХИЦУУЛАЛТ”** гэсэн гарчгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Автомээврийн тухай хуулийн 15.1 дэх хэсэг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “авто замын даацыг” гэснийг “тээврийн хэрэгслийн өсөлт, авто замын сүлжээний нягтрал, замын хөдөлгөөний түгжрэлийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 12.2 дахь хэсгийн “тээврийн хэрэгслийн” гэсний өмнө “тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.14 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтын “авто зогсоолыг” гэснийг “автобусны буудал, авто зогсоолыг” гэж, 13.1.3, 13.1.4, 13.5.1, 13.5.4 дэх заалтын “чиглэлийн” гэснийг “нийтийн” гэж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “дүрэм, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг” гэснийг “дүрмийг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 13.5.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

68.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.4 дэх хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“16.4.Газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас энэ хуулийн 16.2-т заасан хугацаанд үнэлгээ хийлгээгүй бол уг хугацаа дууссанаас хойш 14 хоногт багтаан үнэлгээг хийлгэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “байриил буюу дэд төвийг түшиглэн” гэснийг “дэд төвийн байриилд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтын “барилгажилтын

төслийг” гэснийг “хот байгуулалтын холбогдох баримт бичгийг” гэж өөрчилж, мөн зүйлийн 19.1.2 дахь заалтын “гэрээ байгуулах” гэсний дараа “, төслийн нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;” гэж, мөн зүйлийн 19.1.5 дахь заалтын “талбарыг” гэсний өмнө “нэгж” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

69.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.7 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

67.14 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.1.4, 20.1.5 дахь заалт тус тус нэмэх.

“20.1.4.холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын ажлын уялдааг нэгдсэн удирдлагаар хангах;

20.1.5.төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг хөгжүүлэх.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтын “нийслэлийн авто замын даацыг харгалзан” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.4 дэх заалтын “байдал, замын хөдөлгөөний төлбөртэй бүс, түүнийг

тойрон өнгөрөх замын” гэснийг “байдлын” гэж өөрчилж, мөн зүйлийн 23 дугаар зүйлийн 23.2.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

62.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2 дахь хэсэг нэмэх.

“22.2.Нийслэлийн Засаг дарга Хот байгуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан ерөнхий архитекторын чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал уу. Гочоогийн Ганболд гишүүнээр үг тасаллаа. Гочоогийн Ганболд гишүүн үг хэлнэ дэмжсэн, дэмжээгүй.

Г.Ганболд: Энэ жоохон найруулгын хувьд ч юм уу жоохон алдаатай болчихоод байгаа юм. Ерөнхий архитектурын чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллага хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно гэхээр энэ болохгүй болчихоод байгаа юм л даа. Энэ ерөнхий архитектур өөрөө албан тушаал. Тэгэхээр ерөнхий архитектурын чиг үүргийг гэхээр энэ болохгүй. Харин зарим чиг үүргийг нь гээд эсвэл Нийслэлийн Засаг дарга Ерөнхий архитектурынхаа эрхлэх ажил, ажлын байрны тодорхойлолтоос зарим чиг үүргүүдийг нь бүүр авч хаяж байж мэргэжлийн байгууллага хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

Тэгэхээр шууд ерөнхий архитектурынхаа бүх чиг үүргийг гэх юм бол энэ чинь хүн биш болчих гээд байгаа байхгүй юу. Архитектур чинь өөрөө хариуцлага хүлээдэг ерөнхий төлөвлөгөө баталдаг тийм гарын үсэг зурж, тамга дардаг хүн шүү дээ. Тэгэхээр энэ чиг

үүргүүдийг нь өгчихнө гэхээр болохгүй байгаа юм. Яг энэнтэй адилхан ард нь тэр нэмэлт хуулийн Хот байгуулалтын хууль дээр бүүр ерөнхий архитектурын сонгон шалгаруулалтад аж ахуй нэгж орж болно гэж байгаа байхгүй юу. Энэ хоёрыг арай өөрчлөхгүй бол болохгүй юм шиг байна. Гүйцээн боловсруулах чиглэл өгдөг юм уу. Энийг өөрчлөхгүй бол арай болохгүй байх л гэж бодоод байна. Хот байгуулалтын хууль дээр ерөнхий архитектурын сонгон шалгаруулалтад нь аж ахуй нэгж орж болно гэж байгаа байхгүй юу.

Г.Занданшатар: Чиг үүргийг гэж биччихсэн байна тээ. Бүхэлд нь тэр үндсэн чиг үүрэг нь байх юм уу аль эсвэл зарим чиг үүрэг нь байх юм уу. Үүнийг гүйцэтгэн боловсруулах чиглэл.

25.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

26.Төслийн 25 дугаар зүйлийн хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

27.Төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.1.Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Үг хэлэх асуудал тооцсон учраас. Энэ 5-наас Төсөв гэхээд 15-наас гэхээр наад дотор чинь тэгэхээр төсөвтэй холбоотой юм байхгүй бол хуулийн хугацаа яаж уялдах юм байгаа юм. Энийгээ, энийг ч уул нь эцсийн

хэлэлцүүлэг дээр л хуулийн хугацааг заадаг л даа. Гүйцээн боловсруулах чиглэл өгье. Эцсийн хэлэлцүүлэг дээрээ яг хугацаагаа тодорхой болгож өг. Оны эхнээс байх юм уу.

Хоёр.Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал байна.

1.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “65” гэснийг “70” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ 14.3 дугаар заалт бол газар чөлөөлөлтөд өртөж байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах учраас 70 болгох ёстой. Энийг хэлмээр байна.

Хоёрдугаарт нь яг энэ газар чөлөөлөлттэй холбоотой энэ нөхөн олговор болон бусад зохицуулалт энэ 14 дүгээр бүлэг маань маш онцгой анхаарууштай заалт байгаа. Яагаад гэхээр өмнөх жилүүдэд тухайлбал тэр Нийслэлийн даргаар Бат-Үүл даргыг ажиллаж байх үед маш олон иргэд газар чөлөөлөлт дахин төлөвлөлтийн улмаас орон байргүй газраа өгөөд орон байргүй олон жил болсон. Тухайн үед хуулийн зохицуулалт байхгүй, журмаар бол хоёр, гурван талтай гэрээ байгуулна гээд. Нөгөө Засаг дарга нэг талаасаа, нөгөө талаас тэр гүйцэж байгаа хувийн компани гээд.

Тэгэнгүүт энэ яг гэрээний хугацаандаа иргэдийн маань орон байр гээд мөнгийг нь олгоогүй их олон жил болсон. Энэ бол асар тийм гомдол бүхий энэ Хүний эрхийн Комисс болон Олон улсын байгууллагын дүгнэлтэд орсон. Тэгээд Азийн хөгжлийн банкнаас ер нь энэ газар чөлөөлөлттэй холбоотойгоор иргэдийн эрхийг хэрхэн хамгаалах тухай гээд маш нарийн зөвлөмж өгсөн байдаг юм. Тэгэхээр энэ 14 дүгээр бүлэг энэ 14.3, 14.7 гээд заалтууд маань бүгдээрээ хүний

эрхийн суурь эрхийг хөндөж байгаа учраас энийг дахин боловсруулах чиглэлийг авмаар байна. Энэ дээр бол журмаар явж болохгүй.

Хэрвээ журмаар газар чөлөөлөлтийг зохицуулчих юм бол бид нар Монгол Улсын Үндсэн хуулийн 5.3-ыг зөрчих болчлоод байгаа. Үндсэн хуульд өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно гэсэн Үндсэн хуулийн заалт байгаа.

Тийм учраас энэ 14 дүгээр бүлэг 14.3 гэдэг дээр дахин боловсруулах чиглэл өгөөд энэ ажлын хэсэг энэ дээр ажиллаж бүх энэ нөхөн төлбөр, газар олголттой холбоотой асуудлыг хуулиар зохицуулах ёстой. Энийг бол хэлмээр байна.

Ер нь энэ хуулиар зохицуулахгүй бол журмаар зохицуулна гэхээр тухайн иргэд хохирсон олон кэйсүүд байна. Тэр олон улсын байгууллага, Азийн хөгжлийн банкнууд бол маш тодорхой журам, хугацаануудыг зааж өгөх ёстой гэж хэлж байгаа юм. Жишээлбэл, газраа чөлөөлчихсөн тохиолдолд хэдий хугацаандаа нөхөн төлбөр олгох юм. Азийн хөгжлийн банкны зөвлөмж дээр бол тухайн иргэнийг нүүхээс өмнө тэр нөхөн олговрыг олгосон байна. Үүний дараа тэр чөлөөлөлт явагдана. Тэгээд энэ газар чөлөөлөлтөд өртсөн хүмүүстээ зориулсан энэ гомдол барагдуулах механизм байх ёстой гэж.

Гэтэл яг энэ хууль дээр бол хэнд хандах яах вэ гэдэг нь ерөөсөө байхгүй. Энийг журмаар гаргана гэхсэн байгаа маань яг тэр 2010 хэдэн оны үеийн Ардчилсан намын Бат-Үүл даргын үеийн тэр зөрчлүүд дахин гарах эрсдэлтэй байна. Тийм учраас энийг дахин гүйцээн босгох чиглэлийг авах ёстой гэж бодож байна. Хүний эрхийн дэд хорооны даргын хувьд.

Г.Занданшатар: Тэгэхдээ 14.3-ыг санал хураалт явуулах гэж байгаа шүү дээ. Тэгэхээр та 14.7-г яриад байна л даа.

14.7 бол нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журмыг Засгийн газар батална гэж байгаа юм. Энэ хөндөгдөөгүй заалт учраас гүйцээн боловсруулах чиглэл өгч болохгүй болчлоод байна л даа. Энэ чинь 65-ыг 70 болгох л тухай асуудал шүү дээ. Газар чөлөөлөх бол тухайн иргэн, хуулийн этгээдийн тухайн үед газар үл хөдлөх нь өмчилж байгаа иргэдийн 65 хувь нь дэмжсэн бол гэж байсныг л 70 хувь болгоё л гэсэн санал гаргаад тэр нь дэмжигдээгүй юм байна л даа тийм ээ. Үлдсэн 30 хувийн цөөнхийн эрх зөрчигдөнө гэсэн асуудал тэгээд 25, 32 ямар ч ялгаагүй шүү дээ. 35, 32-ын хооронд л.

Энэ дээрээ санал хураалт явуулъя тээ. Энэ дээрээ санал хураалт явуулчих уу, тэгэх үү Энхболд даргаа. Санал хураалт. Дэмжихгүй юм уу дарга.

Дэмжигдсэнгүй энэ санал. Тэгэхдээ олон улсын практик энэ Солонгос энэ тэрд бас тийм практик байдаг хувь нь хэд байдаг юм энэ тэр. Айн санал хураагаад дуусчихлаа одоо. 70 болчихлоо. Байнгын хороон дээрээ л ярья даа.

Гурав. Найруулгын санал.

1.Төслийн “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэснийг “ГУРАВДУГААР БҮЛЭГ” гэж, “ТАВДУГААР БҮЛЭГ” гэснийг “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэж, “ЗУРГАДУГААР БҮЛЭГ” гэснийг “ТАВДУГААР БҮЛЭГ” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 9 дүгээр зүйлийн дугаарыг “8” гэж, 10 дугаар зүйлийн дугаарыг “5” гэж, 11 дүгээр зүйлийн дугаарыг “6” гэж, 12 дугаар зүйлийн дугаарыг “9” гэж, 13 дугаар зүйлийн дугаарыг “7” гэж, 14 дүгээр зүйлийн дугаарыг “10” гэж, 15 дугаар зүйлийн дугаарыг “11” гэж, 16 дугаар зүйлийн дугаарыг “12” гэж, 17 дугаар зүйлийн дугаарыг “13” гэж, 18 дугаар зүйлийн

дугаарыг “14” гэж, 19 дүгээр зүйлийн дугаарыг “15” гэж, 20 дугаар зүйлийн дугаарыг “16” гэж, 21 дүгээр зүйлийн дугаарыг “17” гэж, 22 дугаар зүйлийн дугаарыг “18” гэж, 23 дугаар зүйлийн дугаарыг “19” гэж, 24 дүгээр зүйлийн дугаарыг “20” гэж, 26 дугаар зүйлийн дугаарыг “21” гэж, 27 дугаар зүйлийн дугаарыг “22” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Хатантуул аа энэ найруулгын саналыг, дугаар өөрчлөх саналыг ингэж бичдэггүй. Энэ дотор ингэж байгаа янз янзын юм байвал нааш цааш хөдөлгөөнд оруулснаас үр дагавар, хууль зүйн үр дагавар гарахгүй биз. Энэ чинь найруулгын санал шүү дээ. Айн хууль зүйн үр дагаваргүй саналыг л найруулгын саналаар авна шүү дээ.

Тэгэхдээ дугаар өөрчлөхийг бол заавал ингэж бичихгүйгээр авч болдог. Дугаар бичээд байхыг бодоход энэний цаана юм хийчхэж байгаа юм биш биз. Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналууд дэмжигдсэнтэй уялдуулан дугааруудыг өөрчлөх, шинэчлэх гэсэн ерөнхий заалтаар хураагддаг байхгүй юу. Энэ дээр яг ингэж бичээд байхаар би бас нарийвчлан тулгаж үзэхгүй бол энийг Байнгын хороо тулгаж үзээрэй Үнэнбат даргаа. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалтб

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмж, үүнтэй холбогдуулан 1 дүгээр зүйлийн хүснэгтийн 3 дахь заалтын “, цахилгаан тэжээлт автомашин” гэснийг хасах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

11.Цахилгаан тэжээлт автомашин 0-100000. Дараагийн хэсэгт нь 0-80000. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин.

Цахилгаан машиныг татвартай болгоё гэж байгаа юм уу тээ. Тэгэхдээ дэлхий нийтээрээ л цахилгаан машиныг дэмжих бодлого явуулж байгаа. Манайх л хязгаарлах бодлого явуулна гэсэн үг болно шүү дээ. Санал хураалт.

Хөдөө тэгэхдээ нээх цахилгаан тэжээлтэй автомашин. Тэгэхдээ 0-оос гэсэн юм байна л даа. 0 тогтоож бас болох л юм байна. Энийг чинь хурал тогтоох юм уу.

Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 12.6 дахь хэсгийн “төлбөрийг” гэснийг “төлбөрийн орлогыг” гэж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 15.9.2 дахь заалтын “боловсон хүчин” гэснийг “хүний нөөц” гэж тус тус өөрчилж, 15.10 дахь хэсгийн “, нэг өнгийн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ Автотээврийн болон өөрөө явагч хэрэглэгчдийн албан татварыг чинь орон нутаг тогтооно гэсэн үг биз дээ эхлээд. Тийм тэгэхээр орон нутагтаа 0, аймгийн болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал өөрсдөө 0-100000 тогтоон шийднэ гэж үзэж болно.

2.Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар. Энэ хураачихсан.

2 дахь заалт нь.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 17^{1.5} дахь хэсгийн “олгоно” гэсний өмнө “энэ зүйлийн 17^{1.2}-т заасан журмын дагуу” гэж нэмж, 17^{1.7} дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17^{1.7}.Энэ хуулийн 17^{1.5}-д заасан хязгаарт багтаан олгох автотээврийн хэрэгслийн төрөл, ангилал, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлтийг нийслэлийн Засаг дарга батална.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

70.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 10.1.10 дахь заалтыг болон мөн зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “замын хөдөлгөөний төлбөртэй бүс болон” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18 цаг болж ажлын цаг дууссан байна. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу

олонхын саналаар сунгаж хуралдаж асуудлыг шийдвэрлэдэг учраас санал хураалт талдаа ч ороогүй байгаа учраас энэ асуудлаа дуустал нь хуралдаад, саналаа хураалдаад явуулчихъя гэсэн саналтай байна. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү.

Олонх дэмжсэн учраас хуралдааны цагийг сунгалаа.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 13.2.9 дэх заалтын “торгох шийтгэл” гэсний өмнө “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан оногдуулсан” гэж нэмэх. Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал байна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 13.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.5.Иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 13.2.9, 22.4-т заасан үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол автотээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахыг хориглоно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэг ийм утгатай заалт оролцсон шүү дээ. Дөрөв, төлбөр, татвараа төлөөгүй л гэсэн үг дээ.

4.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

27.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя. 1 санал хураалттай.

1.Төслийн 4 дүгээр зүйлийн “38 дугаар зүйлийн” гэсний өмнө “25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “хариуцсан газартай” гэснийг “хариуцсан байгууллагатай” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 9.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.7.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй барьсан, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг зөрчсөн барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгах зэргээр орц, гарцыг гаргах арга хэмжээг авах.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Энэ хуулийн 9.1.7-д заасан барилга байгууламж, инженерийн дэд бүтцийг шилжүүлэх, албадан буулгахтай холбоотой зардлыг буруутай этгээдээр гаргуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 9.3, 9.4, 9.5 дахь хэсэг нэмэх:

“9.3.Энэ хуулийн 9.1.2-т заасан аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын сонгон шалгаруулалтад Барилгын тухай хуулийн 44.3-т заасан мэргэшлийн зэрэгтэй архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтэн, эсхүл мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд оролцож болно.

9.4.Аймаг, нийслэлийн ерөнхий архитекторын эрх, үүргийг мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд хэрэгжүүлэх бол аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулна.

9.5.Энэ хуулийн 9.4-т заасан мэргэжлийн байгууллага, хуулийн этгээд нь энэ хууль болон гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлж, хариуцлага хүлээнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хороон дарга.

Н.Энхболд: Энэ заалт дээр чиглэл аваад, гүйцээн боловсруулах шаардлага байгаа. Түрүүн бас хэн нь ярилаа Сандагаа гишүүн яриу уу, Ганболд гишүүн ярьсан. Тэгэхээр үүнийг үзээд эцсийн хэлэлцүүлэг дээр арай жаахан янзлаад оруулах чиглэл өгөх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол нөгөө сонгон шалгаруулалтад байгууллага энэ тэр гээд үгнүүд орчихсон байгаа болохоор тэрэнтэйгээ уялдуулж янзалья.

Г.Занданшатар: Тийм. Энийг ер нь бас гүйцээж сайн харахгүй бол. Бусад хуулиар чинь ерөнхийдөө архитектурын зөвшөөрөл, гарын үсэгтэй шийдэгддэг юм уу, хуулийн этгээд дээр очихоор хүнд суртал, чирэгдэлтэй болоод л байгууллагын нэг юм, процессуудаа яаж шийдэж байгаа юм гэдгийг бас судалж үзэх ёстой.

Гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “70 хувиас” гэсний дараа “илүүгүй” гэж, “60 хувиас” гэсний дараа “илүүгүй буюу төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-иос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-иос доошгүй хувь нь авто зогсоол” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Хөөе Дамдины Цогтбаатар гишүүн хавтсаа сугавчлаад хаашаа явах нь вэ.

65.1 хувийн саналаар санал дэмжигдсэн.

6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал юм. Тэгэхдээ Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал юм байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Санал хураалт.

Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулаад дэмжигдчихлээ шүү дээ.

7.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 9.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.Энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван сарын дотор уг хэсэгт заасан гэрээг нөхөн байгуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцъё. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Энэ Зөрчлийн тухай хууль дээр түрүүн Пүрэвдорж гишүүн хэлсэн та яг тэр асуудал нь болохоор яриарай гээд. Энэ тэр заалт Зөвшөөрлийн тухай хууль явж байх ишг байна. Тэгэхээр энэ дээр та гүйцээн боловсруулах санал өгмөөр юм байна лээ. Өөрөөр хэлбэл зөвхөн иргэнийг торгоно гэгчээр “Uber”-үүд орохгүй гэж жолооч нар санаад байгаа учраас цахим платформоор дамжин жолооч, хэрэглэгч хэн нь хэн нь бүртгэлтэйгээр зорчигч тээвэрлэдэг үйлчилгээ үүнд хамаарахгүй гэдэг үгийг нэмэх ёстой. Тэгэхээр энийг та гүйцээн боловсруулахаар санал өггөх үү. Айн үгүй ээ Зөрчлийн хууль дээр чинь байгаа юм биш үү. Үгүй энэ чинь Зөрчлийн хууль л гэж байна шүү дээ.

Г.Занданшатар: Зөвшөөрлийн тухай хууль байна.

С.Одонтуяа: Тийм үү.

Г.Занданшатар: Түрүүний төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг 65.1 хувийн саналаар санал дэмжигдсэн гэдгийг хэлье. Хэлэлцүүлэг хийж байгаад хэлээгүй байж магадгүй.

Санал хураалт явуулъя. Энэ Зөвшөөрлийн тухай хууль. Энэ чинь Шүүх байгуулах тухай хууль байна уу, саяын хуулийн багц хууль аваад ир дээ Зөвшөөрөл. Тэгэхдээ энэ дээрх 3.4.3 дахь

чинь тийм л байгаа. Яах вэ санал хураалт явуулъя.

Зөвшөөрөл хүчин төгөлдөр болсноос хойш 3 сарын дотор уг хэсэгт заасан гэрээг нөхөн байгуулна гэдэг чинь.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т заасан нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх зохицуулалтыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Ярих хэрэг байгаа юм уу энэ дээр. Үгүй ээ энэ чинь. Санал хураалт явуулъя. Энэ 24 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс. Үгүй ээ энэ заалт чинь уначих юм бол тэгээд шууд хэрэгжээд эхэлчихнэ шүү дээ энэ чинь 12 сарын 15-наасаа. Тэр заалт чинь өнгөрчихсөн. Одоо энэ чинь бол ерөөсөө дагаж мөрдөх хугацааны л тухай санал хураалт явуулах гээд байна. Айн энэ заалт чинь ийм заалтаар санал хураалгах гээд байна шүү дээ. Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т заасан нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх зохицуулалтыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энийг наашлуулъя гэвэл бид нар, төслөөрөө үлдчих юм бол 12 сарын 15-ны өдрөөс шууд зохицуулалттай болчихно гэсэн үг. Зөвшөөрөлтэй болчихно гэсэн үг. Энийгээ 10 сарын 15 хүртэл хойшлуулж байгаа юм байгаа биз дээ. Амартүвшин гишүүн тээ. Тийм, санал хураалт явуулъя. Санал хураалт.

Үгүй үгүй тэр заалт чинь өнгөрчихсөн. Энэ чинь хэрэгжих хугацааны тухай л санал хураалт шүү дээ. Энэтэй шууд холбоогүй биш шүү дээ. Нийслэлийн иргэн л гэж байгаа юм л даа.

Тэр нь өнгөрчихсөн л дөө. Тэр нь нийслэлийн 1.2 нь бол нийслэлд л гэсэн юм байсан биз дээ Амартүвшин гишүүн ээ. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал. Цааш нь.

8.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 13.7 дахь хэсгийн “зориулалтыг” гэсний өмнө “хийц, бүтээц,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тогтохоо дарга та л өөрөө ажлын хэсгийг ийм саналтай байгуулсан шүү. Би та нарын оруулж ирсэн юман дээр л гарын үсэг зурсан болохоос биш. Та нарын саналаар л энэ ажлын хэсгийг байгуулсан. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр ярихгүй яасан юм. Чуулган дээр энэ шал өөр заалт дээр, шал өөр заалт дээр өөр, шал өөр заалт дээр чиглэл өгье гэвэл дэг зөрчигдөнө. Хуулийн дагуу явна. Цаашаа явъя.

9.Төрийн албаны тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд. Санал гаргасан гишүүн үг хэлж болно. Нямаагийн Энхболд гишүүн гаргасан саналаа тайлбарлаж үг хэлнэ.

Н.Энхболд: Энэ яг ингээд орчихоор бас оруулж ирсэн төслөөр нь оруулчихаар, 20.3-аар нь оруулчихаар дараа нь нийслэл, аймаг, салбар гээд янз бүрийн чиглэлээр хуульд өөрчлөлт оруулаад байх боломж нээгдчих гээд байгаа юм.

Тийм учраас энэ заалтаа дэмжиж хасчихаад, тэгээд нийслэлд өгөх чиглэлийн тогтоол дотор энэ асуудлаа зохицуулсан

заалтаа оруулж ир гэсэн юмаа. Бид нар ярья гээд тохирчихсон юм Нямбаатар даргатай. Тэгэхээр та энэ дээр одоо саналаа хураачхаад тэгэхдээ тогтоолд оруулаарай гэдэг, агуулгыг нь тогтоолд оруулаарай гэдэг тийм чиглэл өгчихвөл болчихож байгаа юм.

Г.Занданшатар: Тэгэхээр Нямаагийн Энхболд даргаа тогтоол дээр. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “түүний иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар” гэснийг “тухайн шатны Засаг даргаар” гэж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэснийг “Засаг дарга” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн.

Энэ чинь ерөөсөө нэгхэн заалттай. Хуульд хуулийг тэр чигээр нь буцаачихвал яадаг байсан юм. Хасчихаар үндсэндээ, хасчихаар үндсэндээ энэ чинь байхгүй болчхов.

Ганболд гишүүн хаачсан өөрөө. Энэ чинь Үндсэн хуулийн хувьд ч гэсэн хурлынхаа дэргэд байдаг ёстой юм л даа. Энэ ч ганцхан л заалттай хууль байсан л даа. Тэр хуулиа л буцаахад болчих байх. Яах вэ ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд анхааралтай. Санал хураалт, дэмжчихээд.

65.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 35.2.1 дэх заалтыг хасаж, 35.2.2 дахь заалтын дугаарыг “35.2.1” гэж өөрчлөн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.2.1.амьтны хүрээлэн ажиллуулах журам;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Зөрчлөөрөө л явж байна уу. Тийм.

12.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалтын “5 000 000-10 000 000” гэснийг “3 000 000-10 000 000” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ улсын тэмдэгтийн хураамж энэ таксины үйлчилгээ байхгүй юу 29.1.14. Энийг бүртгэлтэй болгоод 5-10 сая төгрөг болгож байгаа юм. Манай хөдөө чинь яах вэ би нийслэлийг ойлгож байна. Хөдөө чинь 5 сая төгрөгөөр зөвшөөрөл авах хүн олдохгүй шүү дээ. Би энэ хот, нийслэл хоёрыг салга гээд байдаг нь л ийм байгаа байхгүй юу. Энийг уул нь салгах ёстой байхгүй юу. Ингээд түрүүн хууль нь явчихсан, бид нар түрүүн Замын хөдөлгөөний хуулиараа явчихсан таксины зөвшөөрлийг олгоно гээд. Одоо энэ хураамжийг болж өгвөл хоёр салгамаар байгаа юм. Аймагт юу гэдэг юм арай бага. Би бүртгэлтэй байлгах, хяналттай байлгах, хариуцлагатай байлгахыг ойлгож байна. Мэдээж энэ гэмт хэрэг гарахад нөлөөлж байгаа нэг хүчин зүйл байгаа юм. Энэ бүртгэлгүй олон таксинууд энийг ойлгож байна.

Гэхдээ бүртгэлийн хураамж нь ийм өндөр байж болохгүй. Тийм учраас энийг дараагийн хэлэлцүүлэг дээр нь

салгаад нийслэлд, аймагт гэж ингээж хоёр салгамаар байна.

Г.Занданишатар: Амартүвшин гишүүн.

Г.Амартүвшин: Тогтохсүрэн дарга энэ чинь ийм учиртай юм л даа. Такси үйлчилгээний зөвшөөрлийг авч байгаа хуулийн этгээд 1 удаа 3-10 сая төгрөгийн хураамж төлж байгаа байхгүй юу зөвшөөрөл авахдаа. Тэгэхээс биш хувь хүмүүс такси үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсийн асуудал биш. Энийг нэгэнт л бид нар Зөвшөөрлийн хууль такси үйлчилгээ зөвшөөрөлтэй байна гэж тогтоосон тул энийг ингээд хураамжтай болгож байгаа юм.

Тийм болохоор энэ бол бол нээх их тэгж байнга сар болгон юм уу, жил болгон аваад байдаг тийм хураамж биш шүү.

Тийм болохоор энэ санал хураалтыг, тийм. Ер нь тэгээд Нийслэлийн Иргэдийн Хурал нь ч 3 сая байх уу, 10 сая байх уу гэдгийг нь өөрсдөө шийднэ. Аймгийн Иргэдийн Хурал нь ч гэсэн өөрсдөө шийдэх байхгүй юу.

Тэгэхлээр энэ асуудлыг таны хөндөж байгаа асуудалдаа арай өөр гэж би хэлэх гээд байна. Тийм болохоор санал хураалтыг үргэлжлүүлж явуулна уу.

Г.Занданишатар: Ер нь энэ асуудлаар байна шүү дээ. Тогтохсүрэн даргаа түрүүний тусгай зөвшөөрлийн асуудал угаасаа Зөвшөөрлийн хуульдаа байсан бөгөөд энэ дээр сая Зөвшөөрлийн тухай хууль дээр нэмэгдсэн юм чинь гуравласан гэрээ байгуулах энэ тэр заалт орж байгаа юм. Энэ асуудал яагаад бас яг энэ тэмдэгтийн хураамж энэ дээрээ л таны ярьж байгаа чинь зөв байгаа юм. Түрүүн ярих юм бол дэг зөрчигдөх байсан бөгөөд Дорноговьд болсон хэрэг явдал одоо энэ такси чинь тусгай зөвшөөрөлтэй байхгүй бол нийтийн тээвэр тусгай зөвшөөрөл ямар нэгэн

байдлаар аймгийн Засаг дарга энэ тэр хянаж байхгүй бол хүүхдийн эрх зөрчигдөх, хулгай дээрэм гарах, тэгээд гэмт хэрэг зөрчилд ял шийтгүүлж байсан хүмүүс энэ нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэх чинь өөрөө эрсдэлтэй байдаг учраас дэлхий даяар энэ дээр хяналт тавьж байх. Орон нутагт ч гэсэн тэр хяналт тавих ёстой. Энэ зөвхөн хуулийн этгээд таксины үйлчилгээ үзүүлэхдээ UB cab ч байна уу, аль эсвэл Улаанбаатар такси ч байна уу тэр газар нь бас хариуцлагаа хүлээж ингээж такси тээврээ зохицуулдаг энэ тэр тийм зохицуулалт байхгүй бас энэ шилжилтийн үеэр юу шигээ яваад байх нь өөрөө эрсдэлтэй байгаа учраас л энийг зохицуулалт бас аль аль талаас шаардлагатай гэж үзсэн байна. Тэгэхдээ энийгээ яах вэ зүгээр эцсийн хэлэлцүүлэг дээрээ тэнд зүгээр нэг юм нь юу л байгаа юм л даа авто тээврийн хэрэгсэл дэх техникийн хяналтын үзлэг хийх ажлын тусгай зөвшөөрөл гэж нэг байгаа юм. Ингээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Тэгвэл 3-10 сая гэдгээрээ.

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 23.6.11 дэх заалтыг хасаж, 23.6.12 дахь заалтын дугаарыг “23.6.11” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсгээс. Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Энд хууль хоорондын нийцлийн зөрчил гараад байгаа юм. Үл хөдлөх хөрөнгийн орлогын албан татварын тухай хуульд оруулж байгаа өөрчлөлт нь энэ 23.6.12 байхгүй юу. Үндэсний стандарт барихгүйгээр барилга барьж болно тэгэх юм бол үл татварыг 1 функтээр нэмэгдүүлээд авна

гэж ярьж байгаа юм. Сая биднүүс Хот байгуулалтын тухай хууль яриад тэр 4 дэх санал хураалтаар нь тодорхой квотууд хэлээд, 20 хувиас доошгүй ногоон байгууламж энэ тэр гээд хэлчихсэн. Гэтэл тэрийгээ барихгүй байж болно. Тэгвэл үл хөдлөхийн чинь татварыг илүү авна гэж хэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ байж боломгүй хууль хоорондын нийцэл хангагдаагүй ийм зүйл, нэг.

Хоёрдугаарт Төсвийн хуульд энэ нийтийн тээврийг хөгжүүлэх сантай байна гэж байгаа байхгүй юу. Нийслэл тэр урд 10.6 дээр билүү дээ. Тэгвэл энэ төсвийн хуульд орж ирэх ёстой шүү дээ. Төсөв өөрөө нэгдсэн байх ёстой. Тэгэхээр зэрэг нийслэл ямар сантай байх юм гэдэг асуудал Төсвийн хуульдаа орох ёстой тэр нь ороогүй. Ийм сан болчихоод байгаа.

Г.Занданшатар: Батжаргал гишүүн ээ та будлиад байна. Энэ дараагийн санал хураалтын асуудал. Энэ байна шүү дээ замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөрийг хасаж байгаа юм.

Ж.Батжаргал: Үгүй үгүй харин наад.

Г.Занданшатар: Биш ээ харин замын хөдөлгөөний төлбөртэй.

Ж.Батжаргал: 23.6.12 чинь үл хөдлөхийн татвар байхгүй юу.

Г.Занданшатар: Биш ээ 23.6.11 замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөр гэдгийг хасаж байна. 23.6.11 нь.

Ж.Батжаргал: 11 нь тэр нь, 12 нь өөр юм байхгүй юу.

Г.Занданшатар: 12 нь тэрийгээ л нэг болгож урагшлуулж байгаа юм. Нэг нь хасагдчихаар нь 2 болж өөрчлөгдөж байгаа.

Ж.Батжаргал: Үгүй үгүй. Харин тэр урагшлуулж байгаагаа чинь өөрөө хууль хоорондын нийцэл хангагдаагүй.

Г.Занданшатар: Энэ санал хураалт бол 23.6.11-ийг л хасаж байгаа юм. Энийгээ хассантайгаа холбогдуулаад 12 нь 11 болгож дугаарыг нь өөрчилж байгаа л ийм санал хураалт. Тэн дээр, дараагийнх дээр ярих юм. Санал хураалт явъя.

Дараагийнх нь үл хөдлөх эд хөрөнгө. Энэ ер нь тэгэхдээ зарчмын хувьд зөв шүү дээ. Санал хураалт явуулъя.

Ер нь үл хөдлөх хөрөнгийн татвар Хувь хүний орлогын албан татвар, хотын татвар орон нутгийнхаа төсөвт ордог татвар шүү дээ. Ер нь харин үл хөдлөх хөрөнгийн татварыг их хуулийг нь шинэчилж, энэ хуулийг их оновчтой болговол Улаанбаатар хотын төсөв энэ түгжрэлээ шийдчих хэмжээнд бүрэн шийдэхгүй юм гэхэд тодорхой хэмжээнд шийдэх эх үүсвэр бүрдэнэ. Энэ А бүсэд байгаа үл хөдлөх хөрөнгүүдийн үнэлгээ ялгаатай, маш бага татвар төлдөг хэсэг байхад зарим нь шударга татвар төлдөг. Ялгаатай үйлчилж байгаа. Дэлхий даяар үл хөдлөх хөрөнгийн татвар бол шаталсан хэлбэртэй байна. Англид бас 1 сая фунт стерлингээс дээш 5 хувь, доош 4, 3, 2, 1 гээд байдаг. Энэ дээр бол 1 хувиар л тогтоож байгаа юм байна лээ. Дараагийн асуудалд орно. Энэ сая 58, сая энэ санал олонхын саналаар дэмжигдсэн.

14.Үл хөдлөх хөрөн эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.2 дахь хэсгийн “12.6.3-т” гэснийг “12.6.3, 12.8-д” гэж, “татварын хэмжээг” гэснийг “татварын хувь, хэмжээг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт явуулах уу. Санал хураалт.

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ. 15.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хүртэл” гэснийг “дуустал” гэж, 2 дугаар зүйлийн “бараа” гэснийг “барилгын материал” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ чинь л харин асуудалтай л эд байна даа. Энэ барилгын материал машин механизмыг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр бүгд л гэр хорооллыг орон сууцжуулж байгаа гээд л чөлөөлөгдөх ийл л нүхтэй болчихлоо. Тэгэхдээ л бараа, машин механизмын жагсаалт, тоо хэмжээг кодоор уялдуулах системээр ангиллын дагуу Засгийн газар батална гэж байна л даа. Тэгэхдээ л энэ. Ер нь бол валютын хани л 4, 5 мянга болох байх.

58.3 саналаар санал дэмжигдлээ.

16.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.10.гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

71.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ Тэлмүүн дарга тэгээд энэ гаалийн татварын чөлөөлөлтөөр чинь ямар төсөвт нөлөө үзүүлэхийг нь тооцсон юм уу. Ажлын хэсгийг та л хариуцах нь байна шүү. Шууд

барааны...гарчихаар бүх барилгын материал чөлөөлөгдөх нь байна шүү дээ.

16.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

17.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “22.5.15, 22.5.16 дахь заалт” гэснийг “22.5.18, 22.5.19 дэх заалт” гэж өөрчилж, 22.5.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.5.19.гэр хорооллыг орон сууцжуулах ажилд зориулан гэрээний дагуу газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхээ гэр хорооллыг орон сууцжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагад борлуулсан, шилжүүлснээс олсон орлого.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо НӨАТ, гааль, НӨАТ-ын татвараас чөлөөлөлт гэхэд 450 тэрбум төгрөг төсөвлөсөн байсан. Ингээд гааль, татваруудаас чөлөөлчихнө.

18.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 4.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Хүн, хуулийн этгээд энэ хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11.19 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 14.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэж торгох шийтгэлийг хугацаанд нь төлөөгүй нь энэ хуулийн 3.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу автотээврийн

хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах үндэслэл болно.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Дамдины Цогтбаатар гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн хоёроор тасаллаа.

Д.Цогтбаатар: Дарга энэ Зөрчлийн хуультай холбогдуулаад яах аргагүй хот дээр ярих асуудал байгаад байгаа юм. Энэ ажлын хэсэгтэй ярихад энэ таксины компанийн энэ зөвшөөрөл чинь зөвхөн такси компанидаа л хамаатай. Түүнээс “Uber”-т ерөөсөө ямар нэгэн хориг байдлаар зохицуулалт үйлчлэхгүй шүү гэдэг байр суурийг энэ ажлын хэсэг хэлж байгаа юм. Энийг би яг протоколд албан ёсоор тусгамаар байгаа юм.

Яагаад гэвэл энэ чинь Зөрчлийн хуулийн дагуу дараа нь торгуулиа яриад ирэхлээр “Uber”-ийнхнийг очоод торгох гээд байхгүй шүү гэдэг энэ ойлголттойгоор энэ Зөрчлийн хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд орж ирсэн гэж би ойлгож байгаа. Ажлын хэсгийнхэн яг ийм тайлбарыг надаа өгч байгаа. Энэ үүднээс нь энэ юуг дэмжээд явж байгаа. Энийг би зүгээр тэмдэглэлд үлдээх гэсэн юм, протоколд.

Г.Занданшатар: Маши зөв зүйтэй санал байх. Тэгэхдээ одоо энэ торгууль, шийтгэлийн хөдөлгөөнийг хязгаарлах энэ үндэслэл чинь алийг нь “Uber” -ийнх, алийг нь “Uber” биш гэж тодорхойлох юм. “Uber” гэж яг манайд байгаа юу гэж нэрлэж байгаа. Энэ чинь яг тод протоколдоо тэр нэрээр нь тэмдэглэхгүй бол энэ үндэслэлээр чинь хууль хэрэгжих үндэсгүй болно шүү дээ. “Uber” гэж манайд байхгүй шүү дээ.

Салдангийн Одонтуяа гишүүн

С.Одонтуяа: Тэгэхээр UB cab гэдэг нэрээр болохгүй. Яагаад гэхээр UB cab-аас өөр бас ийм компаниуд гарч ирэх ч боломжтой шүү дээ. Тэгэхээр энийг юу

гэж тодорхойлох ёстой вэ гэхээрээ зөвхөн протоколд үлдээгээд энэ хэцүү. Яагаад гэхээр цагдаа нар торгохдоо хуулиа л барина. Энэ чинь хэдэн жилийн дараа ч гэсэн энэ асуудал үүснэ.

Тэгэхээр юу гэж оруулах ёстой вэ гэхээр энэ заалт чинь 6.30.4 дүгээр заалт хөндөгдөөгүй байхгүй юу ажлын хэсэг дээр. Тэгэхээр энэ хөндөгдөөгүй заалт дээр ийм юм нэмж оруулах ёстой юм “цахим платформоор дамжин жолооч, хэрэглэгч хэн хэн нь бүртгэлтэйгээр зорчигч тээвэрлэдэг үйлчилгээ үүнд хамаарахгүй. гэж хаалтад оруулах ёстой.

Өөрөөр хэлбэл энийг чинь “Uber”-ийг чинь монголчилсон нэр нь цахим платформоор дамжин жолооч, хэрэглэгч, хэн хэн нь бүртгэлтэйгээр зорчигч тээвэрлэдэг гэж байгаа. Тийм ингэж оруулах ёстой байхгүй юу. Тэгэхгүй бол амаар тайлбар өгөөд байна гээд энэ 40000 гаруй автомашины жолооч нар чинь сандралдаад байна шүү дээ. Тэгэхээр энийг хууль тодорхой байх ёстой. Амаар тайлбар өгнө. Протокол гэхээр протоколыг чинь тэр цагдаа олж үзэж чадахгүй. Тэгэхээр энийг та дараагийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулахаар оруулаад өгчихсөн нь дээр.

Г.Занданшатар: Ганибалын Амартүвшин гишүүн тайлбар. Ажлын хэсэг, үг хэлнэ дэмжиж.

Г.Амартүвшин: Тэгэхлээр энэ 6.30, нэгдүгээрт бид нар 6.30-ийг арай санал хураах болоогүй байгаа. 6.29 дээр явж байна. 6.30 нь болохоор компани, аж ахуй нэгж, хуулийн этгээд нь таксины зөвшөөрөл авах ёстой гэсэн бид нар заалт оруулсан шүү дээ Зөвшөөрлийн хуульд. Тэрэнтэй холбоотой хэрвээ таксины зөвшөөрөл аваагүй тийм авто тээврээр хүмүүсийг зөөсөн байвал торгууль төлнө л гэсэн байгаа шүү дээ. UB cab бол огт хамааралгүй. Энэ UB cab-хан аймаар лоббитой. Бүх гишүүдэд энэ

та таны хэлсэн Одонтуяа гишүүний хэлсэн юмыг явуулсан байна лээ. Үгүй болно.

Гэхдээ байна шүү дээ бид нарт ажлын хэсэг дээр тэр компанийн гүйцэтгэх захиралтай нь, бүгдэд нь уулзаад, тайлбарлаад бүх ойлголцохгүй юмаа ойлголцсон. Энэ зөвшөөрөл чинь UB cab-д огт хамааралгүй. Энэ такси үйлчилгээ чинь зөв талдаа рултэй машин байх ёстой. Одоо стандартын дагуу зөвшөөрлөө авсан тийм л машин тээврийн хэрэгслийн асуудал ярьж байгаа шүү дээ. Хувь хүмүүс ерөөсөө энд өртөгдөхгүй. UB cab-д бүртгүүлсэн хувийн машинтай нөхөрт өөрөөр хэлбэл тэр иргэддээ үйлчилгээ үзүүлж байгаа л үйлчилгээ байхгүй юу. Энд такси үйлчилгээний үйлчилгээ биш. Тийм болохоор энд огт хамааралгүй зүйл заалт.

Тийм болохоор энэ такси үйлчилгээ бол яг энэ Зөвшөөрлийн тухайн хуульдаа орсон өөрчлөлтийн дагуу такси зөвшөөрлийн авсан компаниудтай хамааралтай. Тэр UB cab болон бусад цахим платформын үйлчилгээ бол энд огт хамааралгүй байхгүй юу. Тэр такси үйлчилгээ биш.

Г.Занданшатар: Үгүй яах вэ энэ уг агуулга нь бол замын хөдөлгөөнд оролцуулахгүй гэсэн байсан. Торгууль, шийтгэлээ төлөөгүй бол замын хөдөлгөөнд оролцуулахгүй гэсэн байсныг тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах үндэслэл болгоно л гэж өөрчилж байгаа юм л даа. Тэр 14.7-г зааж байгаа бол 14.7, 14.4 дэх ... хэсгүүдтэй холбогдоод яриад байна тээ.

Торгууль, шийтгэлийг нь яагаад байгаа юм уу тээ. Зөрчлийн тухай хууль дээр чинь өөр хөндөгдөөгүй юм алга байна л даа. Тэр 14.7. Тэгвэл энэ өөр хууль руу орох гээд байна шүү дээ.

Санал хураалт явуулъя. Яг энэ заалттай холбогдохгүй юм байна.

Дараагийн санал хураалт дээр гүйцэтгэн боловсруулах чиглэл өгье. Санал хураалт. Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хороон дарга Баттөмөр гишүүн суудалдаа суугаарай санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ заалтаа дэмжих юм байна. Энэ дээр.

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Яг холбогдох заалтууд дээр ярихгүй бол нөгөө юмыг нь хайж цаг алдах нь байна шүү. Дараагийнх нь.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 6.30 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Үүнийг гүйцээн боловсруулах чиглэл өгье. Яагаад гэхээр энэ дээр 6.4 нь байна шүү дээ. 4 дээр л тодотгол хийгээд байна шүү дээ тээ. 6.30.4 дээр. Тэгвэл гүйцээн боловсруулах чиглэл өгөхөө больё. 6.5 дахь хэсгийг хасах санал хураалтаа явуулъя. Санал хураалт.

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ бараг найруулгаараа ч хасагдах санал. Төлбөртэй бүс нь байхгүй болчихсон биз дээ. Тийм тэгэхээр зөв зөв хасах нь. Найруулгаар хасчихна.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7.6 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг хасаж, 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.Амьтны хүрээлэн ажиллуулахад тавигдах шаардлагыг зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 2 дугаар зүйл буюу 12.5 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн” гэсний өмнө “хэсэгчилсэн ерөнхий” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хэсгийн “11.24 дүгээр зүйл,” гэсний дараа “6.30 дугаар зүйлийн 5 дахь хэсэг” гэж, мөн” гэснийг хасаж, “7.6 дугаар зүйлийн 9, 10” гэснийг “7.6 дугаар зүйлийн 9” гэж тохиолдол бүрд өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.3 хувийн саналаар санал дэмжигдсэн.

Энэ 35 хасагдахаараа тэгж байгаа шүү дээ 6.35. 6.34 чинь хасагдахгүй өөрчлөгдөн найруулагдана шүү дээ тээ. Өөрчлөн найруулах ч яах вэ нэмэлт тодотгол оруулах.

20.Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Санал хураалтыг хүчингүйд тооцсон.

Энийг чинь ерөөсөө хасдагаараа хасах ёстой юм биш үү. Энэ чинь төсөвтэй хамт батлагдсан хуулиар

Засгийн газарт эрх нь шилжчихсэн шүү дээ Ерөнхий сайдад. Тийм, тэгэхээр энэ Нийслэлийн Засаг дарга дээр энэ ирэхгүй л дээ угаасаа л. Тэгээд хасчхаж байгаа юм биш үү. Хасахгүй бол энэ чинь ахиад гүйцээн боловсруулахаар гүйцээн боловсруулж болно л доо. Илүү л ажил байх. Санал хураалт явуулъя. Хасна, хасна, хасаад явчихъя. Энэ чинь агентлаг Ерөнхий сайдын мэдэлд ирээд тийшээ шилжчихсэн юм. Энийг нутгийн удирдлага дээр.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“21.5.4.Энэ хуулийн 21.2.7-д заасан эрх шилжүүлэн авсан бол энэ хуулийн 21.2.4, 21.2.6-д заасан шийдвэр гаргах.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Цахим системийн үйл ажиллагааны журмыг чинь Засгийн газрын хурлаар хэлэлцэж батлах байх билүү. Энийг ч яах вэ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 29.8.1 дэх заалтын “жагсаалтын эхэнд” гэсний дараа “, цахим системд хүсэлт гаргасан огноогоор” гэж, 29.11 дэх хэсгийн “аймаг,” гэсний дараа “сум,” гэж нэмж, мөн хэсгийн “газар ашиглалтын” гэснийг “эдэлбэр газрын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ Газрын хууль энэ тэрийг ингэж хууль дагуулж хамаагүй Үндсэн хуулийг ингэмээргүй л байгаа юм. Энэ дотор чинь ерөөсөө сайн анзаарч байхгүй бол хуулийн хулгай гэдэг юм чинь дундуур гүйчих гээд байх юм энэ чинь. Энэ чинь гэр орон сууцын хашаа барих болон

хүнсний ногоо, жимс жимсгэнэ энэ тэр хүртэл ороод явчихсан байна шүү дээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 12.4, 12.6 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Бүсчлэлд тавигдах шаардлагыг хот, тосгон, бусад суурины эдэлбэр газарт дүрмээр зохицуулах бөгөөд бүсчлэлийн дүрмийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“5 дугаар зүйл.Энэ хууль батлагдахаас өмнө Газрын тухай хуульд заасны дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гаргасан газар эзэмших, ашиглах хүсэлтийг хүлээн авсан эрх бүхий этгээд уг хүсэлтийг шийдвэрлэнэ.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ чинь юу болоод явчлав. Хүсэлт гаргасан болгоныг шийдээд байна гэсэн үг үү. Хууль гарахыг мэдэж байсан хүмүүс давуу эрх эдэлнэ гэсэн үг үү. Тэгвэл амжаад хүсэлтээ гаргачихсан хүмүүсээ хожно гэсэн үг үү. Харин тийм энэ жагсаалтын эхэнд энэ тэр гээд энэ жоохон л. Санал хураалт явуулъя.

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энийгээ үзээрэй. Уул нь яг хууль батлагдахаас өмнө чинь ердийн журмаараа зохицуулагдаад явж болно шүү дээ. Энэ их л сонин зохицуулалт болчихлоо шүү.

21.Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 33.1.25 дахь заалтын “хэмжээг” гэсний өмнө “жишиг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Түрүүний 5 дугаар зүйлийг эцсийн хэлэлцүүлэг дээр нэлээн сайн үзэж болох юм байна шүү. Холбогдох хууль тогтоомжийн дагуу үндэслэн шийдвэрлэнэ гэх юм уу. Ажлын хэсэг дээр энэ 5 дугаар зүйлээ сайн ярихгүй бол дараа нь баахан хүн хэрэгт орох ажил болж магадгүй.

22.Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.3 хувийн саналаар энэ саналыг дэмжиж, хууль санаачлагчид буцаалаа.

23.Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар.

1.Төслийн 1, 2 дахь заалтыг 1.1, 1.2 дахь дэд заалт болгож, төсөлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Бүгд л Засгийн газарт даалгасугай л гэсэн юм.

2.Төслийн 1 дэх заалтад доор дурдсан агуулгатай 3, 4 дэх дэд заалт нэмэх:

“3/Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах хүрээнд нийслэл Улаанбаатар хотын орон сууцны байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл фасад, дээвэр, босоо шугам, хаяавч, узель-д шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

4/Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дахь заалтыг 2 дахь заалт болгон “Эдийн засгийн байнгын хороо” гэсний өмнө “Төсвийн байнгын хороо Г.Тэмүүлэн, Төрийн байгуулалтын байнгын хороо Н.Энхболд,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Нямаагийн Энхболд Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга үг хэлнэ.

Н.Энхболд: Яг энэ заалт дотор багтах уу, үүний өмнө оруулаарай гээд чиглэл өгөх үү. Түрүүчийн хуулиас хасагдсан. Тэгэхдээ Засгийн газарт өгөх чиглэл дотор багтаая гэсэн 2, 3 зүйлээ энэ дотор 2 зүйлээ энэ дотор багтаагаарай гэдэг чиглэлийг та хэлчихвэл би хотод Засгийн газарт өгөх

тогтоол дотроо тэрийгээ багтаах шаардлагатай. Түрүүн ярьчихсан л даа. Тэгэхдээ энэ дээр хэлчихвэл болж л байна.

Г.Занданшатар: Тогтоолоо ахиж найруулъя гэж үү.

Н.Энхболд: Тийм яагаа вэ төрийн үйлчилгээнийхнийг захиргаанд шилжүүлэх асуудал байна, архитектуртай хамт холбоотой ганц нэг юмнууд гарсан. Тэд нарыгаа энэ Засгийн газарт өгөх чиглэл дотроо багтаагаарай гэдэг чиглэл өгчихвөл болчихно. Үгүй бүүр хасагдчихна.

Г.Занданшатар: Тогтоол нэг л хэлэлцүүлэгтэй шүү дээ тээ. Эцсийн хэлэлцүүлэг дээр та хэд нэмж болно л доо. Эцсийн хэлэлцүүлэг дээр. Түрүүний тэр нээрээ өмнө өгсөнд нь давуу эрх олгох утгатай заалт чинь бол ашиг сонирхлын зөрчил үүсгэж мэдэх эвгүй заалт болж магадгүй шүү. Тийм, өмнөх нь давуу эрхтэй, газар олголтыг чангалчхаад, өмнөх нь арай давуу эрхтэй юм шиг өгсөн агуулгатай заалт байж болох гээд байна шүү дээ. Тийм тийм. Угаасаа ерөнхий зарчмаараа эрх зүйн байдлыг муутгаж болохгүй. Тэрийг нь харин өөр зохицуулж болмоор юм.

24.Бусад санал.

1.Дээрх хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энхболд дарга байж байгаарай. Түрүүнийхийг чинь санал хураахгүй гүйцээн бус болгох чиглэл өгчихсөн шүү дээ тогтоолыг чинь.

Тэгэхээр тогтоолыг нэгдсэн нэг тогтоол болгоод л батлаад л, эцсийн

хэлэлцүүлэг хууль батлагдсантай холбогдуулан батлах тогтоолыг иүүд баталж болдог тэр дэгээр явах нь байна шүү.

18.59 цаг

Байж байгаарай. Энэ Тилеуханы Аубакир гишүүн өнөөдөр тусгай чухал өдөр учраас үг хэлэх хүсэлт гаргасан байна. Ингээд Тилеуханы Аубакир гишүүн. Өнөөдөр дэлхийн.

Т.Аубакир: Баярлалаа. Энэ гишүүдээ нэгэнт оройтсон юм чинь маргаашаас ачаалал ихтэй байх байх. Энэ гэрийн тэгжээврийнхээ хуулийг явуулчихмаар байна. Өнөөдөр дэлхийн гэрийн тэгжээвэр амьтны өдөр юм байна 11 сарын 30. 2-хон саналтай. Маргааши ачаалал ихтэй байх юм чинь сая Занданишатар даргаас горимын санал гаргаж байна. Гэрийн тэгжээврийн хуулиа дуусгачихъя. 2-хон саналтай.

Г.Занданишатар: Дэлхийн гэрийн тэгжээвэр амьтны өдөртэй холбогдуулж хуралдааныг сунгаж 1 асуудлыг урагшлуулж хэлэлцэх нь. Энэ чинь дарааллаараа 3 асуудал нь дараагаад байгаа асуудлыг урагшлуулж хэлэлцье гэсэн горимын санал гаргалаа. Энэ санал хураалтыг. Хөөе гишүүд, хөөе Одонтуяа гишүүн та хаачих нь вэ. Одоо ид түгжрэлийн үед түгжрэл нэмээд яах вэ. Хуралдаад сайхан асуудлуудаа шийдээд, 8 хүртэл хуралдаад асуудлаа шийдээд явчихъя гэсэн ийм горимын саналаар.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хамт эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

Сунгаж хуралдаад өнөөдөр 2 саналтай 1 хуулийн төслийг гүйцээгээд хэлчихье гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Дэмжиж байгаа гишүүд гараа өргөчихнө үү. Олонх дэмжсэн учраас ингээд сонгож хуралдахаар шийдвэрлэлээ.

Сунгаж хуралдаад горимын саналын дагуу **Гэрийн тэгжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.**

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар танилцуулна. Цогтбаатар дарга гадаад арга хэмжээнд явах гэж байсан ингээд үлдээчихсэн хуулиа хэлэлцүүлэх боллоо шүү дээ.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр нарын 3 гишүүнээс 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гэрийн тэгжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 16-17-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу Гэрийн тэгжээвэр амьтны тухай хуулийн төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийг агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Идэрийн Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Бямбын Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах газрын дарга, Батбаярын Мөнх-Эрдэнэ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга, Цэдээгийн Гантөмөр Нийслэлийн Мал эмнэлгийн газар газрын Мал, амьтны эрүүл мэндийн хэлтсийн дарга, Бандийн Мөнхжаргал Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын

удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, Цогийн Зориглон “Азтай савар” ТББ-ын тэргүүн, Цэвэлмаагийн Болормаа “Азтай савар” ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн, Мөнгөний Ариунзул Эм Ди Эс Энд ХаанЛекс хуулийн фирмийн хуульч, Нямдоржийн Баясгалан Өмгөөллийн Легал Гайд хуулийн фирмийн хуульч, Дэлгэрийн Цэрэнханд “Монгол банхар” судлалын төвийг үүсгэн байгуулагч, Амгаланбаатарын Наранбаяр Монголын нохой судлалын холбооны тэргүүн.

Асуулт байхгүй байна.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлээ.

19.04 цаг

Холбогдуулан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг, санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар танилцуулна.

Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга, Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Дамдины Цогтбаатар танилцуулна. Зарчмын зөрүүтэй саналын томъёолол байхгүй, дагалдуулан боловсруулсан энэ хууль дээр санал хураалттай.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр нарын 3 гишүүнээс 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн

мэдүүлсэн Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 16, 17-ны өдөр нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт заасныг баримтлан Зөвшөөрлийн тухай хууль шинэчилсэн найруулгад нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар төсөл хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Монгол Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22-т заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зөвшөөрлийн тухай хууль, шинэчилсэн найруулгад нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Ажлын хэсгийн албан тушаал, овог нэр, эрхэлж байгаа ажил бүгд нэгэн адил.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Байнгын хороо Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Өнөөдөр бас заавал Гэрийн тэжээвэр ч гэхгүй ер нь Амьтны тухай хуулийг л гэж нэрлэвэл зохих. Ер нь зарим нэг хүмүүс нохой, муураасаа дор байгаад л асуудал байгаа шүү дээ. Тэд нар л ингээд. Санал хураалт явуулъя.

Байнгын хороо Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ ажиллахгүй байна уу.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Миний санал дэмжигдээгүй гараад байна. Энэ төхөөрөмж ажилласангүй дэмжсэнээр тооцож протоколд тэмдэглэе.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

19.09 цаг

Маргааш 10 цагаас хуулиудыг эцэслэн батална. Түр байж байгаарай байж байгаарай. 1 асуудал явуулчихъя. Угаасаа түгжрэлтэй байгаа.

Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцье. Айн, тэгвэл гишүүд өглөө больё доо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дуусаж, Төрийн байгуулалтын байнгын хороо маргааш өглөө 9 цагаас хуралдаж Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хуулийн эцсийн найруулга сонсох юм байгаа билүү Үнэнбат даргаа? Өөр унших юм байгаа билүү?

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан. Ажлын цаг өндөрлөсөн тул өнөөдрийн нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР